

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-14
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	
	1. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	18-51
	2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	52-144
	3. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	144-150

**Монгол Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы
11 дүгээр сарын 14-ний өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 75 гишүүнээс 59 гишүүн ирж, 78.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 47 минутад Төрийн ордны Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны танхимд эхлэв.

Чөлөөтэй: Я.Санжмятав;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Сумъяабазар, Д.Тэрбишдагва;
Тасалсан: Б.Наранхүү, Н.Номтойбаяр;
Хоцорсон: Ж.Бат-Эрдэнэ – 23 минут, Б.Батзориг – 57 минут, Б.Энх-Амгалан – 20 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 11 дүгээр сарын 14-ний өдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Хэлэлцэх асуудлын дараалалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг эхэлж хэлэлцсэний дараа Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг хэлэлцэх нь зүйтэй гэсэн горимын санал хэлэв.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 43
Бүгд: 65
66.2 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт /76/ гишүүний дөрөвний гурав /57/-аас доошгүйн ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ” хэмээн заасныг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын 75 гишүүнээс 60 гишүүн ирж, 80.0 хувийн ирцтэй байгааг дуулган “Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл”-ийн анхны хэлэлцүүлгийг эхлүүлэв.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, профессор, хууль зүйн ухааны доктор А.Бямбажаргал, дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Ц.Даваасүрэн, Х.Баделхан, С.Чинзориг, З.Нарантуяа, Д.Эрдэнэбат, Б.Бат-Эрдэнэ, Т.Аюурсайхан, Ц.Мөнх-Оргил нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналын томъёололтой холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, О.Баасанхүү нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 15
Бүгд: 70
78.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батзориг, С.Бямбацогт, Г.Солтан нарын дэмжсэн санал техникийн саатлын улмаас эсрэг гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргав.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Б.Батзориг, С.Бямбацогт, Г.Солтан нарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 55
Татгалзсан: 15
Бүгд: 70
78.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 10
Бүгд: 70
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 11
Бүгд: 70
84.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 10
Бүгд: 70
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 9
Бүгд: 70
87.1 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Баасанхүү, Д.Дамба-Очир, О.Содбилэг нарын гаргасан, Төсөлд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.” гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат, С.Бямбацогт, О.Баасанхүү, Ч.Хүрэлбаатар, Н.Оюундарь, З.Нарантуяа, Ц.Цогзолмаа, Н.Цэрэнбат, Ш.Раднаасэд нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 11
Бүгд: 70
84.3 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, “Энэ хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 9
Бүгд: 70
87.1 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нарын гаргасан, Төсөлд “Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн агуулгатай зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 54
Татгалзсан: 16
Бүгд: 70
77.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хоёр. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй санал:

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн саналыг дэмжих боломжгүй гэснийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 11
Бүгд: 70
84.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 12 цаг 44 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор, профессор, А.Бямбажаргал, дэд ажлын хэсгийн гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат, Үндэсний статистикийн газрын дарга А.Ариунзаяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Р.Дагва, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномцэрэн, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч асан Б.Лхагважав, Үндсэн хууль судлаач, Монгол Үндэсний Ардчилсан намын дарга Б.Цогтгэрэл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор Ч.Өнөрбаяр, Үндсэн хууль судлаач,

хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал, Үндсэн хууль судлаач, хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Захиргаа, аж ахуйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга П.Цэрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Гадаад харилцааны хэлтсийн дарга Ц.Нарантунгалаг, Захиргаа, санхүү үйлчилгээний хэлтсийн дарга Л.Хосбаяр, Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Элбэгзаяа, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга С.Батбаатар, Улсын Их Хурлын даргын Хууль зүйн бодлогын зөвлөх Ж.Сүхбаатар, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны дарга Н.Энхтайван, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.1-д “Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт /76/ гишүүний дөрөвний гурав /57/-аас доошгүйн ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ” хэмээн заасныг танилцуулж, чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг хангасан байгааг дуулган Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг эхлүүлэв.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Энх-Амгалан 13 цаг 20 минутаас хуралдааныг даргалав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Ё.Баатарбилэг, М.Оюунчимэг, Л.Болд, Х.Нямбаатар, Б.Бат-Эрдэнэ, Б.Ундармаа, Ц.Гарамжав, Х.Болорчулуун, Г.Тэмүүлэн, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баттөмөр, Ш.Раднаасэд, Н.Учрал, Л.Элдэв-Очир нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан, дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 14 цаг 50 минутаас хуралдааныг даргалав.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн саналын томъёоллуудаар санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа,

Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гаргасан, Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд доор дурдсан агуулгатай Гучин есдүгээр зүйлийн 4 дэх хэсэг нэмэх:

“4.Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү үг хэлэв.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 8
Бүгд: 69
88.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх санал дэмжигдсэн тул хууль хооронд нийцүүлэх үүднээс 2.а саналаар санал хураалт явуулав.

2.а.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн “өөрчилсүгэй” гэсэн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэсний дараа “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 60
Татгалзсан: 9
Бүгд: 69
87.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Содбилэг, О.Баасанхүү, Д.Эрдэнэбат нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 28
Бүгд: 69
59.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх санал дэмжигдээгүйтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн дарга Д.Эрдэнэбат Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлэгт

зөвшилцлийн хүрээнд Ардчилсан намаас тавьсан зарчмын гурван саналын хоёр нь унасанд харамсаж байгаагаа илэрхийлж, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн гишүүд Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн цаашдын хэлэлцүүлэгт оролцохгүй гэдгийг мэдэгдэж хуралдааныг орхиж гарав.

Мөн Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Б.Пүрэвдорж, З.Нарантуяа нар үг хэлж хуралдааныг орхиж гарав. /16.24 цагт/

4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	4
Бүгд:	65

93.8 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	62
Татгалзсан:	3
Бүгд:	65

95.4 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараах “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Цэрэнбат үг хэлэв.

Зөвшөөрсөн:	61
Татгалзсан:	3
Бүгд:	64

95.3 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 2
Бүгд: 64
96.9 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,” гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 2
Бүгд: 64
96.9 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 3
Бүгд: 64
95.3 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Гарамжав үг хэлэв.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 1
Бүгд: 64
98.4 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батзандан, Ц.Цогзолмаа нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 5
Бүгд: 63
92.1 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 6 дугаар зүйлийн “рашаан барилдлагатай өлзийт сайн шар луу” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 59
Татгалзсан: 4
Бүгд: 63
93.7 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Оюунхорол үг хэлэв.

Зөвшөөрсөн: 58
Татгалзсан: 5
Бүгд: 63
92.1 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 61
Татгалзсан: 2
Бүгд: 63
96.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураалтыг явуулж дуусав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал хураалтаар дэмжигдсэн саналуудыг нэмж тусгах редакцын ажил бэлэн болох хүртэл чуулганы нэгдсэн хуралдааныг түр завсарлуулж байгааг мэдэгдэв.

Чуулган нэгдсэн хуралдаан 17 цаг 03 минутад завсарлаж, 17 цаг 43 минутаас үргэлжлэн хуралдав.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн нэр, зүйл, хэсэг, заалт, цэг, таслал нэг бүрээр нь уншиж сонсгов.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг бүхэлд нь батлах санал хураалтад Улсын Их Хурлын гишүүд гар өргөн оролцов.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг батлах санал өгсөн Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийг дуудав.

1. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан,
2. Дуламдоржийн Тогтохсүрэн,
3. Миеэгомбын Энхболд,
4. Сандагийн Бямбацогт,
5. Дуламсүрэнгийн Оюунхорол,
6. Баттогтохын Чойжилсүрэн,
7. Баагаагийн Баттөмөр,
8. Содномын Чинзориг,
9. Жамъянгийн Мөнхбат,
10. Өлзийсайханы Энхтүвшин,
11. Сүхбаатарын Батболд,
12. Данзангийн Лүндээжанцан,
13. Цэндийн Нямдорж,
14. Отгонбилэгийн Содбилэг,
15. Шатарбалын Раднаасэд,
16. Батбаярын Ундармаа,
17. Агваансамдангийн Сүхбат,
18. Жаргалтулгын Эрдэнэбат,
19. Чүлтэмийн Улаан,
20. Янгугийн Содбаатар,
21. Дорждамбын Дамба-Очир,
22. Хишгээгийн Нямбаатар,
23. Цэдэнгийн Гарамжав,
24. Ганзоригийн Тэмүүлэн,
25. Намсрайн Амарзаяа,
26. Ням-Осорын Учрал,
27. Наваан-Юндэнгийн Оюундарь,
28. Лхагвын Мөнхбаатар,
29. Төмөрбаатарын Аюурсайхан,
30. Цэндийн Мөнх-Оргил,
31. Хаянгаагийн Болорчулуун,
32. Агваанлуvsангийн Ундраа,
33. Хавдисламын Баделхан,
34. Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ,
35. Лувсангийн Энхболд,
36. Цэрэнпилийн Даваасүрэн,
37. Дамдины Хаянхярваа,
38. Даваагийн Ганболд,
39. Мөнхөөгийн Оюунчимэг,
40. Даваажанцангийн Сарангэрэл,
41. Ёндонпэрэнлэйн Баатарбилэг,
42. Магваны Билэгт,
43. Борхүүгийн Дэлгэрсайхан,
44. Жадамбын Бат-Эрдэнэ,
45. Гомпилдоогийн Мөнхцэцэг,
46. Жамбалын Ганбаатар,
47. Жадамбын Энхбаяр,

48. Чимэдийн Хүрэлбаатар,
49. Отгоогийн Батнасан,
50. Батсүхийн Саранчимэг,
51. Батжаргалын Батзориг,
52. Намсрайн Цэрэнбат,
53. Болдын Жавхлан,
54. Гомбожайн Солтан,
55. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ,
56. Нямаагийн Энхболд,
57. Лхагваагийн Элдэв-Очир,
58. Цэдэнбалын Цогзолмаа,
59. Дамдины Цогтбаатар,
60. Бямбасүрэнгийн Энх-Амгалан,
61. Самандын Жавхлан,
62. Жалбасүрэнгийн Батзандан,
63. Лувсанвандангийн Болд,
64. Гомбожавын Занданшатар.

Санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын 64 гишүүний 100 хувийн саналаар Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдлаа. /18:04 цагт/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар үг хэлж дууссаны дараа Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэхэд Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын удирдлагууд болон хуралдаанд оролцсон ажлын хэсгийн гишүүд, зочид төлөөлөгчид, ажилтнууд босож хүндэтгэл үзүүлэв.

Чуулган нэгдсэн хуралдаан 18 цаг 11 минутад завсарлаж, 19 цаг 06 минутаас үргэлжлэн хуралдав.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Улсын Их Хурлын 2019 оны 68 дугаар тогтоолоор байгуулагдсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэгтэй дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн, дэд ажлын хэсгийн ахлагч, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Р.Хатанбаатар, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын гавьяат хуульч Н.Лувсанжав, дэд ажлын хэсгийн ахлагч, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан, дэд ажлын хэсгийн гишүүн, Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан Д.Ламжав, дэд ажлын хэсгийн гишүүн Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор, профессор, А.Бямбажаргал, дэд ажлын хэсгийн

гишүүн, Үндсэн хууль судлаач О.Машбат, Үндэсний статистикийн газрын дарга А.Ариунзаяа, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Р.Дагва, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Амарсайхан, Сонгуулийн Ерөнхий Хорооны дарга Ч.Содномцэрэн, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Ерөнхийлөгч асан Б.Лхагважав, Үндсэн хууль судлаач, Монгол Үндэсний Ардчилсан намын дарга Б.Цогтгэрэл, Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн ухааны доктор Ч.Өнөрбаяр, Үндсэн хууль судлаач, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал, Үндсэн хууль судлаач, хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Хууль, эрх зүйн асуудал хариуцсан нарийн бичгийн дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ж.Бямбадулам, зөвлөх Ц.Болормаа нар байлцав.

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт танилцуулав.

Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Оюун-Эрдэнэ, Л.Болд нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга С.Бямбацогт, дэд ажлын хэсгийн ахлагч, Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан Ц.Товуусүрэн нар хариулж, тайлбар хийв.

Төслийн талаар үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаар Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Содбилэг, Д.Оюунхорол, Ж.Батзандан нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 62
Татгалзсан: 2
Бүгд: 64
96.9 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн зүйл нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 63
Татгалзсан: 1
Бүгд: 64
98.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Г.Занданшатар: Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг бүхэлд нь батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 64
Татгалзсан: 0
Бүгд: 64
96.9 хувийн саналаар хууль батлагдлаа.

Уг асуудлыг 19 цаг 47 минутад хэлэлцэж дуусав.

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн 5 дугаар хорооны иргэд, сонгогчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Наранхүүгийн урилгаар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын сургуулийн багш, сурагчид, Олон Улсын дээд сургуулийн оюутнууд, Улсын Их Хурлын гишүүн Ө.Энхтүвшингийн урилгаар Чингэлтэй дүүргийн 12, 13, 14, 15 дугаар хорооны Засаг дарга нар болон хэсгийн ахлагч нар, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнийн урилгаар Баянгол дүүргийн 3, 4 дүгээр хорооны иргэд сонгогчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн сумдын төрийн албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны иргэд сонгогчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Б.Дэлгэрсайхан, Г.Мөнхцэцэг нарын урилгаар Дорноговь аймгийн Айраг сумын төрийн албан хаагчдын төлөөлөл, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цогзолмаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга З.Нямцогт, мөн хэлтсийн шинжээч Р.Дэлгэрмаа, М.Номиндулам нар хариуцан ажиллав.

Хуралдаан 7 цаг 26 минут үргэлжилж, 75 гишүүнээс 70 гишүүн ирж, 93.3 хувийн ирцтэйгээр 19 цаг 48 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ПРОТОКОЛЫН АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2019 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 14-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Г.Занданшатар: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын 2019 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл.

Хоёрдугаарт, Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ төслийг эхэлж хэлэлцэхгүй бол манай зарим гишүүдийн дунд одоо сонгуулийн тогтолцоог 2020 оноос болгох гэж байна гэсэн тийм буруу ойлголт яваад байгаа гэж бүлгээс мэдэгдлээ. Тийм учраас энэ дагаж мөрдөх журмын тухай хуулиа эхэлж хэлэлцээд хугацааг шийднэ.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2020 оны 5 дугаар сарын 25-наас хэрэгжиж эхэлнэ. Ямар ч заалтыг тусгайлан наашлуулах бололцоогүй. Тэрнээс хойш дандаа. 5 сарын 25-наас хойшлуулж л болох ийм хууль журамтай.

Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.1-т, Үндсэн хуулийн Жаран есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурав буюу 57-оос доошгүй ирцтэй бол түүнийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг авч хэлэлцэхэд хүчин төгөлдөр гэж үзнэ гэж заасан. Өнөөдөр 60 гишүүний ирцтэй Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэх ирцийн шаардлага хангагдсан байна.

Одоо хэлэлцэх асуудалдаа орж байна. Энэ журмын тухай хуулийг хэлэлцэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулна. Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх. Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн горимын санал хэлнэ.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэг болж байгаатай холбогдуулаад хурлын хэлэлцэх асуудлын дараалал ярьж байх шиг байна.

Дарааллаар бол бид Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлгийг эцэслэн хийж батлаагүй байхад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулахад дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг хэлэлцэж болохгүй л дээ. Дараалал нь өөрчлөгдчихөөд байна.

Бид өнөөдөр яг нэмэлт, өөрчлөлтөөрөө юугаараа батлахаа эцэслэн шийдээгүй байж дагаж мөрдөх журмын тухай ярьж болохгүй шүү дээ. Энэ яагаад ингээд өөрчлөгдчихөв. Тэгээд юу батлагдахаа мэдэхгүй байж журам батална гэж. Нэмэлт, өөрчлөлт нь батлагдаагүй байхад батлагдсан мэтээр журам хэлэлцдэг дараалал байж болохгүй.

Тийм учраас манай гишүүд энэ дээр онцгой анхаарах хэрэгтэй байх. Тэгээд аливаа нэгэн юм бас нэг журамтай, дараалалтай байдаг байх ёстой. Эхлээд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зарчмын зөрүүтэй гаргасан саналуудаар санал хураагаад Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг шийдсэний дараа үүнээс дагаж мөрдөх журмаа бол батлах ёстой гэж бид үзэж байгаа.

Тийм учраас энэ хэлэлцэж байгаа асуудлынхаа дарааллыг өөрчлөөд Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцэх асуудал руу орох нь зүйтэй гэдэг асуудлаар горимын санал гаргаж байна. Тэгээд энэ саналыг авч үзэхийг хүсье.

Г.Занданшатар: Д.Эрдэнэбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалгаж болно.

Гэхдээ энд ийм асуудал байгаа юм. Анхны хэлэлцүүлэг учраас анхны хэлэлцүүлгээ явуулчихаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хэлэлцэж санал хураалт явуулаад. Эцсийн хэлэлцүүлэг. Энэ журмын тухай хуулийн чинь эцсийн хэлэлцүүлэгт Төрийн байгуулалтын байнгын хороо ахиж шилжиж байж эцэслэн батлагдахдаа журмын тухай хуулиа тусгаад. Энд хууль, журам зөрчигдөх зүйл үгүй. Батлагдахдаа л дараалал нь гарчихна. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Би нэг зүйл тодруулъя. Бид чинь намар ээлжит бус хурал хийгээд Үндсэн хуулийнхаа асуудлыг яриад. Тэгээд нөгөө ард түмнээрээ хэлэлцүүлж санал асуулга явуулна гээд тогтоол баталчихсан шүү дээ. Тийм ээ.

Тэгээд одоо ингээд гуравдугаар хэлэлцүүлэг шууд явах гээд байна шүү дээ. Ямар нэгэн ард түмний санал хэлэлцүүлэггүйгээр. Энийгээ яаж зохицуулсан юм бэ? Өмнөх шийдвэрээ хүчингүй болгосон юм уу? Яагаад асуухгүй байгаа юм. Асуухгүй байгаа шалтгаанаа нэг хэлээч.

Г.Занданшатар: Ц.Даваасүрэн гишүүн чуулгандаа оролцохгүй учраас энийг мэдээгүй юм байна. Мэдээллийг хэн өгөх вэ.

85 дугаар тогтоол батлаад Ерөнхийлөгч хориг тавигдаад. Ерөнхийлөгчийн хориг тавигдаад. Ард нийтийн санал асуулга явуулах тухай Улсын Их Хурлын тогтоол дээр Ерөнхийлөгчийн хориг тавигдаад. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваад. Тэр тогтоол хүчингүй болоод. Тэр хүчингүй болсонтой холбогдуулаад 85 дугаар тогтоол батлагдаад. Тэр тогтоолоор гуравдугаар хэлэлцүүлэг явуулах шийдвэр гараад. Ингээд гурван чуулган дараалаад энийг хэлэлцээд явж байгаа.

Тийм учраас энэ дээр өмнөх чуулганы хэлэлцсэн асуудлын протоколыг аваад уншиж үзэх нь зүйтэй байх гэж бодож байна.

Ингээд Д.Эрдэнэбат гишүүний гаргасан горимын саналаар. Д.Эрдэнэбат гишүүн. Тодруулах дэг байхгүй. Одоо тайлбар хэлчих та.

Д.Эрдэнэбат: Энэ анхны хэлэлцүүлэг хийх ёстой гэдэгтэй бол санал зөрөлдөхгүй байгаа л даа. Хамгийн гол нь энэ журмын тухай хуульд чинь гуравдугаар хэлэлцүүлгээр орох холимог тогтолцооны асуудлыг хэзээнээс хэрэгжүүлэх вэ гэдэг оны тухай асуудал энэ дээр яригдаж байгаа байхгүй юу даа.

Тийм учраас би энийг онцолж хэлээд байгаа юм. Бид нар энийг одоо хэлэлцэхгүйгээр шууд Үндсэн хууль руугаа ороод, тэгээд Үндсэн хуулийн асуудал шийдэгдсэний дараа Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаад нэгдүгээр хэлэлцүүлгээ яг Үндсэн хуулийн батлагдсан эхийн дагуу хугацааныхаа асуудлаар холимог тогтолцоо шийдэгдвэл энийг өөрчлөх тухай асуудлыг ярьж болно. Дараа нь буцаад чуулганаар орж ирээд эцэслэн баталж болно. Энэ дээр ямар ч асуудал байхгүй гэж бодож байна. Зарчмын зөрүүтэй саналын зөрүү гарахгүй бол шууд баталсан ч болно. Их Хуралд бүрэн эрх нь байгаа.

Тийм учраас энийг заавал ингэж зүтгүүлэх бол би процедурын хувьд буруу болчихжээ гэж хэлж байгаа. Яагаад вэ гэвэл нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэгт орох, орсон зүйл, заалттай холбоотой асуудлыг энэ шилжих журмын тухай хууль чинь өөрөө хугацаа тодорхойлж байгаа учраас зарчмын хувьд буруу байна гэж хэлж байгаа юм. Их Хурлын дарга аа, манай гишүүд ээ, энийг бас маш зөв ойлгож байх хэрэгтэй. Наадах чинь дараа нь хуулийн зөрчил болж хувирна.

Г.Занданшатар: Ер нь Үндсэн хуулийн хоёрдугаар хэлэлцүүлгээр энэ журмын тухай хуулийн төсөл батлагдахад.

Ер нь одоо энэ Төрийн байгуулалтын байнгын хороо өчигдөр хуралдаад Үндсэн хууль бүхэлдээ 2020 оны 5 дугаар сарын 25-наас эхлэн хүчин төгөлдөр болно гээд заачихсан. Тэрнээс хойш л хугацаа тавигдана уу гэхээс биш. 2020 оны 5 дугаар сарын 25-наас урагшлуулж тусгайлан зүйл, заалтуудыг тухайлбал сонгуулийн холимог тогтолцоо ч гэдэг юм уу, энэ заалтууд урагшлах бололцоогүй. Хууль зүйн хувьдаа тийм. Техникийн хувьд.

Хоёрдугаарт нь, тэр заалтад чинь сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Нэг жилийн өмнө сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж болохгүй

гэсэн ийм заалт хүчин төгөлдөр болчихсон. Тэр заалт чинь бас зөрчилдөх учраас сонгуулийн тогтолцоог 2020 оноос мөрдөж эхлэх ямар ч хууль зүйн болон техникийн боломжгүй байна гэдгийг зөвөөр ойлгоорой. Харин Сонгуулийн хууль дээрээ энэ асуудлыг жич ярьж болно.

Ингээд Д.Эрдэнэбат гаргасан горимын саналаар санал хураалт явуулна. Энийг Байнгын хороон дээрээ сайн нягталж шалга. Хууль зүйн хувьд Улсын Их Хурлын Тамгын газар бол ийм тодорхойлолт, лавлагаа өгсөн.

Энэ долоо хоногт төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүндээ мэндчилгээ дэвшүүлчихье.

11 дүгээр сарын 14-нд Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг төржээ. Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс Мөнхөөгийн Оюунчимэг гишүүнд төрсөн өдрийн мэнд хүргэж эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Дондогдоржийн Эрдэнэбат гишүүний гаргасан горимын саналаар санал хураалт явуулъя. Д.Эрдэнэбат гишүүний гаргасан санал бол чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын дарааллыг өөрчилж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөө эхэлж, гурав дахь хэлэлцүүлгээ явуулаад, дараа нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслөө хэлэлцье гэсэн ийм горимын санал гаргалаа.

Бид Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслөө анхны хэлэлцүүлэг учраас эхэлж явуулчихаад, тэгээд Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлчхээд, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийнхөө гурав дахь хэлэлцүүлгийг явуулъя гэсэн ийм дараалал тавьсан. Тэгээд энэ дарааллыг өөрчилье гэсэн Дондогдоржийн Эрдэнэбат гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалтад 65 гишүүн оролцож, 22 гишүүн дэмжиж 66.2 хувиар татгалзсан учраас энэ горимын санал дэмжигдсэнгүй.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт даргыг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн Улсын Их Хуралд 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 08 дугаар сарын 28, 29, 30, 09 дүгээр сарын 4, 5, 6, 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулсан болно.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2019 оны 9 дүгээр сарын 07-ны өдөр болон 11 дүгээр сарын 13-ны өдрүүдийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁷ дугаар зүйлийн 24^{7.6} дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийлээ.

2019 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн нар Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үед Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оруулсан Улсын дээд шүүхийн шүүгчийн болон Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт оруулсан Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа, шалгууртай холбоотой зохицуулалтыг тус тус төслөөс хассан тул Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн 3, 4, 5 дугаар зүйлийг төслөөс хасах, Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвших шалгуур, бүрэн эрхийн хугацааг нэмэхтэй холбоотой зохицуулалтын дагаж мөрдөх хугацааг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн дагаж мөрдөх хугацаатай адил байхаар тогтоох нь зүйтэй гэж үзэн төслийн 2 дугаар зүйлийг төслөөс хасах, мөн Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн нар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Баасанхүү, Д.Дамба-Очир, О.Содбилэг нар "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлэнэ." гэсэн санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Байнгын хороо 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаараа төслийн анхны хэлэлцүүлгийг үргэлжлүүлэн явуулах үед Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн буюу мажоритар болон хувь тэнцүүлэх буюу пропорционал зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэсэн агуулга бүхий 1, 2 дахь өгүүлбэр нэмсэнтэй холбогдуулан Ажлын хэсгээс

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөлд “Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн зүйл нэмэх санал гарсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатаас “Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн санал гаргасныг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.19 дэх хэсэгт “Төслийн нэг зүйл, хэсэг, заалтын талаар хоёр буюу түүнээс дээш саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа зэрэгцээ саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож санал хураалт явуулахгүй.” гэж заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд саналуудыг танилцуулж, эхэнд ирүүлсэн Ажлын хэсгийн саналаар санал хураахад хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь дэмжсэн тул Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатын гаргасан саналыг дэмжээгүйд тооцсон болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Б.Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа. Орчихсон байна. Ц.Даваасүрэн гишүүн хоёрт байна. Т.Аюурсайхан, Ж.Мөнхбат гишүүнээр нэмлээ. Октябрийн Баасанхүү гишүүн асуулт асууна.

О.Баасанхүү: Баярлалаа. Би нэг зүйл асууя.

Энэ гуравдугаар хэлэлцүүлэг 56-аас дээш хүмүүс кнопдоод явах байх л даа. Яг аль нь батлагдаад, аль нь батлагдахгүй гэдгийг яаж мэдээд байгаа юм? Батлагдахгүй болчихвол энэ одоогийн хэлэлцэж байгаа хууль чинь өөрөө ямар ач холбогдолтой болох юм? Жишээлбэл, одоо жагсаалтын ч гэдэг юм уу, та нарын яриад байгаагаар холимог тогтолцоо гээд байгаа зүйл байна. Тэр батлагдах ч юм у, үгүй ч юм уу? Ойлгомжгүй байгаад байгаа юм.

Тэгэхээр гурав дахь хэлэлцүүлгийг өнөөдөр явсны дараа бид нар нэг суугаад энийг нь одоо 2020 оноос, энийг нь одоо 2024 оноос, энийг нь 2025 оноос гэх мэтчилэн ингээд Ерөнхийлөгч энэ тэртэй яриад, ингээд журмын тухай хууль баталдаг л даа.

Тэгэхээр анхны хэлэлцүүлэг гэдэг чинь би ойлгохдоо юу гэж бодсон бэ гэвэл хэлэлцэх эсэхийг шийдэх асуудал бол өөр асуудал байх. Яагаад гэвэл энэ нөгөө өргөн бариад ийм журмын тухай хууль гаргах нь зөв үү, буруу юу? Мэдээж одоо тусдаа хууль гарна биз дээ гээд ярина. Одоо анхны

хэлэлцүүлгээр хийсэн юмаа эцсийн хэлэлцүүлгээр оруулна гээд ингээд шууд явж байгаа нь арай л дээрэнгүй хандаж байгаа юм биш үү гэж би хэлэх гээд байна л даа.

Анхнаасаа та бүхнийг энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэгтээ. Би өмнө нь хэлж байсан. Улс төрийн намын тухай хууль болон Сонгуулийн хуулиар суудал бүхий нам гэдэг бол сонгуулийн үр дүнд Монгол Ардын Хувьсгалт нам 114 мянган хүний санал өгсөн тэр намыг оролцуулаад Ардчилсан нам гээд тухайн үедээ 11 байж байгаад аймхай 2 нөхөр гараад явчихсанаас болоод бүлэггүй болсон. Тэр хоёр нөхрийг хасаад бүлэггүй болсон ч гэсэн Ардчилсан нам гээд хэлэлцүүлэгтээ ороод Ардын нам гээд өнөөдөр 65 байсан. Одоо бөгс, бөөрний асуудал болоод 64 болчихсон ч гэсэн 64 гэдэг байдлаар нь оруулаад ингээд нэг Ажлын хэсэг гаргаад яваач гэсэн. Харамсалтай нь Зөвшилцлийн ажлын хэсэг санал өгөх асуудлаараа Монгол Ардын Хувьсгалт намыг оруулаагүй.

Аргаа бараад бид нар ард түмэн эрх барьдаг гэдэг өнөөдөр афоризм гэж хэлж болно. Аксиом тавиад өнөөдөр одоо тэмцлийн нэлээн хурц хэлбэр лүү орох алхам руу түлхэж байна. Тэгээд ийм байхад өнөөдөр, ядаж байхад өнөөдөр гуравдугаар хэлэлцүүлэг дотор заримыг нь аваад, заримыг нь авахгүй. Зарим нь болно, болохгүй гэж байхад шууд батлагдах нь ойлгомжтой. Хэлэлцэгдэх нь ойлгомжтой, батлагдах нь ойлгомжтой. Тийм учраас одоо ингээд журмын хуулиа нэгдүгээрт нь явъя гэж. Дарааллаараа ядаж хоёрт нь оруулж болдоггүй юм уу? Дарааллаараа. Эхлээд Үндсэн хуулиа ярьчихъя. Дараа нь журмын хуулиа ярьчихъя. Яагаад заавал нэгдүгээрт нь оруулаад байгаа юм бэ?

Дээрээс нь энэ Үндсэн хуулийг хэлэлцэхэд бас нэг хууль байгаа шүү дээ. Үндсэн хууль хэлэлцэж байхад өөр ямар ч хуулийг хэлэлцэхгүй гэдэг байгаа. Журмын хууль гэдэг чинь ердийн хууль болоод явчихна. 35, 36 хүний кнопоор шийдэгдэнэ гэсэн үг.

Тэгэхээр энэ чинь нөгөө Үндсэн хуулийг хэлэлцэх хуультайгаа зөрчилдөөд байгаа юм биш үү. Үндсэн хууль нь батлагдлаа гэх юм бол араас нь хууль явах юм бол өөр. Гэтэл Үндсэн хууль хэлэлцэж байхад дундуур нь оруулж өөр хууль. Тэгвэл одоо энэ дотор нөгөө бусад янз бүрийн тэр Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо энэ тэрээ оруулаад яв л даа. Эхний ээлжид ярьж болдог л юм бол.

Тийм учраас энэ журмыг хуулийг хамгийн эхэнд оруулж тавиад, хэлэлцээд байгаа юм бэ гэдгээ яриач. Энэ дээр Ардчилсан нам ч гэсэн хатуу байр сууриа илэрхийлээч гэж хэлмээр байна. Юунаас нь айдаг юм бэ? Манай энэ Ардчилсан намынхан арай л сул байна шүү. Сайн муу ч гэсэн дөч гаран хувь гудамжинд та нарыг хараад суугаад байхад чинь л орой нь очоод эвлэрчих юм. Боль л доо.

Г.Занданшатар: Анхны хэлэлцүүлэг. С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: О.Баасанхүү гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт нь, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг бид нар хэлэлцэж байгаа. Энэ хэлэлцүүлэг маань анхны хэлэлцүүлэг. Энэ хэлэлцүүлгийн дараа эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Эцсийн хэлэлцүүлэг. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль маань бид эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа. Эцсийн хэлэлцүүлэг.

Өөрөөр хэлэх юм бол үндсэндээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл маань эхэнд нь явж байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн дараалал маань хоёрт нь явж байгаа.

Цаг хугацааныхаа хувьд үндсэндээ эцэстээ батлагдахдаа Үндсэн хуулийн гурав дахь хэлэлцүүлэг хийгдэж дууссаны дараа дагаж мөрдөх журмын тухай хууль эцэслэж батлагдана. Хоцорч явж байгаа учраас бид нар бас зэрэгцүүлэх үүднээс эхэнд оруулж ирж байна сая. Нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь, яг ямар зүйл нь батлагдаад, ямар зүйл дэмжигдэхгүй болчих вий гэж санаа зовж байх шиг байна. Дагаж мөрдөх журмын тухай хуульд бид нар анх тусгасан байсан зарим зүйл заалтуудыг бас хассан байгаа. Тухайлах юм бол тэр шүүхтэй холбоотой. Шүүгчид тавигдах шаардлагыг тэдэн оны, тэдэн сарын, тэднээс мөрдөнө гэсэн заалтыг бид нар нэгэнтээ шүүгчдийн холбоонд тавигдах шаардлага Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс хасагдсан учраас дагаж мөрдөх журмын тухай хууль дээр оруулах шаардлагагүй гэж үзсэн.

Мөн одоо Үндсэн хуулийн цэцийн талаар бас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өргөн баригдсан заалт хасагдсан. Дэмжигдээгүй учраас үүнийг одоо бас дагаж мөрдөх журмын тухай хуулиас хассан. Өчигдөр Байнгын хороон дээр ярьсан асуудлаар бол зөвхөн одоо сонгуулийн холимог тогтолцоотой холбоотой асуудал дагаж мөрдөх журмын тухай хууль дээр нэмж орж ирэхээр болж байгаа.

Бусад асуудлуудыг Дархан, Эрдэнэтийг хот болгох, Үндсэн хуулийг нэмэлт, өөрчлөлтийг хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусгах, Үндсэн хуулийн хүчин төгөлдөр байх хугацаа зэрэг асуудлыг бид нар ард нийтийн санал асуулга явуулах тухай, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоол батлах үед хэлэлцээд шийдвэрлэчихсэн. Одоо зөвхөн сонгуулийн тогтолцоог 2024 оноос хэрэгжүүлнэ гэдэг заалтыг бид нар дагаж мөрдөх журмын тухай хуульд оруулж ирж байгаа.

Тийм болохоор одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс хасагдчих юм бол энэ журмын тухай хууль чинь өөрчлөгдчихвий гэж санаа зовох зүйл байхгүй. Анхны хэлэлцүүлэг хийж байгаа. Одоо үүний дараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ. Үүний дараа дахиад Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийгдэнэ.

Тийм болохоор хэрвээ энэ холимог тогтолцоотой холбоотой асуудал гурав дахь хэлэлцүүлэг дээр уначих юм бол түүнтэй холбоотойгоор эцсийн

хэлэлцүүлэг хийх үедээ журмын тухай хуулийнхаа өөрчлөлтийг хийгээд явчихна.

Дараагийн асуудал тэр Үндсэн хууль хэлэлцэж байхад бусад асуудал хэлэлцэхгүй гэсэн одоо яасан бэ гэж. Бусад асуудал хэлэлцэхгүй байгаа. Үндсэн хууль хэлэлцэж байгаа үед зохион байгуулалтын болон хуулиар тогтоосон, хуулийн хугацаатай асуудлыг хэлэлцэнэ гэсэн журмын тухай хуульд ийм заалттай. Энэ заалтыг бид нар зөрчөөгүй. Төсвийг бол хэлэлцээд явж байгаа. Зохион байгуулалтын шинжтэй, нэг удаагийн арга хэмжээнд хэлэлцээд явах нь хуулиар нээлттэй байгаа. Бусад асуудлыг бол хэлэлцэх нь хориотой. Энэ дэг зөрчигдөхгүй явж байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн асуулт асууна. Ц.Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Өнөөдрийн энэ хэлэлцээд байгаа асуудал бол Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлсэн зарчмаар хослуулан явуулах асуудлыг хэзээ мөрдөж эхлэх вэ гэдэг л хугацааны асуудал яриад байгаа юм л даа. Хувь тэнцүүлсэн зарчим гэдэг маань үндсэндээ бол пропорционал буюу нам сонгох тухай асуудал байгаа юм.

Тэгээд би нэг хэд хэдэн зүйлийг протоколд тэмдэглүүлж үлдээе гэж ингэж бодож байгаа юм. Бид ард түмнийхээ сонгох эрхэнд халдаж байна. Ингэхдээ Үндсэн хуулийн хэд хэдэн хуулийн зөрчил гарч байгааг би хэлэх ёстой гэж бодож байгаа юм. Жишээлбэл, Ерөнхийлөгч ингээд хориг тавилаа гээд. Хориг тавьж болно. Гэтэл шинэ саналууд орж ирээд хураагдаад байгаа чинь өөрөө хууль зөрчиж байгаа юм. Шинэ саналууд. Гурав дугаар хэлэлцүүлэг дээр.

Энэ дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5.4.1 дээр чинь ингэж байгаа. Энэ хуулийг хэлэлцэхдээ дур зоргын шинжтэй байж болохгүй гэж байгаа. Одоо жишээлбэл бид асуудлаа шийдээгүй байж хэзээ мөрдөж эхлэх вэ гээд төгсгөлөөс нь хэлэлцэж эхэлж байгаа энэ тэрийг хэлж байгаа шүү. Тэр Ерөнхийлөгч дундуур нь орж ирээд ингээд байгааг хэлж байгаа юм. Дур зоргын шинжтэй байж болохгүй гэж.

5.4.2 дээр аль нэг намын ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаалж болохгүй гэж байгаа. Яахаараа бид нар Ардчилсан намын 3 саналыг, нам сонгох саналыг хүлээж аваад байгаа юм. Энийг та нар бодох хэрэгтэй. Аль нэг намын ашиг сонирхлыг илэрхийлсэн байж болохгүй. Энийг цэцийнхэн сонсох хэрэгтэй.

5.4.3 иргэний эрх, эрх чөлөөг дордуулж болохгүй гэж байгаа шүү. Сонгох эрхэнд нь бид нар халдаж байгаа шүү, иргэний. Сонгох эрхэнд нь халдаж байгаа. Яах вэ нэр тавина. Хүний жагсаалт байна гээд байгаа юм. Тэгж худлаа ярьж болохгүй. 2012 онд бас тэгж байсан. 30 нам байдаг гэж бодъё. 26 хүн жагсаая. 600 хүний нэртэй саналын хуудсыг бөглөөд сууж байдаг, тэрийг шүүгээд сууж байдаг хүн байх уу? Багтаагаад хэвлэж чадах уу? Олон юм гарч ирнэ.

Ер нь зүгээр олон түмнээрээ шүүгдэхэд буруу юм байхгүй байсан юм. Бас нэг хэтэрхий төрийн эрх дээр дураараа дургиж дунд чөмгөөрөө жиргээд байгаа улсуудыг шүүдэг байх хэрэгтэй шүү дээ, энэ олон түмэн.

Нам төлөвших тухай яриад байгаа юм. Энэ дураараа дургидаг нөхөд чинь л энэ оройд нь гарч аваад энэ намын жагсаалтын ард нуугдаж ард түмнээрээ шүүгдэхгүй болно шүү дээ. Би тэр тухай санаа зовж байгаа юм. Олон сонгогдсон гээд цаашдаа бол намын жагсаалтад багтах боломж жишээлбэл мань бидэнд гарах байх л даа. Гэхдээ би тэрийг хүсэхгүй байна. Олон түмнээрээ шүүгдсэний буруу гэж ерөөсөө байхгүй. Тэр нэр байна, 2024 оноос эхэлнэ. Худлаа, худлаа. Тийм учраас би.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулсны дараа нэг минут тодруулна. Дэгээрээ.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн 5 дугаар хорооны иргэд, сонгогчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

С.Бямбацогт гишүүн асуултад хариулна. С.Бямбацогт гишүүн сайн тайлбарлаж өгөөрэй. Хүмүүс чинь ойлгохгүй. Одоо нам дугуйлна энэ тэр гээд өөр юм яриад байна шүү.

С.Бямбацогт: Нэгдүгээрт нь, тэр дур зоргын шинжтэй байж болохгүй, дараалал өөрчилж байна гэсэн асуудал ярьж байна.

Тэгэхээр энэ дээр түрүүн би О.Баасанхүү гишүүний асуултад хариулсан. Журмын тухай хуулийн, Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлэг хийгдэж байгаа. Үүний дараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эцсийн хэлэлцүүлэг буюу гурав дахь хэлэлцүүлэг хийгдэнэ. Үндсэн хуулийн эцсийн хэлэлцүүлгээр дэмжигдсэн болон дэмжигдээгүй асуудлуудыг бид нар журмын тухай хуульдаа, журмын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг хийх үед суулгах бүрэн бололцоотой байгаа.

Тийм болохоор бас дараалал дээр одоо манай сая хуралдаан даргалагч тайлбарласан. Тодорхой хугацаагаар тэр нам дугуйлдаг болох гээд байна. 2024 он гэж орж байгаа, 2020 он болох гээд байна гэсэн хардлага дагуулаад үүнээсээ болоод Үндсэн хуульд оруулах тодорхой нэмэлт, өөрчлөлтүүд уначих гээд байна гэсэн учраас дарааллыг бас өөрчиллөө гэдгээ тайлбарласан. Тийм болохоор энэ дараалал өөрчилж байгаа асуудал дээр бол ямар нэгэн зөрчил бол байхгүй. Энэ бол үндсэндээ Үндсэн хуулийнхаа бас журмын тухай хуульд нийцэж байгаа гэдгийг хэлье.

Хоёрдугаарт нь, аль нэгэн намын одоо ашиг сонирхол байж болохгүй гэж. Энэ дээр яах вэ Ардчилсан намын зөвлөлөөс Монгол Улсын Ерөнхийлөгчийн парламентаас сонгодог больё. Ерөнхий сайд нь кабинетаа өөрөө бүрдүүлдэг байя. Дээрээс нь одоо энэ сонгуулийн холимог тогтолцоо гэсэн одоо 3 саналыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгая. Нэгэнтээ гурав дахь хэлэлцүүлэг хийж, ард нийтийн санал асуулга явахаа больсон.

Гурав дахь хэлэлцүүлэг хийх гэж байгаа юм чинь зөвшилцье. Олонх одоо 65 суудалтай Ардын нам одоо дангаараа хүч түрж Үндсэн хуулийн битгий батлаач ээ, зөвшилцөөч ээ, харилцан ойлголцооч. Энэ улс орны эрх ашгаа бодооч гэдэг санал тавьсан. Энэ дээр Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн даргаар ахлуулсан Зөвшилцлийн ажлын хэсэг гарч ажилласан. Энэ ажиллаад одоо хэд хэдэн удаа уулзалт хийгээд эцэстээ Ардчилсан намын зөвлөлөөс гарч байгаа хоёр саналыг нь авъя гэсэн.

Энэний нэг санал нь энэ холимог тогтолцоогоор сонгууль явуулах асуудал байж байгаа. Холимог тогтолцоогоор сонгууль явуулахдаа энэ дээр орж байгаа заалт нь та бүхэн мэдэж байгаа байх. Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө. Энэ нөгөө 2012 оных шиг нам дугуйлна гэсэн үг биш. Нам дугуйлна гэсэн үг биш. Намын жагсаалтад орсон нэг нэр дэвшигчийн төлөө сонгогч саналаа өгнө гэдгийг Үндсэн хуульдаа суулгаж өгье гэж байгаа юм.

Энийг Үндсэн хуульдаа ингэж суулгаж өгөхгүй бол одоо Үндсэн хуульд ерөнхий суучихаар сонгуулийн тогтолцоог эрх барьж байгаа нам болгон өөр өөрсдийн хүсэл сонирхлоороо өөрчилдөг, өөртөө ашигтай байдлаар эргүүлдэг. Нам ч дугуйлж болдог. Хүн ч дугуйлж болдог. Том ч тойрог байж болдог, жижиг тойрог ч байж болдог.

Ийм болгох гээд байдаг учраас Үндсэн хуульдаа маш тодорхой нам хэзээ ч дугуйлахгүй зөвхөн одоо хүн дугуйлдаг байя гэдэг томъёоллоор ингэж суулгаж өгье гэдэг дээр зөвшилцөж, ойлголцож явж байгаа. Энд намын жагсаалтын ард нуугдсан зүйл байхгүй. Ардчилсан намын зөвлөлөө гарсан саналыг бид нар ийм томъёоллоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтдөө тусгаж оруулахаар бэлдсэн байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Ц.Даваасүрэн гишүүн тодруулна. Эрхэм гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнд 1 минут.

Ц.Даваасүрэн: Тэгвэл заавал холимог тогтолцоо энэ тэр гээд оруулаад байх ямар шаардлага байх вэ дээ. Гэхдээ энэ олон түмэн нэг их хууртахаа больчихсон доо л гэж би ингэж хараад байгаа юм. Одоогийн сонгуулийн хуулиар ч гэсэн улс нэг тойрог болгоод, нэр жасгаад хийвэл болно шүү дээ. Одоогийнх дээр байгаа. Заавал холимог гэж оруулж яах гээд байгаа юм бэ гэдэг асуудал.

Тэр цэц, цаг хугацаа хоёр шүүнэ гэж би ингэж бодож байгаа юм. Ерөнхийлөгч нэгдүгээр хэлэлцүүлэг дээр л үг хэлэх эрхтэй юм. Өөр юм байхгүй юм. Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр санал оруулж ирээд, хориг тавьж шинэ санал оруулж ирээд. Нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг дээр хэлэлцэгдээгүй саналыг бид нар өнөөдөр яриад байна шүү дээ. Энэ чинь өөрөө болохгүй юмаа гэдгийг би хэлээд байгаа юм.

Тийм учраас би протоколд энэ бүгд байг гэж ингэж бодож байна. Шууд нэг, хоёрдугаар хэлэлцүүлэггүйгээр саналууд оруулж ирж байна шүү дээ. Энэ чинь өөрөө байж болохгүй зүйл. Олон нийтээрээ хэлэлцүүлэхгүй байхыг би

Ерөнхийлөгч болиулсан юм байна гэж түрүүний тайлбараас сонссон. Ард түмэн Үндсэн хуультай хэлэлцэх эрхгүй байхыг .../Үг тасрав/

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн асуултад хариулна. Тодруулж, 1 минут.

С.Бямбацогт: Ард нийтийн санал асуулга явуулах Улсын Их Хурлын тогтоолд Ерөнхийлөгч хориг тавьсан, хориг тавьсантай холбоотойгоор бид нар хоригийг хүлээж аваад гурав дахь хэлэлцүүлгийг хийж байгаа.

Гурав дахь хэлэлцүүлэг хийж байх явцад Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тодорхой санал гаргаад тэр нь дэмжлэг авах юм бол зарчмын зөрүүтэй томъёоллоор санал хурааж болно гэсэн дэгийн хуультай. Энэ хуулийн дагуу бид нар сонгуулийн тогтолцоотой холбоотой болон Ерөнхий сайд нь кабинетаа бүрдүүлдэг байх гэсэн үндсэн хоёр саналыг Байнгын хороон дээр зарчмын зөрүүтэй санал болгож хураагдсан.

Бусад хураагдах саналууд бол ард нийтийн санал асуулгын үед хураагдсан байсан ийм саналууд байгаа. Журмын тухай хууль болон дэгийн тухай хуулийн та бас сайн үзээрэй. Тэр нь дээр маш тодорхой хуулийн зохицуулалтыг заагаад өгчихсөн байгаа. Би танд тухайлах юм бол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁷⁶. Энд одоо 21-ээс 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг одоо хэлэлцэнэ гээд заачихсан байж байгаа.

Г.Занданшатар: Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууна.

Х.Баделхан: Баярлалаа. Бид одоо мөрдөж байгаа Үндсэн хуулиар Улсын Их Хурлын гишүүн ард түмний төлөөлөл мөн. Тэгээд Улсын Их Хурлын гишүүдийг шууд сонгоно гэж.

Үндсэн хуулийн энэ заалт хөндөгдөөгүй хэвээрээ байгаа гэж ойлголоо. Тэгэхээр ард түмний төлөөлөл мөн гэж. Манай аймгаас жилийн жилд 3 гишүүн сонгогдоод ирсэн. Та нөхөд мэдэж байгаа. Бүр 1924 онд 72 гишүүн анхны Үндсэн хуулиа баталж байхад 3 төлөөлөл сууж байсан байна. Ганц удаа 2 гишүүн болсон байна. Тэр нь хэзээ бэ гэвэл 2012 онд холимог тогтолцоогоор явахад 2 гишүүн сонгогдсон. Нэг ёсондоо манай аймгийн ард иргэдийн үндэсний цөөнхийн сонгох эрх зөрчигдсэн гэж бид нар ингэж үзэж байгаа.

Тийм учраас энэ удаагийн Үндсэн хуулиар тэр сонгуулийн холимог тогтолцоог дэмжихгүй байгаа бид. Манай аймгаас сонгогдсон 3 гишүүн, 3-уулаа дэмжихгүй байгаа. Энийг ард иргэд бидэнд хэлж байгаа. Үеийн үед 3 төлөөлөл бол Их Хуралд суудаг байсан. Хэрэв сонгуулийн холимог тогтолцоо байвал сонгогчдын эрх зөрчигдөнө. Тийм учраас энийг одоо зохицуулах ямар арга байна. Энэ журмын хуулиар зохицуулах арга байна уу? Өөрөөр хуулиар одоо энийг баталгаажуулж өгөх арга байна уу гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Д.Лүндээжанцан гишүүн асуултад хариулна. Д.Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр бид Үндсэн хууль баталсан цагаас, тэрний өмнө 1990 онд одоо бас Ардын Их Хурал Үндсэн хууль баталсан, Ардын Их Хурлыг байгуулсан. Бүх үе шатанд энэ Баян-Өлгий аймгийн төлөөллийг оролцуулах энэ чигийг сонгуулийнхаа хуулиудад оруулж ирсэн.

Энэ холимог тогтолцоо гэж яриад байгаа олонхийн болон хувь тэнцүүлэх тогтолцоогоор сонгууль явуулахад энэ Баян-Өлгий аймгийн төлөөлөл, мөн түүнчлэн казак иргэдийн төлөөлөл багасна гэдэг ийм зүйл байхгүй.

Сая би Д.Мурат гишүүнтэй нэлээн удаан ярилцлаа. Х.Баделхан гишүүн үг хэлэх гээд хараахан уулзалдаж чадсангүй. Энийг би оруулж байгаа юм биш шүү дээ. Зөвшилцлийн ажлын хэсгээс л оруулж ирж байгаа юм.

Баян-Өлгий аймагт жишээ нь 2024 онд Баян-Өлгий аймаг хоёр мандаттай тойргоор ороод ирнэ. Дээр нь Улсын хэмжээний тойрогт нэр дэвшигчид намуудаас орж ирнэ. Ингэсэн тохиолдолд Улсын хэмжээнд байгаа манай Баян-Өлгий аймгийн уугуул иргэд оролцоход дор хаяхад 3-аас 4 гишүүн тодрох ийм магадлал тооцоогоор байгаад байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ дээр одоо манай улсын хувьд эд хөрөнгө, нас хүйс, гарал угсаагаар ялгаварлан гадуурхахгүй гээд нөгөө Үндсэн хуулийн манай сонгуулийн суурь зарчим байна шүү дээ. Энэнтэй огт харшлахгүй. Харин энийг улам баяжуулж байгаа юмаа гэж би ойлгож байна.

Холимог тогтолцооны яг энэ асуудлыг бид 62 гишүүний төсөлд орж ирээгүй. Гэхдээ хандлага нь сонгогчийн санал хаягддаггүй. Харин ганцхан юманд дургүйцээд энэ хүмүүс яриад байдаг нь намын нэрийн дор хаалттай жагсаалтаар олон түмэнд тааламжгүй, хүсээгүй хүмүүс намын нэрээр дулдуйдаж орж ирээд байна гэдэг шүүмжлэл их байгаа учраас харин энийг бид нээлттэй жагсаалт болгож тойрогт болон жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэдгийг энд оруулж өгч байгаа гэдгийг хэлмээр байна.

Г.Занданшатар: Х.Баделхан гишүүн нэг минут тодруулна.

Х.Баделхан: Д.Лүндээжанцан гишүүн Улсын хэмжээнд одоо дэмжихэд сонгогдох магадлалтай гэж ярьж байна шүү дээ. Магадлалтай гэж. Би магадлалын асуудал биш ээ, би баталгаатай асуудал ярих гээд. Яагаад гэвэл бид Үндсэн хууль өөрчилж байгаа. Үндсэн хуулиа одоо өөрчлөхөд ерөөсөө тэр Баян-Өлгий аймгийн төлөөлөл 3 байхыг баталгаажуулж өгөх арга байна уу гэдгээ би асуугаад байгаа л даа.

Яагаад гэвэл дараа нь энэ чинь бид нар одоо яваад өгнө. Дараа нь залуучууд гараад ирнэ. Тэгээд асууна шүү дээ, энийг чинь. Тухайн үед энэ гишүүд юу хэлсэн юм бэ? Тийм учраас энэ асуудлаа би баталгаажуулж авмаар байна. Энэ бол зөвхөн миний санал биш. Манай 3 гишүүний санал гэж ойлгох хэрэгтэй.

Г.Занданшатар: Д.Лүндээжанцан гишүүн тодруулж хариулна.

Д.Лүндээжанцан: Сонгуулиас нэг жилийн өмнө сонгуулийн хууль батлахыг хориглоно гээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд байгаа.

Тэгэхээр 2022, 2023 он гэхэд ямар ч байсан нэг жилийн өмнө батлах ёстой. 2022 онд сонгуулийн хууль. Энэ үед Баян-Өлгий аймаг 3 мандатаа багасгахгүй байх энэ нөхцөл, бололцоог сонгуулийн хуульд нь зориуд зааж өгөх ёстой юм. Энэ бол протоколд үлдэх ёстой гэж би бодож байна.

Өөрөөр хэлбэл бид Сонгуулийн хуулийг удаа дараа ярьж өөрчилж, янз бүрээр үзэж, одоо хэдэн метр даавууг өрөөлдөөд бариад дээл хийх гэж байгаа юм шиг янз бүрээр нь үзсээр яваад ирлээ. Энэ хугацаанд. Энэ үедээ туж Баян-Өлгий аймгийн төлөөлөл 3-аас доошгүй байна гэдгийг ямагт баримталж ирсэн шүү. Энэ зарчим одоо байна шүү дээ ямар ч тогтолцоогоор байсан. Нөгөө Сонгуулийн хуулийг хэлэлцэхэд үед нэг .../минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая.

Би хоёрхон товчхон зүйл дээр тайлбар авмаар байгаа юм. Нэг дэх асуудал одоогийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа Үндсэн хуульд Хорин нэгдүгээр зүйлийн 2 дээр иргэд Улсын Их Хурлын гишүүдийг шууд сонгоно гэсэн ийм хуулийн заалт хэвээрээ байгаа. Иргэд сонгогчидтой уулзаж ярьж байхад ч гэсэн өөрсдийгөө төрд төлөөлөх төлөөллөө дуу хоолойг нь сонсож байж, нүүр царайг нь харж байж, бүр нэг барьж үзэж байж дээлийнхээ өнгийн сонгох гэж байгаа юм шиг эмхэрч үзэж байж сонгох тийм хэрэгцээ шаардлага байна гэж байнга л ярьдаг л даа. Би ч бас энэ зарчмыг нь зөв гэж боддог хүний л нэг.

Тэгэхээр одоогийн энэ журмын тухай хуулиар сонгуулийн тогтолцоог холимог болгоно. 2024 оны ээлжит сонгуулиас эхлээд олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гээд ингээд ороод ирж байна.

Тэгэхээр энэ журмын тухай хуульд орж байгаа энэ заалт маань Үндсэн хуулийн одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь тэр шууд сонгох эрх гэсэн энэ заалттай зөрчилдөхгүй юу? Манай ажлын хэсэг, Байнгын хороо юу гэж үзэж байгаа вэ? Энэ дээр нэг маш одоо тодорхой тайлбар өгөөч ээ.

Хоёр дахь асуудал нь, гишүүдийн дунд ч тийм эргэлзээ байгаа байх. Миний хувьд ч бас нэг эргэлзээ байгаа юм. Энэ Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хууль маань ямар хүчин чадалтай байх юм бэ? Нэмэлт журмын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал маань ердийн олонхоор явдаг байх юм уу? Үндсэн хуулийн, энэ дотор нь бичсэн байна. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй байна гээд.

Журмын тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал яригдвал Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудалтай нэгэн адил үзээд босго нь 57-оос дээш босготой байх юм уу? Эсвэл журмын тухай хуульд өөрчлөлт

оруулах асуудал яригдаад өөрчлөлт оруулбал ердийн олонхоороо бас журмын тухай хуульд өөрчлөлт оруулаад явах боломж нь байгаа юм уу, хаагдах юм уу гэдэг асуудлыг бас нэг эргэлзээг маш сайн тодорхой болгож өгөөч.

Хэрвээ шаардлагатай бол энэ журмын тухай хуульдаа өөрчлөлт оруулах асуудлыг шийдэхдээ Үндсэн хуулийн нэгэн адил авч үзэж 57-оос гишүүний босготойгоор нэмэлт, өөрчлөлт оруулна гэдэг юм уу ийм чиглэлээр тодорхой болгож өгөөч. Ингэхгүйгээс болоод бас гишүүдийн дунд дараагаар нь ердийн олонхоороо энэ журмын тухай хуульд өөрчлөлт оруулна гээд ямар нэгэн асуудлууд өөрчлөгдөөд нэмэгдээд, хасагдаад байх ийм нөхцөл боломж нь байгаа юм биш үү гэсэн ийм болгоомжлолууд байгаа юм. Ийм хоёр асуудал дээр Ажлын хэсэг, Байнгын хороо маш тодорхой хариулт өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Эхнийх дээр Д.Лүндээжанцан дарга асуултад хариулна.

Д.Лүндээжанцан: Энэ холимог тогтолцоо л гэж яриад байгаа юм. Холимог тогтолцоо өөрөө олон хэлбэртэй. Энэ сонгогчид эмэрч үзэж байж сонгомоор байна гэж. Энэ хүн ямар хүн бэ гэдгийг. Энийг бидний энэ нэмэлт, өөрчлөлтөөрөө алдагдуулаагүй оруулж ирж байгаа. Тэр тойрогт өрсөлдөх тэр тогтолцоо хэвээрээ байна. Дээр нь Улсын хэмжээнд юм уу, ямар хэмжээнд байдаг юм. Нэрсийн жагсаалтаар өрсөлдөхдөө барьж үзэж байгаад эхлээд намуудыг нь, аль намын хэнийг сонгох вэ гэж. Тэгээд одоо хэдэн нам байдаг юм. Нэг намаас хорин хэдэн хүн нэрсийн жагсаалтад дэвшсэн байлаа гэхэд 7, 8 нам, 10 нам дэвшлээ гэхэд тэр одоо 200 гаруй хүнийг үзэж байгаад алийг нь би дэмжиж байгаа юм бэ гэдгээ хүний төлөө санал өгч дэмжинэ. Яг л адилхан барьж үзэж дэмжиж байгаа юм.

Улсын Их Хурлын манай одоогийн Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн шууд сонгоно гэдэг байна шүү дээ, яг ийм адилхан Үндсэн хуульдаа байгаа заалттай орнууд олон байна. Жагсаалт нь гарчихсан байна. Эд нар тэгсэн мөртлөө бүр намын төлөө санал өгөөд, тэр намын нэрсийн жагсаалтаараа ороод ингээд хаалттай жагсаалтаар яваад сонгож байгаагаа хүртэл шууд гэж ойлгодог.

Бидний хувьд тэгж ойлгохгүй байгаа. Бид юу гэхээр хүний төлөө өгснийг л одоо шууд гэж ойлгож байгаа. Ийм учраас тэр ямар ч хоёр янзын тогтолцоо байлаа. Тэр нь бол нэр дэвшигчийн төлөө сонгогч саналаа өгнө гэдэг энэ зарчмыг барьж байгаа юм. Харин тэр нэрсийн жагсаалтад байгаа хүний төлөө өгсөн саналууд нь намын санал болоод пропорцлогдоод аль намд хэдэн суудал ноогдох уу, тэрэнд орохдоо сонгогчдоос авсан саналын тоогоор эрэмбэлэгдэж орно гэсэн энэ зарчмыг оруулж байгаа учраас Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн зарчимтай харшлах ийм зүйл байхгүй.

Ер нь энэ холимог тогтолцоо гэдэгт манайхан ерөнхийдөө дурамжхан байдаг учраас энэ асуудал яригдаж байгаа болохоос биш харшлах шалтгаан бол байхгүй.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын эрхэм гишүүн Жаргалтулгын Эрдэнэбатын урилгаар Сэлэнгэ аймгийн Ерөө сумын тариаланчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт тариаланчдадаа эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

С.Бямбацогт гишүүн хоёр дахь асуултад хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 2 дээр Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын Сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ чөлөөтэй шууд сонгох эрхийн Үндсэн дээрээ саналаа нууцаар гаргаж 4 жилийн хугацаагаар сонгоно гээд заачихсан. Энэ заалттай ерөөсөө харшилж байгаа заалт ерөөсөө байхгүй.

2012 онд нам дугуйлдаг жагсаалт, холимог тогтолцоо орж ирсэн. Энэ бол бас жаахан шууд сонгохтой зөрчилдөж байна гэж үзэж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гарсан. Одоо орж ирж байгаа энэ холимог тогтолцоо бол 2012 оныхтой адилхан нам дугуйлдаг холимог тогтолцоо биш. Сонгуулийн тогтолцоо биш. Энэ улс нэг тойрог. Улсын хэмжээнд хүн дугуйлдаг. Нэр дэвшигч, намын жагсаалтаас хүнийг нь дугуйлна. Ийм тогтолцоо орж ирж байгаа юм. Энийг бас манай гишүүд ялгаж ойлгомоор байгаа юм. Тэгэхгүй холимог л гэхээр нөгөө намын жагсаалтын ард л нөгөө болохгүй, бүтэхгүй нөхөд нь нуугдах гээд байна. Намын даргатайгаа хуйвалдаж байгаад мөнгө, төгрөгөөр одоо бас жагсаалтад орох гээд байна гэдэг ойлголт байхгүй. Энэ намын жагсаалтад орсон нэр дэвшигчийг ард түмэн өөрсдөө имэрч үзэж байгаад шууд дугуйлна. Нам огт дугуйлахгүй.

Өөрөөр хэлэх юм бол аймгийн хэмжээнд 76 тойргоос, аймаг аймгаас, аймаг дотроо дахиад тойрог. Жижиг тойрог. Ингээд эд нар чинь 76 тойргоос нэг жалга, довны депутатууд гараад ирдэг. Тэгээд дандаа нөгөө сумынхаа асуудал, тойргийнхоо асуудлыг байнга ярьдаг. Улс орны бодлогын асуудал ярьдаггүй. Оюу Толгойн асуудал гээд хааяа нэг попорно. Улс орны өрийн асуудал гээд хааяа нэг попорно. Энэний оронд байнга улс орны эрх ашиг гэж юу юм бэ, улс орны тийм үү. Үндэсний аюулгүй байдал, энэ өр зээлийн асуудал гэдгийг байнга боддог, ярьдаг үүнд анхаардаг бас улс орныхоо эрх ашгийг боддог гишүүд хэрэгтэй байгаа юм.

Улсын наадамд барилддаг бөх, аймгийн наадамд барилддаг бөх хоёр чинь бас нэг боддог бодлого, эрэмбэ зиндаа нь өөр шүү дээ. Түүнтэй адилхан уг нь улсын хэмжээний нэг тойргоос хүнийг дугуйлдаг ийм тогтолцоо бол оруулж ирж байгаа юм. Энэ бол Ардчилсан намын гаргасан санал. Гэхдээ энэ бас зөв юм байна гэж бид нар үзэж байгаа. Бусдаар энэ намын жагсаалтын ард нуугдах гэж байгаа юм ерөөсөө байхгүй гэдгийг нэгдүгээрт нь хариулчихъя.

Хоёр дахь асуулт. Чуулганы тухай хуулийн дэгийн тухай хуульд заачихсан байгаа. Маш тодорхой. Мөн Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай заачихсан байгаа. Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль нь Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр гэж үзэж байгаа. Өөрөөр хэлэх юм

бол гуравны хоёрын саналаар энэ асуудал хэлэлцэгдээд явж байгаа. Байнгын хороон дээр ч өчигдөр Үндсэн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн санал хураалтууд гуравны хоёроос дээш санал хураагдсан. Одоо бас энэ босгоороо хураагдана. Ердийн хуультай адил дэг үйлчлэхгүй гэдгийг бас энд хэлье.

Г.Занданшатар: Загдхүүгийн Нарантуяа гишүүн асуулт асууна.

3.Нарантуяа: Яг одоо бид нар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуульд өөрчлөлт оруулах энэ саналын томъёоллыг хэлэлцэж байгаа.

Тэгэхээр гишүүдийг би энэ хоёр зүйлийг хольж хутгахгүй анхааралтай сонсоосой гэж хүсэж байна. Энэ томъёоллыг бид нар хэлэлцэж болохгүй байгаа хоёр үндсэн техникийн алдаа байна. Өргөн барьсан томъёололтой холбогдуулаад.

Нэгдүгээрт, би Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах гуравдугаар хэлэлцүүлгийн тухай ерөөсөө яриагүй байгаа. Энийг бид нар дараа нь ярина шүү дээ. Яагаад энэ шилжих журмын тухай хуульд өөрчлөлт оруулах томъёоллыг одоо ярьж болохгүй байгаа тухай тайлбарыг хэлэх гэж байгаа.

Нэгдүгээрт. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн Их Хурал өргөн барьчихсан одоо байгаа төслийн чинь Дөрөвдүгээр заалт дээр 2020 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө томилогдсон Улсын Дээд шүүхийн шүүгчийн бүрэн эрхийн хугацаа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 12 жил байна гээд одоо энэ төсөл дээр чинь байж байгаа.

Энэ төсөл дээр, энэ төслийн оронд нь сонгуулийн тогтолцоог, сонгуулийн 2024 оны ээлжит сонгуулийн жилээс эхэлж дагаж мөрдөнө гэдэг энэ юмаа оруулах гээд байгаа юм уу? Энэ заалтаа эсвэл байхгүй болгочоод оронд нь Дөрөвдүгээр зүйл нэмэх гээд байгаа юм уу? Энэ чинь тодорхойгүй байна шүү дээ. Техникийн хувьд энэ маш том алдаа шүү.

Тамгын газрынхан, Э.Түвшинжаргал дарга, Л.Өлзийсайхан дарга ийм техникийн алдаатай зөвлөмжийг техник мэдэхгүй, хуулийн практик мэдэхгүй энэ Их Хурлын дарга, С.Бямбацогт дарга нартаа зөвлөөд энэ хуулийг одоо хэлэлцүүлэх гээд ингээд зүтгүүлээд байх шаардлага байхгүй.

Хоёрдугаар том алдаа нь юу вэ гэхээр, одоо бид нар Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг гуравдугаар хэлэлцүүлгээрээ батлаагүй байж хугацаа тавих нь Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн Хорин нэгдүгээр зүйлийн Дөрөв дэх зүйлээ тодорхойгүй байдалд оруулах гэж байна. Бид нар холимог системийг хэрвээ батлахгүй байвал одоо энэ хуульд байж байгаа Дөрөвдүгээр зүйд Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэдэг юм чинь 2024 оноос мөрдөхөөр байх юм уу? Тэгээд хуульгүйгээр 2020 онд сонгуульд орох юм уу?

Ийм эрсдэлтэй нөхцөл байдлыг үгүйсгэхээр томьёолол хийчхээд энийгээ одоо хэлэлцүүлнэ гэж улайрч дайраад байх хэрэггүй. Эхлээд Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн Гуравдугаар хэлэлцүүлгийг хийгээд баталчих. Тамгын газрынхан энэ алдаагаа засаад зөв томьёолол оруулж ирж байгаад хэрвээ тэр холимог тогтолцооны санал чинь дэмжигдчихвэл энэ юмаа оруул ир гэдэг яах аргагүй цагаан дээр хараар бичсэн хуулийн техникийн зөрчил байгааг хэлж өгье.

Г.Занданшатар: Э.Түвшинжаргал. Улсын Их Хурлын Тамгын газраас хариуг өгнө. Анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлгээр засдаг дэгээ мэдэхгүй байна.

Э.Түвшинжаргал: З.Нарантуяа гишүүний асуултад хариулъя.

Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁷ гэсэн зүйлийг сая 10 сарын 11-ний өдөр Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбоотойгоор нэмэлт, өөрчлөлт орсон.

Энүүгээр нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулах журмыг дэгийн хуулиар зохицуулж өгсөн байгаа. Дэгийн хуулийн 24⁷6-д Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуулийн 21-ээс 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно гэж заасан.

Энэ хуулийн 21-ээс 24 нь анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг, Байнгын хороо, Чуулган гэсэн дөрвөн хэлэлцүүлгийн шатыг бас хуульчилж өгсөн. Тэгэхээр өнөөдөр дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль бол зөвхөн анхны хэлэлцүүлэг нь хийгдэж байгаа. Зарчмын зөрүүтэй санал гарсан төслийг заавал эцсийн хэлэлцүүлгээр батлах дэгийн хуулийн зохицуулалттай юм.

Г.Занданшатар: З.Нарантуяа гишүүн нэг минут тодруулна.

З.Нарантуяа: Чиний наад уншаад байгаа дэгийн хуулийн заалтыг чинь би маш сайн мэдэж байна. Гэхдээ чи маш гаргаж боломгүй хуульчийн хувьд алдаа гаргачихсан байна шүү дээ.

Чи одоо өргөн баригдсан байгаа Дөрөвдүгээр зүйлийнхээ энэ заалтыг яах гэж байгаа юм. Чиний томьёолол чинь буруу байгаа байхгүй юу. Одоо чи шүүгчийг 12 жил байна гэдэг энэ юм дээр нэмж энэ сонгуулийн холимог тогтолцооны Дөрөвдүгээр заалтаа араас нь бичих гээд байгаа юм уу? Энийгээ хүчингүй болгочоод оронд нь оруулах гээд байгаа юм уу? Тэр томьёолол чинь чиний энэ дотор алга байна шүү дээ. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, миний хэлсэн чи энэ томьёоллоор одоо санал хураалгачхаад холимог тогтолцоог хэрвээ юмыг яаж мэдэхэд гуравдугаар хэлэлцүүлгийн үед гишүүд унагаачихвал чи одоо байж байгаа Үндсэн хуулийн Дөрөвдүгээр заалтыг 2024 оноос мөрдөх болгох гээд байна шүү дээ. Чи ийм алдаа гаргачихсанаа мэдэхгүй худлаа тайлбар хэлээд байх юм.

Г.Занданшатар: Эцсийн хэлэлцүүлэг дээр хасаад хаячихна.

3.Нарантуяа: Тамгын газрынхан битгий ингэж улс төрийн өнгө аяс харж дагаж бай. Та нар ажлаа хийх ёстой байхгүй юу.

Г.Занданшатар: Буруу ойлгоод байна.

3.Нарантуяа: Ажлаа хий. Би тайлбар авахгүй чамаас.

Г.Занданшатар: Э.Түвшинжаргал тайлбар өгье. Нэмж тодруулж асуусан.

Э.Түвшинжаргал: Гишүүн ээ, энэ дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль нь тань дээр саналын томъёолол нь гүйцэд очоогүй байгаа юм байна. Бид нар энийг нөхөөд тарааж байна.

Яг саяны тэр нөгөө шүүгчтэй холбоотойгоор Хоёрдугаар зүйл, Гуравдугаар зүйл, Дөрөвдүгээр зүйл, Тавдугаар зүйл гэсэн зүйлүүд Үндсэн хуулийн хоёр дахь хэлэлцүүлгээр хасагдсан учраас журмын хуулиас энэ заалтууд бүхэлдээ хасагдаж байгаа.

Тэгээд энэ нийтдээ зургаан хасагдах санал Үндсэн хуулийн журмын хуулийн Байнгын хорооны эхний хэлэлцүүлгээр дэмжигдчихсэн юм. Энэ саналын томъёоллыг одоо Та бүхэнд дахиад тарааж байгаа. Зарим нэг гишүүдэд сая дутуу тараагдсан байна.

Сая Байнгын хорооны санал, дүгнэлт дээр С.Бямбацогт даргын уншсан дээр энэ ямар үндэслэлтэй, ямар заалтууд Үндсэн хуулийн хоёр дахь хэлэлцүүлгээр хасагдсан. Түүнтэй холбоотой бүх юуг бол дэлгэрэнгүй санал, дүгнэлтийг уншиж танилцуулсан.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Батсүхийн Наранхүүгийн урилгаар Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын сургуулийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе, гишүүдийнхээ өмнөөс. Гэвч Б.Наранхүү гишүүн маань хаана байна аа? Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн асуулт асууна.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ хуулийн дараалал болон процедурын алдаа яах аргагүй гарчихсан энэ дээр. Бид нар аливаа асуудал дээр бие биедээ итгэлцэлтэй, зөв горимоор энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хэлэлцэгдэхгүй бол дараа нь олон сөрөг үр дагаврыг дагуулна гэдгийг би хэлээд байгаа юм.

Энэ бол алдаа шүү. Магадгүй эрх баригчид дотроо бас энэ үл ойлголцлоосоо болоод ерөөсөө эхлээд энэ оноо шийдэж байж дараа нь тэр холимог тогтолцоог шийдье гэсэн маягтай оруулж ирсэн байж болзошгүй. Тэгэхдээ энэ дээр намын эрх ашгийн тухай яригдаж болохгүй л дээ. Маш буруу инцидент тогтож байгаа юм.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь өөрөө эцсийн шийдлээр батлагдаагүй байхад дагаж мөрдөх журам гэдэг өөрөө нэр томьёо нь ойлгомжтой шүү дээ. Батлагдаагүй хуулийг өнөөдөр хэлэлцэж дуусаагүй байхад дагаж мөрдөх журам ярилцана гэдэг нь өөрөө логикийн хувьд маш буруу зүйл байхгүй юу. Тэгээд нэг үнэмлэхүй олонхоороо түрээд ингэж давхиж оруулж ирээд байх юм. Бүр ойлгомжтой хуулийн зөрчил шүү дээ энэ.

Хэрвээ нэмэлт, өөрчлөлт батлагдаад цаашаа асуудал үүсээд, маргаан үүсэх юм бол энэ цэц дээр асуудал үүсвэл яах юм. Тэгээд бидний нэмэлт, өөрчлөлт хэлэлцсэний ач холбогдол нь юундаа байгаа юм. Тэгээд урд урьдын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн юмнуудыг харахаар хэрэгжих хугацааг дагаж мөрдөх журмын хуулиар биш Үндсэн хуульд нь хийсэн байдаг юм байна лээ. Тэгвэл бүгдээрээ энийгээ Үндсэн хуульд нь л хийчихье л дээ. Маргаангүйгээр нь. Тэгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэг рүү орохдоо энэ холимог тогтолцоотой холбоотой зүйл, заалт дээр хэрэгжих хугацааг нь дор нь тавьчхаж болно шүү дээ.

Ер нь өөрөө энэ шилжих журам чинь гол процедурыг заадаг болохоос биш хэрэгжих хугацааг бол заадаггүй шүү дээ. Урд талын тэр анх Үндсэн хуулийн дагаж мөрдөх журмын хууль чинь дандаа аливаа нэг үйл ажиллагааны шилжих процедурыг л заасан болохоос биш хэрэгжих хугацаа гэж ерөөсөө огт заагдаагүй л юм байна лээ шүү дээ. Энэ бол яг хуулийнхаа дагуу явсан процесс мөн шүү дээ, тэр бол. Тэгтэл энийг яамны хоёр том зөрчил рүү оруулж ирж байгаа байхгүй юу.

Журмын тухай хуульд хэрэгжих хугацаанууд заагаад. Заах заахдаа энэ хэрэгжих хугацааг хууль батлагдаагүй байхад, эцэслэн батлагдаагүй байхад энийг батлагдах мэтээр төсөөлж энийг хийж болохгүй шүү дээ. Энэ чинь хуулийн зөрчил шүү дээ.

Тэгэхээр би ийм санал оруулж байна. Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо эцсийн хэлэлцүүлэгт энэ журмаа хэлэлцэхдээ хуульд нийцүүлэх ажлыг хийхгүй бол болохгүй. Тэгэх юм бол одоо хэдүүлээ ярьж байгаад Төрийн байгуулалтын байнгын хороон дээр энэ холимог тогтоолцоо, одоо заалтын зүйл, заалт доор энэ заалт нь 2024 оны хэрэгжинэ гэдэг юм уу, 2020 оноос хэрэгжинэ гэдэг юм уу. 2020 он ч хэрэггүй байх л даа. Хууль батлагдвал тэр чигээр явчихна. Хэрвээ хугацаа хойшлоод 2024 онд гэж байгаа бол энийгээ хуульдаа зааж өгөх хэрэгтэй. Ингэж байж энэ өөрөө хуульд нийцнэ.

Би Их Хурлын даргыг энийг албан ёсоор анхааралдаа аваасай гэж би хүсэж байна. Авах ёстой зүйл шүү энэ. Хурлын дарга өөрөө энэ алдаанд оров оо. Хууль зөрчсөн алдаанд. Би энийг Тамгын газартай ярихгүй ээ. Би Их Хурлын даргатай ярина энэ асуудлыг. Дараа нь асуудал үүсэх юм бол таны асуудалтай ярина шүү.

Г.Занданшатар: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлэг дууссаны дараа гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн анхдугаар хэлэлцүүлгийг явуулж байна.

Гуравдугаар хэлэлцүүлэг хийгээд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараа эцсийн хэлэлцүүлэг хийгдэж энэ хууль чинь батлагдана. Эцсийн хэлэлцүүлэгтэй андуураад, зөрүүлж тайлбарлах хэрэггүй. Төсвийн хууль, бүх хуулиуд ч гэсэн хамт өргөн мэдүүлсэн хууль дагаж мөрдөх журмын тухай хуультай хамт хэлэлцээд явдаг. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг хэлэлцэж байна л даа. Тэгээд энэ дээр хэд хэдэн зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгах юм байна.

Би нэг асуух гээд байгаа юм бол энэ 5-д төсөл засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль, тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг Улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ гэсэн зүйл, заалт нэмэх гээд ийм юм оруулаад ирж байна л даа.

Тэгтэл энэ улс орон даяар бүх аймгуудад байж байгаа хуучин сум байсан, сангийн аж ахуй байсан, үйлдвэр, уурхай төвлөрсөн ийм хот суурин байсан. Одоо тосгон, багийн статустай энэ газруудаа яах юм бэ? Зөвхөн Дархан, Эрдэнэтийнхээ асуудлыг шийдчихээд ингээд бусдыг нь хаячих юм уу? Энэ чинь өмнөх 2012-2016 онд би энэ Улсын Их Хурал дээр гишүүддээ ойлгуулаад энэ ханыг чинь цөм цохиод бүгдээрээ хамтдаа гарч чадахгүй. Нэг нүх гаргая. Тэр нь энэ уул уурхайн том төвлөрсөн хот Бор-Өндөрийг одоо сумын статус зэрэглэлтэй болгоё гээд ингээд.

Ер нь 1990 оноос хойш Цахираас, Цахир сум Архангай. Тийм ээ? Тэрний дараа бол Хэнтий аймгийн Бор-Өндөр хот, тосгон. Тэгэхдээ хот. Тэгсэн мөртлөө баг байсан. Энийг бол сум болгосон шүү дээ. Тэгээд одоо нөхөдтэй хэлсэн ярьсан. Энэ бүх аймгуудад байгаа. Тосонцэнгэл ч гэдэг юм уу. Өөр одоо Хархорин ч гэдэг юм уу. Өшөө ингээд явах юм бол зөндөө олон байна шүү дээ. Тэгээд энэ газруудыг зүгээр ингээд хаячих юм уу? Энэ дээр нэг хариулт өгөөч ээ гэж.

Хоёрдугаарт, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх амьдралд хэрэгцээ шаардлага байна гэж ингэж үзэж санаачлагч 62 гишүүний нэг болж оролцож байгаа ийм хүн би.

Тэгэхдээ энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн бүр тусгайлсан бүлэг болгоод заачихсан ард түмний санал асуулга явуулах. Гуравдугаар бүлэг тэр чигээрээ байгаа байх аа? Үүний дагуу ард түмний санал асуулгыг явуулах ёстой гэсэн ийм Гуравдугаар бүлэг. Энэ журмын дагуу ард түмний санал асуулга явуулна гэсэн ийм байр суурийг би энэ хаваржингаа, зунжингаа, намаржингаа тавьсан хүн.

Тэгээд харин энэ Ардчилсан намын зөвлөл, бусад Улсын Их Хурлын гишүүд дэмжээд ингээд ард нийтийн санал асуулгыг явуулъя. Гуравдугаар хэлэлцүүлгийн өмнө явуулъя гэсэн. Гэтэл одоо энэ маань ингээд таг

болчихлоо. Тэгээд гуравдугаар хэлэлцүүлэг дээрээ хэлэлцүүлнэ гээд ингээд яриад байдаг. Ийм асуудал байна.

Тэгэхээр энэ дээр ямар тайлбар хариулт өгөх вэ? Ингээд цаг нь багтахгүй юм. Би дараа нь нэг сунгаж асууя даа.

Г.Занданшатар: Д.Лүндээжанцан дарга асуултад хариулна. Дараа нь тодруулж С.Бямбацогт дарга.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр манай энэ нэмэлт, өөрчлөлтийн төсөлд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот. Одоо бид найруулгаар түүнчлэн гэж үг нэмэх гэж байна. Түүнчлэн тосгоны өөрийн удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно. Хот тосгон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ гээд.

Тэгэхээр энд манай нэр бүхий 6 гишүүн санал гаргаад, тэр нь олонхын санал аваад Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан Засгийн газраас Улсын Их Хуралд оруулж ирж шийдвэрлүүл гэдэг заалтыг шилжих журмын хуульд оруулсан байна. Нэг удаа.

Одоо ингээд сонгууль болох гэж байна. Одоо сонгуулиас өмнө бүх улсын хэмжээний хот, тосгоныг шийдэж чадахгүй нь. Ийм учраас Нутгийн удирдлагын хуулийг одоо Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын хууль хоёрыг нэн даруй гаргах шаардлага байгаа учраас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр.

Нутгийн удирдлагын хууль бэлэн болсон гэсэн. Тийм үү? Ямар ч байсан эхний ээлжид бэлэн болчихоод байна. Төсөл нь. Тэгээд энийг өргөн барих асуудал яригдана.

Гэхдээ энэ заалтууд цөм 5 сарын 25-наас хойш, нөгөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт үйлчилж эхэлснээс хойш хүчин төгөлдөр болох юм. Ийм учраас. Дээр нь энэ өөрчлөлт оруулах хуулиудын жагсаалтыг Улсын Их Хурал батална гэж байгаа юм. Тэр нь дээр Б.Бат-Эрдэнэ гишүүний удаа, дараагийн яриад байгаа, Б.Бат-Эрдэнэ гишүүний удаа, дараагийн яриад энэ асуудлууд тэр жагсаалтад графикайн дагуу орно. Өөрөөр хэлбэл бусад хот, тосгоны эрх зүйн байдлын асуудлууд ингээд нэг нэгээрээ орж ирэх юм. Сонгуулиас өмнө арай амжихгүй байна гэж яригдсан гэдгийг хэлье.

Хоёрдугаарт. Тийм. 2020 оны. Тэр бол Нутгийн удирдлагын хуульд таны Улаанбаатар дахь 20, хөдөө дэх 10 гэрийн тогтолцоо буюу аравны тогтолцоо бол Нутгийн удирдлагын хуульд сууж өгнө гээд бүр чиглэл аваад гарсан. Ажлын хэсэг нь ажиллаж байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн ээ.

Хоёр дахь нь, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хоёрдугаар хэлэлцүүлэг хийсний дараа хоёр салаа зам үүснэ. Энэ бол Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн журмын хуульд байгаа. Таны ярьдаг Гуравдугаар бүлэг. Цөмөөрөө АНСА буюу ард нийтийн санал асуулгаар

батлуулах эсвэл гуравдугаар хэлэлцүүлэг хийж батлах гэсэн хоёр зам үлдсэн. Эхнийхээр нь яваад бүтэлгүйтээд тэгээд ер нь бүгдээрээ Улсын Их Хурлаар гуравдугаар хэлэлцүүлгээр хийж батлуулах нь зүйтэй гэж шийдвэр гараад, 80 дугаар тогтоол байх. Тэгээд 11 сарын 11-н хүртэл хугацаанд иргэдтэйгээ уулзаж зөвшилцөөний асуудлаар санал ав гэж тогтоол гараад, одоо ингээд гуравдугаар хэлэлцүүлгээр орж ирж. Эсвэл ард нийтийн санал асуулгаар батлах. Эсвэл Их Хурлаас өөрсдөө батлах ийм хоёр эрх нь аль аль нь Үндсэн хуульдаа ч байж байгаа, журмынхаа хуульд ч байж байгаа учраас нөгөө замаар нь явж байна. Тийм.

Г.Занданшатар: Б.Бат-Эрдэнэ гишүүн 1 минут тодруулна.

Б.Бат-Эрдэнэ: Би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тухай асуудал хэлэлцсэн цагаас эхлээд ард нийтийн санал асуулга, нөгөөх нь энэ Үндсэн хууль бол тусгаар тогтнолын тунхаг бичиг. Энэ нийгмийн эв зохицлын баримт бичиг байх ёстой. Бүгдээрээ санал нэгдэх ёстой. Энэ Ардчилсан намын зөвлөл, энэ улс төрийн намуудыг, иргэдийн санал оролцоог ханга гэдэг ийм л байр суурийг тавьж байсан.

Гэтэл өнөөдөр ч гэсэн жишээлэх юм бол бид нар та бүхэнд ирсэн байх. Энэ шаардлага ирсэн байж байна. Энэ ард нь Төрийн бус байгууллагууд ингээд ирчихсэн. Тэгээд энэ Ардчилсан намын зөвлөл маань яах гээд байна вэ, янз янзын шаардлага хэлээд л одоо. Та бүхэн маань тэр том зөвшилцлийн хүрээндээ жаахан юмнууд ярьсан юм байгаа биз дээ гэж.

Хоёрдугаарт нь, нэг хэлэх юм бол би 2012-2016 онд энэ намын жагсаалтаар намын нэрийн ар талд нуугддаг ийм юмыг боль оо гэсэн хатуу байр суурьтай байсан хүн. Одоо та нар энэ холимог яриад байгаа энэ зүйл чинь ямар учиртай юм бэ? Энийг одоо нэг.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Одоо бид нар журмын тухай хууль хэлэлцэж байгаа. Тэгээд яг журмын тухай хуулиасаа асуумаар байна. Тийм.

Журмын тухай хууль дээр заагдсан анхны хэлэлцүүлэг хийж байгаа. Анхны хэлэлцүүлэг хийчхээд бид нар дараа нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл үүний дараа хийгдэнэ. Энэ дээр холбогдох асуудлыг энэ дээр нь асуумаар байна гэж хэлье.

Г.Занданшатар: Т.Аюурсайхан гишүүн асуулт асууна. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн.

Т.Аюурсайхан: Ер нь нэмэлт, өөрчлөлтийнхөө төслийг хийчхээд, тэгээд журмын тухай хуулиа явуулсан нь зөв байсан юм уу гэдэг ийм л байр суурьтай байна.

Нэмэлт, өөрчлөлт дээр юу орж байгаагаа мэдэж байж, юуг нь батлагдаж байна гэдгээ мэдэж байж тэрийгээ хэзээнээс яаж хэрэгжүүлэх вэ гэдэг хугацаагаа тавих ёстой л доо.

Яах вэ, зүгээр нэг, хоёрдугаар хэлэлцүүлэг байгаа гэж, дараа нь бас хоёрдугаар хэлэлцүүлэг байгаа гэж яриад байгаа юм. Ер нь аливаа юмыг анхнаасаа ямар ч хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг эхний хэлэлцүүлгээсээ л эхлээд одоо батлагдах баримжаатай, үндэслэлтэй л явуулдаг биз дээ.

Тэгээд энэ чинь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 21.4 чинь одоо жишээлбэл пропорционал орно, орохгүй, батлагдана гэдгийг нь яаж мэдээд ингээд 2024 оноос эсвэл 2020 оноос гэж яриад байгаа юм.

За яах вэ, ингээд янз бүрийн юм болчихвол эцсийн хэлэлцүүлэг дээр засчихна гээд байгаа юм. Тэгээд эцсийн хэлэлцүүлэг дээрээ засах нь битгий хэл тэр пропорционал чинь байхгүй болчихвол энэ хоёр санал чинь бүхлээрээ л огт хэлэлцэх шаардлагагүй л болчихно шүү дээ. Тэгээд тэрийгээ ер нь зөв талаас нь хийж яагаад болдоггүй юм бэ?

21.4 пропорционал чинь хэрвээ дэмжигдэхгүй болчихвол энэ хоёрдугаар хэлэлцүүлэг дээр тэртэй тэргүй одоо ингээд хэрэлдээд уралцаад 2020 он уу, 2024 он уу гээд байгаа юм чинь байхгүй болчихно шүү дээ. Дахиад энэ чинь өөрчлөгдөнө шүү дээ. Тийм биз дээ. С.Бямбацогт дарга аа.

Тийм учраас энийгээ нэг цаг хугацааны ямар асуудал байгаа юм. Гуравдугаар хэлэлцүүлгээ хийж дуусаад л тэгээд ер нь энэ 21.4 чинь пропорционал орох уу, орохгүй юу тэрийгээ харж байгаад энийгээ хэлэлцэх үү, үгүй юу гэдгээ шийдэж ер нь яагаад болдоггүй юм. Надад тийм л асуулт байна.

Тэгээд мэдээж тэр 21.4 дээр ярих цаг нь хэлэлцэх тухайн үедээ асууж, тодруулах, гишүүд саналаа хэлэх тийм боломж нь гарах байх. Яг одоо энийг хэлэлцэж байгаа нь яах вэ, түрүүчийн горимын санал бас харамсалтай нь уначихсан л даа. Ээлж дарааллаараа энэ батлагдсан саналуудаа хэзээ хэрэгжүүлэх вэ гэдгийг л ярьж байгаа шүү дээ. Гэтэл батлагдаагүй саналыг хэзээ хэрэгжүүлэх үү гэдэг юм яваад байгаа байхгүй.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна. Төрийн байгуулалтын байнгын хороо.

С.Бямбацогт: Ер нь гишүүдийн ярьж байгаа агуулга, зарчмыг ойлгож байгаа.

Гэхдээ нөгөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу эцсийн хэлэлцүүлэг хийгдэж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн анхны хэлэлцүүлэг хийгдэж байгаа юм. Тийм болохоор одоо саяны хэлж байгаа тэр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээрээс өөрчлөгдсөн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуульдаа тусгах боломжтой юм уу, боломжгүй юм уу. Боломжгүй болчих юм бол та нар эхэлж хэлэлцээд байгаа чинь буруу юм биш үү гэсэн асуулт яриад байна л даа.

Хамгийн гол нь боломж нь эцсийн хэлэлцүүлэг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг үүний дараа хэлэлцэнэ. Энэний дараа дахиад бид нар

дагаж мөрдөх журмын тухай хуулийнхаа хоёр дахь хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг хийнэ. Энэ үедээ хэрвээ хөдлөх юм бол хөдөлснийг нь зохицуулаад өөрчлөх, эцсийн хэлэлцүүлэгт ийм боломж байгаа юм. Тийм болохоор эхэнд нь хэлэлцэж байгаа.

Эхэнд нь яагаад хэлэлцсэн бэ гэдэг дээр гишүүд маань бас Их Хурлын дарга хэлсэн шүү дээ өөрөө. Энэ холимог тогтолцоо гээд намын жагсаалтаар хүн сонгодог болох нь гэдэг буруу ойлголтоор, 2012 оны ойлголтоор энэ холимог тогтолцоо буюу улс нэг тойрог, хүн дугуйлдаг. Улсын хэмжээнд хүн дугуйлдаг энэ тогтолцоог унагах гээд байна. Тийм болохоор эхлээд энэ 2024 он гэдгээ шийдчихье. Түүний дараа холимог тогтолцооныхоо асуудлыг ярьж гэж гишүүд яриад байгаа учраас ингэж дарааллын өөрчилье гэж ярьсан. Д.Эрдэнэбат дарга бол журмын тухай хуулиа биш Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг эхэлж хэлэлцье гэсэн. Гишүүд маань эхлээд журмын тухай хуулиа хэлэлцье гээд горимын саналыг дэмжээгүй учраас одоо ингээд явж байгаа шүү дээ.

Тийм болохоор нэгэнт одоо ингээд явж байгаа процесс нэг их хууль зөрчсөн алдаа бол байхгүй. Уг нь бол зарчмын хувьд ярьж байгаа санал чинь бол зөв өө. Гэхдээ хууль зөрчсөн алдаа байхгүй. Эцсийн хэлэлцүүлэг дээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөс хөдөлгөөн орох юм бол журмын тухай хуулийнхаа эцсийн хэлэлцүүлэг дээр тэрийг дагуулаад засчих боломж нь нээлттэй байгаа.

Г.Занданшатар: Ж.Мөнхбат гишүүн алга байна. Л.Мөнхбаатар гишүүн алга байна. М.Оюунчимэг гишүүн алга байна. С.Эрдэнэ гишүүн алга байна. Цэндийн Мөнх-Оргил 1 минут.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би товчхон санал хэлье. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуульд дээр энэ Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судалж Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлэх заалт оруулж байгаа юм байна. Би энэ саналыг дэмжиж байгаа юм.

Гэхдээ энэний зэрэгцээ жишээ нь өнөөдөр Улаанбаатар хотын дагуу хот нэртэй. Тэгсэн мөртөө Улаанбаатар хотын дүүрэг болчихсон. Ингээд нэг талаас дүүрэг. Тэгсэн мөртлөө алслагдсан. Тэгээд иргэн тойрон байгаа Хэнтий, Төв аймгийнхаа сумдад эмнэлэг, боловсролын үйлчилгээг хүргэсэн. Ингээд жишээ нь Багануур хот шиг хотуудын асуудлыг энд дурдаж шийдэх хэрэгтэй байна. Тухайлбал, одоо Дархан, Эрдэнэт гэдгийн ард Налайх, Багануур хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судалж, оруулж ирэх нь зүйтэй байгаа юм.

Яагаад гэвэл Налайх, Багануур хоёр цаашаа өсөөд хөгжих нь, хүн ам нь олшрох нь ойлгомжтой. Гэхдээ Улаанбаатар хотын алслагдсан дүүрэг гэдгээр нь цаашид энэ хоёр том хотыг хөгжүүлж болохгүй. Биеийг нь даалгах хэрэгтэй байгаа юм. Хөрөнгө мөнгөнийх нь бололцоог нь шилжүүлж өгмөөр байгаа юм. Дархан, Эрдэнэт улсын зэрэглэлтэй хот болоод явж байгаатай адилхан Налайх, Багануураа тэр хэмжээнд нь аваачиж хөгжүүлэх нь бид нар энэ Улаанбаатар хотын ачааллыг бууруулах тэр Налайх, Багануурт амьдарч

байгаа иргэдийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд их чухал ач холбогдолтой юм.

Тийм учраас би одоо санал оруулж байна. Дархан, Эрдэнэт гэдгийн дараа Багануур, Налайхыг нэмж оруулах саналтай байна. Энийг хоёрдугаар хэлэлцүүлгээр, эцсийн хэлэлцүүлгээр нэмж оруулж, судалж өгөхийг хүсэж байна. Би бас ийм санал Байнгын хороон дээр оруулна. Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хороо энэ асуудлыг анхаарах чиглэлийг өгч байна. Судалж шийдвэрлэх.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Байнгын хорооноос асуулт асууж, хариулт авч дууслаа. Одоо санал хураалт явуулна. Байнгын хорооноос гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураана.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэмжсэн саналууд, ажлын хэсгээс зөвшилцөн оруулж ирсэн хоёр дахь хэлэлцүүлгээр шийдвэрлэгдсэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Нэг. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Энэ хооронд ажлын хэсгийн гишүүдийг дахин танилцуулж байя.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл боловсруулах ажлын дэд хэсгийн гишүүдийг танилцуулъя.

- Ц.Товуусүрэн Улсын Бага Хурлын гишүүн, Улсын Их Хурлын гишүүн асан, дэд ажлын хэсгийн ахлагч.
- Р.Хатанбаатар Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан, дэд ажлын хэсгийн ахлагч.
- Д.Ламжав Ардын Их Хурлын депутат, Улсын Бага Хурлын гишүүн асан.
- Н.Лувсанжав Монгол Улсын гавьяат хуульч, доктор, профессор, дэд ажлын хэсгийн ахлагч.

- О.Мөнхсайхан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн ухааны доктор, дэд ажлын хэсгийн ахлагч.
- А.Бямбажаргал Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн эрдэмтэн, нарийн бичгийн дарга, профессор, Хуульзүйн ухааны доктор.
- О.Машбат Үндсэн хууль судлаач, Аюулгүй байдал судлалын академийн захирал.

Гишүүд чуулганы танхимдаа цугларъя. Ө.Энхтүвшин сайд, Ц.Даваасүрэн сайд, Ёс зүйн хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Тэрбишдагва гишүүн, Ч.Хүрэлбаатар сайд, Б.Чойжилсүрэн гишүүн. Ө.Энхтүвшин дарга энд орж ирчихсэн байна. Б.Чойжилсүрэн гишүүн, Ч.Улаан сайд. Б.Чойжилсүрэн гишүүн орж ирсэн. Төсвийн байнгын хороон дарга Б.Чойжилсүрэн гишүүн орж ирсэн. Ч.Улаан сайд, Н.Цэрэнбат сайд, Ч.Хүрэлбаатар сайд, Ц.Даваасүрэн сайд. Д.Сумъяабазар сайд хайчсан бэ? Л.Оюун-Эрдэнэ дарга аа, 5 сайд алга байна. Ц.Даваасүрэн, Д.Сумъяабазар, Ч.Улаан, Н.Цэрэнбат. Ёс зүйн хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн сайд нарыг олж ирье. Хамт өөрөө ирье.

Л.Оюун-Эрдэнэ сайд аа, таны карт уншигдаагүй байна шүү. Н.Цэрэнбат сайд карт уншигдаагүй байна. Д.Сумъяабазар сайд карт уншигдаагүй байна.

Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн. Санал хураахад бэлдээрэй. Д.Тогтохсүрэн гишүүн суудалдаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлж болно. 3 хүртэл. Төслийг хоёрдугаар зүйлийг хасах дээр үггүй бол тэгээд шууд явчихъя. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ. Д.Лүндээжанцан гишүүн үг хэлнэ.

Д.Лүндээжанцан: Энэ байна шүү дээ, дагаж мөрдөхөд шилжих журмын хуулийг 62 гишүүн гарын үсэг зураад өргөн барьсан. Тэр дотор Хоёрдугаар зүйлд Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2025 онд болох Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиа эхлэн дагаж мөрдөнө гэж байгаа.

Дараа нь болохоор Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт оруулсан өөрчлөлтийг 7 сарын 01-ний өдрөөс эхлэн анхан болон давж заалдах шатны шүүгчид хамаарахгүй гээд.

Дараа нь Дээд шүүхийн шүүгчдийн, дараа нь Цэцийн.

Ингээд энэ асуудлууд хоёрдугаар хэлэлцүүлэг дээр бүгдээрээ энэ сүүлийн хэсгүүд нь хасагдчихсан учраас энд байх шаардлагагүй болоод цөмийг нь хасаж байгаа юм шүү.

Ерөнхийлөгчийн 6 жил, нэгэн бүрэн эрхийн хугацаа 6 жил байдгийг заавал 2025 он хүргэх шаардлагагүй юмаа гээд Байнгын хороон дээр үзсэн учраас хасаад 2020 оныхоо 5 сарын 25-наас хүчин төгөлдөр болоод явахаар аяндаа үйлчлээд явах юмаа гээд. Ингээд ийм маягаар. Тийм. Ийм өөрчлөлтүүд байгаа учраас.

Хэрвээ энэ хасагдахгүй гээд үлдчих юм бол нөгөө зөрчил чинь нөгөө хоёрдугаар хэлэлцүүлгээр шийдсэн асуудлуудын зөрчил үүсчих учиртай гэдгийг зүгээр тайлбарлачихъя.

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн. О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Түрүүн би хэлж байсан юм. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын хуулиа гуравдугаар хэлэлцүүлэг дууссаны дараа хийе гэдэг чинь одоо яг энэ Д.Лүндээжанцан гишүүний хэлж байгаатай адил л даа.

Манайхан одоо жишээлбэл шүүхийн асуудлыг хэлэх 12 жилээр гэхээд одоо байгаа шүүгч нарыг 12-оор дахиж батлах юм уу? Эсвэл эд нарыгаа байхгүй болгоод, шинээр цоо шинэ орох юм уу гэдэг шиг. Одоо энэ ингээд гуравдугаар хэлэлцүүлэг алх цохилоо, шинэ Үндсэн хуультай болчихлоо гэсэн үг. Тэгэнгүүтээ энэ ердийн хууль болоод явчихна. Тэгэнгүүтээ дурын байдлаар 34 хүний юм уу, 35 хүний кнопоо цуглуулаад хугацаан дээр тоглолт хийнэ. Одоо тэр холимог тогтолцоо гээд та нар 24 гээд сайхан инээж байгаа.

Фронтод гэж хэлж болно доо одоо, дайны талбар луу явах гэж байгаа хүмүүс чинь жагсаалтад орсон хүмүүсээрээ доромжлуулаад дуусна. Тэгээд та нар өөрсдөө л мэд. Энийг хуулийг баталж байгаа бол ихэнх нь өнөөдөр яах вэ, нөгөө архагууд бол арын фронтод буюу намынхаа нэрийн дор нуугдаад явах байх. Тэгээд нөгөө жижиглэсэн нөгөө нөхөд нь очоод жижиг тойрог дээр очоод 5 мянган хүн очихоор таныг голчихсон юм байна лээ, нам чинь. Та хөөгдчихсэн юм байна лээ дээ. Нам чинь та энэ 4 жил болгон үнэлэгдээгүй байна лээ шүү дээ. Та тэгээд ядаж 2020 оноос ингээд явж байгаа гэдэг чинь ер нь та манайд гурил, будаа, талх тариа, нөгөө хүүхдийн төлбөр төлсөн үү гээд, ингээд ам амандаа яриад энэ 4 жил та нар 5 мянган хүнийг хагартал нь баяжуулж тэжээж чадаагүй бол хол явахад хэцүү.

Тийм учраас өнөөдөр энэ журмын тухай хуулиа одоо явуулах гээд байгаа цаад санаа чинь одоо ингээд тавьчихсан шүү. Одоо цөөхөн нөгөө гурав дахь хэлэлцүүлэг дээрээ зарчмын зөрүүтэй санал орлоо гээд 39-өөрөө шийдэх гэж ингэж давхцуулж яваад байгаа юм. Тийм учраас энэ хуулийг бол заавал одоо хэлэлцэж болохгүй гэдгийг би хатуу анхааруулж байна. Үндсэн хуулийн хэлэлцүүлгийн дараа..../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хураалт явуулъя.

Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн. Төслийн хоёрдугаар зүйлийг хасах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна.

Б.Батзориг гишүүн.

Б.Батзориг: Санал хураалтад би дэмжсэн санал өгсөн. Тэгээд энэ кноп ажиллахгүй байна. Дахиж санал хураалт хийж өгөөч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн тайлбар өгнө.

С.Бямбацогт: О.Баасанхүү гишүүн ингэж мушгиж тайлбарлаад байх юм.

Энэ журмын тухай хуулийг дөнгөж түрүүн би хариулсан. Ердийн хууль шиг байхгүй. Ердийн хууль шиг хэлэлцээд ингээд ердийн хуулиар одоо худлаа ингэж 2024 оноос баталчхаад дараа нь та нарыг хулхидаад 2020 он болгочихно шүү. Ердийн хуультай адилхан гэж О.Баасанхүү гишүүн улаан, цагаан мушгиж тайлбарлаж байхад тэрэнд нь гишүүд битгий итгээч ээ.

Дагаж мөрдөх журмын хуулиа та бүхэн харчих. Энэ хууль дээр чинь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр гээд биччихсэн байгаа. Одоо санал хураах саналууд маань бүгд тийм учраас 57-оос дээш босготой явах ёстой юм.

Гэтэл ердийн хууль 34-өөр явна. Одоо 2024 он гэхээд дараа нь 2020 он болгоод ердийн хуультай адилхан хулхидчихна та нар гэж О.Баасанхүү гишүүн улаан, цагаан мушгихад тэрэнд нь автаад, хуулиа уншихгүй автаад байна шүү дээ. Одоо бид нар 57-аас дээшээ саналаар энэ дагаж мөрдөх журмын тухай хуулиа батлах ёстой юм.

Хоёрдугаарт нь, яагаад энэ дагаж мөрдөх журмын тухай хууль хэлэлцэж болоод байгааг би хэллээ. Тэр Ерөнхийлөгчтэй холбоотой заалтыг бид нар хэлэлцээд шийдчихсэн. Тийм болохоор түүнтэй холбогдуулж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр, түүнтэй холбогдуулж дагаж мөрдөх журмын тухай хуулийнхаа энэ заалтыг хасах гэж байгаа юм. Шүүгчтэй холбоотой асуудлыг бид нар хэлэлцээд Үндсэн хууль тусгах шаардлагагүй гээд үзчихсэн. Түүнтэй холбоотойгоор дагаж мөрдөх журмын тухай хуулиас хасах гэж байгаа юм. Энийг ингээд болохгүй гээд мушгиж ярихаар нь тэрэнд нь битгий автаач гэдгийг хэлье. Үндсэн хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр дагаж мөрдөх журмын тухай хууль маань. Энийг гишүүд минь ойлгочхоосой гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Б.Батзориг кноп ороогүй байна. Г.Солтан гишүүн гишүүний санал эсрэг гарсан. Кноп ажиллаагүй гэсэн ийм санал гарсан. Г.Солтан гишүүн үг хэлэх үү?

Г.Солтан гишүүний микрофоныг өгье.

Г.Солтан: Уг нь би дэмжих санал өгсөн. Харин кноп ажиллаагүй болохоор дахин санал хураалт явуулж өгнө үү гээд хүсэж байна.

Г.Занданшатар: Б.Батзориг, Г.Солтан гишүүн нарын санал эсрэг дарагдсан. Техникийн шалтгаантай байгаа учраас өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцох тухай санал хураалт явуулъя. Өмнөх санал хураалтыг

хүчингүйд тооцох санал хураалт явуулж байна. 3 хүртэл санал хураалт явуулж болно.

Хүчингүйд тооцогдлоо. Одоо санал хураалт дахиж явуулна. Энэ чинь Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацааг өөрчлөлт орсон утга 2025 оноос гэдгийг л хүчингүй болгож байгаа заалт шүү дээ. Тийм ээ?

Хоёрдугаар зүйлийг хасах гэсэн санал хураалт байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Үндсэн хуулийнх биш, энэ журмын тухай хуулийнхаа хоёрдугаар зүйлийг хасаж байгаа байхгүй юу.

60 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Д.Лүндээжанцан гишүүн. Санал хураалт явуулъя. Чи буруу тайлбарлаад, холбоогүй юм яриад байвал хасна шүү. Буруу ойлголт өгөөд байна.

Энэ санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Гишүүн үг хэлнэ гэсэн учраас. О.Баасанхүү гишүүн үг хэлнэ.

О.Баасанхүү: Би ийм зүйл хэлээд байгаа шүү дээ.

Одоо тар нар хар л даа. Үндсэн хуулийн хэмжээгээр яваад 57-оор гэж байгаа бол хэлэх үг 10 минут байх ёстой юм байгаа биз дээ. Би 5 минутаар ярьж байгаа биз дээ. Дэгээрээ ярих юм бол. Одоо өнөөдөр та нар яагаад энийг яаравчлан оруулаад байгаа вэ гэвэл одоо ингээд гуравдугаар хэлэлцүүлгээ дуусангуут дахиад дөрөвдүгээр хэлэлцүүлэг гэж ойлголт Үндсэн хуульд байхгүй.

Энэ хуулийн дөрөвдүгээр хэлэлцүүлэг автоматаар нөгөө ердийн олонхоороо буюу 34-өөрөө шийдэж байгаа юм. Сая та нар 2025 оноос гэснийг зориуд өөрчилж байгаа байхгүй. Яагаад вэ гэхээр энэ бол 50 нас орсон учраас 45-тай хүмүүсийг Ерөнхийлөгчид дэвшүүлэхгүй гэдэг юу тавьж байгаа, гогцоо. 45-тай хэн ч гараад ирэх магадлалтай учраас одоо тэр нь шигээ өнөөдөр холимог тогтолцоогоо зориуд оруулж ирэх гээд ингээд хуйвалдаж байна.

Тэгээд би хэлэх ёстой үгээ дэгийн дагуу хэлнэ. Зөв хэлэх үү, буруу хэлэх, үнэн хэлэх үү, худлаа хэлэх Улсын Их Хурлын гишүүнд олгогдсон бүрэн эрх гэж нэг юм байгаа. Тийм учраас хэлэх үгийг хэрвээ саад болох юм бол ард түмэнтэйгээ нийлэхээс өөр аргагүй. Яагаад гэвэл үнэндээ бол энэ журмын хууль чинь Үндсэн хуулийн дараа ярих ёстой юмыг одоо оруулж ингэж та нар жүжиг тоглохоо болиоч гэж би хэлсэн.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Санал хураалт.

59 гишүүн дэмжиж хоёрдугаар санал дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн.

Санал хураалт явуулъя.

60 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийг хасах.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт явуулъя.

61 гишүүн дэмжиж 87.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

5.Төсөлд “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судлан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлнэ.” гэсэн зүйл нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Б.Жавхлан, Д.Хаянхярваа, О.Баасанхүү, Д.Дамба-Очир, О.Содбилэг.

Үг хэлэх. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Д.Эрдэнэбат. Санал тасаллаа. Дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн үг хэлж болно. Дэмжсэн, дэмжээгүйгээ хэлээд хэлээрэй. Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ дээр юу шүү дээ. Хууль бол зөрчигдөөд дараалал алдагдсан гэдгийг би байн байн хэлж байгаа шүү. Буруу явчихсан наадах чинь.

Энэ 5 дугаар төсөл бол уг нь бол энд орж ирэхдээ процедурын шинжтэй юм зөв л дөө. Гэхдээ би энэ Байнгын хороон дээр нэг санал хэлсэн. Юу гэж хэлсэн гэхээр өнөөдөр 11 сарын 14-ний өдөр Дархан, Эрдэнэт хот гэж байхгүй. Өнөөдөр байгаа нь бол Дархан-Уул аймаг, Орхон аймаг гэж хоёр аймаг байгаа.

Тэгэхээр энэ Дархан-Уул аймгийг, Орхон аймгийг улсын зэрэглэлтэй хот болгох гэж томьёолох юмыг өнөөдөр яг хот байгаа юм шиг ингээд биччихсэн нь буруу байна гэж байгаа юм. Одоо энэ чинь Дархан, Эрдэнэт хот гэж өнөөдөр байхгүй шүү дээ, Монголд. Тэгэхээр энэ алдаагаа нэгдүгээрт засах шаардлагатай шүү гэдгийг би хэлмээр байна.

Хоёрдугаарт, энэ асуудалтай бид журмын тухай хууль чинь хууль зөрчиж, дэг дараалал алдагдаж орж ирж байгаа учраас Ардчилсан намын зөвлөл санал өгөхгүй байгаа шүү гэдгийг би бас ташрамд анхааруулж хэлмээр байна.

Г.Занданшатар: Баярлалаа. Сандагийн Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Баярлалаа. Саяны Д.Эрдэнэбат даргын, бас гишүүний хэлж байгаа тэр Дархан, Эрдэнэт хотыг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг судална гэдгийг би нар анхаарч үзье бас. Үнэхээр тийм.

1992 оны Үндсэн хуулиар хотын асуудал байхгүй болчихсон. Дархан-Уул аймаг, Орхон-Уул аймаг гэж нэрлэдэг болсон. Одоо энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэг гол зүйл бол энэ 21 аймгийн төвийг хот болгох улсын чанартай Дархан, Эрдэнэт хотуудыг бий болгох, зарим ярьж байгаа тосгодыг бий болгох ийм бололцоо, боломжийг Үндсэн хуулиараа нээж өгч байгаа. Үүнтэй холбоотой зохицуулалтыг Үндсэн хуульдаа сууж өгч байгаагаараа энэ удаагийн Үндсэн хуулийн бас хамгийн чухал ач холбогдол нь оршиж байгаа.

Хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн болохоор Налайх, Багануур дүүргийн асуудлыг бид нар бас эцсийн хэлэлцүүлэг дээрээ ярьж. Энэ анхны хэлэлцүүлэг хийж байгаа учраас эцсийн хэлэлцүүлэг дээр ярих боломж бидэнд байгаад байгаа юм.

Дараагийн нэг зүйл бол дагаж мөрдөх журмын тухай хуулийн сая Үндсэн хуулийн цэцийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байна гэдгийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үед бид нар хасчихсан. Тийм болохоор түүнтэй холбоотойгоор дагаж мөрдөх журмын тухай хуулиас хасаж байгаа юм. Ингээд хоорондоо уялдаад явж байгаа гэдэг маань зөвхөн одоо энэ заалтаас ингээд харагдаж байгаа.

Дараагийн нэг тайлбарлах зүйл бол 6 дугаар зүйл гээд биччихсэн байгаа. Дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйл. Энэ дээр энэ хууль бол Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн нэгэн адил хүчинтэй гээд биччихсэн байж байгаа. Тийм болохоор бас О.Баасанхүү гишүүний тайлбарлаад ердийн хуультай адил та нарыг хулхидаад одоо ингээд 2024 оныг 2020 болгочихно шүү гэдэг ойлголт байхгүй. Энийг гишүүд маань бас зөв ойлгоорой гэдгийг бас хэлээд өгье. Баярлалаа.

Г.Занданшатар: О.Баасанхүү гишүүний өөрийнх нь гаргасан санал шүү дээ. Дархан, Эрдэнэтийн гишүүдийн.

Олон Улсын дээд сургуулийн оюутнууд хичээлээр судалсан мэдлэгээ бататгах зорилгоор Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. Улсын Их Хурлын гишүүд нь.

Октябрийн Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Үндсэн хуулийг хэлэлцэхэд Дархан, Эрдэнэтийг хотын статус олгоё гэдэг дээр санал нэгдэж гарын үсэг зурсан л даа.

Тэгэхдээ ийм журмын тухай хуулиар ингэж өөрчлөхийг бол дэмжиж гарын үсэг зураагүй байхгүй юу. Журмын тухай хууль дээр О.Баасанхүү гишүүн оролцсон гэсэн маягтай ингэж хүн гүтгэх хэрэггүй.

Би анхнаасаа л хэлээд байгаа. Халтмаагийн Баттулга Ерөнхийлөгч хага төмсөгдүүлсэн Ардын намын ЖДҮ-чид, концессчид дээрээс нь нөгөө Ж.Батзандан, Л.Болд зэрэг нөхөд Ц.Нямдоржийнхоо суганд хавчуулагдчихаад үхэн хатан өнөөдөр энэ Монгол төрөөр тоглож байгаад би ичин дургүйцэж байна.

Г.Занданшатар: Энэ Дархан, Эрдэнэт хотыг эхний хагаст шийдвэрлэх асуудлыг энэ Дархан, Эрдэнэтийн гишүүд санал гаргасан байх юм. Дэмжсэн 3 гишүүн хэллээ. Одоо дэмжээгүй 3 гишүүн. Тухайн саналын томьёоллоор л үг хэлнэ. Дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл үг хэлнэ. Чимэдийн Хүрэлбаатар гишүүн.

Ч.Хүрэлбаатар: Би нэг ийм санал хэлэх гэсэн юм. 2020 оны эхний хагас жилд багтаагаад Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг Засгийн газар судлаад холбогдох хуульд нь өөрчлөлт оруулаад Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ гэж байгаа. Аймгийн төвүүдээ хот болгох тухай асуудлаа энэ дээрээ оруулъя. Яахаараа заавал одоо цөөн тооны хотыг оруулж ирж шийддэг. Бусад тэр аймгийн төвүүдээ хот болгох асуудлыг тодорхой хугацаагүйгээр хойшлуулаад яах юм бэ?

Нэгэнт л энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж байгаа юм бол тэр аймгийн төвүүдийг сум биш хот буцааж олгох энэ асуудлыг бол нэг мөсөн шийдчихмээр байна. Би лав Улаангом хотод төрсөн гэж явдаг. Одоо сум биш тэрийгээ эргээд Улаангом хот гээд болгочихмоор байна.

Тэгэхээр энэ дээр байгаа юм чинь заавал хоёр асуудлыг нь шийдээд бусдыг нь одоо тодорхойгүй хугацаагаар хойшлуулъя. Аяндаа болно биз, тэгж байгаад болно биз гэсэн юм хойшлуулах гэсэн сэтгэхүйгээр хандмааргүй байх юм. Шийдэж байгаа бол бүгдийг нь энэ хотын асуудлыг 2020 оныхоо эхний хагас жилдээ багтаагаад бүгдийг нь нэг мөсөн шийдчихмээр байна.

Тийм учраас би ингэж зөвхөн хоёрыг салгаж ирж байгааг дэмжих боломжгүй байна. Одоо санал хураагаад шийдлээ гэхэд тэр редакц, дараагийн хэлэлцүүлэг дээр нь энийг засах боломж гарахгүй шүү дээ. Тийм учраас энэ асуудлыг бүр тусгайд нь одоо Засгийн газрын тогтоол гаргаад шийдчихмээр байна.

Тийм учраас би энэ дээр унагаагаад Үндсэн хууль батлагдсаны дараагаар гарахад тусгайлаад Улсын Их Хурлын тогтоол болгоод гаргачих нь илүү зөв шийдэл болов уу гэж бодож байна. Энэ хотуудаа нэг мөсөн нэг мөр ойрын хугацаанд шийдэх ёстой юм. Шийдэх, шийдэхдээ энэ Их Хурлын бүрэн

эрхийн хүрээнд шийдэж дуусгах учиртай шүү гэдгийг л хэлэх гэсэн юм. Тийм учраас энэ саналыг дэмжих боломжгүй байна.

Г.Занданшатар: Дэмжихгүй нэг, дэмжиж хоёр гишүүн үг хэлсэн. Н.Оюундарь гишүүн. Наваан-Юндэнгийн Оюундарь гишүүн.

Н.Оюундарь: Яах вэ, ерөнхийдөө бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөж байгаа энэ журмын тухай хууль дээр ямар юм орох ёстой байсан бэ гэхээр Дархан, Эрдэнэт хот бол улсын чанартай хотууд болно. Тэгээд дээрээс нь тосгодын асуудлуудыг ярьсан байхгүй юу. Тэгээд тосгодын асуудлыг хоёрдугаар хэлэлцүүлэг дээр ярьж байхад Л.Мөнхбаатар гишүүн Хөвсгөлийнхөө жишээн дээр, би Сэлэнгийнхээ жишээн дээр, Л.Оюун-Эрдэнэ Хэнтийнхээ жишээн дээр бүгдийг нь ярьчаад ерөнхийдөө Их Хурлын даргаас тийм чиглэл өгсөн юм.

Ерөөсөө дараагийн удаа энэ тосгодын асуудлыг бас энэ дараагийн хэлэлцүүлгээр оруулж ирээрэй. Тэгээд тэр журамдаа бас, дагаж мөрдөх хуулиудын төсөлдөө бас оруулж ирээрэй гэсэн тийм чиглэл өгчихөөд байж байхад Г.Занданшатар даргын зүгээс. Тэгж байхад яагаад өнөөдөр энэ нь орж ирээгүй ганцхан Дархан, Эрдэнэтийн асуудал улсын чанартай хотын асуудал орж ирчхээд байгаа юм бэ. Угтаа бол 57.2-т бол угаасаа энийг нь хот, тосгод гэж байгаа. Гэхдээ дагаж мөрдөх журам нь бол 2020 оныхоо эхний хагас жилдээ энэ дагаж мөрдөх хуулиараа орж ирэх ёстой байгаа байхгүй юу. Тэгээд бид нар тийм үндэслэлээр энэ дээр ийм асуудлыг бас тавьж байна.

Г.Занданшатар: Загдхүүгийн Нарантуяа гишүүн. Хоёр дэмжиж, хоёр дэмжихгүй үг хэлчихсэн.

З.Нарантуяа: Яг энэ заалттай холбоотой биш. Миний хэлэх үг болохоор 6 дугаар заалттай холбоотой байсан юм байна. Тэгэхээр дараагийнх руугаа шилжүүлчихье.

Г.Занданшатар: Ц.Цогзолмаа гишүүн. Цэдэнбалын Цогзолмаа.

Ц.Цогзолмаа: Өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэг дээр яг одоо Ч.Хүрэлбаатар сайдын хэлж байгаа саналтай санал нэг байна. 21 аймаг, аймгийнхаа төвүүдийг бид нар хөгжлийнх нь концепцийн хувьд одоо нээж өгөх ийм том бодлогын өөрчлөлтийг нэгэнтээ л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ярьж байгаа бол хамтад нь хийгээд явах нь зүйтэй.

Яагаад гэвэл энэ удаагийн нэмэлт, өөрчлөлт орсноор тодорхой цаг хугацааны дараа энэ асуудал дахин сөхөгдөх ийм эрх зүйн зохицуулалттай учраас одоо нээж өгөөд, тэгээд хууль, эрх зүйн хувьд дагаж гарах бусад органик хуулиудын өөрчлөлтийг хийгээд явах нь зүйтэй гэсэн ийм саналыг хэлэхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Намсрайн Цэрэнбат сайд.

Н.Цэрэнбат: Энэ асуудлыг бас гишүүдтэйгээ санал нэг байгаа. Аймгийн төвүүд төдийгүй цаашид Улаанбаатар хотын дагуул хотуудыг бий

болгож байж энэ төвлөрөл, орчны бохирдлыг бууруулах хөгжлийн шинэ хандлагад оруулна гэж байгаа.

Тэгээд энэ агуулгын хувьд сая С.Бямбацогт дарга хэлж байна. Эхний хэлэлцүүлэг учраас хоёр дахь юун дээр агуулгын хувьд бол тэгээд бусад хотуудыг гэдэг агуулгыг оруулж өгөх нь зүйтэй байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн.

Ш.Раднаасэд: Энэ гишүүдтэй ерөнхийдөө санал нэг байна. Нэг зүйл байна. Энийг чухам Төрийн байгуулалтынхан яаж харсан юм.

Одоо 57 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг. Хот, тосгон байгуулах эрх зүйн үндэс өөрөө энэ дээр явж байгаа. Зөв үү? Нэгжийн удирдлага дахь улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хот, тосгоны өөрийн удирдлага зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж.

Одоо энэ нэмж байгаа зүйл чинь болохоор энэ хуулийг нь 2020 оны эхний хагас жилд багтаан шинэчлэн батал гэж байна шүү дээ, зөв үү? Энэ батлагдсаны дараа Дархан нь байна уу, Эрдэнэт нь байна уу, тийм ээ? Тэр хаана байна. Өөр Улаангом хот байна, Алтай хот байна уу. Хаана ямар тосгон байгуулах асуудал чинь аяндаа өөрөө үндсийг нь тавьчхаж байгаа учраас энэ хоёр чинь ач холбогдох нэг их ингэж онцгойлон өгөх шаардлага эндээс чинь харагдахгүй байна л даа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, энэ чинь өөрөө эрх зүйн үндэс нь тухайн нутаг дэвсгэрийн эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзаад Иргэдийн хурлын саналыг үндэслээд Засгийн газар өргөн мэдүүлж Их Хурал шийдвэрлэнэ гэж байна. Зөв үү? Нэг нэгээр нь шийдэх гээд байна уу эсвэл нийтлэг байдлаар шийдчих гээд байна уу?

Тэгэхээр энэ чинь нэг ийм авцалдаагүй л юм үүсчих гээд байна. Тэртэй тэргүй хуулийг нь баталчихсан юм чинь заавал энэ дээр Дархан, Эрдэнэт гэхгүйгээр бүх аймгийн төвүүдийг нь тэр шаардлагатай гээд байгаа тосгодыг нь одоо сумаас том хүн амтай, сумаас олон хүм амтай тосгод, багууд байна шүү дээ. Тосгон нэртэй жишээлэх юм бол.

Энэ бол хот, тосгон хоёрыг ялгаагүй нэг эрх зүйн үндсийг нь тогтооно гэж байгаа байхгүй юу. Одоо хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль гэдэг байгаа хуулийг нийлэг байдлаар нэг өөрчлөөд ямар нь улсын байх юм, ямар нь орон нутгийн шинжтэй хот байх юм гэдгийг нь тогтоогоод нэг хуулийг л 5 сараас өмнө батал гэж байгаа юм байна.

Тэгэхээр энэ дээр Дархан, Эрдэнэт гэж онцлохгүйгээр энэ гишүүдийн гаргаад байгаа энэ саналыг бүгдийг нь багтаагаад нэг хуулиар хийх л юм чинь тийм байдлаар өөрчлөөд явчих боломжтой юм болов уу гэж харагдаад байна л даа.

Тэртэй тэргүй 5 сард багтааж Дархан, Эрдэнэт гэж хотыг байгуулахгүйгээс хойш, байгуулж чадахгүйгээс хойш хуулийн баталж эрх зүйн үндсийг нь тогтоо гэж байгаа юм чинь энэ хуулийн өөрчлөлтийг нэгэнт хийх

юм бол бусад аймгуудын асуудлыг нь ч гэсэн, бусад тэр шаардлагатай гээд тосгодын асуудлыг нь ч гэсэн тавих, шалгуур шаардлага гээд олон юмнууд энэ дээр бичигдэнэ. Мэдээж тэр хууль дээр. Ямрыг нь орон нутгийн чанартай тосгох гэх юм, ямрыг нь улсын чанартай тосгон гэх юм. Хот гэх юм гэдэг ч юм уу.

Тийм учраас энийг бол нийтлэг байдлаар нь зүгээр орхиод энэ хот, тосгодын асуудлыг нь тэр 5 сардаа багтаан шийд гэдгээр нь биччих нь зөв болов уу л гэж хараад байх юм.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Ер нь олон гишүүдийн гаргасан саналын дагуу. Хэрвээ энэ санал уначих юм бол энэ заалт тэр чигээрээ дахин сэргэх боломжгүй болно. Энэ саналыг дэмжээд Улсын Их Хурлын даргын зүгээс чиглэл өгч бусад аймаг, тосгодын асуудлыг нэг мөр шийдвэрлэхээр оруулж ирэх ийм чиглэлийг өгч байна.

Нэгдүгээрт нь, хууль бол бэлэн болчихсон байгаа. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл Нэгдсэн Үндэстний Байгууллагын дэмжлэгтэйгээр боловсрогдоод үндсэндээ бэлэн болчихсон байгаа. Үндсэн хуулиа хүлээж байгаа. Энэ бол энэ ондоо ч багтаад хэлэлцэгдээд батлагдах бололцоотой. Харин Засгийн газраас Улсын Их Хуралд оруулж ирэх шийдвэрийг нь албажуулж байгаа. Үндсэн хуулиар Засгийн газар Улсын Их Хуралд оруулж ирж байж хотод засаг захиргааны нэгжийн эрх өгөх асуудлыг шийдвэрлэж байгаа юм.

Зочид танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн, Шадар сайд Өлзийсайханы Энхтүвшиний урилгаар Чингэлтэй дүүргийн 12, 13, 14, 15 дугаар хорооны Засаг дарга нар болон хэсгийн ахлагч нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе.

Ингээд санал хураалтаа явуулна. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт явуулна.

Чиглэл өгчихсөн. Бусад аймгийн төвийг хот болгох асуудал, тосгодын асуудлыг бас нэг мөр шийдвэрлэе гэсэн чиглэл өгч байна. Чиглэл өгөөд эцсийн хэлэлцүүлэг дээрээ засаад оруулж ирээд батална. Болно. Тийм чиглэл өгч байна.

Д.Эрдэнэбат гишүүн ээ. Санал хураалт явуулах гэж байгаа тул зааланд 60 гишүүн байна. Гэхдээ нэмэгдэж бусад гишүүд орж ирээрэй. Санал хураалт явуулна.

Санал хураалт явуулахад бэлэн болж байна. Х.Болорчулуун гишүүн суугаарай. Ж.Батзандан гишүүн суугаарай. Санал хураалт явуулъя. Санал хураалт эхэллээ.

59 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ. Чиглэл өгөгдсөн. Бусад аймаг, хотууд, тосгодын асуудлыг эцсийн хэлэлцүүлэг дээр шийдвэрлэж ор ирээрэй.

6.Энэ хуулийг 2019 оны 11 дүгээр сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Д.Тогтохсүрэн.

Санал хураалт явуулъя. Анхааралтай байцгаагаарай. Санал хураалтад бэлтгэж байгаарай. Санал хураалт.

61 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ.

7.Төсөлд “Улсын Их Хурлын сонгуулийг 2024 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.” гэсэн агуулгатай зүйл нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтаа анхаараарай. Эхний хэлэлцүүлэг хийгдэнэ л дээ.

Энэ чинь заавал 57-оор уу? Эцсийн хэлэлцүүлэг дээр энэ асуудлаа эцэслэн орж ир. Энэ санал дэмжигдсэнгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллын Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжээгүй саналаар санал хураалт явуулна.

1.Төсөлд доор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйл нэмэх:

“4 дүгээр зүйл. Улсын Их Хурлын сонгуулийг 2020 оны ээлжит сонгуулиас эхлэн олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбат. Дэмжээгүй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна шүү. Дэмжээгүйг дэмжье. Дэмжээгүйг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Бүгд “yes” дарах ёстой.

59 гишүүн дэмжиж энэ санал дэмжигдлээ. Өөрөөр хэлбэл Д.Эрдэнэбат гишүүний гаргасан санал дэмжигдсэнгүй. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ анхаарах боллоо.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.

Хоёр. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл
/Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын 62 гишүүн 2019.06.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, **гурав дахь хэлэлцүүлэг**/

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.1-т ирц 57-оос дээш бүрэлдэхүүнтэй байна гэж заасан. Ирцийг хангасан байгаа.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт даргыг индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Лүндээжанцан нарын нэр бүхий 62 гишүүнээс 2019 оны 6 дугаар сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Улсын Их Хурал 2019 оны 8 дугаар сарын 28, 29, 9 дүгээр сарын 4, 5, 7-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар явуулж төслийг ард нийтийн санал асуулгад оруулах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь тогтсон тул Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн дагуу ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг, хоёр дахь хэлэлцүүлгийг явуулж ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 73 дугаар тогтоолыг баталсан.

Уг тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч 2019 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсныг Улсын Их Хурлын 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцүүлэн авах нь зүйтэй гэж үзэж “Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай Улсын Их Хурлын 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 73 дугаар тогтоолыг тогтоолыг хүчингүй болгосон болно.

Ингэснээр Улсын Их Хурал төслийг гурав дахь хэлэлцүүлэгт шилжүүлэн, Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг, хугацааг тогтоосон Улсын Их Хурлын тогтоолыг баталсан.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2019 оны 11 дүгээр сарын 13-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хийж, Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶ дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн

гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх санал, дүгнэлтийг танилцуулж байна.

Төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх хүрээнд Улсын Их Хурлын даргын 199 дүгээр захирамжаар байгуулагдсан Зөвшилцлийн ажлын хэсэг нь 2019 оны 9 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 07, 08, 09, 11 дүгээр сарын 05, 12-ны өдрүүдэд нийт 7 удаа хуралдаж тодорхой асуудлуудаар зөвшилцөлд хүрч санал нэгдсэн.

Байнгын хорооны хуралдаанд Ерөнхий сайд танхимаа өөрөө бүрдүүлэх, Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн /мажоритар/ болон хувь тэнцүүлэх /пропорциональ/ зарчмыг хослуулан явуулж сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх гэсэн зарчмын шинжтэй хоёр асуудлаар гарсан саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар санал хурааж хуралдаанд оролцсон нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶²-т заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ард нийтийн санал асуулгын нэг, хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн найруулга, редакцын шинжтэй 11 саналаар дахин санал хураах санал гаргасныг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн.

Улсын Их Хурлын гишүүн Х.Нямбаатараас Ерөнхийлөгчийг Улсын Их Хурал өргөтгөсөн бүрэлдэхүүнээс сонгохтой холбоотой санал ирүүлснийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁶² дахь хэсэгт заасны дагуу Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжээгүй тул уг асуудлаар санал хураах шаардлагагүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт, саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Д.Эрдэнэбат гишүүнээр тасаллаа. Б.Чойжилсүрэн гишүүнээр тасаллаа. Одоо Октябрийн Баасанхүү гишүүн асуулт асууна.

О.Баасанхүү: Асуулт 10 минут гэж ойлгож байгаа, зөв үү?

Г.Занданшатар: Асуулт 8 минут.

О.Баасанхүү: Тийм. Яагаад гэхээрээ өнөөдөр Үндсэн хуулийн хэлэлцэж байгаа учраас тусгай дэгээр явах байх.

Үндсэн хуулийн анх 62 гишүүн гарын үсэг зурахад миний бие орсон. Дараа нь тэгсэн чинь Ерөнхийлөгчийгөө сонсьё гээд. За яах вэ анхны хэлэлцүүлэг дээр угаасаа Монгол Улсын Ерөнхийлөгч орж бас үг хэлэх, ард түмний юм байлгүй яах вэ, орсон.

Хоёр дахь хэлэлцүүлэг бий болсон. Хоёр дахь хэлэлцүүлгээр нийт ард түмний санал асуулгыг авъя гээд. Тэгээд Ерөнхийлөгч бас л ард нийтийн санал асуулга авч болохгүй гээд хориг тавьсан гээд. Тэгээд Ерөнхийлөгчийн хоригтой холбоотойгоор зөвшилцлийн ч гэж нэрлэнэ үү, эсвэл одоо хоригийг авах ажлын хэсэг ч гэж нэрлэнэ үү. Нэг ажлын хэсэг байгуулагдсан юм шиг байгаа юм.

Тэр ажлын хэсэгтээ Монгол Ардын Хувьсгалт намыг оруулаагүй. Харин хууль бусаар суудалгүй хоёр гишүүнийг намын нэр барьж оруулсан. Тэр хоёр нь ядаж байхад Монгол Улсын Ерөнхийлөгчид дэлбэртлээ төмсөгдүүлсэн хоёр хүн байгаа. Харамсалтай нь ЖДҮ гээд л. Одоо тэр Хүнс сервис гээд балай юм гарна.

Тэгэхээр өнөөдөр Үндсэн хууль хэлэлцэж байгаа юм бол эсвэл ард түмэнтэйгээ зөвшилцөх, үгүй бол Улсын Их Хуралд суудал бүхий намуудтай зөвшилцөх. Ингэж зөвшилцөхдөө Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвхөн хоригийн хүрээнд зөвшилцөх ёстой л доо. Хоригийн хүрээнд. Гэтэл харамсалтай нь намын хүрээнд зөвшилцчихлөө. Ардчилсан намын одоо өгсөн хүсэлтийг нь анхааран үзлээ гэж яриад байгаа байхгүй юу.

Миний ойлгож байгаагаар бол Үндсэн хуулийг бол нийт ард түмнээр хэлэлцэн батална гэсэн Үндсэн хуулийн зарчим байгаа. Нийт ард түмний гэж. Төлөөллийн зарчмаараа Их Хурлын гишүүд нь ярьдаг л байх. Тэгэхдээ өнөөдөр “намын” гэж ойлголт байхгүй л дээ. Монгол Ардын Хувьсгалт намын саналыг аваач гэдэг юм уу. Би тэгж яваагүй. Өр тэглээч гэдэг юм уу.

Тэгэхээр Ардчилсан намын саналыг үндэслэн гээд таны одоо энэ хэлэлцүүлгийн гэдэг юм уу, саяны юм дотор чинь тийм юм яваад байдаг. Хориг дээр болохоор Ардчилсан нам дээр байгаа энэ саналын талаар нэг ч үг үсэг ороогүй. Жишээлбэл, холимог тогтолцоо ч гэдэг юм уу. Жишээлбэл, Ерөнхийлөгчийг Их Хурлаас сонгоё ч гэдэг юм уу. Жишээлбэл, өөр юу ч байдаг билээ. Гурван саналыг яриад байна гээд байгаа юм.

Тэгэхээр энэ нам төвтэй төрийн тогтолцооноос уг нь арай өөр түвшин рүү ороод нийт ард түмэн төрийн эрх мэдлийг гартаа атгана гээд байгаа шүү дээ. Төрийн эрх мэдлийн хүрээнд гэдэг чинь намаас хамаарахгүй явах ёстой юмыг очоод ингээд гурван нам биш хоёр нам яриад, хуурамч нэг суудалгүй намыг. Саяхан бүртгэгдсэнийг нь ойлгож байна. Суудалгүй намыг болохоор зөвлөл гэдэг нэр өгөөд явчихсан. Зөвлөл гэж одоо ойлголт манай өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хуулийн хаана ч байхгүй.

Ардчилсан намын зөвлөл ч гэдэг юм уу, Ардын намын зөвлөл ч гэдэг юм уу, Хувьсгалт намын зөвлөл гэдэг юм уу. С.Жавхлан бид хоёр нийлээд

одоо зөвлөл байгуулчихъя л даа, тэгвэл. Ялгаа байхгүй шүү дээ. Гишүүдийн зөвлөл гээд нэрлэх юм уу?

Тэгэхээр ийм парламентад боломжгүй, хууль бус жишиг тогтоож байгаад их харамсаж байна. Тэгээд Үндсэн хууль дээр ийм юм ярьсан бүр харамсаж байна. Би одоо дотор байгаа заалтуудаар яримааргүй байна. Яагаад гэвэл хэлэлцэхээр үг тус бүрээр авдаг болохоор. Харин би одоо яг зөвшилцсөн энэ хэлбэр чинь яагаад хууль зөрчсөн юм бэ гэдгийг нэгдүгээрт асуумаар байна. Зөвшилцсөн хэлбэр. Яагаад гэвэл суудал бүхий намууд хоорондоо зөвшилцөж болно. Суудал бүхий намууд. Эсвэл одоо юу байдаг юм, нийт ард түмнээрээ зөвшилцөж болно. Нийт ард түмний хүрээнд одоо ард нийтийн санал асуулгаар. Тэрнээс биш намууд хоорондоо зөвшилцөж болохгүй. Ийм хууль байхгүй. Үндсэн хуулийг хэлэлцэж байгаа учраас би хэлж байна. Намууд улс төрийн янз бүрийн тохироо, улс төрийн яриа хэлцэлд орохыг бол үгүйсгэхгүй.

Тэрнээс биш хэрвээ намуудын зөвшилцөл хийх гэж байгаа бол 34 намын хүрээнд зөвшилцөл яагаад хийгээгүй юм бэ? Яагаад гэхээр нийт ард түмнээр хэлэлцүүлнэ гэдэг үг чинь суудал бүхий намаар ярина. Үгүй бол Улсын Их Хурлын гишүүдийн хүрээнд ярина. Улсын Их Хурлын гишүүдээс томилогдсон ажлын хэсэг байгуулагдах ёстой болохоос Ардчилсан нам, Ардын нам, ШИНЭ намын зөвлөлийн ажлын хэсэг гэж байж болохгүй. Тийм зөвлөл байдаг хууль зүйн гарц байхгүй гэдгийг анхаарна биз дээ.

Ганцаараа байна гэдэг чинь өнөөдөр энэ намыг төлөөлөхгүй гэсэн үг биш. Улс төрийн намын тухай хууль дээр 114 мянган хүний санал авсан Монгол Ардын Хувьсгалт нам суудалтай. Ардчилсан нам бүлэгтэй байсан. Харамсалтай нь нөгөө аймхай хоёр маань гараад ингээд бүлэггүй болгоод ард түмний эрхийг байхгүй болгосон. Энийг ойлгох хэрэгтэй.

Тэгээд өнөөдөр хамгийн их миний санаа зовж байгаа зүйл зөвшилцөхдөө ард түмний эсрэг зөвшилцсөнд бүр их гайхаж байна. Яагаад ард түмний эсрэг зөвшилцөөд байгаа юм бэ? Ард түмэн чинь юуг хүсээд байгаа вэ гэвэл нам төртэй төрийн тогтолцооноос татгалзаад байхад намын даргыг Ерөнхий сайд байлгаад, намын дарга нь Засгийн газрыг удирдана гээд тавьсан байна. Намын даргыг яагаад ингэж Засгийн газрыг удирдаад улсаас, төрөөс тусдаа намын ийм Засгийн газрыг бий болгох гээд байна. Бид нар зөвхөн тэрийг нь сонсох юм байна. Бид нар зөвхөн тэр танилцаад ийм сайдууд орж байгаа юм байна гэж л ойлгох гээд байна л даа. Тэгэхээр намд зориулсан Засгийн газрын ингэж байгуулах зөвшилцөл хийсэн шалтгаанаа тайлбарлаж өгнө үү? Баярлалаа.

Г.Занданшатар: Зөвхөн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууна гэж журмын тухай хуулиар зохицуулсан байгаа. Гишүүд анхаараарай. С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг О.Баасанхүү бид нарын 62 гишүүн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байна гэдэг асуудлыг 2000 оны дордуулсан долоо гэж нэрлэгддэг тэр өөрчлөлт орсон цагаас эхлээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийе. Төрөө бас нэг төр шиг болгоё. Энэ төрийн бодлого нь тодорхой, тогтвортой байдаг байлгая. Энэ 20 гаруй жилийн хугацаанд 1 жил 6 сарын настай олон 14, 15 Засгийн газрын нүүр үзлээ. Үүнээс болж Монгол Улсын эдийн засаг, Монголын ард түмний амьдрал одоо хохирдог юм байна. Яаж нэг тогтвортой төртэй болох вэ, яаж нэг Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг хийх вэ гэдэг асуудлыг үе, үеийн Их Хурал, ялангуяа 2010 онд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль батлагдсанаас хойш 3 парламентад дамжиж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл яригдсан.

Өнгөрсөн 2012-2016 онд хамгийн сүүлд 47 гишүүн, Фортуна Батбаяр гэж одоо Нямжавын Батбаяр нарын одоо 47 гишүүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг өргөн мэдүүлсэн. Энийг харамсалтай нь хэлэлцэж амжаагүй. 2016 онд бас Д.Лүндээжанцан нарын гишүүд одоо Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг санаачлаад ажлын хэсэг байгуулагдаад тэр үед одоо Ж.Эрдэнэбатын Засгийн газраас авахуулаад анхаарч ажиллаж байсан.

Ингээд ард нийтийн зөвлөлдөх санал асуулга, ард нийтийн хэлэлцүүлэг бүтэн хоёр жил, гурван жилийн хугацаанд хийж байж өмнө нь одоо Үндсэн хуульд нэмэлт оруулах ёстой гэсэн олон гишүүдийн, улс төрийн намуудын ярьж байсан саналуудыг нэгтгээд 62 гишүүн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн Улсын Их Хуралд өргөн мэдүүлээд одоо бид хэлэлцэж байна.

Ингэж хэлэлцэхдээ бид нар Үндсэн хуулийг аль болох ард нийтийнхээ санал бодлыг сонсьё, эрдэмтэн судлаачдынхаа үгийг сонсьё, улс төрийн намууд болон төрийн бус байгууллагууд, төрийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг хийе гэдэг байдлаар эхнээсээ тийм зарчим баримталж ирсэн. Одоо хүртэл тэр зарчмаа баримталж хандаж байгаа. Өнгөрсөн зун бүх улс төрийн намуудыг оролцуулсан, Монгол Улсын Ерөнхийлөгчийг оролцуулсан хэлэлцүүлэг бүтэн 5 өдрийн турш зохион байгуулсан. Байнга хэлэлцүүлэг хийгдэж байгаа.

Ингээд бид нар Үндсэн хуулийг хоёр дахь хэлэлцүүлгээрээ ард нийтийн санал асуулгаар баталъя гэж шийдсэн. Ард нийтийн санал асуулгаар батлах шийдвэр дээр Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан. Хоригийг Улсын Их Хурал хүлээж авсан. Ингээд гурав дахь хэлэлцүүлэг хийгдэж байна. Гурав дахь хэлэлцүүлэг хийгдэх явцад бид нар хориг хүлээж авсантай холбогдуулан тодорхой хуульдаа өөрчлөлт оруулаад энэ зайлшгүй ярих ёстой, боломжтой асуудлыг эргэж ярья гэдэг энэ бололцоо нь нээгдсэн.

Үүний дагуу Улсын Их Хурлын даргын 199 дүгээр захирамжаар Зөвшилцөх ажлын хэсэг байгуулагдсан. Зөвшилцөх ажлын хэсэгт парламентад суудалтай намуудын бас тодорхой төлөөлөл орсон. Ингээд 7 удаа хуралдсан гэдгийг түрүүн би бас танилцуулгадаа хэлсэн.

Яагаад одоо бас таныг оруулаагүйг би сайн мэдэхгүй байна. Тэрийг Их Хурлын даргаас асуугаарай. Ингээд зөвшилцлүүд хийгдсэн. Тэгээд хуулийн хүрээнд зөвшилцлүүд хийгдээд тодорхой санал орж, Монгол Улсын Ерөнхий

сайд Засгийн газраа, кабинетаа, сайд нараа өөрөө томилж, чөлөөлж, огцруулдаг байх энэ санал орсон. Энэ нь намын дарга Ерөнхий сайд байна гэсэн санал ерөөсөө ороогүй. Энийг битгий бас ингэж мушгиж яриач ээ. Ерөнхий сайд нь Засгийн газрынхаа сайд нарыг өөрөө томилж, чөлөөлдөг байя. Тэгэхгүй одоо хэт их Их Хурлаас хараат, Их Хурлын бүлэглэл, фракцад барьцаалагдсан байдлаар Засгийн газраас ард түмний өмнө, Улсын Их Хурлын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх бололцоо, боломж нь бага байдаг юм байна. Тийм болохоор Засгийн газраа бас үйл ажиллагаагаа сайн хэрэгжүүлэх, кабинетынхаа сайд нартаа Ерөнхий сайд нь бас хариуцлагаа тооцдог байх гэдэг үүднээс одоо ийм санал орсон.

Нөгөө санал нь улс нэг тойрог, намын жагсаалтаар биш ард түмнээс сонгогддог байх асуудлыг Ардчилсан намын саналаар орж ирж байгаа. Ийм байдлаар одоо зөвшилцөж ажлууд хийгдсэн болохоос биш ард түмний эсрэг намын даргыг Ерөнхий сайд байлгах гэж ард түмний эсрэг тийм зөвшилцөл хийсэн зүйл байхгүй гэдгийг бас танд хэлье. Тэгээд энэ зөвшилцөх ажил бол байнга явагдаж байгаа. Зөвшилцөнө гэдэг маань харилцан ярилцаж ойлголцохыг хэлж байгаа юм.

Монгол Ардын нам хэдийгээр Улсын Их Хуралд 65, 64 суудалтай Үндсэн хуулийг 57 гишүүнээс дээш батлах бололцоотой боловч бид нар аль болох зөвшилцөж, ойлголцож Монгол Улсын Ерөнхийлөгчдөө, парламентад суудалтай намууд болон парламентад суудалгүй намуудтай зөвшилцье. Энэ хийж байгаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг аль болох олон нийтэд ил тод хийе. Энд нэг их яарах, сандрах шаардлагагүй гэдэг үүднээс өнгөрсөн хавраас хойш одоо бүтэн хаваржин, зунжин, намаржин Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцээд одоо бид нар батлах гээд явж байна. Энийг батлахын тулд, Улсын Их Хуралд өргөн барихын тулд бас бүтэн 2, 3 жил гаруй хугацаанд бас олон нийтийн дунд хэлэлцүүлэг хийсэн. Ийм процесс дундуур одоо нээлттэй явж байгаа. Аль болох харилцан бие биедээ хүндэтгэлтэй хандаж, хүн түрэхгүйгээр зөвшилцөж, ойлголцож бие биеийнхээ бие биедээ хатуу тулгалт хийхгүйгээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх гэж л ингэж ажиллаж, одоо хүртэл ажиллаж байгааг хэлье. Энд ямар нэгэн хуулийн зөрчил, ямар нэгэн хүч түрсэн асуудал, тэгээд ард түмний эсрэг хийж байгаа зүйл байхгүй гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Содномзундуйн Эрдэнийн урилгаар Баянгол дүүргийн гуравдугаар хорооны иргэд сонгогчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе.

Цайны цаг болсон боловч сунгаж хуралдана. Завсарлахгүй. Одоо мэтгэлцээн, асуулт хариултын цаг явж байгаа. Санал хураалтын үед бүх гишүүд цуглана. Одоо Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн асуулт асууна.

Ё.Баатарбилэг: Үндсэн хуулийн өөрчлөлтөөр төрөө нэг төр шиг болгох, тогтвортой байлгах асуудлуудыг оруулж ирж байгаа гэж. Тэрэнтэй нэг талаараа санал нэг байна.

Тэгэхдээ нөгөө талаараа өнгөрсөн энэ 1992 оноос хойших засаг төрийн тогтворгүй байдал, энэ олон засгийн газар солигдсон энэ асуудал. Төр засгийн одоо үйл ажиллагаа нэлээд асуудалтай, бужигнаантай явж ирсэн. Төрийн нэр хүнд гэж хэлж болдог ч юм уу, үгүй ч юм уу одоо энэ. Ямар ч байсан энэ төрийн байгууллагуудын нэр хүнд одоо нэлээд муудсан. Төрд иргэдийн итгэл нэлээд доройтлоо гэдэг энэ асуудлууд бол төдийлөн нэг их тийм Үндсэн хуулиас боллоо гэж бол бас нэг үзэмжгүй байгаа юм.

Үндсэн хууль бүх болохгүй, бүтэхгүй байгаа өнгөрсөн энэ олон жилийнхээ бүх болохгүй, бүтэхгүй зүйлийг Үндсэн хууль ийм байсан болохоор ингээд байгаа юм. Үндсэн хууль ийм заалттай болохоор л энэ хагарал талцал ингээд байгаа юм. Үндсэн хуульдаа л ингээд заачихсан болохоор одоо төр засгийн нэр хүнд ингээд унаад байгаа юм гэдэг юм уу. Ажил хийж болохгүй байгаа юм. Олон засгийн газар солигдоод байгаа юм гэж ингэж бас яриад байгаатай бол санал нэгддэггүй юм. Тийм болохоор яах вэ, одоо энэ хэдэн заалтууд орж ирж байна.

Анх бол одоо 62 гишүүний өргөн барьсан Үндсэн хуулийн өөрчлөлтийн заалтууд бол нэлээд чухал заалтууд орж ирсэн. Одоо яг тэр орон нутагт, ялангуяа аймагт, суманд тэр талцал хуваагдлыг хамгийн их бий болгодог орон нутгийн сонгуультай холбоотой, сум аймаг Засаг даргаа сонгохтой холбоотой. Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль гэж ямар юм болдог уу. Багийн даргаа сонгох гэж яаж талцаж, жалга довын үзэл гаргадаг вэ. Энэ болгоныг бас нэг арай гайгүй болгочих аятайхан заалтууд орсон.

Яг энэ ажлын хэсэгт нь бол би өөрөө ажиллаж байсан болохоор бас хэрвээ энүүгээр явчихвал бас нэг аятайхан болох нь дээ гэтэл харамсалтай нь бас энэ заалтууд явсангүй. Босго давсангүй. Эхний нэг, хоёрдугаар хэлэлцүүлгүүдийн босгыг давсангүй.

Үндсэндээ одоо энэ нэг орон нутгийн асуудлыг, аймаг сумын асуудлыг энэ удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр бүр хойш нь тавилаа л даа. Бараг өөрчлөлт ороогүйтэй адилхан. Энэнд бол үнэхээр харамсалтай байна.

Хоёрдугаар хэлэлцүүлэг өнгөрөөд гурав дээр нэгэнт хоёрдугаар хэлэлцүүлэг алх цохичихсон бол ямар ч өөрчлөлт орох боломжгүй л гэсэн. Ахиад зөвшилцлийн ажлын хэсэг гээд ахиад нэг өөрчлөлтийн юмнууд орж ирээд байгаа юм. Энэ болж байгаа юм уу? Хууль зөрчиж байгаа юм биш үү. Энэ Үндсэн хууль сүүлд нь одоо энэ чинь нөгөө Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулиа ингэж, ингэж зөрчсөн байна гээд цэц рүүгээ явах асуудал гарах уу гэдгийг одоо энэ ажлын хэсгийн дарга, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаас асууя.

Тэгээд нэг ийм зөвшилцөл гээд гардаг. Тэгээд хоёр талаасаа нэг зөвшилцсөн гээд л баахан юм болж болж орж ирээд тэгээд нөгөөдөх нь дэмжлэг авдаггүй. Угаасаа энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийг явуулахгүй санаатай албаар ийм юм цаг авч ингэж яваад байдаг юм уу гэж бараг хардмаар шахуу л юм болох юм нээрээ. Тэгэхээр энэ дээр нэг тодруулга өгөөч. Энэ гурваар ийм юмнууд орж ирж байгаа нь болж байна уу, үгүй юу?

Түрүүн зүгээр О.Баасанхүү гишүүний асуултад зарим юмнууд нь давхацчихлаа гэж бодож байна. Яах вэ зүгээр ард нийтийн санал асуулга явуулна гэж алх цохиод хориг тавигдаж хориг авагдаад ингээд явчихлаа л даа. Уг нь хэрвээ боломжтой байсан бол ард нийтийнхээ санал асуулгаар энэ хайнаа хагалаад явчихсан бол их зүгээр байсан юм.

Тэгээд хэрвээ энэ зөвшилцөл ингээд явж болж байсан юм бол энэ зөвшилцлийнхөө хүрээнд энэ орон нутгийн засаг захиргаатай холбоотой асуудал яригдаагүй юу? Манай энэ сөрөг хүчин одоо маш чухал заалтуудаар одоо зөвшилцөж л одоо орж ирэх гэж байгаа гэсэн. Ерөөсөө нөгөө нэг холимог тогтолцоог 2020 оноос оруулж ирэх л юм ярьж орж ирлээ шүү дээ. Холимог тогтолцоог 2020 оноос. Нөгөө нэг листэд хавчуулагдаж Их Хуралд орж ирэх юм. Үгүй ийм эрх ашиг байна уу? Үндсэн хуулийг саатуулан саатуулан, Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг саатуулан саатуулан, баахан бойкот хийн хийн. Ард түмэн ерөөсөө хүсэхгүй байна гээд ийм заалтууд руу ийм заалт руу ерөөсөө манай ажлын хэсгүүд бол ерөөсөө халгаагаагүй шүү дээ. Энэ холимгийг.

Тэгээд байхад чинь ингэж сөрөг хүчний зүгээс одоо нэг ийм асуудал оруулж ирлээ гэдэг ийм юмаар ингэж нэг тийм оруулж ирж бөөн хэрүүлийн алим болж байна шүү дээ. Тэгээд одоо бол 2024 оноос гэж байх шиг байна. 2024 он нь аягүй бол яг нэг батлах үед 2020 он болчихсон ингээд явж байх юм биш шүү. Хэрвээ 2020 он болоод ороод ирвэл энэ хариуцлагыг хэн хүлээх вэ? Төрийн байгуулалтын байнгын хороон дарга, одоо энэ Д.Лүндээжанцан дарга байх шиг байна. Та нар хариуцлага хүлээх үү, энэ дээр.

Наадахад чинь ард түмэн үнэхээр дургүй байгаа. Үндсэндээ бол. Тийм болохоор энд эргэлзэж байгаа. Үнэхээр тийм зөв шийдвэр болж байгаа гэдэгт бол эргэлзэж байгаа.

Тэгэхээр нэг ийм эргэлзээтэй юмнууд байгаад байгаа болохоор эд нарт бол тайлбар нэгдүгээрт бас хариулт авмаар байна. Хоёрдугаарт хариуцлагыг хэн хүлээх вэ гэдгийг бол тодорхой болгомоор байна.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Ё.Баатарбилэг гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээрт нь, энэ саяны орж байгаа хоёр зарчмын санал маань журмын тухай хууль зөрчиж байгаа юу гэсэн асуулт асуусан. Ерөнхий сайд кабинетаа бүрдүүлдэг байх. Дээрээс нь холимог тогтолцоотой холбоотой. Энэ дээр бол Ерөнхийлөгчийн хориг хүлээж авсантай холбогдуулан холбогдуулан холбогдох хуулиудад бид нар өөрчлөлт оруулсан. Тухайлах юм бол Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль.

Энэ хуульд бас өөрчлөлтүүд ороод бид нар гурав дахь хэлэлцүүлэг хийж байгаа. Ингэхдээ бид нар бас тодорхой зүйл, заалтууд дээр дахиж ярих бололцоо боломжийг нээж өгсөн байгаа. Тийм болохоор одоо журмын тухай хууль зөрчөөгүй гэдгийн энд хэлье.

Энэ дээр тийм учраас зөвшилцье. Ардчилсан намын зөвлөлийн тавьж байгаа саналыг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьж байгаа саналыг, бусад намуудын тавьж байгаа саналуудыг бас харгалзан үзье гэдэг үүднээс саяны асуудлуудыг ярьж байж орж ирж байгаа.

Манайхан бол яах вэ, намын жагсаалт гээд 2012 онд нэг удаа холимог тогтолцоогоор сонгууль явсан. Намын жагсаалтад одоо ерөөсөө тэгээд хатуу жагсаалттай тэгээд гишүүдийг бичээд тэгээд хэн мэдэхгүй хүмүүс нь одоо ингээд ороод ирсэн. Тэрэнд бол маш их дургүй байдаг, ард түмэн. Тэрэнтэйгээ санал нэг байдаг. Тийм. Яг тэр жагсаалттай адилхан гэж ойлгоод байх шиг байна. Ардчилсан намын зөвлөлийн саналаар одоо бас зөвшилцөөд орж ирж байгаа. Энэ холимог тогтолцоог бас яг түүнтэй адилхан намын жагсаалтын ард одоо ард түмэнд очих нүүргүй болчихсон хэдэн нөхөд л жагсаалтын ард нуугдаад л Улсын Их Хурлын гишүүн болчих гээд байгаа юм шиг байна гэж тийм ойлголтоор ойлгоод байх шиг байгаа юм. Тийм юм бол байхгүй.

Энэ бол холимог тогтолцоогоор сонгууль явна. Намын жагсаалтад бичигдсэн нэр дэвшигчийг сонгогч иргэн өөрөө дугуйлна. Нам дугуйлахгүй. Өөрөөр хэлэх юм бол нам дугуйлахгүй. Хүн дугуйлна. Ийм холимог тогтолцоо юм. Нэг хэсэг нь аймгаасаа, тэр тойргоосоо сонгогддог байна. Нэг хэсэг нь бол улсын хэмжээнд нэг тойргоос сонгогддог байя гэсэн ийм жагсаалт юм. Энийг манайд гишүүд, ард түмэн бас зөв ойлгоосой гэж бодож байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол улсын хэмжээнээс тойргоос сонгогддог. Улс орны одоо хөгжлийн бодлого, улс орны үндэсний эрх ашиг энийг ярьдаг гишүүдтэй байхгүй бол 76 тойргоос, 76 жалга, довоос гишүүд, сонгогч нар зөвхөн тэр жалга дов руугаа, тэр сум руугаа, тойрог руугаа бүх хөрөнгө оруулалтыг боддог, татдаг. Тэрний эрх ашгийг бодож ажилладаг дахин сонгогдохын тулд. Өнөөдөр улс орны эрх ашгийг бодож ажилладаг гишүүд цөөхөн болчихоод байна.

Оюу Толгойн асуудал гээд одоо хааяа нэг хүмүүс ярьдаг. Тэгээд зөвхөн тэр тодрохын тулд л ярьдаг. Тэгвэл үнэхээр улс орноо боддог гишүүдтэй болчих юм бол үнэхээр ингэж шийдье, ингэж тийм шийдэл байна, ийм хууль ингэе гэдгээ ярих ёстой. Өрийн асуудал өнөөдөр ярьж байгаа. Монгол Улс өртэй, бөөстэй болчихлоо гээд. Тэгтэл тэрийг зүгээр тухайн үед яриад өнгөрдөг болохоос биш гараад за байж яаж нэг тойрогтой нэг жаахан хөрөнгө оруулалт хийчих үү, яаж нэг тойргийнхоо ард иргэдийн амьдрал ахуйд юм шийдчих үү гэдэг байдлаар ханддаг. Тэгвэл энэ улсын хэмжээнд нэг тойргоос сонгодог болчих юм бол энэ гишүүд нь бас улс орныхоо хэмжээний том бодлогын асуудалдаа анхаарал тавьдаг байх гэдэг үүднээс одоо холимог тогтолцоо буюу нам дугуйлдаг биш, хүн дугуйлдаг улсын нэг том тойрог байх энэ одоо том тогтолцоог Ардчилсан намын зөвлөлөөс хатуу шаардлага бидэнд тавьсан. Ингээд зөвшилцөөд оруулж ирж байгаа гэдгийг хэлье.

Дараагийн асуудал. Орон нутагтай холбоотой асуудлууд орхигдчихлоо гэж байгаа. Ер нь яах вэ дээ, анх бол Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслийг бид өргөн барихдаа сумын Засаг даргыг ард түмнээс сонгодог больё. Сумын Иргэдийн хуралд улс төрийн нам оролцохыг бас болиулъя. Аль болох жалга довондоо, тэр сумандаа, салаандаа, авгай нөхрөөрөө, ах дүү нараараа талцаж хуваагдаж улс төржихийг болиулъя гэсэн санал бас тодорхой

хэмжээгээр тусч байсан. Үүнийг яг өнөөдөр шийдэх ёстой асуудал биш юм байна. Сумын Засаг даргыг ард түмнээс сонгодог болчих юм бол ерөөсөө би одоо Их Хурлын гишүүнтэй, Монгол Улсын Ерөнхийлөгчтэй адилхан ард түмнээс сонгогдсон Засаг дарга учраас энэ сумандаа би одоо хаан нь, заан нь гээд одоо төрдөө удирдагдахгүй байх ийм асуудал үүсэж болзошгүй. Цаг хугацааны хувьд энийг бусад хуулиар зохицуулах бололцоо боломжийг нээлттэй үзье. Энийг бол нээлттэйгээр үлдээе. Үндсэн хуульдаа одоо тусгах шаардлагагүй. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дараа дагаж гарах хуулиараа шийдэх бололцоо, боломж бүрдэж болно гэдэг үүднээс хойшлуулсан байгаа. Өөрөөр хэлэх юм бол Үндсэн хуулийг баталсны дараа органик хуулиар тэр Нутгийн удирдлагын тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль бусад хуулиудаараа зохицуулаад энийгээ шийдчих бололцоотой гэж хойшлуулсан байгаа гэдгийг хэлье.

Нөгөө талаар Үндсэн хуульд бас Нутгийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх бас тодорхой заалтууд орсон. Тухайлах юм бол одоо 59.2 дээр аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй гэж оруулж ирж байгаа. Урд нь ийм заалт байдаггүй байсан. Өөрөөр хэлэх юм бол тодорхой хэмжээнд орон нутагт энийг дагасан эрх мэдэл шилжиж байгаа.

Мөн одоо бас нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно гэж оруулж ирж байгаа. Энэ маань үндсэндээ бас төвлөрлийг сааруулах, орон нутагт эрх мэдлийг шилжүүлэх нэг том боломжийг бий болгож өгч байгаа.

Дараагийн нэг асуудал, гол чухал асуудал бол 57.2 дээр бид нар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр хот, тосгон байгуулах боломжийг нээж өгч байгаа. 1992 оны Үндсэн хуулиар хаагдчихсан байсан, хот байсан Дархан, Эрдэнэт хотууд бүгд аймаг болчихсон. 21 аймгийн төв хот гэж нэрлэгддэг байсан бол сум болчихсон байсан. Сум болчихсон. Одоо бол буцаагаад 21 аймгийн төвийг хот гэж нэрлэх. Тухайлах юм одоо Ховд аймгийн төвийг Ховд хот гэж нэрлэх. Дархан-Уул аймгийг, Дархан сумыг Дархан хот гэж нэрлэх бололцоо, боломжийг энэ Үндсэн хуулиар нээж өгч байгаа. Мөн одоо бас тосгодыг бас тосгон болгох бололцоо, боломжийг нээж өгч байгаа. Ийм байдлаар үндсэндээ бас орон нутагт нутгийн удирдлагатай холбоотой зохицуулалтууд орж ирсэн байж байгаа. Өмчийн харилцаа, төсвийн удирдлага гээд түрүүн хэлсэн 59.2-т тодорхой эрх мэдэл шилжиж байгаа. Үүгээрээ бас өмнөх Үндсэн хуулиасаа илүү давуу талтай болж байгаа гэдгийг бас танд хэлье.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Нийгэм энэ хариуцлага, ёс зүйг хамгийн их хүсэмжилж байгааг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн зайлшгүй хийх ёстой гэсэн ард түмний энэ санал асуулгаар өгсөн хариултуудаас маш тодорхой харагдаж байгаа.

Тийм учраас одоо энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаараа бид намууд хэн их мөнгө төлснийг биш харин хэн хариуцлагатай, ёс зүйтэй байж хэлсэн ярьсандаа байдгийг сонгох энэ өөрөө Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр орох ёстой.

Бид нар тэр хэдэн хэлэлцүүлэг, ард иргэдтэйгээ уулзсан уулзалтууд, яг энэ чиглэлийн эрдэмтэн судлаачид, Монгол Ардын нам, Ардчилсан нам, МАХН, бусад намууд гээд үнэнийг хэлэхэд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийхэд оролцоогүй хүн улс төрийн намууд байхгүй гэж хэлж болно. Одоо тэгээд цаг нь болсон.

Иргэд хэлж байна лээ. Харин ч Их Хурал өөрөө энийгээ шийдээд ингээд батлах ёстой. Харин ард түмэн энийг хэлэлцүүлэг хийлээ, саналаа өглөө. Одоо та бүхнийг харж байна. Юуны төлөө 65 суудал өглөө. Юуны төлөө ард түмний төлөөлөл болсон парламент байгаа билээ. Энийгээ баталчихаач гээд иргэдтэйгээ уулзаж байхад надад лав тийм захиас өгсөн. Тийм учраас бид, энэ Их Хурал хариуцлагаа ухамсарлаж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө зайлшгүй хийх ёстой гэсэн байр сууриа юуны өмнө илэрхийлмээр байна.

Тэгээд хамгийн гол юм манай гишүүдийн ч гэсэн, ард иргэдийн санаа зовоод байгаа зүйл юу юм бэ гэхээр энэ нөгөө намын нэрийн ард листэд хавчуулагдаж нөгөө ёс зүйгүй, хариуцлагагүй Улсын Их Хурлын нэр хүндийг энэ сүүлийн 25 жил унагааж ирсэн ийм л хүмүүс дахиад Их Хуралд гараад ирэх вий дээ гэсэн болгоомжлолын үүднээс холимог тогтолцоог шүүмжлээд байгаа юм.

Тийм учраас энэ албаны хүмүүс маань ийм байдал гаргахгүй, ард түмэн нөгөө улсыг энэ 23.1 дээр заасан, 21 дүгээр зүйлийн 2 дээр заасан шигээ Улсын Их Хурлын гишүүдийг ард түмэн шууд сонгодог байх тэр агуулга маань өөрөө бат оршиж байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ч, Үндсэн хуулийн энэ заалтаараа ч гэдгийг тодорхой хариулт өгөхийг би хүсэж байна л даа.

Яагаад гэвэл өнөөдөр нэр хүнд нь муу, амласнаа, хэлсэн ярьсандаа байдаггүй. Тойрогтоо юм уу, улс орон даяар холимог ч бай мажоритар ч бай хэлсэндээ хүрдэггүй. Тэгээд дараа нь Улсын Их Хуралд гарахын тулд тойрог сольдог. Эсвэл янз бүрийн аргаар их хэмжээний мөнгө өгөөд гараад ирдэг энэ буруу тогтолцоо чинь, энэ буруу сонголт чинь өөрөө Монголын нийгмийн өнөөдөр туйлдуулж, ажилгүйдэл, ядуурал буурахгүй хүн амын гурав орчим хувь нь л тансаг баян амьдралтай. Дундаж давхарга гэж бараг байхгүй болчихсон. Ихэнх нь бас нэлээд хүнд амьдралтай байгааг бид өнөөдөр хүлээн зөвшөөрөөд Үндсэн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулъя. Энэ гажуудлыг засъя гээд. Засаглалын энэ гажуудлыг засъя гэж явж байгааг би үнэхээр хүлээн зөвшөөрч энд бол маш идэвхтэй оролцож байгаа.

Тийм учраас ч Ерөнхий сайд өөрөө танхимаа бүрдүүлдэг байя. Ерөнхий сайдад нь эрх мэдэл өгье. Харин Ерөнхий сайд нь танхимын сайд нартайгаа сайн ажиллаж чадвал сайн байна, чадахгүй бол хариуцлага тооцож чаддаг тэр механизмыг нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулаад өгье гэдгийг бид одоо энэ эмхэлж оруулж ирж байгаа нь бол маш

зөв юм. Үнэнийг хэлэхэд Улсын Их Хурал дэндүү их томилгоо руу ордог болсноос зөвхөн сайд, дарга нарыг юм уу, прокурорыг юм уу ямар нэгэн томилгоотой холбоотой асуудал орж ирэхэд 4 жилийн хугацаанд энэ нэг, хоёр гишүүн тэр үед л үзэгддэг. Бусад үед байдаггүй ийм юмыг би анх удаа жишээ нь олж харсан л даа. Ийм хариуцлагагүй байж болохгүй.

Тэгээд энэ жалга тойрсон гэхээс илүү тэнд ч гэсэн бас ард түмэн амьдарч байгаа учраас Улсын Их Хурлын гишүүн төлөөллийн л хүн энэ парламентад төлөөлж сууж байгаа юм чинь эрх ашгийн үүднээс хийх гэсэн юмаа хийх ёстой. Тийм хариуцлага, ёс зүй байх ёстой. Тийм ч учраас бид өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр парламентын чадавхыг сайжруулах, парламентаа бэхжүүлэх, Улсын Их Хурлын гишүүд хариуцлагатай байх. Хариуцлагагүй бол эргээд тэнд нь хариуцлага тооцож чаддаг ийм заалтуудыг нэмж оруулж ирж байгаа нь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бас нэг онцлог хэлэх ёстой зүйл гэж би бас харж байгаа. Тиймээс бид энийг бас дэмжиж байгаа.

Өнөөдөр олон нийттэй явдаг хүний хувьд бас маш их мэдээллүүдийг авч байгаа л даа. Биднээс Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг сайн хийгээд өгөөсэй, батлаад өгөөсэй гэж нийгэм бол харж байгаа. Одоо ч гэсэн энэ бид нарт ирж байгаа мессеж тийм л байна. Харин бид нар хамгийн гол нь энэ заалт маань нийгэмд шударга ёсыг тогтоох тэр хүсэмжлэлийг бий болгох тал дээр л анхаарах нь чухал байгаа.

Үнэнийг хэлэхэд хариуцлагатай байгаад хэлсэн ярьсандаа байдаг бол нэг жилийн дотор ч гэсэн Улаанбаатарын энэ сүүлийн 15, 20 жил явж ирсэн утааг арилгах бололцоо байгааг эхнээс нь бид харж байна шүү дээ. Өргөдлийн байнгын хороо тэр гүйцэтгэлийн аудитын хийгээд мөнгө санхүүг жишээлбэл зөвхөн энэ утаатай тэмцэхэд, хөрсний бохирдолтой тэмцэхэд зарцуулах ёстой юм байна гэдгийг гаргаж ирсэн Засгийн газар, Их Хурал, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Өнөөдөр утаа бас гайгүй болж байна. Хүмүүс хүлээн зөвшөөрч байна. Энэ өөрөө юу юм бэ гэхээр хариуцлагыг бид тооцож чаддаг, бас засаж чаддаг гэдгийг харуулж байгаа шүү дээ.

Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт дээр энэ мэтчилэн хариуцлага, ёс зүйтэй холбоотой асуудлуудыг бид хэр их нарийн тусгаж өгсөн бэ гэдгийг л нийгэм харна. Тэрнээс биш зүгээр нэг өөрчлөлт оруулахын тулд өөрчлөлт оруулаагүй гэдгийг би бас дахиж хэлмээр байна л даа.

Ялангуяа энэ дээр Засгийн газрыг эмхлэн байгуулахтай холбоотой асуудал, парламентын засаглалыг бэхжүүлэхтэй холбоотой асуудал, байгалийн баялаг нь цөөн хэдэн гэр бүлд, цөөн хэдэн хүнд очдог биш харин энэ бол Монголын нийгмийн ард түмний өмч шүү, төрийн өмч шүү гэдгийг бид бас энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр баталгаажуулж өгч байгаа маш сайн заалт энд орж байгаа. Энэ заалтыг бол нийгэм хүсэж байгаа. Яагаад вэ гэвэл ард түмэн сайхан байгалийн баялаг ард түмний өмч гэсэн хэр нь тэр ард түмэн нь энэ өмчөө эдэлж чадахгүй, цөөн хэдэн хүний гараар ороод алга болж байгаа жишээг бид өнгөрсөн хугацаанд маш сайн харлаа шүү дээ. Энэ алдааг засах гэж яаж их зовж байгааг бид нар ч харж байна. Энэ үүднээс л Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт орж байгаа гэдгийг би бас дахин давтаж хэлмээр байна.

Тэгээд энэнд тодорхой хариулт С.Бямбацогт гишүүн өгөхгүй юу. Энэ дээр юу юм бэ гэхээр тэр хариуцлага, ёс зүй. Зүгээр нэг сайхан мөнгөөр намууд, хэн их мөнгө өгсөн нь биш харин хэн сайн хариуцлагатай, ёс зүйтэй тийм хүнээ гаргаж ирэх бололцоог энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр гаргаж өгч чадаж байна уу, үгүй юу гэдэгт нэг тодорхой хариулт авахыг хүсэж байна.

Л.Энх-Амгалан: Байнгын хороон дарга С.Бямбацогт.

С.Бямбацогт: Энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд бид нар нийтдээ 24 зүйлийн 52 заалтыг хөндөхөөр Үндсэн хуулийнхаа оруулж ирсэн. Одоогийн байдлаар 19 зүйл 35 заалт хөндөгдөхөөр болж одоо ингэж багассан байгаа. Энд бас олон асуудлуудыг бас орхигдуулсан зөвшилцөөд, ойлголцоод хассан ийм зүйлүүд байгаа. Зарим зүйл дээр тодорхой бас нэмэлт орсон асуудлууд байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бас нэг гол онцлог бол Улсын Их Хурлын бас тодорхой хязгааргүй эрх мэдлийг хязгаарлаж байгаа. Тухайлах юм бол та сая хэллээ. Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүдийг томилдог, чөлөөлдөг, огцруулдаг ийм бүрэн эрхтэй. Энүүгээрээ одоо юу гэдэг юм сайд нарыг, Засгийн газрыг байнга дарамталдаг. Аятайхан байхгүй бол миний асуудлыг шийдэхгүй бол, эрх ашигт үйлчлэхгүй бол та нарыг бид нар огцруулна шүү гэдэг байнга тийм далдчуулсан байдалтай байдаг байсан бол энэ бололцоо боломжийг нь хааж өгч байна.

Хоёрдугаарт нь, Засгийн газарт төсвийг өргөн мэдүүлэхэд төсвийг юу гэдэг юм, өөр өөрсдийн тойрог руу дур зоргоороо чирээд алга болдог байсан бол тэгээд нөгөө төсвийн тогтвортой байдал, төсвийн орлого, зарлага, төсвийн алдагдал гээд энэ чинь бас улс орны эдийн засгийн асуудал гээд юм байж байгаа. Ийм юмыг орхигдуулдаг байсан бол энэ юмыг шийдэхээр бас тийм үү, Улсын Их Хурал өргөн мэдүүлсэн төсвийг дураараа өөрчлөхгүй байх, нэмэгдүүлэхгүй байх заалтыг Үндсэн хуульд суулгаж өгч байгаа.

Монгол Улсын хөгжлийн бодлого, урт хугацааны бодлого байх ёстой. Төр маань өөрийн гэсэн бодлоготой, тогтвортой тэр бодлого нь тогтвортой бололцоо боломжийг энэ Үндсэн хуульд суулгаж өгч байгаа.

1992 онд Үндсэн хууль баталж байх үед төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засаг, социализм, коммунизм гэдэг юмнаас хүмүүс татгалзсан. Түүн шиг буруу юм байдаггүй юм байна. Ерөөсөө л зах зээл эдийн засагт шилжих бүх юмыг л чөлөөтэй байх ёстой гэдэг ойлголтоор ерөөсөө төлөвлөгөө, төлөвлөх гэдэг асуудлаа хаясан байсан. Үндсэн хуулийн одоо нэг удаагийн, 1992 оны Үндсэн хуулийн сул тал нь энэ байсан. Үүнийг Монголын төр бас өөрийн гэсэн хар хайрцгийн бодлоготой байх ёстой. Монгол Улс бас тийм үү, өөрийн гэсэн бодлогод хөгжүүлэх хөтөлбөртэй, төлөвлөгөөтэй, хөгжлийн бодлоготой байх ёстой. Ингэж төрийн зохицуулалт, төрийн бодлого энэ явж байхгүй бол болдоггүй, хэтэрхий дураараа чөлөөтэй байж болдоггүй юм байна гэдгийг бас Үндсэн хуульдаа суулгаж өгч байгаа.

Улсын Их Хурлын гишүүдэд хариуцлага тооцох асуудал. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд сууж өгч байгаа. Улсын Их Хурлын гишүүд юу гэдэг юм, ерөөсөө л гэмт хэрэг үйлдэхээс бусад тохиолдолд хариуцлага хүлээдэггүй байсан бол одоо Үндсэн хуулиараа бид нар Үндсэн хууль зөрчсөн бол, өргөсөн тангаргаасаа няцсан бол Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах энэ бололцоо боломжийг нээж өгч байгаа. Ийм зохицуулалтууд орж ирж байгаа.

Таны сая ярьж байгаа асуудал дээр жагсаалтын гишүүд гээд байгаа. Жагсаалтын гишүүд, Намын жагсаалт гээд 2012 онд үнэхээр намын жагсаалт гэдэгт ард түмэн жаахан дургүй болсон. Дургүй болсон тэрэнд. Яг түүнтэй адилхан гэж ойлгоод байх шиг байна гишүүд маань. Ялангуяа манай шинэ гишүүд тиймэрхүү ойлголттой байх шиг байгаа юм. Энэ дээр улсын цолтой юу гэдэг юм, улс орон даяар ард түмнээ баясгадаг бөхтэй больё, тухайлбал Б.Бат-Эрдэнэ аварга тийм үү, ард түмнээ баясгаад олон жил улсын наадамдаа түрүүлээд, хүн болгон мэддэг, улсын хэмжээнд л барилддаг. Аймгийн наадамд очиж барилддаггүй. Ийм улсын хэмжээнд улс нэг тойргоос сонгогддог гишүүнтэй больё гэж байгаа юм. Аймгаас сонгогддог, тойргоос сонгогддог гишүүд нь аймгийн наадамд барилддаг бөхтэй адилхан аймгийнхаа ард түмнийг баярлуулдаг, аймгийнхаа эрх ашгийн төлөө дуугардаг ингээд л тойргийнхоо эрх ашгийг хамгаалдаг ийм бөхтэй байя гэдэг л тийм асуудал яригдаж байгаа юм ер нь бол.

Одоо манай Ховд аймагт Б.Ичинхорлоо гэж арслан байсан. Зууны манлай аймгийн арслан, 10 удаа аймгийн наадамд түрүүлсэн. Улсын наадамд ирж барилдахаараа 3 давдаг, 4 давдаг. Улсын цол хараахан авч чадаагүй. Тэгвэл ийм байдлаар улсын хэмжээнд улсад нэг тойргоос сонгогддог гишүүд тэд нар улс орны эрх ашиг, улс орны том бодлого ярьдаг байя. Аймгаас сонгогддог, тойргоос сонгогддог гишүүд байя.

Тэр жагсаалт гэж яриад байгаа нь ноёны бөх барилдахгүйгээр давдаг, барилдахгүйгээр түрүүлдэг, үзүүрлэдэг, тэр ноёны бөх гэдэг жагсаалт юм байхгүй. Тэр улсын хэмжээнд нэр дэвшүүлээд намын жагсаалтаас, тэд нараас нь барилдаад одоо нэр дэвшээд тэгээд түрүүлдэг хүмүүсийг л байя гэдэг. Хүнийг нь сонгодог байя. Ийм бас ялгаа байгаа юм. Зүгээр жирийн иргэд ойлгогдохоор хэлэх юм бол ийм байдлаар л улс нэг тойргоос сонгогддог гишүүд байх нь. Нэг хэсэг нь намын жагсаалтаар. Гэхдээ тэр жагсаалт дундаас хүнийг нь сонгодог. Нам сонгодог биш, нам дугуйлдаг биш. Нөгөө нэг хэсэг нь аймгаасаа, тойргоосоо сонгогддог ийм холимог тогтолцоо байя гэдэг саналыг Ардчилсан намын зөвлөл маань холимог тогтолцоог байнга санал тавьсан. Гэхдээ бид нар холимог тогтолцоог оруулж ирэхдээ нам дугуйлдаг тийм үү, намыг сонгодог ийм жагсаалт биш. Хүн сонгодог, хүн дугуйлдаг ийм тогтолцоог оруулж ирж байгаа гэдгийг бас өмнөх 2012 оныхоос ялгаатай гэдгийг дахиад хэлъе.

Л.Энх-Амгалан: М.Оюунчимэг гишүүн тодруулъя.

М.Оюунчимэг: Миний давтан давтан хэлээд байгаа нь хариуцлага, ёс зүйтэй холбоотой энэ асуудал нийгмийг хүсэмжилж байгаа учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр үүнийг баталгаажуулж өгч байгаа гэдгийг л хэлээд байгаа юм.

Энэ дээр Улсын Их Хуралд орсон шинэ гишүүд хувьсгал хийсэн шүү. Шинэ гишүүд ойлгохгүй байгаадаа биш. Энэ 15, 20 жил явж ирсэн парламент доторх энэ бугласан юмыг нийгэм шүүмжлээд ямар түвшинд муухай хүрчхээд байгаа билээ. Харин энэ парламент бол өөрчилж болдог юм байна. Улсын Их Хурлын гишүүнд эргээд хариуцлага тооцдог юм байна. Одоо бас идэж уух, эсвэл компанийнхан янз бүрийн хувийн юм хийгээд яваад байдгийг хийж болохгүй юм байна гэдэг энэ сигналыг Улсын Их Хуралд орсон шинэ гишүүд өгч чадсан.

Тийм ч учраас өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг гишүүд маань дэмжээд харин ч бүр идэвхтэй оролцоод явж байгаа. Нийгэмд эд нарыг ч дэмжиж байгаа. Үүнийг би маш сайн хэлье гэж бодож байна.

Тэгээд хөгжлийн бодлоготой холбоотой заалт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд зайлшгүй орох ёстой саналыг миний бие Эдийн засгийн байнгын хороон дээр манай 5 гишүүний хамт, одоо Б.Баттөмөр гишүүн энд сууж байна, Д.Тэрбишдагва гишүүн, манай Ж.Ганбаатар гишүүн гээд, С.Бямбацогт гишүүн гээд бид нар бүгдээрээ. Б.Ундармаа гишүүн. Ингэж оруулж ирсэн. Энэ маань тусгагдаад явж байгаа нь өөрөө ер нь эдийн засаг, нийгмийн хувьд ч, улс төрийн хариуцлагын хувьд ч гэсэн энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр бид бас хувьсгал, өөрчлөлт хийж байгаа шүү гэдгийг бид хэлээд байгаа юм.

Тэрнээс биш хэн нэгэн ноёны бөх ордог ч гэдэг юм уу иймэрхүү маягийн жишээ бас арай л зохицохгүй л дээ. Хэн хариуцлагатай нь, хэн чадалтай нь нас үл харгалзан парламентын танхимд суугаад, харин зөвхөн Их Хурлын гишүүний ажлаа сайн хийдэг байх ёстой гэдэг үүднээс асуудалд хандаж байгаа гэж байгаа. Тиймээс Их Хурлын гишүүд маань Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө цаг алдалгүй батална гэдэгт итгэлтэй байна.

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: М.Оюунчимэг гишүүний санал, асуултад хариулахад ингэж байна шүү дээ. Бүх шатанд хариуцлага, хяналт тэнцэл, тэгээд тогтвортой байдал гэсэн ийм л үзэл баримтлал дээр зангидагдаж хийгдэж байгаа.

Тэгэхээр энийг тайлбарлавал их олон цагийн яриа болох учраас тийм үү, нөгөө бидний 19 зүйлд оруулсан энэ заалт болгон цаанаа хариуцлага. Эцсийн эцэст хариуцлага. Тэгээд хяналт тэнцлийг зөв болгох. Тэгээд тогтвортой байдлаа хангаад улс орноо урагшаа хөгжүүлээд аваад явах энд л чиглэж байгаа юм.

Хоёр дахь нь, бид бол энэ ардчиллыг гүнзгийрүүлж байгаа гэж бодож байгаа. Ардчилал гэдэг нэрийг их гутаалаа л даа сүүлийн үед бид нар. Ер нь хариуцлага сулрахаар чинь ардчиллын нэр хүнд одоо унадаг юм байна шүү дээ.

Тэгэхээр бид энэ сонгосон замаасаа ухрахгүй. Харин энийг засаад урагшаагаа явах ёстой юм гэж. Энэ дээр сүүлийн үед нэг шүүмжлэл, олон

улсын байгууллага энэ тэр ч орчуулга энэ дээр буруу ташаа ойлгодог юм уу. Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллага гэдгээс бас нэг зөвлөмж юм уу, шүүмжлэл юм уу ирсэн гээд байгаа юм. Тэр нөгөө нэг хувь. Тийм ээ. Одоо 20 мянган хүн гишүүнтэй байж нам байгуулна. Энэ бол ухралт. Ардчиллын юу байна энэ тэр гээд. Ийм шүүмжлэлүүд гараад байдаг.

Тэгэхээр бид өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хорооны хурал дээр ярьсан. Энэ бол жишээ нь энэ асуудал бол 2020 оны сонгуулиар шийдэгдэхгүй. Улс төрийн намын хууль гараад бүртгэлийн асуудал бол жич яригдах юм гээд. С.Бямбацогт дарга хариулт өгсөн шүү дээ өчигдөр.

Хоёрдугаарт, энд ийм заалт байгаа байхгүй юу. Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас нь доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна гэж. Энэ бол хатуу гишүүн... /минут дуусав/

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүнд нэмж 1 минут.

Д.Лүндээжанцан: Хатуу гишүүнчлэлийг хэлж байна уу, дэмжигчдийг хэлж байна уу гээд. Жишээ нь, Л.Болд гишүүн, Ж.Батзандан гишүүн ШИНЭ нам бол эхлээд юугаар аваад биз дээ. Тийм үү. Дэмжигчдийнхээ саналыг цуглуулсан биз дээ.

Тэгэхээр энэ бол гишүүн дэмжигчид гэдэг утгаар анх байгуулагдахад тийм үү энийг яах вэ гэдэг асуудал улс төрийн намын хуулиар тодорхой болоод суугаад өгөх юм. Тэрнээс биш иргэдийнхээ эвлэлдэн нэгдэх эрх чөлөөнд халдаад, яг тэдэн хүн хатуу гишүүнчлэлтэй байж одоо яана гэдэг асуудал бол бас нэг тийш нь туйлшруулж ойлгож болохгүй. Энийг болохоор улс төрийн намынхаа хуулиар зохицуулаад иргэдийнхээ эвлэлдэн нэгдэх эрхийг хангаад явах боломжтой юм гэж ингэж хэлэхийг хүсэж байна.

Л.Энх-Амгалан: Л.Болд гишүүн.

Д.Болд: Баярлалаа. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хамгийн хариуцлагатай хэлэлцүүлэг дээрээ явж байна.

Энэ нэмэлт, өөрчлөлт олон парламент дамжсан. Парламент бүрийн нэмэлт, өөрчлөлтийг боловсруулах ажлын хэсэгт миний хувьд орж ажиллаж байсан. Тэр бүгд дээр маш тодорхой асуудлууд дээр очоод Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бүтэлгүйтэж байсан. Үүнд жишээ нь миний хувьд байнга эсэргүүцэж байсан асуудлын нэг бол энэ Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодоггүй болгох оролдлого байнга хийгдэж байсан. Энэ бол болохгүй гэдэг дээр.

Дээр нь сумын Засаг даргыг ард түмнээс сонгодог болох. Энэ бол өөрөө нэгдмэл бүрэн эрхт Монгол Улсын хувьд үнэхээр үр дагаврыг олон талаас нь тооцож үзэх ёстой. Сумын иргэдийн гэхээсээ илүү компанийн засаг дарга нар тодорхой хэсэг, бүлэглэлүүдийн Засаг дарга нар шат шатанд олон гарах аюул гээд. Иймэрхүү асуудлууд дээр бид нэлээн зөрчилдөж байсан юм.

Эдгээр асуудлууд бас нааштай ойлголцсоны үр дүнд энэ удаагийн Үндсэн хуульд нэлээн хэдэн өөрчлөлтүүд орох гэж байгаа. Эдгээрийг

түрүүчийн хоёр дахь хэлэлцүүлэгт бид авах гээхийн ухаанаар харилцан ойлголцоод явж байгаа. Хамгийн гол нь нэгэнт ард нийтээс санал асуулга явуулах асуудлыг больсон учраас бид гишүүн бүр тойрогтоо ажиллаж, ард түмний сонгогчдын саналыг нэг бүрчлэн авсан. Ялангуяа одоо батлагдаад байгаа 35 нэмэлт, өөрчлөлт, мөн шинээр Ардчилсан намын саналаар орсон 3 саналыг бид нэг бүрчлэн хэлэлцүүлсэн. Миний хувьд яармагийн 4-өөс 8 дугаар хороо бүр дээр уулзалтууд хийж, хороо бүрд, асуудал болгоныг танилцуулж, хэлэлцүүлж санал хураалгасан.

Энэ дээр маш ойлгомжтой саналыг гаргасан. Одоо жишээ нь Ерөнхий сайдад Засгийн газраа бүрдүүлэх бүрэн эрхийг нь олгоё гэдэг. Энд би хувь хүний хувьд эсрэг байдаг. Энэ бол бидний социализмын үед байсан тогтолцоо. Одоо эргээд ардчиллын үед парламентын хяналт Засгийн газрын гишүүдийн түвшинд байна гэдэг бол ерөөсөө тийм муу зүйл огт биш. Монголд боломжийн хэрэгжээд явах ёстой зүйл гэж хардаг.

Гэсэн хэдий ч түрүүчийн Их Хурал, түрүүчийн Засгийн газар бүрэлдэхэд бид нар хэд хэдэн сайд нарыг буцааж байсан байхаа. Хэрвээ Ерөнхий сайдын мэдэлд байсан бол тэр буцааж байсан сайд нар чинь бүгд шууд томилогдоно шүү дээ. Гэх мэтчилэнгээр бидний өөрийн түүхэн сургамж байгаа юм.

Гэхдээ ард иргэд 100 хувь энийг дэмжиж байна билээ. Ард түмэн мэдээлэлтэй байна. Тодорхой ойлголттой байна. Нөгөө хоёр санал дээр 100 хувь санал хураахад заал дүүрэн 100 хувь таван удаагийн уулзалтад тавууланд нь эсрэг өгч байна билээ. Энэ юу гэхээр Ерөнхийлөгчийг Их Хурлаас сонгох. Энийг хэзээ ч зөвшөөрөхгүй гэдгийг өгч байна.

Хоёрт нь сонгуулийн холимог тогтолцоо. Ингээд ШИНЭ намын хувьд бол бид нар анхнаасаа хийсэн. Бид ард иргэдийн хөдөлгөөнөөс үүссэн нам гэхээсээ илүү олон түмний эвсэл, хөдөлгөөн. Тийм учраас бид гаргаж байгаа аливаа шийдвэрээ ард түмнээс л асуудаг. Ард түмэн өнөөдөр ард иргэд бидний санал асуулгад оролцож байгаа иргэд сонгогчид юу гэж үзэж байна тэр бол бидний өнөөдрийн гаргаж байгаа шийдвэрийн хамгийн гол мөрдлөг болгодог удирдлага болгодог зүйл.

Тэгээд ард түмэн үнэхээр маш их мэдээлэлтэй байна. Маш их, улс төрийн хувьд маш их хэрсүүжсэн байна. Дахиж хэзээ ч алдахыг хүсэхгүй байна. Сонгуулийн тогтолцоонд гишүүд энэ хоёр өөр зарчимтай гишүүд гарахыг бол үнэхээр болохгүй гэдгийг ард түмэн бид нараас илүү мэдэрсэн байна шүү.

Дээрээс нь, одоо Байнгын хорооны дарга С.Бямбацогт дарга бол бас их буруу тайлбарлаж байна. Энийгээ бол яах вэ одоо зөвшилцлийн үр дүн гээд хамгаалж болно л доо. Тэгтэл бөхөөр харьцуулаад л, энэ нь одоо улсын хэмжээний бөх юм, энэ нь аймгийн начин гээд. Тийм ээ. Энэ бол болохгүй л дээ.

Бид парламент гэдэг бол гишүүн болгон адилхан эрхтэй. Тийм учраас хоёр өөр зарчмаар сонгох дээр энэ алдагдчихаад байдаг байхгүй юу. Тийм учраас сонгуулийн хууль хийхэд Б.Чимид гуай бид хоёрын одоо тэр ажлын

хэсэг байгуулаад олон жил сараар, тэр 7 сарын 01-ний сургамж дээр хийсэн хуулийн бүхэлд нь одоо давхар өргөн бариад ерөнхийдөө яг тэр хууль өнөөдрийг хүртэл ингээд өвлөгдөөд явж байгаа шүү дээ.

Ганцхан заалтыг нь юу өөрчилсөн бэ гэхээр яг тэр тойрог дээр нь аваачаад хоёр өөр болгож хаяад. Ингээд энэ бол өөрөө 2012 оны үнэхээр хар мөртэй хууль болсон л доо. Бүх саналыг нь авчхаад яг хамгийн гол тойрог дээр яг гишүүн бүр адилхан байх ёстой гэдгийг нь өнөөдрийг хүртэл энэ дээр бүрэн нэгдмэл ойлгож бий болж чадахгүй яваад байгаа. Гэхдээ одоо хоёр том нам нь өнөөдөр зөвшилцөөд, Ерөнхийлөгчтэй зөвшилцөөд энэ дээр холимгийг ядахдаа харанхуйгаар нам биш. Тийм ээ. Олон гишүүд энэ асуудлыг ярьсан. Яагаад энэ болохгүй гээд.

Нам дотроо тэр намыг төлөөлж байгаа хүнийг нь сонгох. Өөрөөр хэлбэл иргэн шууд төрийн төлөөллөө сонгох тэр Үндсэн хуулийн эрхийг хүндэтгэхгүй байх. Тэр эрхийг нь хангах асуудлаар ингээд тодорхой заалт орж байгаа учраас ШИНЭ намын зөвлөл бид зөвхөн энэ зөвшилцлийн хүрээнд л хүндэтгэж, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт яваасай гэж цаад олон энэнээс чухал ач холбогдолтой заалтууд яваасай гэж л бид түр зуурын гэх юм уу, аргагүй эрхэнд ийм буулт хийгээд явж байгаа юм.

Гэхдээ мэдээж хэрэг энэ бол их сайн зүйл биш. Гэхдээ энэний цаана хамгийн аймшигтай юу гэхээр хэрвээ бид энэ Үндсэн хуулийн өөрчлөлт унах юм бол бид 20 гишүүн нэгдээд ШИНЭ намын саналаар баялгийн заалттай стратегийн ордуудаа ард түмэн эзэмших, үр ашгийг нь хүртэх тэр заалт давхар унах учраас. Тэгээд энэ баялгаа Монголын ард түмэн бүрмөсөн алдсан энэ нөхцөл байдал цаашаа үргэлжлэх. Ер нь Монгол Улс нэлээд тийм уруудах зам руугаа орох учраас одоо энэтэйгээ балансжуулж дэмжиж саналаа өгсөн.

Гэхдээ өнөөдөр ажлын хэсгээс нэг зүйлийг асуухад, Байнгын хорооноос. Түрүүчийн тэр 35 заалт дотор 20 гишүүний саналыг дэмжээд тэр баялгийн заалт, тэр стратегийн ордтой холбоотой тэр дөрөв дэх өгүүлбэр батлагдсан шүү дээ. Хоёрдугаар хэлэлцүүлгээр. Тэгсэн одоо энэ гуравдугаар хэлэлцүүлэг дээр бас дахиж санал хураах болчихоод байгаа юм. Энийг би ерөөсөө ойлгохгүй байна.

Яагаад тэр 35 заалтаас гэнэтхэн зөвхөн энэ баялгийн заалтыг сугалж авч одоо энэ чуулганаар дахиж санал хураалгах гээд байна. Энэний цаана заль мэх явж байгаа юм биш биз. Өөрсдийнхөө энэ холимог тогтолцоо, элдэв төрийн панз наймааг багтааснаа яг түүн дээр нь очоод буруу тийш нь хууран мэхлэх ажил явуулах юм биш биз гэж үнэхээр айж байна. Тэгэхээр энэ санал хураалт ямар учиртай болохыг тайлбарлаж өгнө үү.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга С.Бямбацогт гишүүн хариулах уу.

С.Бямбацогт: Тэгэхээр сонгуулийн тогтолцоотой холбоотой асуудал дээр би бас дахиад С.Болд гишүүнд тайлбарлаад хэлэх нь зөв болов уу гэж бодож байгаа юм.

Ер нь мажоритар тогтолцоо буюу олонхын тогтолцооноос сонгогчдын санал маш их гээгддэг. 5 хүн оролцох юм бол 28 хувиас дээш нь санал авсан хүн буюу одоогоор 30 орчим хувийн санал аваад л Их Хурлын гишүүн болдог. Цаад талд нь 70 хувь нь өөр хүмүүс санал өгсөн байдаг. Нөгөө талдаа холимог. Бид нарын ярьж байгаагаар пропорционал. Пропорционалаар сонгогчдын санал гээгддэггүй. Тэгээд сонгогчдын санал гээгдэхгүй байх арга талыг бодъё. Ингэхдээ нам дугуйлдаг биш хүн дугуйлдаг байя гэдэг саналаар томъёолол орж ирж байгаа.

Түрүү ярьсан. Аймгийн түвшний асуудал ярьж байна. Улсын түвшний асуудал ярьдаг. Одоо хоёр өөр түвшний асуудал ярьдаг гишүүдтэй болох гэж байгаа юм биш үү гэдэг ойлголт явж байх шиг байна. Тийм бол биш.

Ер нь хаанаас сонгогдоно тэр сонгогдсон иргэдийнхээ төлөөллийг, эрх ашгийн төлөө л ажилладаг. Улсын Их Хурлын гишүүний үүрэг бол үндсэндээ тэр сонгогдсон ард иргэдийнхээ эрх ашгийг төлөөлөх үүрэгтэй.

Бүтэн томсгосон тойргоос, аймгаас сонгогдох юм бол тэр аймгийнхаа эрх ашгийн төлөө ажилладаг. Аймаг дотроо 3 хуваагдаад 3 тойрог болоод явах юм бол тэр тойрог тойргийнхоо иргэдийн эрх ашгийн төлөө ажилладаг. Угаасаа ингээд яваад ирсэн.

Тэгээд улс орныхоо бодлогын асуудлыг ярьдаг ч гэсэн нэгдүгээрт нь тойргийнхоо эрх ашгийг ярьдаг энэ хандлагыг өөрчилъё гэж байгаа юм. Улсын хэмжээнээс улсад нэг тойргоос сонгогдсон гишүүд улс орны том бодлогын асуудлыг ярья. Энийг нэгдүгээрт тавьдаг байя. Энэ хандлагын төлөө ажиллана, энэ хандлага ингэж өөрчлөгдөнө. Бусдаар Их Хурлын гишүүн болгон адилхан эрхтэй, адилхан үүрэгтэй, адилхан эрх мэдэлтэй. Аймгаас сонгогдсон нь бага эрх мэдэлтэй, улсаас сонгогдсон нь одоо юу гэдэг юм улс нэг тойргоос сонгогдсон нь их эрх мэдэлтэй гэсэн утгаар биш шүү. Энийг энэ талаас нь ойлгоорой.

Тэгээд шууд Үндсэн хуульд заасан нь шууд сонгоно. Хүнийг ч шууд дугуйлж сонгоно. Нам дугуйлж сонгохгүй. Жагсаалт гээд холимог болгох гэж байна. Намын ард нуугдах гэж байна гэдэг байдлаар битгий мушгиж тайлбарлаж ойлгоосой гэдгийг дахиж хэлье.

Дараагийн асуулт. Тэр баялгийн, байгалийн баялгийн өгөөжийг ашиглахтай холбоотой. Энэ заалт явж байгаа. Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол батлах үед энэ заалтаар санал хурааж сүүлд оруулсан. Ард нийтийн санал асуулга явуулах дээр Ерөнхийлөгч хориг тавиад энэ одоо гурав дахь хэлэлцүүлэг орж байгаа учраас Байнгын хороогоор өчигдөр санал хураагдсан. Энэ заалтыг чуулган дээр бас дахин санал хураана. Санал хураана.

Ингэхдээ байгалийн баялгийн үр өгөөж гэдэг ойлголтыг анх ярьсан тэр зарчмаараа. Нийгэмд бас буруу ойлголт яваад байх шиг байгаа юм. Үр өгөөж гэдэг утга нь үр ашиг гэдэг утгаараа ойлгогдоно шүү дээ гэж. Үр өгөөжийг бид нар анх ярьж байсан. Татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг буюу нийгэм эдийн засгийн үр өгөөж гэсэн өргөн утгаар нь ойлгож оруулна гэж ард

нийтийн санал асуулга явуулах үед энийг тайлбарлаж бид санал хураалгасан. Яг энэ зарчмаараа явна.

“Дийлэнх” гэдэг үгийг бид нар бас бичгээр, тоон утгыг бичгээр илэрхийлдэг тэр агуулгаар биш. Тийм үү. Олонх гэх юм бол 51-ээс дээш, дийлэнх гэх юм бол 66-аас дээш, үнэмлэхүй гэх юм бол өөр дээшээ явдаг энэ утгаар нь биш ээ. “Дийлэнх” гэдэг үгийг бид нар 50 дээр нэмэх нь 1 гэдэг утгаар нь ойлгоно гэж ярьж байгаа энэ агуулгаар нь өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хорооноос санал хураасан.

Ер нь үр өгөөжийн дийлэнхийг гэдэг үгийг үндсэндээ үүгээр чинь ерөөсөө л байгалийн баялгийг стратегийн ордыг ашиглах дээр дандаа төрийн өмч давамгайлсан компани байгуулаад төр бүгдийг мэддэг болох юм байна. Хөрөнгө оруулагч ерөөсөө хөрөнгө оруулчхаад хажуугаас нь хараад сууж байх юм байна гэсэн ойлголт байх шиг байна. Тийм бол биш.

Тэр өмчлөл дээр бол мэдээж хөрөнгө оруулж байгаа хувь хэмжээгээрээ өмчлөөд явна. Үр өгөөжийн “дийлэнх” гэдэг маань тэр нийгэм, эдийн засгийн гэдэг утгаараа, том агуулгаараа татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг гэсэн агуулгаараа явна гэдэг байдлаар ойлголцож өчигдөр бас Төрийн байгуулалтын байнгын хороон дээр дахиж санал хураагдсан. Одоо чуулган дээр бас яг энэ агуулгаараа дахиж санал хураагдана. Энэ агуулгаар нь бид цаашдаа дэмжигдээд явах юм бол органик хууль буюу Үндсэн хуулиас урган гарах салбарын үндсэн хуульчилсан хуулиудтай яг энэ агуулгаар нь суулгаж өгөх ёстой гэдгийг хэлье.

Л.Энх-Амгалан: Л.Болд гишүүн 1 минут тодруулъя.

Л.Болд: Тэгэхээр өнөөдөр гишүүд энэ баялгийн заалт дээр ямар ч эргэлзээгүй бичсэн утгаар нь дэмжээд явна гэдэгт найдаж байна. Энэний цаана бид олон янзын баялаг биш, яг л стратегийн орд гэдэг бол өнөөдөр Монголын ард түмэн энэ 3 их наяд долларын үнэлгээтэй ордоос ард түмэн иргэн бүрд сая долларын хувь ногдохоор байгаа. Тэгэхээр энийг хэрэгжүүлэх энэ зам нээгдэж байна гэж нэг мөр ойлгож байгаа.

Энэний эсрэг маш том хөдөлгөөн зориудын мушгин гуйвуулах, бид нар руу дайрах ажлууд нэлээд хийгдэж байгаа. Тэгэхдээ ард түмэн бол асуудал санал нэг талдаа байна билээ. Энэ дээр бол ямар ч эргэлзээ байхгүй байна билээ гэдгийг хэлмээр байгаа юм. Нэг тодруулах зүйл гэвэл одоо маш олон байгууллагууд, олон улсын шинжээчид ч гэсэн санаа зовж байгаа. Түрүүн гишүүд бас дурдсан. Энэ намын гишүүнчлэлийг 20 мянгаас доошгүй гэсэн энэ асуудлыг... /минут дуусав/

Л.Энх-Амгалан: С.Бямбацогт гишүүн хариулах уу. Намын гишүүнчлэлийн асуудлаар.

С.Бямбацогт: Тэр улс төрийн намын гишүүнчлэлтэй холбоотой асуудлыг бас ер нь улс төр судлаачид, улс төрийн намууд санал хүсэлт тавьж байгаа. Эргэж хараач гэсэн. Энийг ч зөвшилцлийн ажлын хэсэг дээр эргэж харъя гэдэг саналыг оруулсан боловч харамсалтай нь хэт их олон асуудал болоод Үндсэн хууль маань задарчих ийм эрсдэл байгаа учраас энийг эргэж

харах боломжгүй гэдэг байдлаар зөвшилцлийн ажлын хэсэг дээр ярьсан байгаа.

Ер нь яах вэ, улс төрийн намууд маань өнөөдөр олон намууд байгуулагдсан, үйл ажиллагаа нь тодорхой бус, тодорхой юу гэдэг юм сонгууль болохоор л гараад ирдэг, сонгуулийн бус үед алга болчихдог. Энэнээсээ болоод улс төрийн намуудын явуулж байгаа үйл ажиллагаа, мөрийн хөтөлбөр, үзэл баримтлал нь энэ ойлгомжтой биш ийм байдлаар улс төрийн намуудын нэр хүнд олон түмэнд маш их унасан. Улс төрийн намуудад итгэх итгэл ард иргэдийн итгэл маш их буурч байгаа.

Тийм болохоор улс төрийн намуудад тавьдаг шалгуурыг бас өндөрсгөө, бас нэг зарчимтай, бас өөрийн гэсэн үзэл баримтлалтай, бодлоготой, түүндээ нийцсэн үйл ажиллагаа явуулдаг байх ёстой. Энэ бол хувьцаат компани биш. Энэ бол зүгээр нэг төрийн бус байгууллага биш. Улс төрийн намаар дамжиж төрийн эрхийг сонгуульд оролцож, төрийн эрхийг барих ийм үндсэн онцлогтой учраас улс төрийн намуудад тавигдах шалгуур шаардлага өндөр байх ёстой гэдэг агуулгаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс улс төрийн намуудад 50 мянгаас дээш гишүүнчлэлтэй бол улс төрийн намыг бүртгэнэ гэсэн заалтыг Үндсэн хуульд оруулъя гэж орж ирсэн. Улсын Их Хуралд хэлэлцэх хэлэлцүүлгийн явцад сонгогчдын нэг хувь буюу 20 орчим мянган дэмжигчтэй болъё гэдэг агуулгаар. Гишүүнчлэлтэй биш дэмжигчтэй болбол гэдэг агуулгаар Үндсэн хуулийн төсөл дээр сууж явж байгаа.

Энийг цааш цаашдаа бид бас аль болох уян хатан байх. Энд сонгогчдын иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхэнд халдсан зүйл байхгүй. Тодорхой шалгуур л тавигдаж байгаа. Энэ тийм хатуу гишүүнчлэлийн асуудал яригдаагүй. Энд эвлэлдэн нэгдэх бололцоог хаахгүйгээр дэмжигчдийн асуудлыг бас ярих байдлаар органик хуульдаа бид зохицуулж явах бололцоотой гэж үзэж байгаа.

Д.Энх-Амгалан: Х.Нямбаатар гишүүн.

Х.Нямбаатар: Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг судлах ажлын хэсгээс эхлээд энэ ажилд оролцсон.

Бид нар энэ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад гурван том уриа лоозон дэвшүүлж өнөөдрийг хүртэл явж байгаа. Нэг нь “хариуцлага”, “хяналт тэнцэл”, “тогтвортой байдал” гэсэн ийм гурван зорилгын хүрээнд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт маань хийгдэж байгаа.

Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хоёрдугаар хэлэлцүүлгээр босго давсан олон зөв зүйтэй, улс орны хөгжлийг түргэтгэх, төрийн тогтвортой байдлыг хангах, ийм олон зохицуулалтууд бас батлагдах яг босгон дээр ирээд байна. Тухайлбал баялгийн тэгш хуваарилалт, түүний үр өгөөжийг ард түмэнд хүртээх, төрийн эрх мэдлийн хуваарилалтыг боловсронгуй болгох, парламент нь парламентынхаа ажлыг хийдэг, гүйцэтгэх засаглал Засгийн газар нь Засгийн газрынхаа ажлыг хийдэг, шүүх эрх мэдлийн байгууллага нь улс төрөөс хараат бус ангид байх, Ерөнхийлөгчийн эрх мэдлийг хуулиар хязгаарлах, орон нутгийн бие даасан байдлыг хангах, хот суурин газруудыг цаашид засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн зарим

чиг үүргийг авах үндсэн дээр илүү хурдацтай хөгжих, түүндээ түшиглэсэн төсвийн хуваарилалтыг хийх гэх зэрэг ийм олон дэвшилтэт ийм зохицуулалтууд орж ирж байгаад их баяртай байгаа.

Миний бие хоёр зүйл дээр их харамсаж байгаа. Нэгдүгээрт, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг ард нийтийн санал асуулгаар явуулна гэдэг амлалтыг бид өгсөн. Хоёрдугаар хэлэлцүүлгийн дараа ард нийтийн санал асуулгаар явуулах тогтоолоо баталсан. Харамсалтай нь хориг тавигдаж, хоригийг хүлээж авч, ард нийтийн санал асуулга явуулах энэ зам үндсэндээ хаагдсан. Ийм олон дэвшилттэй цаашид бид нарын хөгжилд саад чөдөр тушаа болж байгаа асуудлуудыг шийдэж байгаа зохицуулалтууд байгаа учраас гуравдугаар хэлэлцүүлгээр батлахыг дэмжиж байгаа.

Миний хоёр дахь ихэд харамсаж байгаа зүйл бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг парламентаас сонгох, парламентын засаглалыг төгс төгөлдөр болгох энэ санал маань хоёрдугаар хэлэлцүүлэг дээр унасан.

Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороон дээр миний бие дахиж санал хураалгасан. Төрийн байгуулалтын байнгын хороон дээр 55.3 хувиар миний саналыг дэмжсэн Төрийн байгуулалтын байнгын хорооныхоо гишүүддээ талархлаа илэрхийлье.

Цаашид энэ асуудал бидний шийдээгүй ийм цаашид шийдэхээр асуудал болж үлдэж байгаа. Энэ хэлсэн, хураалгасан саналууд мэдээж хэрэг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн протоколд өөрөө тусгалаа олж үлдэж байгаа.

Хөгжсөн улс орнуудын засаглалын хэлбэр бол маш тодорхой. Парламентын засаглалтай сонгодог парламентын засаглалтай улс орнууд өнөөдөр хөгжсөн энэ улс орнуудын тэргүүлж байгаа.

Тэгэхээр манайх шиг газар зүйн байршил, хоёр хөршийн дунд байдаг улс орны хувьд энэ засаглалын хэлбэрээ цаашид хэрхэх вэ гэдэг асуудал бидний өмнө бас ингээд асуулт болж үлдэж байгаа шүү гэдгийг бас өнөөдрийн Үндсэн хуулийг хэлэлцэж байгаа яг энэ цаг үед хэлмээр байгаа.

Бид энэ засаглалын хэлбэрээ тодорхой болгосон бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөс бид нар бүр илүү их зүйлийг хүлээх байсан. Бүр их илүү зүйлийг. 2020 онд парламентын сонгууль явна. Маш олон зүйлийг бид иргэд, сонгогчдодоо улс төрийн намууд амлана, 2021 онд Ерөнхийлөгчийн сонгууль явна. Түүнээс дутуугүй зүйлийг амлана. Нөгөө жаахан эдийн засгаа сонгуулиас сонгуулийн амлалтын дунд бид нар үрэн таран хийдэг. Эргээд өрнөөс өрөнд явдаг энэ засаглалын гажуудал гүйцэд засрахгүй гэдгийг би бас яг хэлэлцүүлгийн явцад хэлж, энэ протоколд миний яриа үлдэх байх аа гэж бодож байна.

Үндсэн хуулийнхаа гуравдугаар хэлэлцүүлгийг яаралтай явуулж, энэ ололттой хэдэн дэвшилттэй зүйл заалтуудаа амьдралд хэрэгжүүлэх. Түүнтэй уялдсан органик хуулиудыг гаргах нь зүйтэй байх гэж бодож байна.

Би С.Бямбацогт гишүүнийг саяны тэр үгийг дахиж битгий хэлээсэй гэж бодож байгаа. Юу гэвэл энэ аймгийн цолтой бөхчүүд, улсын цолтой бөхчүүд гэдэг энэ зүйрлэл чинь биш ээ. Өөрөөр хэлбэл улс орнууд мажоритар пропорционал тогтолцоогоор парламентаа сонгодог ийм л уламжлалтай. Энэ нь ердөө л төрөө бүрдүүлж байгаа арга хэлбэр. Арга хэлбэр. Магадгүй бид нар гажуудаж жижиг тогтолцоо дээр илүү ажилладаг, улс орны нийтлэг эрх ашигтай холбоотой том төсөл хөтөлбөрүүд дээр зөвхөн тойрог руугаа гэсэн аминчхан үзлээр төрийн төсвийг хуваарилдаг ийм гажуудлыг байгаа байх.

Тэрнээс биш ардчилсан тогтолцоотой улс орнуудад жижиг том тойрог, пропорционал, жагсаалт аль нь ч бай гэсэн төрөө бүрдүүлж байгаа арга хэлбэр нь. Мэдээж хэрэг мажоритар тогтолцоо, том мажоритар тогтолцоогоор цаашид төрөө бүрдүүлдэг энэ хэлбэршил рүү явъя. Ард түмэн заавал хүний нэр дугуйлж байж, тэр нь биднийг төлөөлсөн тодорхой хугацаатай төр байх юм гэдэг ийм нийгмийн эрэлт, шаардлагад үндэслэж өнөөдрийн ийм өөрчлөлт, Ардчилсан намаас гаргасан саналтай уялдуулж ийм саналуудыг гаргаж байгаа гэдгийг ойлгож байгаа.

Тийм учраас тэр зүйрлэл дээр дахиж өөрийгөө зөвтгөж битгий аймаг, цэргийн, улсын цолтой гэдэг тийм төлөөлөл битгий яриасай. Энэ бол төрийг л сонгож байгаа хэлбэр шүү гэдгийг хэлье. Би бол асуулт байхгүй С.Бямбацогт гишүүн ээ. Би үгээ хэлж байгаа. Хэдүүлээ гуравдугаар хэлэлцүүлгээ яаралтай явуулья гэж бодож байна.

Л.Энх-Амгалан: Х.Нямбаатар гишүүн үг хэллээ. Б.Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр нэгдүгээрт юу хэлэх гээд байгаа гэхээр ийм юм л даа. Бид төрийн үйл ажиллагаа урагшлахгүй байгаа, төрийн нэр хүнд сайнгүй байгаа, улс орны нийгмийн эдийн засгийн амьдралд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа энэ бүх юм хуульдаа байна, Үндсэн хуулиас эхлүүлээд хуульдаа байна. Тогтолцоондоо байна гээд ингээд байдаг л даа.

Тэгэхээр би бол ер нь хүндээ л байна. Хүний үзэл ухамсар хандлагад л байгаа гэж би бат итгэлтэй байдаг хүн. Тэгээд яах вэ, одоо ямар ч байлаа гэсэн энэ дүрэм, хуульдаа нэг өөрчлөлт оруулаад ингээд үзвэл нааштай өөрчлөлт гарах юм болов уу, үгүй болов уу гэж.

Тэгэхээр зэрэг хамгийн том хүчин зүйл хүнтэй ажиллах, хүнийг шилж сонгох, хүнээ бэлтгэх, хүний суурь үзэл ухамсар хандлага. Төрийн хүн гэдэг бол хувийн эрх ашгаа хойш нь тавьж чадсан, энэ хөрөнгө хогшил цуглуулдаг, мөнгө санг нааш цааш нь гувчуулдаг, улс орны нэр нүүр барьж авсан Чингис, Самурай бондыг дэлсдэг. Тэгээд жижиг, дунд үйлдвэрлэл, боловсролын сан юу хамаагүй. Тэгээд юм болгоныг авч суудаг тийм улс байж таарахгүй байгаа юм л даа. Тэгээд төрлийнхөө улсуудыг ажил албан тушаалд томилдог. Тэгээд одоо цааш нь ярих юм бол энэ цаг хүрэхгүй л дээ.

Тэгэхээр хүний асуудал их чухал. Тэгэхээр би энэ дотор гэрэлтэй гэгээтэй юм юу гэж харагдаад байна вэ гэхээр зэрэг тэр төрийн эрх мэдэлд хүрдэг, энэ ажил албан тушаалуудыг авч явдаг, энэ улс орны гол шийдвэрийг гаргах энэ түвшинд байж байгаа хүмүүсийг сонгодог, бэлтгэдэг, дэвшүүлж

тавьдаг, тэр улс төрийн намуудтай нь нэлээн хариуцлага ярих энэ заалт бол дэлхийн бусад улс орнуудын Үндсэн хуульд байдаг тэр жишгийн дагуу шинээр заалт орж ирж, энэ зохицуулалт ирэх нь ээ. Улс төрийн намыг нэлээн хариуцлагажуулах, нэлээн үйл ажиллагаа нь ил тод болох, дотоод ардчилал, тэр дундаа боловсон хүчний бодлого энэ бүх юм дээрээ бас жаахан ахиц дэвшил гарах юм уу даа гэж ингэж гэрэл гэгээтэй юмыг бид ойлгож байгаа юм.

Тэгэхээр зэрэг энэ нэг ийм ойлголт. Нөгөөдөх нь энэ Үндсэн хуулийн өөрчлөлттэй холбоотой асуудлыг энэ нийт нийгмийн хүрээний зөвшилцөлд хүрч байж шийдэх ёстой. Ард нийтийн санал асуулгыг авах ёстой гэдэг ийм хатуу байр суурь дээр байсан. Байгаа хүн. Энэ нийгмийн зөвшилцлийн хүрээнд би анх том гэж нэрлэнэ үү, ажлын хэсэг байгуулахад Монгол Ардын Хувьсгалт Намаас сууж байгаа энэ О.Баасанхүүг оруулахад яадаг юм бэ гэдэг асуудлыг би тавьсан. Тэгтэл чи О.Баасанхүүд хэзээ хайртай болсон юм гээд ингээд над руу дайраад байсан.

Тэгэхээр энэ чинь орхиж болохгүй байхгүй юу. Энд байж байгаа ядаж Улсын Их Хуралд суудалтай байгаа, энд ороод ирсэн улс төрийн намын төлөөлөл хүмүүсийнхээ оролцоог хангах хэрэгтэй. Энэ Ардчилсан намын зөвлөл яагаад хаяад гараад явдаг юм бэ гэдгийг удаа дараа хэлж байсан. Тэгээд энэ зөвшилцөл, ойлголцлын хүрээнд нэлээн ажил нь ойртоод явж байгаа юм шиг байгаа юм. Үүнийг чинь хүрээг нь хумьж байж ойлголт, оролцоог нь нэгтгэж байж энэ нийгмийн хэмжээний зөвшилцлийн баримт бичиг, энэ улс орны тусгаар тогтнолын тунхаг энэ Үндсэн хуульдаа ихээхэн хариуцлагатай хандах ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг хүн.

Дараагийн нэг хэлэх гээд байгаа зүйл бол энэ холимог тогтолцоотой холбоотой асуудал. Энэ холимог тогтолцоо намын нэрийн ард листэнд дээр суудаг ийм зүйл байж таарахгүй гэдэг ийм байр суурь дээр байсан хүн. Би Улсын Их Хуралд 4 удаа сонгогдохдоо иргэд олон түмнээр шүүлгэж байж тэднийхээ саналаар, тэднийхээ төлөөлөл эрх мандат авч л энд ажиллаж байгаа.

Тэгээд энэ завсар зайгаар нь намын голдуу нөхдүүд даргын эргэн тойрон бүжиж байдаг хүмүүс энэ холимог тогтолцоо, намын нэр листэнд суудаг. Энүүгээр чинь сонгогдсон шүү дээ. Хэдэн онд ч билээ дээ. Тэгээд тэр нь одоо иргэд, сонгогчдын хувьд асар их хүчтэй шүүмжлэлд өртөөд бүр Үндсэн хуулийн цэцээр энэ бол Үндсэн хуулийн суурь зарчмыг зөрчсөн байна, Үндсэн хууль зөрчсөн байна гээд ингээд гаргасан дүгнэлт. Одоо дахиад холимог тогтолцоотой холбоотой юм ярьж байгаа юм байна. Энэ дээр тодорхой тайлбар өгөөч ээ гэж.

Энэ Үндсэн хуулийн талаар судалгаа явуулдаг дагнасан судлаачид бол дэлхийн бусад улс орнуудын Үндсэн хуулийг судалж үзээд ерөөсөө манайхаас гадна 3 улс л байна. Мажоритар энэ тогтолцоогоор сонгуулиа явуулдаг. Бусад нь холимог тогтолцоо, пропорционал ийм тогтолцоогоор явсан. Энийгээ Үндсэн хуульдаа хуульчилсан ийм улс орнууд байна гээд ингээд танилцуулга бэлтгээд ингээд яриад байгаа юм. Энэ дээр нэг тогтож тайлбар өгөөч ээ гэж. Ийм зүйлийг асуух гээд байна.

Мэдээж Үндсэн хуульд өөрчлөлт оруулах ийм хэрэгцээ шаардлага бас байгаа юу гэвэл байгаа. Ямар ч байсан би түрүү хэлсэн. Хүнийхээ хүчин зүйл, хүний асуудлыг зэрэгцүүлээд энэ Үндсэн хууль, энэ хуулийнхаа асуудал дээр нэг өөрчлөлт оруулаад үзье гэж. Тэгвэл үнэхээр бас нэг нэг талаасаа жаахан нааштай өөрчлөлт гарах юм уу, үгүй юу гэж. Тийм учраас 62 гишүүний нэг болж санаачлагч болоод ингээд явж байгаа юм. Байр суурь бол их ойлгомжтой тодорхой байгаа юм гэж.

Дараагийн нэг асуудал бол ерөнхийдөө энэ улс орны эдийн засагт томоохон байр суурь эзлэхээр энэ том орд газруудаа гадаадын үндэсний дамнасан компаниудад бид алдсан. Энэ бол зүгээр нэг хэдхэн гишүүд сэтгэлийн хөөрлөөр асуудлыг яриад байгаа юм биш ээ. Энэ анх батлагдаж яригдахаас эхлээд бид тавьсан. Үе үеийн парламент Засгийн газар холбогдох хүмүүсүүд нь хамтарсан тушаалаар ажлын хэсэг гаргаад үзээд шалгаад, Оюу толгой алдаатай байна. Тэрбум шахам долларын зөрчил дутагдал илэрлээ. Энэ Монголын дэлхийд томд орох, Монголын үнэ цэнтэй баялгийг ашиглаж байгаа хэр нь багахан хэмжээний татварыг энэ улсын сан хөмрөгт тушааж чадахгүй, өчнөөн жилээр маргаантай шүүх дээр төлөхгүй, ийм л бодитой явж байгаа зүйл бий шүү дээ.

Тийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой асуудлаар энэ асуудлыг ярьж хэрэггүй байх. Улсын Их Хурлаас байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг авч хэлэлцээд, Улсын Их Хурлаас Засгийн газарт өгөх тогтоолын төслийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж байгаа. Энүүгээрээ тодорхой зүйлүүд тэр үедээ яригдах байх.

Би эндээс надад ямар сэжиг таамаг төрж байна вэ гэхээр зэрэг үндэстэн дамнасан том хүчирхэг компани нэлээн ажиллагаагаа бол эхэлж юм байна. Одоо өөрийнхөө бусармаг булхайтай гэрээ хэлэлцээр, энэ үйл ажиллагаануудаа дахиад парламентын түвшинд, энэ шийдвэр гаргах түвшинд өнөөдөр яригдаж байгаа тэр ажлын хэсгийн дүгнэлт, тэр гарах тогтоол юманд нөлөөлөх ийм ажлаа эхлүүлсэн юм байна гэж надад ойлгогдоод байгаа юм.

Л.Энх-Амгалан: С.Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Б.Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Тэгээд хамгийн сүүлийн асуултад бид анхаарах ёстой. Бас ярьж байгаа. Түрүүн бас Л.Болд гишүүн асуусан. Байгалийн баялгийн өгөөжийг ашиглахдаа энэ удаагийн Үндсэн хуулийн бас нэг онцлог бол ерөөсөө байгалийн баялаг төрийн мэдэлд, төрийн өмч байна гээд заасан. Ард түмний мэдэлд, төрийн өмч байна гэж заасан. Тэр нэрийн дор маш их хулгай хийдэг. Маш одоо юу гэдэг юм, буруу зарцуулдаг асуудлууд байсан. Энийг бид нар засаж залруулах ёстой.

Хэдийгээр Оюу Толгойн гэрээ хууль зөрчөөгүй гэж ярьдаг боловч үнэхээр цаад талдаа Монгол Улсад ашигтай юу гэвэл ашиггүй. Одоо болтол бид нар засаж чадахгүй явж байгаа. Иймэрхүү алдаануудыг бид засах ёстой.

Тийм болохоор бид нар байгалийн баялгийг ашиглахтай холбоотой тодорхой зохицуулалт, зүйл, заалтыг Үндсэн хуульдаа оруулж өгье. Хамгийн гол нь гэхдээ нуухыг авах гээд нүдийг нь сохлох биш тийм үү, харилцан ашигтай хамтарч ажиллах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хохироохгүйгээр бас Монголын ард түмний эрх ашиг хохироохгүй байх тэр тэнцвэрийг олох ийм л бодлогыг бид барих ёстой гэдэг үүднээсээ байгалийн баялгийн үр өгөөжийн дийлэнхийг Монголын ард түмэн хүртдэг байх ёстой шүү. Гэхдээ энийг мушгиж гуйвуулж ойлгохгүйгээр ерөөсөө маш зөв талаас нь томъёолж тайлбарлаж явах ёстой гэдгээрээ бид нар “үр өгөөж” гэдэг үгийг тодорхой тайлбарлаж байгаа. Мөн “дийлэнх” гэдэг үгийг тайлбарлаж байгаа. Энийг бид санал хураах үед анхаарах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Дараагийн асуудал сонгуулийн тогтолцоотой холбоотой асуудал. Түрүүн Х.Нямбаатар гишүүн ярьсан. Дэлхийн улс орнууд ерөөсөө нам дугуйлдаг 100 хувь пропорционал тогтолцоогоор сонгууль явуулдаг улсууд байна. Холимог тогтолцоо буюу нам дугуйлдаг, хүн дугуйлдаг тогтолцоотой улсууд байна. Ерөөсөө хүн сонгодог мажоритар тогтолцоотой улсууд байна.

Дэлхий нийтийн чиг хандлага хаашаа яваад байна вэ гэхээр хөгжингүй орнууд аль болохоор пропорционал руугаа тогтолцоо шилжиж байна. Тухайлбал, би энд уншаад танилцуулж болно. Хувь тэнцүүлсэн тогтолцоогоор буюу пропорционал тогтолцоогоор Австри, Аргентин, Бельги, Люксембург, Норвеги, Швейцарь, Финланд, Швед гэх мэтийн хөгжингүй орнууд үндсэндээ энэ 100 хувийн пропорционал тогтолцоогоор явуулдаг юм байна.

Өнөөдөр Өмнөд Солонгос, Япон, Тайланд, Гүрж зэрэг улсууд холимог тогтолцоогоор сонгуулиа явуулж байгаа юм байна. Олонхыг төлөөлөх тогтолцоогоор Вьетнам, Азербайжан, Куба, Мальдив, Хятад, Туркменистан, Хойд Солонгос гэсэн улсууд явуулж байгаа юм байна. Сонгуулийн тогтолцоо. Ингээд ийм байдалтай байж байна.

Тэгэхээр бид нар дэлхий нийтийн чиг хандлага хамгийн зөв тогтолцоо руугаа шилжих энэ шилжилт рүү холимог тогтолцоо руу оръё гэдэг Ардчилсан намын зөвлөл маань гаргаад байгаа санал. Гэхдээ энийг би буруу биш гэж бодохгүй байгаа.

Ингэхдээ түрүүн хэлдэг. Тогтолцоог би тайлбарлахдаа л аймгийн бөх гэдэг юм уу, улсын бөх гэдэг юм уу тийм байдлаар тайлбарласан. Жаахан буруу ойлгогдоод байх шиг байна. Улс нэг тойргоос сонгогддог, нам дугуйлдаг биш тийм үү, улс нэг тойргоос сонгогддог Улсын Их Хурлын гишүүн нэг хэсэг нь ингэж сонгогддог байя. Нэг хэсэг нь тэр аймгаас, тойргоос сонгогддог ийм нэг хэсэг гишүүд байя гэдэг тогтолцоог бид нар сонгож байгаа.

Өөрөөр хэлэх юм бол намын жагсаалтаар намын нэрийн ард нуугддаг, ичих нүүрээ элгэндээ наасан тэр худалч, хулгайч, луйварчин, одоо юу гэдэг юм мөнгө төгрөг өгдөг, намын даргыг тойрч цүнхийг барьж гүйдэг ийм байдлаар намын жагсаалтын ард сонгогдох бололцоо боломж байхгүй шүү. Энийг хаана гэж байгаа юм ерөөсөө.

Намын жагсаалтад орж болно. Намын жагсаалтад орсон тэр нэр дэвшигчдээс хүнийг нь дугуйлдаг байя. Улсын хэмжээнд хүнийг нь дугуйлдаг байя гэдэг тогтолцоо юм. Нөгөөдөх нь хуучин уламжлал аймагтаа хэдэн тойрог болно тэндээс хүнийг нь сонгодог, хүнийг нь дугуйлдаг ийм тогтолцоо байх гэдэг байдлаар тайлбарлаж бас хэлэх нь зөв байх. Ийм байдлаар явж байгаа гэдгийг хэлье.

Түүрүүн Х.Нямбаатар гишүүн бас ярьсан. Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгох ёстой байсан юм гэж. Энэ дээр би бас санал нэг байсан. Парламентаас. Тийм. Парламентаас. Үнэхээр сонгодог парламент руу шилжье. Нэгмөсөн үндсэндээ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийж байгаа юм чинь энийг шийдчих ёстой гэж. Өчигдөр ч гэсэн Төрийн байгуулалтын байнгын хороон дээр би тэгж санал өгсөн. Гэхдээ бодоод байхад бас бодох зүйл байна.

Энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр Ерөнхий сайдад маш их эрх мэдлийг өгч байгаа. Парламентын маш их эрх мэдэл хасагдаж байгаа. Тухайлбал, Ерөнхий сайд Засгийн газрын кабинетыг өөрөө бүрдүүлэх нь. Кабинетаа өөрөө бүрдүүлэх нь. Улсын Их Хуралд олонх болсон нам олонхын дундаас Улсын Их Хурлын даргыг томилох шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий сайд буюу намын дарга гаргана. Улсын Их Хурлын даргыг хэн байлгах вэ гэдгийг ялсан намын дарга шийддэг болох нь ээ.

Хоёрдугаарт нь, парламентаас Ерөнхийлөгчөө сонгодог болчих юм бол дахиад Монгол Улсын Ерөнхийлөгч хэн байхыг ялсан намын дарга шийддэг байх нь ээ. Тэгээд ялсан намын дарга Ерөнхий сайд хийх нь, Ерөнхий сайд хийгээд Засгийн газрын гишүүдээ, сайд нараа бүгдийг нь өөрөө томилдог, чөлөөлдөг эрх мэдэлтэй боллоо.

Дараад нь Ерөнхийлөгчөөр дамжуулаад нөгөө хууль хяналтын байгууллага, шүүх прокурор одоо юу байдаг юм тэд нарыг Ерөнхийлөгч өөрийнх нь томилсон, өөрийнх нь нэр дэвшүүлсэн хүн Ерөнхийлөгч болсон юм чинь тэрүүгээрээ хууль хяналтын байгууллагыг дамжуулаад дахиад удирддаг болох нь ээ. Ингэх юм бол хэтэрхий их эрх мэдэл Ерөнхий сайд гэдэг хүн дээр нэг туйлаас бид нар тийм үү Ерөнхийлөгч их эрх мэдэлтэй байна, Их Хурал эрх мэдэлтэй байна. Үүнийг багасгая. Засгийн газраа бэхжүүлье. Ерөнхий сайдаа эрх мэдэлтэй болгоё гээд шилжиж байгаа.

Энэ шилжилтийг хийхдээ хэтэрхий Их Хурлаас их эрх мэдлийг нь хасаад нөгөө Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодог болгоод, Ерөнхий сайд дээр аваачаад тавьчих юм бол Ерөнхий сайд бүр дааж дийлэхгүй хадны мангаа тийм үү, хууль хяналтын байгууллагаа атгадаг, Ерөнхийлөгчөө томилдог, Их Хурлын даргаа томилдог, сайд нараа томилдог ийм эрх мэдэлтэй Ерөнхий сайд гараад ирчихвэл дахиад ийм бас нэг хадны мангаа бий болчих юм биш байгаа.

Тийм болохоор шилжилтийн байдлаар шийдье. Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодог хуучин хэлбэрээ хадгалаад энэ Үндсэн хууль маань одоо хэр зэрэг амжилттай үр өгөөжөө өгч улс орны өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэж чадах нь, ард иргэддээ үр өгөөжөө өгч чадах нь түүнийг нь харж байгаад дараад нь зөв байх юм бол зөв заалтуудаа цааш нь

улам хөгжүүлээд, алдаатай дутагдалтай ганц нэг заалт байх юм бол түүнийг засах боломж нь Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсны дараа нээлттэй үлдэнэ. Хэрвээ баталж чадахгүй бол 8 жил Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх боломж нь бидэнд хаалттай болно.

Тийм болохоор хэтэрхий нэг туйлаас нөгөө туйл руу шилжсэн туйлшрал биш, дунд нь бас завсрын шилжилтийн тэнцвэржүүлэгч байдлаар Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгодогийг үлдээгээд, Ерөнхий сайдад эрх мэдлийг нь нэмэгдүүлээд ингээд Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийг хийвэл яасан юм бэ гэсэн бодол зүгээр хувь хүнийхээ хувьд, бас өчигдөр Ерөнхийлөгчийг парламентаас сонгодог тэр саналаа өгсний дараад бодож байх явцдаа энэ зөв юм шиг байна даа гэж ийм ойлголт төрсөн гэдгээ зүгээр хэлчихье.

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүн

Д.Лүндээжанцан: Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад түрүүн бас хариулсан.

Тэгэхээр ингэж байгаа юм. Сая манай О.Содбилэг гишүүн гаргаад ирлээ л дээ. Бид нар та нарт материал тараасан. 195 улсын сонгуулийн тогтолцоог авч үзэхэд 89 нь пропорционалаар, 34 улс холимгоор, 64 улс мажоритараар байна гэж.

Мажоритар тогтолцоо буюу одоогийн бидний явж байгаа энэ тогтолцоо бол хоёр намыг зонхилж, хоёр намын систем рүү түлхдэг. Жишээ нь, Америк байж байна шүү дээ. Тийм үү. Жишээ нь, Их Британи байж байна.

Пропорционал тогтолцоо. Цэвэр пропорционал тогтолцоо бол олон намуудыг ингээд гаргаж ирдэг. Энэ бол Израиль мэтийн. Бас тэдний тогтолцоо бас өвөрмөц.

Холимог гэхээрээ байна шүү дээ аль алиныг нь бас чиглэлийг нь хангасан. Сонгогчдын саналын нэг хэсэг хаягддаггүй байдаг сайн талууд байгаа юм. Ийм учраас аливаа системд эерэг сөрөг хоёр тал байна. Сөрөг талыг нь манайхан өнөөдөр их ярьж байна. Тухайлбал, намын нэрсийн жагсаалтад нуугдаж ард түмний таашаахгүй байгаа хүмүүс орж ирэх магадлал өндөрсдөг гэж.

Тэгэхээр энэ дээр бол одоо энэнээс зайлсхийх арга бол хүний төлөө санал өгөх юм гэж ингэж тайлбарлаж байгаа.

Хоёр дахь нь, ёс зүйн тухай ярьсан. Манай энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол эцсийн дүндээ хариуцлагыг 35 зүйл гэнэ үү, 19 зүйлийн 35 заалт үндсэндээ хариуцлагыг л чангатгаж байгаа юм. Эрх мэдлийг нь зөв хуваарилалт руу явуулах гэж байгаа. Тогтвортой байдлыг хангах гэж байгаа.

Ингэснээрээ ёс зүйг бий болгоход нэмэр тустай юм гэж үзэж байгаа. Цаагуураа. Өнөөдөр сүүлийн 30 жилийн бидний ололт амжилт, алдаа дутагдлын тухай яривал үлгэрийн далай. Маш их олон салбарт хөгжил ирсэн шүү. Тэрийг бас үгүйсгэх арга байхгүй.

Хамгийн гол доголдож байгаа юм бол ёс зүй, ёс суртахуун. Манай академич С.Нарангэрэл багш энийг их ярьж байгаа. Манай ёс зүйн хорооны дарга Б.Бат-Эрдэнэ гишүүн бас их ярьж байна.

Би бол ёс зүйн асуудал бол ерөөсөө орхигдсон. Энэ юутай холбоотой вэ гэхээр хариуцлагын тогтолцоо тал талдаа сайжраад ирэх юм бол тэр салбар болгоны ёс зүй босож ирнэ гэж бодоод байгаа юм. Эмчийн ёс зүй, багшийн ёс зүй, эцэг эхийн ёс зүй, инженерийн ёс зүй. Тийм ээ. Бүх шатны. Шүүгч, прокурорын ёс зүй, цагдаа төрийн албаны ёс зүй гээд.

Тэгэхээр энэ бүх шатанд хувийн аж ахуй, ажлын байр олгогчийн ёс зүй гээд. Энэ бүх ажилтны ёс зүй, ажил хийж байгаа хүний. Энэ бүх шатанд энэ ёс зүйн асуудал ингэж яах юм. Бид төрийн албаны хэсэг дотор бас “ёс зүйтэй” гэдэг нэг үг оруулаад. Тийм үү. Тэгээд ер нь төрийн албаны үнэхээр хүнд суртлаас болоод тэгээд хүмүүсийн дургүйцэл их байсан байх. Энэ бол хасагдсан. Энэ ёс зүйн асуудлыг ингэж л хариуцлагыг дээшлүүлж байж ёс зүйн асуудал босож ирэх юм гэж бид нар ойлгож байгаа юм.

Үзэл суртлын, хүмүүжлийн ажил байлгүй яах вэ. Тэр соёл, урлагаар хүмүүжүүлэх, шашнаар хүмүүжүүлэх гээд олон юм байгаа байх. Хамгийн гол нь хариуцлага, сахилга дээшилж байж л сая ёс зүйтэй болох юм гэж үзэж байгаа.

Л.Энх-Амгалан: Б.Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гол зорилго бол хариуцлага, хяналт тэнцэл, тэгээд төр засгийн тогтвортой үйл ажиллагаа. Энэ дээр ойлгож байгаа.

Тэгэхээр ерөнхийдөө энэ төрийн эрх мэдэлд байж байгаа хүмүүсийн хамгийн чухал юм бол эрх ашгийн эрэмбэ. Тэгээд тэрэнд хөрөнгө мөнгө, санхүүтэй холбоотой юм дээр л очих юм.

Төрд насаараа ажиллаад ямар ч ажил бизнес хийгээгүй хүн хэчнээн тэрбум төгрөгийн байр хаустай, хэчнээн зуун сая төгрөгийн машин унаатай, хэчнээн арван сая төгрөгийн төлбөртэй сургуульд үр хүүхдүүдээ сургадаг. Өөрсдөө гадагшаа дотогшоо дуртай үедээ яваад эмчилгээ, үйлчилгээ, бас л арван хэдэн сая, зуун саяар хэмжигдэх ийм үйлчилгээнд хамрагдаад явж байдаг. Тэгээд хэрэглээ тал дээр нь юмыг нь тодорхой болгоод хаагаад өгөх юм бол энэ асуудал чинь нэлээн цэгцрэх болов уу даа гэж би бодоод л, олон жил энд ярьж байна. Ад болж байгаа хүн л дээ.

Тэгэхээр яах вэ, багш бол хэллээ. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хариуцлагын тогтолцоог нэлээн сайн оруулж өгсөн. Тэгэхээр хариуцлага дээрээ тулгуурлаж байгаад өөрийн чинь яриад байгаа энэ үзэл хандлага, ёс зүйтэй холбоотой юм босоод ирнэ гэж ингэж хэлж байна л даа. Тэгээд ямар ч байлаа гэсэн бид нар тал талаас нь өөр өөрийнхөө харах өнцгөөр асуудлыг тавиад. Тэгэхдээ зүгээр нэгийг нь гэж туйлшрахгүйгээр зэрэгцүүлээд анхаармаар юм шиг байгаа юм.

Хоёрдугаарт, надад тодруулж хэлж өгөөч ээ гэж хүсэж байгаа юм бол би одоо санал өгөх гэж байгаа учраас би бол энэ намын нэрийн ард нэр нүүрээ нуудаг нөхдүүдийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Тэгэхээр энэ холимог оруулах гэж байгаа тогтолцоо чинь чухам ямар юм байгаа юм бэ гэдгийг .../минут дуусав/

Л.Энх-Амгалан: С.Бямбацогт гишүүн нэмэлт тайлбар өгөх үү. Тийм ээ.

С.Бямбацогт: Энэ сонгуулийн тогтолцоотой холбоотой Үндсэн хуульд оруулах гэж байгаа заалтыг танд уншаад, бас тайлбарлаад хэлээдэхье.

Улсын Их Хурлын сонгуулийг олонхын болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө гэж байгаа.

Олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна гэдэг маань түрүүний хэлдэг нөгөө мажоритар буюу бидний хэлснээр пропорционал гэдгээ хэлж байгаа. Сонгогч нь тойрогт нэр дэвшсэн гэдэг нь тухайн оршин сууж байгаа аймагт нь, тэр тухайн суманд нь, дүүрэгт нь нэр дэвшиж байгаа хүний төлөө дугуйлж саналаа өгнө. Түүнээс гадна улс төрийн намууд хүмүүсээ дэвшүүлээд нэрсийн жагсаалт гаргасан байн. Тэндээс дотроос нь сонгож нэг хүнийг сонгож нэрсээ өгнө. Ийм тогтолцоогоо Үндсэн хуульдаа суулгаж өгье. Ийм байдлаар саналаа өгдөг больё гэдэг заалтыг суулгаж өгч байгаа юм.

Сонгуулийн тогтолцооны асуудлыг Үндсэн хуульд суулгаж өгөхгүй болохоор нөгөө сонгууль болгоны өмнө сонгуулийн тогтолцоогоо хуулиараа өөрчилдөг эрх баригч нар. Өөртөө нийцүүлж. Манайх ингэвэл ялж магадгүй гэж. Тийм байдлаар сонгуулийн тогтолцоо байнга өөрчлөгддөг. Одоо та бас мэдэж байгаа байх. 2004 онд нэг тогтолцоогоор, 2008 онд нэг тогтолцоогоор, 2012 онд нэг тогтолцоогоор, 2016 онд нэг тогтолцоогоор. Сүүлийн дөрвөн сонгууль дөрвүүлээ өөр тогтолцоогоор явсан. Дөрвүүлээ өөр.

Тэгвэл Үндсэн хуульдаа ингээд заачих юм бол ерөөсөө нэг л тогтолцоогоор сонгууль явуулдаг болно. Сүүлийн дөрвөн сонгууль болохдоо дунд нь нэг удаа нам дугуйлдаг сонгууль явсан. Намын жагсаалтаар сонгогддог. Энд ард иргэд маш их дургүйцсэн. Тэгвэл Үндсэн хуульдаа нам дугуйлдаг биш, хүн дугуйлдаг тогтолцоог, холимог тогтолцоог суулгаад өгье. Ингээд суулгаад өгөхгүй бол цаашдаа дахиад 2020 оны сонгууль ч байдаг юм уу, 2024 оны сонгуулийн өмнө нам дугуйлдаг тогтолцоог оруулаад ирэх нээлттэй үлдчих гээд байна. Тийм болохоор одоо намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө... /минут дуусав/

Л.Энх-Амгалан: Б.Ундармаа гишүүн.

Б.Ундармаа: Ингээд Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг хэлэлцэж байна.

Намар Сонгинохайрхан дүүргийн 8 хороо буюу 1, 2, 20, 22, 32 дугаар хороодоор одоо бас ард иргэдийнхээ дунд Үндсэн хуулийн хэлэлцүүлгийг хийсэн.

Тэр дээр иргэд нэг л зүйлийг их анхаарлаа хандуулж хэлж байсан. Төрийн буруу бодлогоос болж өнөөдөр эдийн засгийн хямрал нүүрлэж байна, ажилгүйдэл үүсэж байна, ядуурал үүсэж байна. Мөн эдийн засгийн хямралаас үүдээд нийгмийн тогтворгүй байдлууд үүсэж байна. Мөн ард иргэдийн амьдрал доошилж байна. Аж ахуйн нэгжүүд хүндэрч байна. Энэ тал дээрээ одоо яг энэ эдийн засаг тал дээрээ яаж анхаарч байгаа юм бэ гэдгийг иргэд маань маш их сануулж, энэ саналыг тавьж, хэлж байсан.

Тэгвэл өнөөдөр Улсын Их Хуралд ч тэр өнөөдөр энэ Үндсэн хуулийг хэлэлцээд батлах нь зүйтэй юм гэдэг маань яг цаг үеэ олсон нийгмийн захиалга гэдгийг бас онцолж хэлмээр байна.

Энэ Үндсэн хууль дээр бид бас нэг томоохон асуудал болох улс орныхоо хөгжлийн бодлогын төлөвлөлт, хөгжлийн бодлогын зохицуулалт энэ заалтыг бол оруулж өгснөөрөө хамгийн том онцлог нь байгаа. Бид олон зүйлийг одоо энэ зах зээлд шилжсэн 27 жилийн хугацаанд ярьж хэлж ирсэн. Энэ дээр нэг зүйлийг бас ингээд анхааралтай хандахад энэ хугацаанд 14 Засгийн газар солигдсон байгаа юм. Энэ 14 Засгийн газрын маань насжилт нь 1.8-аас 2 жил. Хоёрхон засгийн газар бүрэн эрхийнхээ хугацааг хэрэгжүүлсэн байгаа юм.

Энэ хугацаанд ямар байдлууд одоо үүссэн бэ гэвэл ерөөсөө сахилга батгүй, хариуцлагагүй, мөн эдийн засгийн уналт. Дараагийнхаа сонгуулиар эдийн засгийн өсөлтүүд нь гарч ирдэг. Улс эх оронд маань халамжийн эдийн засаг нүүрлэсэн. Бүтээлч, хөгжлийн эдийн засаг байхгүй ийм үеүд бас ирсэн байна. Тийм учраас бид нар тогтолцоо, бүтцэд дээрээ өөрчлөх шаардлагатай байна.

Ингээд Ерөнхий сайдад бид нар эрх мэдэл өгч байна гэж хэлж байгаа. Үүрэгдүүлж байна, хариуцлагажуулж байна гэж хэлж байгаа. Ерөнхий сайд өөрөө сайд нараа томилж байгаа. Энэ маань сайд нар нь Ерөнхий сайдынхаа өмнө ямар ч хоёрдмол утгагүйгээр хариуцлагыг үүрч байгаа. Энэ яг хариуцлага гээд ингээд ярихаар энэ хариуцлага маань өөрөө бас энэ сайд нарын ажиллах хамгийн гол хөшүүрэг нь байгаа. Төрийн албан хаагчид, төрийн албадын маань бас энэ хариуцлага, сахилга бат, мөн идэвх зүтгэл энэ бүгд маань энэ дээр бас хамаарагдаж байгаа гэдгийг бас онцолж хэлмээр байна.

Дараагийн нэг гол зүйл маань гээд тэгэх юм бол С.Бямбацогт даргаас асуумаар байна. Бид нар одоо энэ улс орны хөгжлийн бодлого. Тийм ээ. Энийг бас нэлээн сайн ярьж хэлэлцэж байгаад энэ заалтыг оруулж ирсэн.

Тэгэхээр хөгжлийн бодлого, энэ хөгжлийн төлөвлөлт, бодлогын төлөвлөлт эд нар маань ингэж орж ирснээр ямар тодорхой үр дүнгүүд гарах вэ гэсэн нэг асуулт байна.

Хоёр дахь нь бол бас бусад гишүүдтэйгээ санал давхцаж байна. Бид нар холимог системийг 2024 оноос гэж оруулж ирж байгаа. Энэ бол бас эмэгтэйчүүдэд ээлтэй гэж манай ажлын хэсгийнхэн зарим нь энэ дээр бас

дүгнэж хэлж байгаа. Тийм. Яг эмэгтэйчүүд гэсэн энэ заалт дээр нь бас тодорхой хэлж өгнө үү.

Л.Энх-Амгалан: Байнгын хорооны дарга С.Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Сая Б.Ундармаа гишүүн маш чухал асуулт асууж байна. Маш чухал.

Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хамгийн том асуудлуудын нэг бол Монгол Улсын төрийн хар хайрцгийн бодлоготой байх ёстой юм байна гэдэг асуудлыг Үндсэн хуульд суулгаж өгч байгаа энэ явдал байгаа юм.

1992 оноос өмнө бид нар та бүхэн сайн мэдэж байгаа байх. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засагтай, зөвхөн төрийн өмчтэй, нэг намын тогтолцоотой байсан. Бүх зүйлийг төлөвлөгөөний дагуу хийх ёстой, коммунизм, социализм байгуулж яваа. Тийм болохоор маш сайн төлөвлөгөөний дагуу ажиллаад байх ёстой гэдэг тийм л ойлголттойгоор бид нар, бидний аав ээж, бидний үед өсөж төрж хүмүүжиж байсан юм билээ. Тэгээд 5 жилийн төлөвлөгөө гаргадаг. 5 жилийн төлөвлөгөө яаж хурдан хугацаанд биелүүлэх вэ гээд л ингээд ажилладаг байсан. Тэгээд төлөвлөсөн болгоноо биелүүлэхийн төлөө. Бүх юмыг төлөвлөж ажилладаг байсан.

1990 онд ардчилсан хувьсгал болоод, 1992 онд Үндсэн хууль баталж байх үед ерөөсөө л төлөвлөгөө гэдэг чинь буруу юм байна. Төвлөрсөн төлөвлөгөө гэдэг чинь болохгүй юм байна. Социализм, коммунизм болох гээд байгаа юм байна. Ерөөсөө бүх зүйлийг зах зээл зохицуулна. Ерөөсөө эрэлт нийлүүлэлтээр үнэ тогтоно. Тийм үү. Ерөөсөө л одоо чөлөөт өрсөлдөөн, зах зээл бүгдийг шийднэ гэдэг байдлаар төлөвлөх шаардлагагүй гэдэг ойлголт, хандлага тэр үед нэлээн хүчээ авсан. Энэ үндсэн суурь дээр 1992 оны Үндсэн хууль батлагдсан юм байна гэж би бас ойлгодог.

Тийм учраас 1992 оны Үндсэн хуульд төлөвлөгөө, хөгжлийн бодлого, төлөвлөлт, улс орны төрийн хар хайрцгийн бодлого гэдэг юм бол ерөөсөө байдаггүй орхигдсон байсан. Энэ удаа бол үүнийг суулгаж өгч байгаа.

Тийм болохоор үндсэндээ төлөвлөх гэдэг юм уу. Монгол урт, дунд хугацааны бодлоготой байх ёстой. Урт, дунд хугацааны бодлого нь хоорондоо уялдаатай байх ёстой. Салбарын бодлоготой. Орон нутгийн бодлоготой. Төрийн бодлоготой гээд ийм зүйлүүд бүгд байдаггүй. Тэгээд л намууд гарч ирэхээр ерөөсөө л ялсан нам болгон өөрсдийн бодлого явуулна гэдэг. Явуулж байтал дараа нь нэг 4 жил болж байтал дараагийн нам гарч ирээд дахиад өөр бодлого явуулдаг. Нэг Засгийн газар, одоо манай Засгийн газар, миний Ерөнхий сайдын бодлого энэ байна гээд асуудлаа дэвшүүлээд явж байдаг. Нөгөө нэг Ерөнхий сайд нь гарч ирэнгүүтээ үгүй ээ. Миний Засгийн газрын бодлого ийм байна гээд дахиад өөрчилдөг.

Ийм байдлаар байрандаа хий эргэсэн. Зүг зүг тийшээ тэмүүлсэн. Нэг барьж байсан байшингаа нураагаад өөр газар барьдаг. Эсвэл модоор барьж байсан бол дараад нь тоосгоор барьж эхэлдэг гэх мэтийн төрийн хар хайрцагны тогтсон бодлого гэдэг ойлголт байхгүй өнгөрсөн 20-иод жил явж

ирсэн. Дандаа бие биеэ үгүйсгэдэг, улс төрждөг, бие биеийнхээ бодлогыг шүүмжилдэг.

Хэрвээ бид нар төрийн нэгдсэн нэг бодлоготой болчих юм бол ямар ч нам, ямар ч Засгийн газар гарч ирсэн үүнийг тогтвортой цааш нь залгамжлаад аваад хэрэгжүүлдэг энэ бололцоог Үндсэн хуульдаа суулгаж өгье гэдэг агуулгаар өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт тодорхой заалтууд орж ирж байгаа.

Тухайлах юм бол би танд уншаад танилцуулъя. 25.1.7 дээр төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого. Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого. Энэ бол урд нь байгаагүй. Хөгжлийн бодлого. Хөгжлийн болон Үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их Хурал батална. Энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийг зааж өгч байгаа.

Өөрөөр хэлэх юм бол урд нь байгаагүй улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг Улсын Их хурал батална.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт нь тогтвортой байна гэж орж ирж байгаа. Өөрөөр хэлэх юм бол хөгжлийн бодлогыг ямар ч нам гарсан, ямар ч Засгийн газар гарсан энэ гаргасан төрийн бодлогыг хэрэгжүүлэх үүрэгтэй шүү. Тэгэхгүй одоо өөрийн намын бодлого, өөрийн Засгийн газрын бодлого гээд шинэ юм, шал өөр юм гаргаж ирээд урд нь хийж байсан ажлаа нураагаад байхгүй шүү, улс төржихгүй шүү гэдгийг Үндсэн хуульдаа суулгаж өгч байгаа. Үүнтэй холбоотойгоор бид нар Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг ойрын үед батлах ёстой. Мөн үүнтэй холбоотойгоор Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого буюу алсын харааг тодорхойлох ёстой.

Энийгээ Монголын аль ч нам, ямар ч Засгийн газар, ямар ч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн болгон зөвхөн алсын хараа, хөгжлийн хэтийн бодлогоо харсан, стратегиа харсан тийм үйл ажиллагаа явуулж байх ёстой гэдгийг хуульчилж өгч байж ийм тогтсон тодорхой бодлоготой болно. Тогтсон тодорхой бодлого, төрийн бодлого маань тогтвортой хэрэгжээд эхлэх юм бол улс орны, ард иргэдийн амьдралд үр өгөөжөө өгнө гэдэг асуудлыг бас суулгаж өгсөн.

Дараагийн нэг зүйл бол байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрт эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, тэгш шударга хүртээхэд чиглэнэ гэсэн үгийг бид нар суулгаж өгч байгаа 6.2-т.

Өөрөөр хэлэх юм бол урт хугацааны хөгжлийн бодлого дээр тулгуурлаж байгалийн баялгаа ашиглая. Өнөөдөр амьдарч байгаа иргэддээ зөвхөн зарцуулаад дуусах биш. Тийм үү. Ирээдүй хойч, үр хүүхдэдээ үлдээе. Тэр хүмүүсийн бас эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулъя. Ингэхдээ бид нар байгалийн баялгийн үр өгөөжийг өсгөдөг,

үржүүлдэг, арвижуулдаг сантай байя. Энэ сангаасаа иргэддээ тэгш, шударга хүртээмжтэй хуваадаг байя гэх мэтийн зохицуулалтыг Үндсэн хуульд оруулж өгч байгаа нь 1992 оны Үндсэн хуулиас илүү ялгаатай, эдийн засгийн хувьд бас илүү тусгагдсан ийм зохицуулалтууд болж байгаа гэдгийг бас хэлье.

Л.Энх-Амгалан: Ц.Гарамжав гишүүн.

Ц.Гарамжав: Баярлалаа. Тэгэхээр энэ удаагийн 2019 оны Үндсэн хуулийн нэмэлтээр бид нар хамгийн гол нь хариуцлага, ёс суртахуун, шударга ёс, мөн баялгийн бодлогын талаарх нэмэлтүүд дээр гол анхаарлаа тавьж ажилласан байгаа.

Хариуцлага, ёс суртахуун гэдэг маань Монгол Улсад ихээхэн олон зүйл дээр, сүүлийн 20 гаруй жилийн турш зөрчигдөж, бид нар ардчилсан нийгэм, эдийн засгийн тогтолцоог сонгож хэрэгжүүлж явахдаа хууль эрх зүйн орчноо баримтлах, ёс суртахуунаа хөгжүүлэх энэ асуудал дээр маш том алдаа завхрал хийж байсан нь олон зүйлээр, олон зүйл дээр харагдаж байдаг юм.

Олон жишээ байна. Жишээлбэл, Монгол Улс 20 гаруйхан жилийн өмнө маш олон үйлдвэрүүдтэй байсан. Бүх үйлдвэрээ хувьчлах нэрээр алга болгож, өнөөдөр бид баяжуулах, боловсруулах, ер нь баялаг бүтээх үйлдвэрүүдгүй болчихоод сууж байгаа хамгийн том харамсал.

Ажлын байргүй. Тэр үед олон мянган иргэд маань ажилгүй болж, ажлын байргүй болж, өнөөдөр хүртэл залуус маань нийгэм, эдийн засгийн тогтолцоонд аж амьдралаа тогтоож чадахгүй, гэр бүлээ орлоготой байж чадахгүйгээр олон мянган хүн маань ажилгүй байсан. Ажлын байргүй болсон, бас нэг харамсал.

Гэх мэтээр явж явж хамгийн сүүлд нийгэм, эдийн засаг маань хариуцлагагүйн тогтолцоонд тэр чигээрээ орсон. Тэгэхээр энэ бүгд ёс суртахууны болоод хариуцлагын алдсан энэ олон зүйлээ засахын тулд одоо энэ удаагийн Үндсэн хууль дээр 35 шинэлэг өөрчлөлт оруулж ирж хэлэлцүүлж байгаа юм.

Тэгээд нэгдүгээрт миний харамсаж байгаа нэг зүйл бол үнэхээр ард нийтийн санал асуулгыг явуулаагүй дээр миний бие туйлын харамсаж байгаа. Ард түмэн бол хамгийн том шүүгч байдаг. Цаг хугацаатай адилхан.

Миний бие Сонгинохайрхан дүүргийнхээ нийт хороодын иргэдэд Үндсэн хуулийн нэмэлт асуулгаар харилцан хэлэлцүүлэг явуулсан, ярилцсан, олон удаагийн уулзалт зохион байгуулсан. Ард түмэн маань үнэхээр юу хүлээж байна вэ гэхээр хариуцлага, шударга ёс, тэгээд баялгийн менежментээ, бодлогоо буруу хийж байгааг маш их шүүмжилж байсан.

Ингэхээр манай ард иргэдээс гаргаж байсан саналууд бол энд бүрэн тодорхой хэмжээгээр тусгагдаж хэлэлцэгдсэн юм. Бидний Улсын Их Хурлын 20 гишүүн өмнөх Үндсэн хууль дээр байсан эдийн засгийн бодлого нэлээн бага тусгагдсан байсан юм билээ. Өмнөх 1992 оны Үндсэн хууль дээр. Тэгэхээр бидний 20 гишүүн нийлээд энэ Монгол Улсын өнөөдрийн нийгэм, эдийн засгийн хүндрэлд ороод байгаа байдал, ард иргэдийн 30-аад хувь, 29

хувь ядуу байгаа байдал, нийгмийн баялгийн бодлого буруу явагдаад байгаа байдал, уул уурхайн бодлого хазайж байгаа байдал, улс төрчид маань эх орон, уул уурхай ер нь ард түмнийхээ эрх ашгаас хохирол оруулсан ийм гэрээ хэлэлцээрүүдийг байгуулж олон жил улс орноо, ард иргэдээ чирэгдүүлж байгаа энэ байдал зэргийг харгалзаад энэ шинэ Үндсэн хууль дээр эдийн засгийн заалтууд нь нэмэгдэж ороосой. Тэртээ тэргүй энэ 29 жилийн хөгжлийн дагуу бид нар баялгийн бодлогоо алдаатай явуулж байсан гэдэг нь харагдаж байгаа учраас энийг зөвтгөхийн төлөө, зөв явуулахын төлөө дараах заалтыг оруулсан юм.

Тэгэхээр энэ байгалийн баялгийг ард иргэддээ болон улс орондоо байгалийн баялгийн ашгийн хуваарилалт нь давуу байх, Монгол улсад давуу байх ийм заалтыг оруулсан юм. Энэ заалт маань одоо яг энэ заалтаараа хэлэлцэгдэх үү гэдгийг асуумаар байна.

Тэгэхээр энэ юу гэсэн гэхээр төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг нь ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэх, түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэж оруулж өгч байгаа.

Тэгээд бидний 20 гишүүн ийм санал оруулж анхны хэлэлцүүлэг дээр дэмжигдсэн байгаа. Энд харин талархаж байгаа. Тэгэхээр энэ маань цаашдаа яг энэ хэлбэрээрээ хэлэлцэгдэх үү гэдэг нэгдүгээр асуудал байгаа.

Цаашдын энэ хоёрдугаар санал дээр арай ондоогоор томъёологдоод танилцуулагдсан байгаа юм. Тэгэхээр бид нар өөрсдийнхөө томъёологдсон хэсгээр л одоо оруулах саналтай байна. Дараагийн нэг асуулт бол ер нь энэ гүйцэтгэх засаглал болоод хууль тогтоогч нарын хоорондын зөрчил буюу энэ нэг ард түмэн давхар дээл гээд нэрлээд байгаа юм л даа. Одоо хууль тогтоогч нар маань өөрөө гүйцэтгэгч ажиллагаагаа хийдэг. Засгийн газрын газрын гишүүд болдог. Энийг олон жил шүүмжилсэн. Одоо өмнөх Үндсэн хуульд нэмэлт оруулсан дордуулсан долоон өөрчлөлт гэдгийг бид нар энэ удаа засаад Засгийн газар зөвхөн Засгийн газар нь ихэвчлэн дангаараа сонгогдъё. Улсын Их Хурлын гишүүдээс 4-өөс 5 гишүүн, 4 гишүүн л одоо үндсэн чиглэлийн 4 яамдыг давхар дээлтэй байлгаж, давхар албан тушаалтай байлгаж болох юм гэсэн ийм саналыг оролцуулсан нь бас ард түмний нэлээн дэмжлэгийг аваад байгаа юм.

Энэ удаагийн оруулж ирж байгаа Ерөнхий сайд кабинетаа бүрдүүлэх энэ зарчмыг би дэмжиж байгаа юм. Яагаад гэвэл хариуцлагыг сайжруулах үүднээс бид нар, хариуцлага гэдгийг ухамсарлах үүднээс илүү сайн хөгжлийн зөв чиг бодлогыг гаргах үүднээс Ерөнхий сайдад кабинетаа сонгох салбар болгоныг мэргэжлийн байлгах, тэр боломжийг нь өгөх ийм хэрэгтэй юм уу гэж бодож байгаа юм. Тийм учраас энэ саналыг дэмжиж байгаа.

Цаашид нь Монгол Улсад өнөөдөр үгүйлэгдээд байгаа шүүх эрх мэдлийн тогтолцооны асуудал. Үнэхээр өнөөдөр ард түмэн бол дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу, итгэж найддаг шүүхийн тогтолцоо үнэхээр ард түмнээс урвасан гэж хэлэхэд болно.

Өнөөдөр шүүх дүүргийн ч бай, нийслэлийн ч бай дээд шүүх дээр асуудлаа шударгаар шийдүүлж байгаа аж ахуйн нэгж, хувь иргэд тун ховор. Нэлэнхүйдээ энэ шүүх тогтолцоо үнэхээр одоо тун хүнд байдалд дийлэнхээрээ орсон байгаа. Итгэлгүй болсон. Шүүх засаглалд бид итгэл алдарсан. Шүүхийн эрх мэдлийг ашиглаж байгаа тэр хариуцлагагүй ийм болсон шүүгчид бол дийлэнх нь болсон учраас энэ шүүх засаглалын тогтолцоог шударга байлгах. Мөн хэтэрхий хараат байгаа. Өөрийнхөө зарчмаас зөрөөд хараат бус биш хараат байгаа энэ байдлыг засагдаасай гэсэн ийм зарчмын өөрчлөлтүүдийг Үндсэн хууль дээр оруулж өгсөн юм.

Тэгэхээр өнөөгийн Үндсэн хуулийн одоо энэ нэмэгдэж орж ирж байгаа заалтуудын дотор шүүх эрх мэдэлтэй холбоотойгоор орж ирж байгаа заалтууд нь ямар үндэслэлээр орж ирж байна вэ? Бид нарын хүссэн шударга шүүх засаглалын тогтолцоог бий болгож чадах уу. Энэ дээр бас нэг асуудал байна.

Тэгээд орон нутгийн зохион байгуулалт, өөрөө удирдах ёсыг бид нар нэлээн боловсронгуй болгож өгсөн байгаа. Хот, тосгодын заалтуудыг, статусыг бас нэлээн сайжруулж олон жил статусаа авч чадахгүй байгаа зарим хот, тосгоны асуудлыг бас шийдвэрлэж өгсөн байгаа. Эдгээр асуудлууд дээр хариулт авъя.

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүн.

Д.Лүндээжанцан: Энэ дээр Ц.Гарамжав гишүүний асуултад хариулъя. Энэ хоёрдугаар хэлэлцүүлгээр хэдэн асуудал санал хураагдаад гүйцээн томъёолохоор болсон. Тийм ээ.

Тэгээд байгалийн баялагтай холбоотой хоёрдугаар хэлэлцүүлгээр шийдсэн асуудал бол Монгол Улсын иргэдэд өмчлөхөөс бусад газар түүнчлэн газрын хэвлий түүний баялаг ой, усны нөөц ан, амьтан төрийн нийтийн өмч мөн. Байгалийн баялаг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурласан одоо ба ирээдүй үеийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг үндэсний баялгийн санд төвлөрүүлж, иргэн бүрд тэгш, шударга хүртээхэд чиглэнэ. Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчны үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй гэдэг нь бол хоёрдугаар хэлэлцүүлгээр дэмжлэг авсан.

Үүний дараагаар ард нийтийн санал асуулгад оруулах. Тийм ээ. Уг эхийн нэг, хоёрдугаар хэлэлцүүлгийг хийсэн. Тэр дээр манай нэр бүхий Ц.Гарамжав тэргүүтэй нэр бүхий, одоо энэ Х.Болорчулуун гишүүн, олон гишүүн нийлсэн байх. Ингээд 20 гишүүний юм дээр томъёоллууд нэмэгдэж орж ирсэн.

Энэ томъёолол бол төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно гэсэн дөрөв дөх өгүүлбэр нэмэх. Ийм

заалт нэмэгдэж орж ирсэн. Энэ болгон нийлүүлэхээр иж бүрэн болж байгаа юм.

Гэтэл энэ хориг хүлээгээд авагдчихаар АНСА буюу ард нийтийн санал асуулгад оруулах хоёрдугаар хэлэлцүүлгээр оруулсан томъёоллын энэ хэсэг алга болчхож байгаа юм. Тийм.

Тэгэхээр одоо энэ санал хураалтын томъёолол дотор энийг яг үг үсэггүй яг байгаагаар нь дахин санал хураалгах гээд ингээд та бүхэнд тараасан байна. Тийм учраас бид бүхэн тэр ард нийтийн санал асуулгад оруулах эхийг хэлэлцсэн хоёрдугаар хэлэлцүүлгийн үед гараад санал хураасан асуудлуудыг хөндөхгүйгээр дахин санал хураалгах ийм томъёоллыг Төрийн байгуулалтын байнгын хороо оруулж байгаа гэдгийг танд хэлье.

Шүүх засаглалтай холбоотой асуулт тавигдсан. Тэгэхээр энэ асуудлаар та олон удаа үг хэлж саналаа гаргасан. Энэ саналууд бол одоо энэ хоёрдугаар хэлэлцүүлгийн эцэст гарсан саналууд хэвээрээ байна. Өөрөөр хэлбэл шүүгчийг сонгон шалгаруулах хариуцсан Шүүхийн ерөнхий зөвлөлийн асуудал. Дээр нь шүүгчид хариуцлага ногдуулах, хариуцлагын зөвлөл сахилгын хорооны асуудал гэх мэтчилэнгээр шүүхийн томилгоо энэ бүхнийг зохицуулсан зохицуулалтууд орж ирж байгаа гэдгийг хэлье.

Бусад нь ерөнхийдөө та бүгдийн гаргасан саналууд тэр чигээрээ явж байгаа. 62 гишүүний хууль санаачлагчдын нэг нь байсан та. Тийм учраас энэ саналууд үндсэндээ ингээд ороод явж байна. Ийм учраас бид түрүүн би Б.Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулахдаа хэлсэн. Ёс зүйн асуудал тийм ээ, газар болгонд ёс суртахууны асуудал хамгийн их тавигдаж байна. Энэтэй холбогдуулаад хариуцлагын тогтолцоо ингээд сэргээд ирэхээрээ аяндаа бас ёс суртахуун шат шатны бүх шатанд ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас эхлээд жирийн иргэнээ хүртэлх хариуцлага ёс зүйн асуудал бас их чухал нөлөө үзүүлэх юм гэж ингэж үзэж байна. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Ц.Гарамжав гишүүн нэмж тодруулъя.

Ц.Гарамжав: Д.Лүндээжанцан гишүүндээ баярлалаа.

Бид нар бас энэ ашигт малтмалын их нөөцтэй, арвин баялагтай улс орны хувьд Баялгийн сан байгуулъя гэсэн саналыг бидний гишүүд гаргасан байдаг. Засгийн газар ч баялгийн санг Ирээдүйн өв сан байгуулаад өнгөрсөн хоёр жилд багагүй мөнгө. Жишээлбэл, 400-аад тэрбум төгрөгийн хуримтлал бий болсон гэж өнгөрсөн жилийн тайланд Сангийн яам мэдээлж байсан.

Тэгэхээр энэ өв сан үүсгээд явагдаж байгаа. Зүгээр энэ “Баялгийн сан” бол “Ирээдүйн өв сан” гэдэг нэрээрээ бусад улс орнуудад хэрэглэгддэг, өсөж байдаг, үржиж байдаг нэг ёсондоо даатгалын сан байгаа юм л даа. Бусад орнуудад тэгж хэрэглэдэг.

Тэгэхээр бид нарын энэ хуульд маань тэгш хуваарилна гээд баялгийн сандаа баахан мөнгө төвлөрүүлж байгаад тэрийгээ хуваарилаад байх ийм утга ороод байна уу үгүй юу. Энэ маань арай ондоо ойлголтоор бусад орон Ирээдүйн даатгал маягаар, Монгол Улсын даатгал маягаар эдийн засаг

хямралтай үед ч юм уу, эсвэл ирээдүй хойч үе, үр хүүхэд, ард иргэддээ зориулж бид нар баялгаа ашигласныхаа одоо роялт шахуу ийм хэлбэрээр хадгалах ийм хадгаламж гэж бодоод байгаа юм.

Тэгэхээр манай энэ хуульд маань тэр хэвээр тусгагдах уу? Эсвэл ондоо ямар байдлаар энийг цаашид нь бид хэрэгжүүлж авч явах бол гэсэн асуудал байна.

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүн нэмж хариулъя.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр энд хэлэлцүүлгийн бүх протоколыг үзнэ.

Өөрөөр хэлбэл энийг ямар зорилгоор яаж оруулсан вэ. Тийм ээ. Тэгээд одоо дараа нь нөгөө газрын хэвлийн баялаг, ашигт малтмалын хууль, бусад сангийн хуулиудыг ярих үед Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн энэ заалт яаж ямар үзэл санаагаар орж тусгаа вэ гэдгийг бид протоколуудаа нэг нэгэнгүй шүүж үзэж байгаад тэгээд энэ асуудал дээр яригдана.

Энэ бол бидний дагаж мөрдөх шилжих журмын хуульд байгаа. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулаад, үйлчилсэнтэй холбогдуулаад дагаж өөрчлөгдөх хуулийн жагсаалт дотор энэтэй холбоотой баялгийн сан, ашигт малтмал үүнтэй холбоотой хууль чухал байрыг эзэлнэ гэдгийг хэлье.

Л.Энх-Амгалан: Х.Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Бид нар Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлийг ярьж байна. Одоо бид батлах ёстой.

Гэхдээ би энэ 1992 оны Үндсэн хуулийг үнэхээр сайн хууль болсон гэж боддог юм. Энд 1992 оны Үндсэн хуулийг баталж байсан Ардын Их Хурлын депутат сууж байна. Тэр үед гавьяат хуульч Б.Чимид гуай тэргүүтэй хүмүүс баталсан. Аймаг, 330 сумаас нийт 400 гаруй төлөөлөгч баталсан.

Тэр сайн Үндсэн хуулийг батлахдаа өгүүлбэр битгий хэл цэг, таслал дээр нь хүртэл анхаарсан нь ажиглагддаг юм. Харамсалтай нь 2000 онд сайжруулж байна гэж байгаад нөгөө дордохын долоон өөрчлөлтөөр хамгийн муухай заалтуудыг оруулж ирсэн. Энэ нь улс орны хөгжилд үнэхээр гай тарьсан юм.

Эрх мэдлийн хэт төвлөрөл явагдсан. Гишүүн хүн сайд хийж болдог болсон. Энэнээс эхлээд засаг тогтворгүй байх, мөнгө төгрөгийн янз бүрийн будлиан үүсэх бүх юм эхэлсэн гэж би боддог юм би. Яах вэ, одоо Үндсэн хуулийг хэлэлцээд бид нар дордохын долоон өөрчлөлтүүдийн болохгүй зүйл, заалтуудыг хасаж байна. Мөн устай заалт болгоныг хасах гэж оролдож байна л даа. Гэхдээ бид нар нуухыг нь авах гээд нүдийг нь сохлох гэсэн тийм зарчим зарим зүйл тал дээр алдах эрхгүй. Яагаад гэвэл үндсэн хуулийг нэг л хэлэлцвэл дахиад 8 жилийн дараа хэлэлцэхээс биш өөр наана нь хэлэлцэх аргагүй.

Яах вэ, энэ Үндсэн хуулийнхаа өөрчлөлтөөр орон нутгийн эрх мэдлийг, татварын бодлогоор эрх мэдлийг нэмэгдүүлсэн нь сайн талтай. Шүүхийн шинэчлэлийг бас ерөнхийдөө хийж байна гэж хэлж болно. Мөн Улсын Их Хурал, Ерөнхий сайдын эрх мэдлийг байр байранд нь тавьсан ийм олон сайхан сайн заалтууд орж байгаа.

Тэгэхдээ би энэ дээр ганц би биш. Гишүүд хардаад байгаа тэр тогтолцоо дээр л одоо үнэхээр эсрэг байр суурьтай байна. Ардчилсан намынхан бол тэр намын жагсаалт буюу тогтолцоог үндсэндээ оруулъя гэсэн санал. Эд нар чинь аргагүй шүү дээ, 7 хүмүүс бүгд жагсаалтад ороод долуулаа жагсаалтаар зардал гаргахгүйгээр суухыг бодож байгаа шүү дээ. Манай нам үүнийг зөвшөөрч болохгүй байхгүй юу.

Тэгээд Ардчилсан намын бүлэг гэж байна. Энэ чинь бүлэг ч байхгүй нэг зөвлөл байгаа шүү дээ. Өнгөрсөн 4 жилийн бие даагчийн зөвлөл шиг зөвлөл шүү дээ. Ийм хүмүүсийн саналыг аваад ингээд хүмүүсийг бухимдуулаад байж болохгүй. Ард нийт ч гэсэн тэр жагсаалтаар намын жагсаалтаар суучих вий гэдэг дээр болгоомжилж байгаа шүү дээ. Ер нь 4 жилдээ Их Хурлын гишүүд нь шүүлтүүрээр ороод байх ёстой юм.

Тэгэхгүйгээр би лав энэ Их Хуралд сууж байхдаа хамгийн удсан гишүүдээс хамгийн сайн санаагаар нь, хамгийн улс орныхоо төлөө ажиллах байх гэж боддог байтал тийм биш байдал өнгөрсөн жилүүдэд харагдсан юм. Тэр Оюутолгойн гэрээ, Дубайн гэрээ, Тавантолгойг талыг нь гаднынханд өгөх гэсэн асуудал, эдийн засгийн ил тод байдлын хуулийг болохгүй гэсээр байтал МАНАН-таж байгаад хамтарсан засгийн үед байгуулсан гэх мэтчилэнгээс авахуулаад дандаа улс оронд хохиролтой юмнуудыг энэ хуучин гишүүдээр дамжиж хийгддэг юм.

Тэгэхээр намаар дамжаад олон суусан гишүүд ороод ирвэл энэ улс орны байдал, төрийн дээр нам гараад ер нь тэгээд хүнд байдалд орохоос биш сайн зүйл авчрахгүй. Харин одоо энэ парламентад 39, 40 гишүүн сууж байгаа тулдаа шинэ салхи сэвэлзэж, бас засах юмыг нь засаж байгаа шүү гэж хэлж. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт түүний нэг гэж хэлж болно.

Одоо сайхан ярьж байна л даа. Үгүй ээ. Намын жагсаалтаар явахгүй. Хүн нь урд нь бичигдэнэ гэж. 76 гишүүний гуравны нэгийг 25 гишүүдийн намын жагсаалтаар хүн урд нь тавиад оруулна гэвэл 20 нам оролцоно. 500 хүнээс яаж хүн сонголтоо хийх юм бэ. Энэ чинь амьдрал дээр боломжгүй шүү дээ.

2012 онд яг ийм болсон шүү дээ. Намыг нь урдаа тавьсан. Хүнийг нь тавих гэхээр практик дээр хүн жагсаах тийм олон хүн жагсаах боломжгүй гээд Сонгуулийн хороонд намууд хүнийхээ жагсаалтыг өгсөн. Яг түүн шиг л юм болох байхгүй юу цаашдаа.

Нам нь урдаа байх уу, хүн нь урдаа байх уу. Нэмэгдэхүүний байрыг солихоор нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй гэгчээр ямар ч чанарын ялгаа гарахгүй. Тэгэхээр энэ тогтолцоо гэсэн ийм санаа зовоосон зүйлээ бид нар орхих ёстой гэсэн ийм бодолтой байна. Намын жагсаалт гэдэг үг орж ирж байгаа байхгүй юу. Энэ Үндсэн хуульд орж ирэхээрээ л будлиан тарьж байгаа

юм. Тарина цаашдаа бол. Бүр намын жагсаалт гэж үг байхгүй байхад Үндсэн хуульдаа намын жагсаалтаар ороод цэц дээр сүүлдээ бас унасан байгаа шүү дээ. Тэг чигээрээ 2012 оны Их Хурал нь батлагдаад явчихсан.

Ер нь тэгээд бид ардчиллын гэх 30 жилд 30 миллиард долларын өртэй болчихлоо. Улс орон. Энэ их өр зээлээс жил болгон 1 миллиард доллар нэмэгдэж байна гэсэн үг. Тэгэхээр энийг олон удаа гишүүн сууснаараа, бас намыг бэхжүүлсэн гэсэн байдлаар намын жагсаалтаар үндсэндээ орно л доо. Тийм байдлаар хүн сууснаараа энэ байдлыг арилгахгүй. Дандаа шинэ хүмүүс сонгогдож байж, ард түмний шүүлтүүрээр орж байж бас энэ улс орны эдийн засгийн хүнд байдал сайжирна, өөрчлөгдөнө гэсэн ийм бодолтой байна.

Байгалийн баялгийн талаар сая Ц.Гарамжав гишүүн хэлсэн. Бид нар 20 гишүүн гарын үсэг зурж байгаад томьёоллоо оруулсан байгаа. Стратегийн ордын. Бүх ордыг биш шүү дээ. Стратегийн ордын дийлэнхийн үр ашгийг ард түмэнд үр өгөөж нь очихыг хуулиар тогтооно гээд тодорхой заасан байгаа. Энийг сүүлийн тэр юугаар өөрчлөөд явж байна. Гэхдээ одоо энэ дээр санал хураалгана гэж байна л даа, Энэ дээр гишүүдийг дэмжинэ гэж итгэлтэй байна. Ерөнхий тийм л үг хэлье дээ. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Х.Болорчулуун гишүүн үг хэлэв үү. Тийм ээ. Асуулт асуусан юм уу. Д.Лүндээжанцан гишүүн тэгвэл асуултад нь хариулъя.

Д.Лүндээжанцан: Энэ холимог тогтолцоо буюу тэр намын нэрсийн жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө санал өгөх бол пээ паа гээд байх ч зүйл биш л дээ.

Өөрөөр хэлбэл олон улсад байдаг л зүйл байна. Түрүүн одоо би О.Содбилэг гишүүн надад авчраад өглөө. Тоог нь. 195 улсаас 89 улс нь пропорционал тогтолцоогоор явагдаад л. Тэгээд энэ чинь яваа яваандаа цэвэршинэ шүү дээ. Улс төрийн нам боловсронгуй болно. Ардчилсан ёс, шударга ёсны тогтолцоо нь ч бүрэн дүүрэн шилжих ёстой. Тэгээд бүх шатанд хариуцлага дээшлэх ёстой. Олон түмэнд дургүй хүн одоо тэр жагсаалтад байвал олон түмэн санал өгөхгүй шүү дээ. Санал өгөхгүй.

Тэгээд тэр намыг биш хүнийг нь сонгоно гэж байгаа юм. Хуучин бол энэ нөгөө машин ч байхгүй байлаа. Тэгэхээр өнгө өнгийн 10 нам, 15 нам орлоо гэхэд 15 лист байж байгаад л тэрнээс нь нэгийг нь, өөрийнхөө сонгох гэснийг сугалж аваад. Энэ дотроос хэнийг нь. Намын даргыг сонгох алба байхгүй. Хамгийн сүүлд Я үсгээр эхэлсэн хүн цагаан толгойгоор дараалуулсан байхад тэр хорин хэдэн хүнээс Я үсгээр бичсэн хүн С үсгээр бичсэнийг нь дугуйлаад л тэгээд л хар хайрцагтаа хийчихнэ. Бусад нь хогийн савандаа л хаягдана биз.

Тэгээд ингээд л дүн гарч байх. Тэгээд энэ саналууд нь намын саналдаа тооцогдоод тэгээд суудлаа хуваарилаад тэрэнд авахдаа тэр жагсаалтад орсон хорин хэдэн хүнээс тэр намд 10 суудал ногдож байвал хамгийн олон санал авсан 10 хүн л орно.

Тэрнээс тэр намын авсан санал гээд хаалттай нэрсийн жагсаалтаар нөгөө яг таны түрүүний хэлдгээр Сонгуулийн ерөнхий хороонд өгчхөөд өөр

газар өгдөггүй гэдэг шиг эхний эхний арвыг салгаж аваад авахгүй. Харин тэр ард түмнээс авсан саналаараа орж ирнэ. Тэнд залуу хүн орж ирж болно, ахмад хүн орж ирж болно, өөр салбарын хүн орж ирж болно, малчин хүн ч орж ирж болно.

Энэ үнэхээр парламентад бас нэг салбарын, тэр тухайн салбарын голлох мэргэжилтнүүд үнэхээр хэрэгтэй гэсэн хүнээ олон түмэн улсын хэмжээнд сонгох байх л даа.

Тэгээд үнэндээ тэр тойрог дээр тэр тойргийнхоо итгэл, сонгогчдын итгэлийг хүлээсэн энэ л биднийг төлөөлж аргагүй гарч байгаа гэсэн тийм хүмүүс нь дэвших байх. Тэгээд ингэж гарч ирнэ.

Улсын хэмжээнд тааруу нь юм уу, мундаг нь дэвшдэг. Тойрог дээр болохоор тааруу нь дэвшдэг гэсэн ойлголт байхгүй. Энэ бол тэр тухайн тойргоосоо л яаж сонгогдохоос шалтгаалах ийм учиртай байгаа юм. Энэ протоколд үлдэг гэж бодож байна.

Яагаад гэхээр энэ бол түүх болоод үлдэнэ. Миний аав, ээж Их Хуралд сууж байхдаа сонгуулийн тогтолцооны асуудлаар ийм үг хэлж байжээ гэж. Энэ бол түүх болоод үлдэнэ. Тэгээд судлаачид, оюутан залуучууд та бидний дараа дараа үеийнхэн энийг тодорхой энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн архиваас үзэцгээх болно.

Тэр үед аль нь ханатай ярьж вэ, энэ дээр буруу ойлголттой байж уу, зөв ойлголттой байж уу гээд байх нь байх. Мань бол бүгдийг мэдэгч биш. Тийм учраас буруу зөрүү ярьж байгаа юм бол бишгүй л байгаа байх гэж бодож байгаа. Би бол олон улсын жишиг, ерөнхий хандлагын дагуу л ийм хариултыг өгч байна.

Л.Энх-Амгалан: Х.Болорчулуун гишүүн нэмж тодруулга хийнэ.

Х.Болорчулуун: Д.Лүндээжанцан гишүүн ээ. Яг 1992 оны Үндсэн хуулиар 21.2-ийг өөрчлөхгүйгээр одоогийн байгаа Үндсэн хууль дээр Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын Сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ чөлөөтэй шууд сонгоно гэж байгаа шүү дээ.

Тэгэхээр заавал үүнийг өөрчлөхгүйгээр том тойргоор, улс нэг тойргоор заримыг нь 30 хувийг нь явуулаад, жижиг тойргоор аймгаар явж болох байхгүй юу. Энийг өөрчлөхгүйгээр. Тэгэхээр яагаад энийг заавал жагсаалт гэдэг үгийг нь, намын жагсаалт гэдэг үгийг оруулах гээд байна гэдэг чинь хардлага төрөөд байгаа байхгүй юу. Энийг хэрэггүй ээ. Больчих.

Хоёрт. Та түрүүн хэлсэн. Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр хасагдсан зүйл, заалтуудыг бүр хасаж байгаа гэсэн. Гэтэл энэ тогтолцоотой холбоотой энэ чинь ороод л ирж. Ганцаархнаа. Энэ чинь хардлага төрүүлээд байгаа байхгүй юу. Би энийг танаас асууя. Яагаад энийг ганцааранг нь оруулж ирж байгаа юм.

Л.Энх-Амгалан: Д.Лүндээжанцан гишүүн нэмж хариулъя.

Д.Лүндээжанцан: Манай энэ Б.Бат-Эрдэнэ гишүүн л хамгийн их ярьсан л даа. Зөвшилцөх ёстой гээд. Тэгээд бид зөвшилцлийн төлөө эцсээ хүртэл явж байгаа. Тултал явж байгаа гэж би бас энэ News.mn дээр зарим нь баахан шүүмжилж байх шиг байна.

Үнэхээр тултал зөвшилцөөн. Яагаад гэхээр Үндсэн хууль өөрөө зөвшилцлийн баримт бичиг байхгүй юу. Тэгэхээр энэ зөвшилцлөөр орж ирсэн. Би зөвшилцлийн комисст байдаггүй. Зөвшилцлийн комиссын ахлагч ирээд ийм ийм асуудлаар зөвшилцлөө. Хоёр асуудлаар гээд ороод ирсэн. Тэр дээр ажлын хэсэг дэмжсэн. Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжээд оруулж ирж байгаа.

Хоёрдугаар хэлэлцүүлэг дээр тэр тогтолцоо гэдэг үг хасагдсан. Тийм учраас энийгээ гуравны хоёроор сэргээх асуудал бол нөгөө журмын хуульд нээлттэй байгаа. Нээсэн байгаа. Тэрний дагуу л хоёр асуудал орж ирсэн. Энэ хоёр асуудал нэг нь энэ. Нөгөөдөх нь Ерөнхий сайд танхимаа бүрдүүлэхтэй холбоотой хоёр асуудал ингэж орж ирсэн.

Ард нийтийн санал асуулгын үед хураагдаад 57 хүний гишүүний дэмжлэг аваад, дээш гишүүний дэмжлэг аваад орсон 10 гаруй асуудал байгаа. Тийм ээ. Зарим нь найруулгын шинжтэй. Энийгээ яг тэр хэвээр нь дахиад хураая гэж ингэж Төрийн байгуулалтын байнгын хороо шийдээд өчигдөр ингээд оруулж ирж байна гэж.

Улсын Их Хурлын гишүүнийг шууд гээд бичсэн байхад энүүгээрээ явж болдоггүй юм уу. Хүний төлөө өгч байгаа юм бол гэж та асууж байна. Би энийг юу гэж ойлгож байгаа гэхээр би өөрийнхөө ойлгоцыг ярьж байна шүү дээ. Тэр зөвшилцлийн комисст байхгүй учраас. Юу гэж ойлгож байна гэхээр ер нь сонгууль болгоны өмнө сонгуулийн тогтолцоогоор байнга оролддог. Энийг л болиулах гээд байгаа юм байна. Ерөөсөө энэ олонхын болон... /минут дуусав/

Л.Энх-Амгалан: Г.Тэмүүлэн гишүүн.

Г.Тэмүүлэн: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Бид нар энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлгийг Улсын Их Хурлаар хийж байна.

Ер нь яах вэ, зарчмын хувьд Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулах зайлшгүй шаардлага байгаа. Энэ үндсэн дээр би бас энэ асуудлыг бүрэн дэмжиж байгаа.

Ер нь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд бид нар Монголын төрийг яаж хүчтэй болгох вэ, төрийн албыг яаж тогтвортой байлгах вэ, цаашид Монголын хөгжилд чөдөр тушаа болж байгаа асуудлуудыг хэрхэн шийдэх вэ гэдэг дээр бид нарын санаа бодол бүгдээрээ чиглэгдэж байгаа гэдэгт итгэлтэй байгаа.

Саяын гуравдугаар хэлэлцүүлэг дээр орж ирж байгаа танилцуулгуудыг харлаа. Ерөнхийдөө саналуудын томъёоллыг уншиж үзлээ. Энэ дээр би энэ төрийн тогтолцоотой холбоотой хоёр өөрчлөлт бол бас Үндсэн хуулиар

нэмэлт, өөрчлөлтөөр хийх ёстой байсан гол хоёр ажил маань бас орж ирээгүй байна. Дэмжихгүй байдлаар хоёулаа орж ирсэн байна.

Нэгдүгээр асуудал бол энэ Ерөнхийлөгчийг Улсын Их Хурлаас сонгох өөрчлөлт орж ирсэнгүй. Зуун хувь Улсын Их Хурлын гишүүд гараа өргөөд дэмжих ёстой санал би орж ирсэнгүй гэж харж байна.

Хоёрдугаар асуудал бол энэ холимог тогтолцоо буюу манайхны хэлж заншсанаар сонгуулийн жагсаалтын асуудлыг бас оруулж ирж байна. Энэ асуудлыг би дэмжихгүй. Эхнээсээ энэ хоёр асуудал дээр хатуу байр суурьтай байсан. Өөрийнхөө итгэл үнэмшил дээр ч гэсэн энэ дээрээ байна. Энэ асуудлыг би дэмжихгүй. Нам улс төрийн хүчнүүдийн зүгээс аль энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудалд ямар нэг байдлаар хайрцаглах гэдэг юм уу, ямар нэг улс төрийн хүчний бодлого гэж тулгах шаардлага бол би байхгүй гэж харж байгаа.

Шинэ Үндсэн хуульд эрх зүйт орчныг бүрдүүлэх гэж байгаа асуудал дээр бол гишүүд болгон чөлөөтэй байр сууриа илэрхийлж, чөлөөтэй ард түмний дуу хоолой болж өөрсдийнхөө итгэл үнэмшлийн хүрээнд, одоо нийгэмд хэрэгтэй тэр эрх зүйн орчныг бүрдүүлэх ёстой гэж би харж байгаа.

Нэг асуулт бол энэ Ерөнхийлөгчийг Улсын Их хурлаас сонгодог болгох асуудлыг зөвшилцлийн ажлын хэсэг дээр Ардчилсан намын зүгээс санал болгож оруулж ирсэн. Уг нь энэ хэрэгтэй саналыг яагаад гацчихав даа. Зөвшилцлийн ажлын хэсэг юун дээр очоод гацав, ямар эрх ашгийн үндсэн дээр ярив. Д.Эрдэнэбат гишүүний ярьж байгаагаар энэ асуудлыг ямар нэг байдлаар Ардчилсан намын зүгээс хойш нь татаагүй. Энийг ярихад бэлэн байна гэсэн асуудал ярьж байгаа.

Тэгэхээр би энэ асуудал дээр уг нь улс төржихгүйгээр, намчирхахгүйгээр нэгдсэн нэг тийм байр суурь, ойлголцолд хүрээд шийдэх л ёстой асуудал.

Бид нар ардчиллын зарчмаар, зах зээлийн замаар яваад 28 жил боллоо. Болохгүй бүтэхгүй зүйл энэ олон жилийн хугацаанд бий болжээ. Төр нь төр шиг, улс нь улс шиг хөгжих ийм шаардлага байна. Бид нар 1992 оны сонгуулиас хойш гээд аваад үзэхэд нийтдээ Улсын Их Хурлын болоод Ерөнхийлөгчийн долоо долоон удаагийн сонгуулийг хийсэн байгаад байгаа. Ерөнхийлөгчийн нь тоогоор аваад үзэхээр 5 Ерөнхийлөгчтэй байж үзсэн. Энэ 5 хүн, 5 Ерөнхийлөгч бол тавуулаа муу байсан гэж бид нар хэлж болохгүй.

Тэгэхээр энэ бол хүндээ биш тогтолцоондоо асуудал нь байгаад байна. Тогтолцоо нь өөрөө болохгүй байгаад байгаа учраас энэ хүнээ эвдээд байна гэдэг асуудал л байгаад байгаа. Тэгэхээр энийг ер нь цэгцлэх үүднээс Ерөнхийлөгчийг Монгол Улсын парламентаас сонгодог сонгодог парламентын зарчим руу бид орох нь зүйтэй гэж харж байгаа.

Цаашдынхаа Монгол Улсын хөгжлийн төлөвшилд би бас хэрэгтэй асуудал гэж харж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгч улс эх орны эв нэгдлийг хамгаалах төрийн эрх бүхий дээд албан тушаалтан. Энэ үндсэн дээрээ бас хэрэгтэй асуудал байна гэж харж байгаа.

Тэгээд бид нар ер нь зүгээр парламентын засаглалтай манайх шиг улсад Ерөнхийлөгчөө парламентаас томилдог, сонгодог энэ парламентын сонгодог засаглал руу шилжих асуудлыг бид нар бас оруулж ирэх хэрэгтэй байна. Зөвшилцлийн ажлын хэсэг энэ дээр яагаад санаачилга гаргаж ингэж хандаад байна. Магадгүй улс төрийн өнцөг юунаас хандаж ингэж байна уу. Би энийг ерөнхийдөө ойлгохгүй байгаад байгаа.

Тэгэхээр ер нь зүгээр бид нар үе үеийн парламентаасаа Ерөнхийлөгчдөө тал зассаар байгаад, эрх мэдлийг нь нэмсээр байгаад энэ тогтолцооны согогтой болсны гажуудал өнөөдөр бий үүсэж байна гэж харж байгаа. Тэгэхээр бид нар энийг нэгд өөрчлөх ёстой асуудал байна.

Хоёр дахь асуудал энэ холимог тогтолцоо буюу намын жагсаалт гэж ярьдаг. Ард түмний зүгээс жагсаалтын ард нуугддаг, эргээд буцаж очих тойроггүй гэдэг юм уу буцаж очих эзэн хаяггүй гэдэг юм уу энэ гишүүд бидэнд хэрэггүй гэдэг асуудлыг ард иргэд ярьж байгаа.

2016 оны сонгуулиар бид нар ч гэсэн бүх баг, сум, хөдөө орон нутаг, дүүрэг дээр очиж ярьж байхад бүгд энийг л ярьж байсан. Хоёр, гуравхан асуудлыг хөндөж байсан. Дан дээл, давхар дээл, жагсаалтын асуудлыг ерөөс байхгүй болгож өгөөрэй гэсэн асуудлыг ярьж байсан.

Тэгэхээр би угаасаа энэ холимог тогтолцоо бол хэрэгжих боломжгүй гэдгийг хараад байгаа. Нэгдүгээрт, техник, технологи болоод тухайн цаг хугацааны хувьд 30 нам байлаа гэхэд 25 хүн дэвшүүлээ гээд аваад үзэхэд нийт 750 хүнээс бид нар яаж сонгох юм бэ. Цаг хугацааны хувьд хэдэн цаг, өдрийг зарцуулах вэ, хэчнээн цаг минутыг зарцуулах вэ, техникийн хувьд бид нар энийг тоолох, эсвэл юу гэдэг юм энэ саналыг хураах боломж бололцоо байгаа юу, үгүй юу. Нөгөө шударга зарчим, асуудал талаасаа хандаад аваад үзэхээр намаас тухайн тэр жагсаалтын 25-д ямар, хэд дэх нэр дээр хэн жагсах вэ гэдэг асуудлууд гарч ирнэ. Магадгүй эмэгтэйчүүд, залуучууд магадгүй 20-иос хойш л жагсана. Энэ чинь нөгөө шударга зарчмаа хадгалж чадах уу. Тэгэхээр би энэ дээр худлаа байна гэж би хараад байгаа.

Тэгэхээр саяын тэр холимог тогтолцоо буюу жагсаалтын асуудлыг оруулж ирж байгаа асуудал бол улс төрийн нам цэвэрших энэ тогтолцооны эсрэг асуудал орж ирж байгаа гэж харж байгаа. Улс төрийн нам эрүүлжих энэ тогтолцооны эсрэг асуудал орж ирж байна гэж би харж байгаа.

Өнөөдөр Монголын нийгэм дэх энэ улс төрийн нам, хүчнүүдийн нэр хүнд унасан. Улс төрийн соёл, төлөвшил нийгэмд бий болоогүй, төлөвшөөгүй өнөөгийн нийгэмд бид нар хэрэггүй заалт юм биш үү. Бусад өөр улсад байж болно. Гэхдээ өнөөдрийн Монголын нийгмийн тогтолцоонд би зохицохгүй заалтын асуудлууд байна. Магадгүй тэр эхний хүнийг сонгоно гэж ярьж байгаа боловч эхний тав, аравт хэн жагсах юм бэ гэдэг асуудал нь улс төрийн нам, хүчнээс бүрэн хамааралтай асуудал.

Эхний тав аравт жагссан хүн бол магадгүй нөгөө бух залсан гэдэг шиг л тэр тав арав хүн бол байнгын сонгогддог, арав хорин жилээр тухайн төрдөө байдаг энэ асуудал гарч ирнэ. Ноёны бөх. Ноёны бөхийг бид нар сонгохгүй

гэж яриад байна. Ноёны бөх чинь өөрөө ноёнттойгоо хамт орж ирэх тогтолцоог л бид нар гаргах гэж хараад байна уу даа гэж би хараад байна.

Тэгэхээр энэ бол би буруу гажуудал. Ардчилсан зарчмаараа, шударга зарчмаараа ард түмэндээ дүнгээ тавиулаад сонгогдоод, эргээд сонгогдохгүй нь дүнгээ тавиулаад явдаг нь энэ тогтолцоо нь өөрөө зарчмын хувьд зөв болов уу.

Ер нь Д.Лүндээжанцан гишүүний хэлсэнтэй санал нэг байгаад байна. Сая сонгууль болгоны өмнө сонгуулийн тогтолцоогоо өөрчилдөг гэдэг асуудал өнөөдөр Монголын нэг эмгэнэл. 7 сонгуулийн өмнө бид 7 өөр тогтолцоогоор явж ирсэн. 7 өөр сонгуулийн асуудлыг ард түмэнд тулгаж оруулж ирж байсан асуудал байгаа. Сонгуулийн тогтолцоог өөрчлөх бол ард түмэнд ямар ч ашиг байхгүй. Нөгөө талдаа улс төрийн хүчин, улс төрийн намуудад хэрэгтэй л зүйлийг бид нар өөрчилж байгаа асуудал байгаа болохоос биш ер нь энүүгээрээ тоглох зайлшгүй шаардлага байхгүй гэж харж байгаа.

Тэгэхээр эцэст нь дүгнээд хэлэхэд яах вэ зүгээр ард иргэдийн хүсээгүй юмыг бид нар хүчлээд хэрэггүй байх. Аль нэг намын өнцгөөс гэдэг юм уу, хувь хүний өнцгөөс гэдэг юм уу, улс төрийн цаг үеийн нөхцөл, байдалд нийцүүлж энийг өөрчлөх шаардлага байхгүй. Энэ хоёр заалтыг хоёуланг нь дэмжихгүй байгаад байгаа.

Бусад асуудлуудыг бүрэн дэмжээд явж байгаа. Монгол Улсын хөгжил дэвшил, цаашдын ирээдүйд хэрэгтэй зүйл, заалт байна гэж харж байгаа.

Л.Энх-Амгалан: Зөвшилцлийн ажлын хэсэг. Л.Оюун-Эрдэнэ гишүүн хариулах уу. Л.Оюун-Эрдэнэ сайд.

Л.Оюун-Эрдэнэ: Баярлалаа. Х.Тэмүүлэн гишүүний асуултад хариулъя.

Би яг адилхан байр суурьтай байсан гэдгийг бас хэлэх нь зүйтэй байх. Миний гарт одоо Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын тухайн үеийн Үндсэн хууль баталж байсан 12 дахь тэмдэглэлийн хоёрдугаар хуралдаан байж байна.

Энэ бол Ерөнхийлөгчийг парламентаас сонгох уу, аль эсвэл ард түмнээс сонгох уу гэдэг маргаан явсан ийм хуралдааны тэмдэглэл. 1991 оны 12 дугаар сарын 1-ний өдөр. Жишээ нь, энд П.Улаанхүү гишүүн бол тухайн үед ингэж хэлсэн байгаа юм. Ерөнхийлөгчийн биш, парламентын биш, Франц маягийн системийг бид авах болчихоод байна. Гэтэл энэ систем Францдаа ч таардаггүй. Францдаа таардаггүй учраас маргаантай байна. Үүнээс болж Үндсэн хууль ойрхон ойрхон өөрчлөгдсөн байдаг. Унгар, Чех, Польш гэх мэтийн улсууд энэ системийг аваад өнөөдөр хямралтай явж байгаа нь энэ тогтолцоотой холбоотой гэж.

Тэр үед 148, 148 хүнээр санал тэнцэж, нэг өдөр завсарлаж, О.Дашбалбар тэргүүтэй Ардын Их Хурлын төлөөлөгчид Ерөнхийлөгчийг ард түмнээс сонгох нь зүйтэй гэж. Санжаасүрэнгийн Зориг нарын залуучууд

онолын хувьд болохгүй гэсэн ийм томоохон маргаан үүсэж. Энэ үед Германы мэргэжилтнүүд тухайн үеийн Үндсэн хууль батлалцаж байсан гишүүдэд ирээдүйд хоёр Засгийн тэргүүнтэй, төр засаг тогтворгүй, эдийн засаг хүндрэх нь. Энэ асуудал дээр Та бүхэн системийн томоохон гажуудлыг хийж байна гэж сануулж байсан байдаг юм билээ.

Яагаад би энийг ингээд авсан бэ гэхээр зөвшилцлийн ажлын хэсэг дээр үүнийг эцсийн мөч хүртэл явуулах гэж хичээсэн. Энийг одоо манай Д.Лүндээжанцан дарга болон зөвшилцлийн ажлын хэсэгт байсан хүмүүс үүнийг бүгдээрээ анхаарч харж байсан.

Хамгийн сүүлд Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргад, Монгол Улсын Ерөнхийлөгчид энэ бол яг түүхэн хариуцлага юм. Төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн тусгаар тогтнолыг эрхэмлэн дээдэлж ард түмнээс сонгогдсон сүүлчийн Ерөнхийлөгч байхыг хүлээн зөвшөөрөв. Халтмаагийн Баттулга гээд бичээд өгөөч ээ гэж хүртэл орж уулзсан. Ингэх юм бол та яг Хорлоогийн Чойбалсан гэдэг хүн шиг түүхэн хүн болох байх гэж.

Тэгэхээр яах вэ миний хувьд ч гэсэн тантай санал нэг байгаа. Энэ Үндсэн хуулийн олон үзэл санаа, дэвшилттэй олон чухал асуудлууд гарч байна. Гагцхүү бид нар хагас парламентын, хагас Ерөнхийлөгчийн засаглалын асуудлыг үндсэндээ шийдэж чадахгүй бид нар дараагийн 30 жил явах болж байна. Гэхдээ яах вэ чамлахаар чанга атга гэдэг шиг бид нар Монгол Улсын Ерөнхийлөгчийг нэг удаа 6 жилээр сонгох ийм асуудал руу шинэ соёл руу явна гэсэн үг.

Ерөнхийлөгч 6 жилээр нэг удаа сонгогдоно гэдэг бол тухайн үед нэр дэвшсэн намдаа дахиж барьцаалагдахгүй байх ийм баталгааг өгч байгаа юм гэж бас үзэж болно. Нөгөө талаараа дахиж сонгогдохгүй учраас тэр хүн ямар нэгэн байдлаар хууль хяналтын байгууллагад ноёрхлоо тогтоох, ямар нэг байдлаар улс төрийн акц хийх зорилгоор хууль хяналтын байгууллагыг хөдөлгөх ийм асуудал үлдэнэ гэж бодож байгаа.

Би тантай яг санал нэг байдаг. Өнгөрсөн хугацааны үе үеийн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нарын дунд байсан зөрчил бол хувь хүнээс болж байсан зүйл бага хэсэг. Ихэнх нь дандаа Ерөнхийлөгчийн институци Засгийн газар хоёр эрх мэдлээ булаацалдсан энэхүү нөхцөл байдлаас болж ийм нөхцөл байдал руу орж байсан юм гэдгийг хэлэхийг хүсэж байна.

Тэгэхээр яах вэ энэ бол ингээд протоколд үлдэх нь зүйтэй. Таны хувьд чухал зүйлийг хөндөж байгаа. Миний хувьд ч гэсэн өнөөдрийг хүртэл Үндсэн хууль батлалцах энэ бүх процесст орж явахдаа энэ зүйлийг шийдэхийн тулд, зөвшилцөхийн тулд, ойлгуулахын тулд одоо бас чадах бүх зүйлээ хийж явсан. Тэгээд энийг бас дараагийн үед дахиж ярьж, энэ тогтолцоо шийдлээ олж. Парламентын засаглал гэдэг бол хүчтэй Ерөнхий сайдын засаглал юм гэдгийг ойлгодог ийм цаг үе Монголын ард түмэн, улс төр судлаачид, сонгогдсон парламентын гишүүн, сонгогдсон Ерөнхийлөгчийн хувьд ирэх ийм цаг ирэх байх гэсэн итгэлтэйгээр энэ протоколд тэмдэглүүлж үлдээе гэж бодож байна. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Баярлалаа. Ж. Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Үндсэн хуулийн өөрчлөлтийг үндсэндээ бид нар ингээд батлаад явах нь зүйтэй гэж үзэж байгаа юм.

Хоёр асуудал орж ирж байгаа. Нэгдүгээрт, Ерөнхий сайдын эрх мэдлийг чангатгах, сайжруулах, хүчтэй Ерөнхий сайдын засаглалыг бий болгох гэдэг асуудал орж ирж байгаа. Энэ дээр үндсэндээ дэмжиж байгаа.

Ер нь Улсын Их Хурлаас Ерөнхий сайдын буюу Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг баталж өгдөг. Тэр мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой хэмжээний өөрсдийнхөө ажлыг зохицуулаад, өөрсдийнхөө зохион байгуулалтыг хийгээд, Ерөнхий сайд явж байдаг энэ бүрэн эрх мэдлийг нь олгоё гэсэн. Энэ асуудал бол урд нь ч бид нарын хэлэлцүүлэг дээр яригдаж байсан. Тэгээд яг цагаа тулаад энэ маань унасан шүү дээ. Тэгэхээр дахиж орж ирээд явж байгаа нь зөв зүйтэй.

Нөгөө талаар одоо өнөөдрийн Монгол Улсын хямралд ороод байгаа байдал бол хууль гэхээсээ илүү үндсэндээ хүнээс маш их шалтгаалж байгаа. Хүнээсээ л шалтгаалж байгаа.

Тэгэхээр бид өнөөдөр Үндсэн хууль, дагалдах хууль нь дараа нь орж ирнэ. Хуулийнхаа цэвэршил, хуулийнхаа шинэчлэлүүдийг хийгээд явна. Хууль гэдэг маань өөрөө би хариуцлага гэж тооцож байгаа. Тодорхой хэмжээнд, Улсын Их Хурал, Засгийн газар холбогдох байгууллагууд, төрийн байгууллагууд эд нар төрийн үйл ажиллагааг хэрхэн авч явах дээр энэ зохицуулсан хуулиудаа хэрхэн мөрдөх вэ гэдэг талаасаа бид нар гол нь харж байх ёстой.

Тэгэхийн тулд нэгдүгээрт хууль нь зөв байх ёстой. Хоёрдугаарт хариуцлагын тогтолцоо байх ёстой. Өөрөөр хэлбэл хуульд хариуцлагын тогтолцоо зөв суусан байх ёстой. Хариуцлагын цаана хэн байна гэхээр түрүүн миний ярьдаг хүн л байх ёстой. Ёс зүйтэй, хуулиа дагасан ийм төрийн хүн, төрийн байгууллагыг удирдаж явж байгаа удирдах албан тушаал байх ёстой гэж ойлгож байгаа.

Тэгэхээр хүн гэдэг асуудлыг. Өөрөөр хэлбэл, зүгээр одоо Улсын Их Хурал дээр авч үзье, Засгийн газар дээрээ авч үзье. Энэ хүнтэй холбоотой, Улсын Их Хурлын гишүүнтэй холбоотой асуудлын хариуцлагыг яаж бид нар сайжруулах вэ, яаж сайжруулах вэ. Нэгдүгээрт, хууль нь байгаа. Хоёрдугаарт, Улсын Их Хурлын гишүүдийн тодруулаад хэлэхэд хариуцлагатай асуудал бол ард иргэдийн хяналтаас хамаарна. Ард иргэдийн хяналтаас хамаарна.

Үндсэн хуулиараа бид нар ард иргэдээ шууд сонгоно гэж байгаа. Нэгдүгээрт, Улсын Их Хурлын гишүүдээс шууд сонгоод. Тэгээд тэнд чинь буцаад тэр тойрог дээр нь ард түмэн өөрсдөө тэр гишүүн хэрхэн ажиллаж байна вэ гэдэг дээр хяналт тавьж байгаа шүү дээ. Хяналт тавьж байгаа.

Одоо хоёр гишүүн маань тайлбар хийгээд л байна. Д.Лүндээцанцан дарга маань нэлээн тайлбар хийж л байна.

Аливаа зүйл дээр нэг тийм бүр баттай зөв гэсэн асуудал байхгүй шүү дээ. Бүх зүйл хоёр талтай. Д.Лүндээжанцан гишүүн өнөөдрийг хүртэл маш олон жил сонгогдсон. Тойрогтоо маш зөв зүйтэй ажлууд хийгээд ард түмний итгэлийг хангаад өнөөдрийг хүртэл зөв зүйтэй явж л байгаа.

Тэгэхээр энэний цаана буцаад ард түмэн дээр очих, тэд нартайгаа ажиллах, тэднийхээ амласан зүйлийг хийх, ард түмнийхээ иргэдийн сайн сайхан байх асуудлыг хариуцаж явах, тэдний төлөө төлөөлөл болж энэ танхимд ажиллах гэсэн энэ том хариуцлагыг эргэж тэр хүмүүстэйгээ уулзах улаан нүүр буюу тэр хүмүүсийн хяналт доор бид нар ажиллаад зөв зүйтэй явж байгаа шүү дээ. Ард иргэдийн болоод Улсын Их Хурлын гишүүдийн хоорондын холбоо холдох тусмаа тэр ажлын хариуцлага бол Улсын Их Хурлын гишүүний хариуцлага холдоод явж байгаа юм.

Тэгэхээр үүнээс юу хэлэх гээд байна вэ гэхээр үндсэндээ энэ холимог тогтолцоо гэдэг дээр бид хараахан ийшээ орох нь болоогүй л гэж үзэж байгаа. Монгол Улсын хувьд бас онцлог байгаа. Бид цөөхөн хүн амтай. Бие биенийгээ сайн мэднэ. Бид тэр хөгжсөн орнууд, төлөвшсөн, ард иргэд нь төлөвшсөн, сонгогчдод нь төлөвшсөн, улс төрчид нь төлөвшсөн ийм тэгээд нам нь төлөвшсөн шүү, ийм улсуудтай бид нар бас ингэж зүйрлэж болохгүй байгаад байна. Дээр нь тэнд чинь хэдэн арван, хэдэн зуун сая хүнтэй ард түмэн ийм улс орнууд байгаад байна шүү дээ.

Тэгэхээр өөрийнхөө нутаг оронд төлөвшсөн, суусан суурьшсан, нутагшсан энэ хүн хүнээ мэддэг, хүн хүнээ сонгодог, буцаад эргэж сонгогчидтойгоо уулзах боломж бололцоо нь нээлттэй байж байгаа энэ тогтолцоогоо аваад өөрөөр хэлбэл одоо мажоритар тогтолцоо дээр яваад нэг хэсэгтээ яваад үзсэн нь зүйтэй байх гэж бодож байна.

Ард иргэдээс нэлээн бухимдалтай байгаа. Өөрөөр хэлбэл урьдын 2012 оны сонгууль дээр үүдээр гараад явсан хүн тооноор орчихлоо гэдэг асуудал өнөөдрийг хүртэл яригдаад байгаа шүү дээ. Яагаад гэхээр тэр гишүүнээ хангалтгүй ажиллаа гээд хэлсээр байтал дараагийн сонголт дээр гүйж очоод тооноор ороод ирлээ гэдэг ч юм уу, буцаад нам дагаж яваад буцаж ороод ирлээ гэдэг энэ асуудал л яригдаж байгаа юм. Тэгэхээр гол асуудал өнөөдрийн хувьд энэ холимог тогтолцоо гэдгийг дэмжмээргүй байна. Дэмжихээргүй байна. Үүнийг хуучнаараа явъя гэсэн ийм саналтай байна.

Сая тэр Ерөнхийлөгчтэй холбоотой асуудлууд сөхөгдөж байх шиг байна. Нэгэнт орж ирээгүй асуудал. Гэхдээ ер нь ард иргэдээсээ төлөөлөл болоод энд орж ирж байгаа 76 гишүүнээс Монгол Улсынхаа Ерөнхийлөгчийг сонгоод явах нь зүйтэй л гэж үзэж байгаа. Бид аль болох ойрхон байж, бид аль болох тэр хүнтэй ойрхон ажиллаж, нэг бодлоготой, нэг зорилготой, нэг хөтөлбөртэй ажиллах нь бол улс орны эдийн засагт нэн тэргүүний чухал үүрэг гүйцэтгэх ёстой гэж ойлгож байгаа. Өнөөдөр үндсэндээ Монгол Улс маань бас нэлээн хүнд байдалтай байгаад байгаа шүү. Хүнд байдалтай байгаа. Эдийн засаг хүндэрсэн байж байна. Гадна байгаа зээл, тусламжийн асуудлууд хүндэрсэн, эдийн засаг эргэлтэд орох процесс нь аажим болсон, удааширсан ийм нөхцөл байдалд байгаа шүү дээ. Энэ дээр улс төрчдийн зөв хандлага байж, зөв тогтолцоотой байж, цаашаа эдийн засгаа хөгжүүлээд

эрчимжүүлээд авч авч явах нь энэ нийгмийн чинь тогтолцоо нь чухал байгаа юм гэдэг дээр анхаарал хандуулж байгаа юм. Баярлалаа.

Л.Энх-Амгалан: Ж.Бат-Эрдэнэ гишүүн үг хэллээ. Ц.Даваасүрэн гишүүн алга байна. Б.Чойжилсүрэн гишүүн алга байна. Б.Баттөмөр гишүүн. Гишүүд хуралдааны танхимд орж ирээрэй. Гишүүд үг хэлж дуусаж байна. Одоо ингээд санал хураалт явагдана.

Б.Баттөмөр: 1992 оны Үндсэн хууль муу хууль байгаагүй. Баталснаас хойш 30-аад жилийн хугацаа өнгөрлөө. Ер нь энэ Үндсэн хуулийг хэрэгжүүлэхдээ бусад хуулиудад тусгаж, тусгахдаа бид нар ихээхэн алдаа гаргаж, энэнээс үүдэлтэй одоо хөгжлийн хоцрогдол, маш их олон зүйлүүд бий болсон. Гэхдээ энэ хуулиас болоогүй гэдгийг би хэлэхийг хүсэж байна.

Өнгөрсөн 30 жилийн хугацаанд ардчилал, зах зээлийн нийгэмд шилжсэн 30 жилийн хугацаанд Монгол Улс хоцрогдолд орсон. Олон үзүүлэлтүүдээр батлагддаг. Хоцрогдол нь бол төрийн тогтолцооны гажиг. Төрд ажилласан хүмүүсийн хариуцлагагүй байдал гэсэн ийм хоёр зүйлийг судалгааны хүмүүс гаргаж хэлдэг. Ялангуяа сахилга, хариуцлага гэдэг үг монгол хэлний үсгийн сангаас хасагдсан. Энэний оронд ардчилал, зах зээл, хүний эрх гэдэг зүйл хэдэн зуу дахин илүү хэрэглэгддэг болсон.

Тэгэхээр ер нь яах вэ энэ сахилга, хариуцлага гэдэг юм бол ерөөсөө амжилтын үндэс гэж байгаа юм. Тэгэхээр сахилга, хариуцлагатай байх чиглэлд олигтой юм хийж чадсангүй. Хууль тогтоомждоо үүнийг тусгаж чадсангүй. Яг ийм яваад байгаа учраас одоо Монголд юу гэхээр хийсэндээ халтай, хийрхсэндээ ээлтэй энэ нийгмийг бид нар 30 жилд бий болгосон. Энэ бол бидний яах аргагүй алдаа юм гэж.

Ер нь тэгээд хүний эрх, эрх чөлөө гэдэг бол хөгжил дээр суурилдаг. Бид нар Монголд хөгжил байхгүй байгаа учраас хүний эрх, эрх чөлөө хангагдахгүй байгаа. Ярьснаар бол багадахгүй.

Ер нь Монголд яг өнөөдрийн байдлаар гурван хүний хоёр нь ядууралд автсан байгаа. Тэгээд ядуурал юунаас болов гэхээр 1992 онд Үндсэн хууль баталж байхтай уялдуулаад бий болсон өмч хувьчлалын алдаа. Өмч хувьчлалаар маш олон хүн гудамжинд гарсан. Өмч маань яг эзэндээ зөв очоогүй. Энэнээс үүдэлтэйгээр өнгөрсөн хугацаанд гаргасан бүх алдаа ядуурлыг дэвэргэж ийм байдалд орлоо. Өнөөдөр гурван хүний хоёр нь Монголд ядуу байна. Үүнийг хэлэхийг хүсэж байгаа.

Өнгөрсөн 30 жилд Монгол Улсын уул уурхайн салбарт явуулсан бодлого Монгол Улсын төдийгүй дэлхийн байгаль орчинд, экологид үзүүлж байгаа их том гэмт хэрэг гэж хэлж болохоор байгаа. Маш олон мянган гол горхи ширгэсэн. Байгаль экологийн маш их олон өөрчлөлтүүд гарсан. Энийг бол экологийн эсрэг хийсэн гэмт хэрэг гэж үздэг байна билээ. Бидэнд ёс зүй, хариуцлага, шударга ёс, үнэт зүйл гэж байхгүй болсон. Үндсэндээ шугуйн дүрмээр амьдарч байгаа. Шугуйн дүрэм гэдэг юу гэхээр чадалтай нь чадалгүйгээ барьж иддэг ийм л орчныг хэлж байгаа юм. Ийм зүйлийг бид 30 жилд бий болгосон байна.

Монгол Улсын сүүлийн үед төсөв, төлөвлөгөө, энэ зүйл дээр ажиллаад ирэхээр Монгол Улсын хөгжлийн зардал асар их өндөр болчхож. Монгол Улс ер нь цаашдаа энэ улс орноо авч явах зардлыг нь дийлдэхгүй болсон байгаа. Халамж гээд л ингэж байж байгаа. Хэрэгтэй хэрэггүй зүйл төлөвлөдөг. Энэ бол хөгжлийн зардлыг өндөр болгоод байгаа юм. Энэ хөгжлийн зардал яагаад өндөр болоод байна вэ гэхээр засаглалын хомстол, хөгжлийн бодлого тодорхойгүй, хөгжлийн загвар нь бас тодорхойгүй, захиргааны хүнд суртал ихтэй, авлига хээл хахууль ийм ихэссэн, мэдлэг чадварын хомстол гэдэг зүйл байна. Дээр нь улс төржилт. Тэгээд энэнээс үүдэлтэй мэргэжлийн бус шийдвэрүүд гардаг болсон. Энэ бол Монгол Улсын хөгжлийн зардлыг их өндөр болгож байгаа юм.

Өнөөдөр гарч байгаа шийдвэрүүд хоёроос гурван жилийн дараа үр дүнгээ өгнө. Үүнийг л хөгжил гэж байгаа юм. Үр дүн нь гарч л байвал. Одоо өнөөдөр Монгол Улс 3 сая хүнтэй, 34 улс төрийн намтай. Уг нь намууд юу гэхээр улс орноо хөгжүүлэх хөгжлийн тэр бодлогоороо өрсөлдөх ёстой байгаа юм. Гэтэл ийм юм байхгүй. Нам гэдэг нэрийн дор хэдхэн хүний эрх ашиг, бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалдаг ийм л зүйл болчихсон. Энэ юу яагаад ингээд яриад байна гэхээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд Монголд бий болсон зүйлийг ярихаас өөр арга байхгүй. Алдаа дутагдлаа ярьж, засаж байж цааш хөгжих ёстой юм.

Бид нар яах вэ, монголын ард түмэн тансаг амьдрахыг хүсээгүй, тайван амьдрахыг хүсэж байгаа юм. Гэтэл тайван амьдарч чадахгүй байна. Яаж тайван амьдардаг вэ гэхээр ажилтай, орлоготой ийм л байх ёстой. Гэтэл тэр ажил, амьдралыг нь зохицуулж чадахгүй байна шүү дээ.

Шийдэх ёстой асуудлуудаа цаг хугацаанд нь шийдэж чадаагүй учраас өнөөдөр бид нар хэтэрхий томдсон хойно нь шийдэх гэж оролдоод, цаг хугацаа алдаад ингээд яваад байгаа юм. Ийм учраас энэ бид нарын цаашдын хөгжилд маш их том сургамж болж байна л даа.

Тогтсон бодлогогүй бол хэчнээн баялагтай улс ч гэсэн колони болдог гэж үг байгаа шүү дээ. Монгол Улсын гадаад өр 30-аад тэрбум доллар болсон байгаа. Зорилгоо биелүүлэхгүй бол зорилгоо өөрчлөх биш, арга барилаа өөрчил гэдэг үг байдаг. Бид арга барилаа өөрчлөхөөс өөр аргагүй байдалд орсон байгаа юм. Ийм учраас бид нар энэ Үндсэн хуулийн өөрчлөлтүүдийг хийх шаардлага бол байна. Энийг би өнөөдөр хэлье гэж бодож байгаа юм. Монгол Улсын хөгжлийн загвар тодорхойгүй. Цаашдаа яаж хөгжихөө одоо хүртэл шийдлээ олоогүй ийм л байдалтай байгаа шүү дээ. Энэ зүйлүүдийг хэлээд нэг асуулт байгаа юм л даа.

Сая түрүүн манай С.Бямбацогт гишүүн ярьж байсан. Энэ Монгол Улсын хөгжлийн асуудал бол урд Үндсэн хуульд тодорхой тусгагдаагүй гэж. Ер нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийг яаж авч явах вэ. Монгол Улс хөгжлийн асуудал тодорхойгүй. Эзэн тодорхойгүй. Ийм байдалтай явж ирсэн. Монгол Улсын хөгжлийн бодлого тогтвортой байна гэснээр бүх асуудлыг шийдэж чадах уу? гэсэн ийм .../минут дуусав/

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Тийм. Б.Баттөмөр гишүүн өөрөө бас хэллээ. Үнэхээр бодлого, төрийн бодлого тодорхой байх ёстой. Төрийн бодлого тогтвортой байж байж улс орон хөгжинө. Үүнтэй холбоотой асуудлууд орхигдсон байсан. Үүнийг Үндсэн хуульд тодорхой хэмжээнд суулгах ёстой гэдэг дээр Б.Баттөмөр гишүүн, нэлээн хэдэн гишүүд хамтарч санал гаргасан байгаа. Тэгээд Үндсэн хуулийн 25.1.7-д улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг батлах. Энэ бол Улсын Их Хурлын онцгой бүрэн эрх байна гэсэн шинэ заалтуудыг нэмж оруулсан байгаа. Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна гэдэг заалт орж ирж байгаа. Ийм өгүүлбэр.

Үндсэндээ энэ хоёр өгүүлбэрийн цаад талд маш том агуулга, маш өргөн утга, агуулга агуулагдаж байгаа. Өөрөөр хэлбэл үүнтэй холбоотойгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиа батлах, шинэчилж найруулах. Үүндээ бас улс орны хөгжлийн алсыг харсан бодлого гэж юу байх юм. Энэ нь урт хугацааны бодлого нь дунд хугацаатайгаа яаж уялдах юм. Дунд хугацаа нь богино хугацаатайгаа яаж уялдах юм. Мөн салбаруудын бодлого хоорондоо яаж уялдах юм. Улс бүс нутгийн бодлого, орон нутгийн бодлого, энэ төвтэйгөө яаж уялдах юм гэх мэт зүйлүүдийг маш сайн тусгаж өгөх ёстой.

Үүнийг хэрэгжүүлэх байгууллага, бүтцийг бий болгох ёстой. Өнөөдөр бид нар Үндэсний хөгжлийн шинэтгэлийн хороо гэж анх 2008 онд байгуулж байсан. Дараад нь Эдийн засгийн хөгжлийн яам байгуулж байсан. Өнөөдөр Үндэсний хөгжлийн газар ажиллаж байгаа. Гэтэл урд нь үндсэндээ Монгол Улсын төлөвлөлтийг нэгдсэн бодлогоороо зангидаж удирдах ёстой энэ байгууллагуудын маань чиг үүрэг, эрх мэдэл хуулиар хүлээсэн чиг үүрэг нь харьцангуй хангалттай биш гэдэг юм уу, зохицуулалт муутайгаас болоод өнөөдөр асуудал шийдэгдэхгүй байгаа.

Тийм болохоор бид нар Монгол Улсын Шадар сайдын дэргэд хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хариуцсан, энэ яамдын бодлогыг нэгтгэсэн, төв орон нутгийн бодлогыг хооронд нь уялдуулсан, салбар хоорондын болон төвийн бодлогыг урт, дунд, богино хугацаанд хугацаагаар нь уялдуулсан ийм тодорхой бүтцийг бий болгох ёстой гэж үзэж байгаа.

Тийм болохоор Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулиар энэ асуудлыг шийдэх ёстой. Цаашдаа Монгол Улсын Шадар сайд энэ асуудлыг хариуцаж, Засгийн газар энэ асуудлыг нэгтгэж явах ийм чиг үүрэгтэй болох ёстой.

Энэ дээр бусад улс орнуудын маш сайн туршлагауд байгаа бас. Хятад Улсын Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо байж байна. Оросын Холбооны Улсынх байж байна. Сингапур Улсынх байж байна. Казахстан Улс гээд бидэнд бас аваад үзэх юм бол маш сайн энэ хөгжлийн бодлогоо зөв тодорхойлж, улс орныхоо төрийн хар хайрцгийн бодлого, алсын хараагаа зөв тодорхойлж, түүнийгээ хэрхэн яаж хэрэгжүүлэх вэ гэдэг дээр төлөвлөдөг, зохион байгуулдаг, хэрэгжилтэд нь хяналт тавьдаг ийм том бүтцийг бий болгож байж явах ёстой. Ингэхгүйгээр бид өнгөрсөн 20-оод жил энэ салбар хоорондын бодлого, энэ хөгжлийн бодлого, урт, дунд хугацаандаа уялдахгүй байгаа байдал маань. Тэгээд дээрээс нь хэт их улс төрждөг. Бие биеийнхээ

явуулж байгаа бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааг үгүйсгэдэг байдал маань өнөөдөр Монгол Улсын хөгжлийн чөдөр, саад тушаа болж байгаа. Үүнийг Үндсэн хуулиараа шийдэх бололцоо боломж нээгдэж байгаа нь энэ удаагийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн бас нэг чухал бүрэлдэхүүн хэсэг.

Г.Занданшатар: Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууна.

Ш.Раднаасэд: Хэд хэдэн зүйл тодруулъя. Одоо байгаа Үндсэн хууль дээр 39.2.3 дээр байна уу. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүнийг өөрчлөлт оруулах төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөж байгаа. Зөв үү? Бүтэц бол танхимын бүтэц. Хэдэн салбарын яамтай байх, хэдэн Засгийн газрын гишүүнтэй байх юм.

Бүрэлдэхүүн гэхээр хүний асуудал явна. Тэгэхээр энэ нэг зөвшилцөнө гээд 39.3 дээрээ бид нар оруулаад ирсэн байна. Дахиад 39.4 дээрээ Засгийн газрын гишүүнийг Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна гэж байгаа. Зөвшилцөл чинь хоёр удаа явагдах гээд байна уу? Бүрэлдэхүүнийг ярих гэж байгаа бол зайлшгүй зөвшилцөл хийгдэнэ. Одоо байгаагаар. Дахиад Засгийн газрын гишүүний асуудлыг ярихаар “танилцуулснаар” гэдэг нь дахиад нэг үе шат шинээр нэмэгдээд ороод ирэх юм. Энийгээ яг яаж харж байгаа юм. Энд нэг давхардал үүссэн байх шиг харагдаад байна.

Хоёр дахь зүйл. Улсын Их Хурлын гишүүд Үндсэн хууль зөрчсөн тохиолдолд зөрчсөн нь тогтоогдох юм бол гишүүнээс эргүүлэн татна гэж байна. Энэ бол шинэ заалт. Одоо энэ цэц дээр тангаргаасаа няцсан энэ Их Хурлын гишүүн гээд маш их хэмжээний өргөдөл явдаг. Ийм зүйл гарах уу, үгүй юу. Бусад улсын жишиг ийм байна уу, ямар байна? Яг энэ шалгуурыг нь өөрчлөхгүй бол өнөөдрийн нөхцөл байдал ер нь цааш цаашдын хорин хэдэн жилийн явсан улс төрийн нөхцөл байдлын юмыг ярихад ерөөсөө энэ дайрсан давшилсан энэ юм чинь эцэс төгсгөлгүй явна. Үүнийгээ ер нь яаж харж байгаа юм бэ? Байнгын хорооны дарга аа.

Гурав дахь юм. Одоо холимог тогтолцоог пропорционал элементийг оруулж ирнэ гэж Үндсэн хуулиараа бид нар. Бид цөөхөн ард түмэн. 3 сая хүнтэй. Гучин хэдэн намтай. Одоо орон нутаггүй, хөдөө орон нутаггүй улс төржилт ямар явагддаг билээ. Сонгуулийн болоод сонгуулийн бус цаг үед. Би нэг зүйл дээр болгоомжлол бид нар бодох ёстой юм болов уу гэж ярьж байгаа юм. Нэг хоногт Улаанбаатарт зөвхөн бүтэн сайн өдөр 60-аас 80 мянган хүн Есүсийн гэдэг юм уу энэ шашны цугларалт болж байна. Казакийн 110 мянга орчим сонгогч байгаа. Жишээлэх юм бол.

Цаашдаа шашны чиг баримжаатай намууд Монголд бий болох талтай. Энэ шашны чиг баримжаа алдагдана гэдэг. Энэ дээр талцал хагарал явна гэдэг нь иргэний дайн руу аваачдаг. Ийм улсуудын жишээг бид нар Энэтхэгээс эхлээд ярьж болно. Энэ дээр ер нь ямар тооцоо судалгаа байна вэ? Ингэхгүй гэх. Шашны үзэл санаагаар ч гэдэг юм уу нам байгуулахгүй гэсэн хандлага бол яах вэ намын тухай хуульд байгаа. Гэхдээ ийм хэлбэрээр байгуулагдахгүй гэх газар бас байхгүй. Энийг яаж харж байгаа юм бэ.

Дөрөв дэх нэг зүйл. Би уг нь Дээд шүүх болоод бүх шатны шүүхийн шүүгч дээр тавих шалгуурыг бичсэн байсан тэр заалтыг их дэмжиж байсан юм. Тэр арилгачихлаа. Энэ шүүхийн шинэчлэлээр өнгөрсөн 2012-2016 онд шүүхийн тогтолцоог гажуудуулсан юм бол болох болохгүй хүнээр шүүгч тавьж оруулж ирсний хар гай.

Шүүхийн ерөнхий зөвлөл нэртэй 5 хүн сууж байгаад үүнийг болгоё гэдэг ийм чиг баримжаагаар хэнийг ч хамаагүй хүнийг томилоод явуулдаг. Тэрийг нь Ерөнхийлөгч нь батламжилдаг. Магадгүй Ерөнхийлөгч нь захиалдаг. Одоо тэр хонгилын шүүгч гээд нэр хаяг хүртэл яваад байна шүү дээ.

Энэ хэлбэрийг хаахын тулд мэргэжлийн болоод бас ажилласан жилийн бусад туршлага дээр нь шалгуурыг нь тавьсан бол их зөв байсан юм. Тэгээд энийг аваад хаясан. Одоо ингээд хуучнаараа. Яг тэр хуучин хэлбэрээрээ явж байгаа учраас бас энэ байдлыг бид нар яаж засна гэж харж байгаа юм бэ? Уг нь анх бичсэн санаа, оруулсан санаа бол энийг хаахын тулд Шүүхийн ерөнхий зөвлөлийн тоог нэмье, олон нийтийн оролцоотой болгоё, сонгон шалгуур тавьдаг, шүүдэг хүмүүсийг нь бас нэг арай олон нүдээр харуулъя, тэндээсээ нууц санал хураалтаар гардаг болог. Нэр дэвшиж өрсөлдөхдөө тодорхой мэргэжил, мэдлэгийн дадлага туршлагатай байг гэж бодож энэ өөрчлөлтүүдийг хийсэн. Гэтэл ингээд өөрчлөөд хаясан. Тэгээд энэ байдлыг, одоо байгаа энэ заалтаараа зохицуулж болно гэж бодож байгаа юм уу? Дөрөв дэх асуулт.

Тавд нь. Орон нутгийн хуралтай холбоотой хэд хэдэн зохицуулалт байсан. Багийн Засаг даргыг томилдог больё. Сумын Засаг даргыг ард иргэдээс сонгодог больё гээд. Ний нуугүй хэлэхэд энийг орон нутаг маш их дэмжиж байсан шүү. Одоо тэгээд бид нар ерөнхийд нь нэг ийм мөлгөр байдалтай болгоод хаясан. Тэгээд энэ цаашдаа засах ямар ч хувилбаргүй болгож байна л даа. Энэ дээр сэтгэл дундуур байгаагаа илэрхийлье гэж бодож байна.

За тэгээд гол нь тэр давхардлын юмыг яаж харж байгаа энэ холимог тогтолцоотой холбоотой юм дээрээ энэ тооцоо судалгаа юмнуудаа хэлж өгөөч.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Ц.Товуусүрэн гуай тэр орон нутагтай холбоотой асуудалд хариулт бэлдэж байгаарай. О.Мөнхсайхан ажлын хэсгийн. Шүүхтэй холбоотой асуудал дээр хариулт бэлдэж байгаарай.

Эхний асуулт. Тэр 39.3 дээр Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Ерөнхийлөгчөөр зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Дараад нь Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хуралд Ерөнхийлөгч танилцуулна гэдэг юм уу, давхардал үүсэж байна уу, хоорондоо утга, агуулга нь зөрчилдөж байгаа юм биш үү гэдэг асуулт асуулаа.

39.3-д байгаа Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд мэдүүлнэ гэсэн заалт байгаа. Энэ нь хэдэн яамтай байх юм. Ямар ямар сайдтай байх юм гэдэг Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль. Үүнийгээ Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцье гэж байгаа юм. Зөвшилцөнө. Хуучин уламжлал нь ч ийм байсан. Энэ бол хэвээрээ хадгалагдаж байгаа.

39.4 дээр Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж огцруулна гэсэн шинэ орж байгаа заалт.

Энэ нь бол хүнийг ярьж байгаа юм. Урд нь 39.3-аараа бид нар ямар ямар яамд байх юм. Хэдэн яамтай байх юм. Ямар ямар сайдтай байх юм гэдэг тийм хүн биш одоо бүтэц бүрэлдэхүүн, хууль ярьсан бол одоо дараад нь тэгвэл байгуулагдсан Ерөнхийлөгчөөр зөвшилцөөд Улсын Их Хурлаар батлагдах хуулийн дагуу тэр байгуулагдсан яамдын сайд нар нь хэн хэн байх вэ гэдэг хүний асуудлыг Ерөнхийлөгч Улсын Их Хуралд танилцуулаад Ерөнхий сайд нь өөрөө томилдог, өөрөө чөлөөлдөг, өөрөө хариуцлага тооцдог байх гэсэн ялгаатай хоёр заалт байгаа юм гэдгийг хэлье.

Дараад нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ 29.3 дээр орж байгаа. Өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эргүүлэн татах үндэслэл болно. Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс эргүүлэн татна гэсэн ийм заалтууд байгаа. 29.3 дээр орж байгаа.

Одоогийн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 3 дээр бас тодорхой зүйл байж байгаа. Монгол Улсын Их Хурлын дарга, гишүүн Үндсэн хууль зөрчсөн эсэхийг Үндсэн хуулийн цэц шийдвэрлэнэ гээд ерөнхий заалттай. Ерөнхий заалтыг маш тодорхой болгоод, зохицуулалтыг илүү нарийвчилж өгсөн ийм заалт болгож өгч байгаа.

Дараагийн асуулт. Намтай холбоотой асуудал хөндсөн. Улс төрийн намуудыг нэгдүгээрт нь бидний өргөн барьсан төсөлд нам, иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлж, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэж байсан. Үүнийг бид улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана. Нам тийм үү, Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэж өөрчилж байгаа.

Энд улсын хэмжээний үйл ажиллагаа явуулна гэдгийн цаад талд 21 аймаг, 330 сум, 1500 багт бүтэцтэй, нэгжтэй даргатай, цэрэгтэй ийм байгуулах ийм асуудал шаардлага тавигдаад улам улс төржилтийг хавтгайруулах ийм юм болох юм биш үү. Энэ чинь ингэж тайлбарлагдвал яах вэ гэдэг асуудлаар хэлэлцүүлгийн явцад бид нар ерөөсөө энэ бас ингэж ойлгогдож болзошгүй юм байна.

Тийм учраас улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэдэг маань үндсэндээ үзэл баримтлал, мөрийн хөтөлбөр, бодлого нь улсын

хэмжээнийх байх ёстой. Бусдаар заавал сум болгонд, баг болгонд бүтэцтэй нэгжтэй байх гэсэн шаардлага тавигдахгүй гэдгийг бид нар органик хуульдаа буюу Улс төрийн намын тухай хуульдаа суулгаж өгөх гэж үзэж байгаа. Энүүгээрээ одоо таны ярьж байгаа тэр шашны нам байгуулагдах юм уу. Христийн шашны гэдэг юм уу, үндэстний ястны нам, Казах үндэстний гэдэг юм уу, юу гэдэг юм. Дөрвөд ястны нам байгуулах гэх мэтийг бид хааж өгч байгаа.

Өөрөөр хэлэх улсын хэмжээнд бодлого, үйл ажиллагаа явуулна гэдэг маань ийм янз янзын намууд байгуулагдах бололцоо боломжийг хаах, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана гэдгийн цаад талд ийм байдлаар. Одоо аймгуудын нам байгуулагдах гэх юм уу, Өмнөговийн нам байгуулах гэхийг үгүйсгэхгүй шүү дээ. Салбарын нам байгуулах. Янз янзын. Энийг бид нар бас ингэж зохицуулж, үндэстний хэмжээнд үйл ажиллагаа явуулна шүү, бодлого үйл ажиллагаа чинь ийм байх ёстой шүү гэдэг байдлаар зохицуулж өгч байгаа.

Улс төрийн намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд эвлэлдэн нэгдэж байгуулна гэсэн заалт Үндсэн хуульд орж байгаа. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 7 дугаар сарын 16-нд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ энэ саналыг оруулж ирсэн. Зөвшилцөөд бид нар оруулж ирэхдээ 50 мянга 1-ээс дээш гишүүнтэй, гишүүнчлэлтэй байж улс төрийн нам байгуулагдана гэсэн санал орж ирсэн. Үүнийг хэлэлцүүлгийн явцад хэт иргэдээ эвлэлдэн нэгдэхийн эрхэнд халдах байх. Хэтэрхий өндөр шалгуур болзол болох байх, .../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр шашин, үндэстэн ястны гэсэн юм бол байхгүй шүү. С.Бямбацогт гишүүн нэмж хариулъя. 2 минут.

С.Бямбацогт: Минут хасахгүй шүү даргаа.

Тэгэхээр намыг Монгол Улсын эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд эвлэлдэн нэгдэж байгуулна гэж байгаа. 50 мянга 1 байсныг бид нар 20 мянга 1 болгож байгаа. Энийг улс төрийн намын тухай хуульд бид суулгахдаа хэт хатуу гишүүнчлэлийн асуудал ярихгүй. Эвлэлдэн нэгдэж, анх байгуулахдаа гарын үсэг цуглуулах гэдэг юм уу ийм байдлаар бас тодорхой иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлахгүйгээр, хэт хатуу шалгуур болгохгүйгээр цаашид ойлгож улс төрийн намын тухай хуульд суулгаж явах нь зүйтэй гэж үзэж байгаа. Улс төрийн намын тухай хууль ингэж гаргана.

Дээрээс нь 2020 оны сонгуулиар энэ үйлчлэхгүй. Энэ 2020 оны 5 дугаар сарын 25-аас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болно. 2020 оны 01 сарын 01-ээс сонгуулийн жил эхэлж байгаа учраас улс төрийн намуудын үйл ажиллагаа эхэлнэ. Тийм болохоор 2020 оны сонгуульд энэ заалт үйлчлэхгүй. 2024 оны сонгуулиас үйлчлэхээр гэдгээ бас ойлгохгүй бол иргэдийн дунд, улс төрийн намуудын дунд бас нэг жаахан буруу ойлголтууд. Том намууд нь, олон гишүүнтэй намууд нь 2020 оны сонгуульд оролцоод, жижиг намуудаа шахах гэж байгаа юм байна гэсэн тийм буруу ойлголт явж байгаад тайлбарлаж хэлэх нь зөв байх.

Г.Занданшатар: 84 дүгээр микрофон. О.Мөнхсайхан доктор асуултад хариулна. Дэг зөрчигдөөгүй. Байнгын хороогоор хэлэлцсэн асуудлаа ярина. Хувийн бодлоо ярихгүй. Дэг зөрчиж болохгүй. Асууж хариулж байгаа аль аль тал нь.

О.Мөнхсайхан: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр 62 гишүүний өргөн барьсан төсөлд анхан давах хяналтын шатны шүүгчид тавигдах насны, мэргэжлээрээ ажилласан жилийн шаардлагуудыг өндөрсгөж оруулсан байсан. Тэгээд нэгдүгээр хэлэлцүүлгийн дараа энийг бас гишүүдийн саналаар тодотгоод. Жишээлбэл, Улсын дээд шүүхийн шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь шүүн таслах ажлын туршлагатай байна гэх мэтчилэн ийм өөрчлөлтүүд орсон байсан.

Ер нь шүүхийн тухай 62 гишүүний төсөлд 7 заалт, цэцтэй холбоотой 2 заалт байсан. Тэгээд наадмын дараа Монгол Улсын Ерөнхийлөгч санал, төслөө ирүүлэхэд энэ шүүхтэй холбоотой заалтуудаа хасаач ээ гэдэг ийм санал, төслөө ирүүлсэн. Энийг хэлэлцээд зөвшилцлийн ажлын хэсэг энэ ойлголцлын хүрээнд шүүхтэй холбоотой нэлээн олон заалтууд хасагдаад, тэгэхдээ Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг заах, мөн шүүхийн сахилгын хороог бие даалган байгуулах, шүүхийг тойргийн журмаар байгуулах гэсэн ийм гурван заалт хоёрдугаар хэлэлцүүлгийг даваад гарсан явж байгаа.

62 гишүүний төсөлд анх тусгагдсан боловч хасагдсан заалтуудын хувьд зарим нь органик хуулиар тусгагдах боломжтой гэж ойлгож байгаа. Тухайлах юм бол одоо үйлчилж байгаа Шүүгчийн эрх зүйн байдлын хуулийн 4, 5, 6, 7 дугаар зүйлүүд дээр шүүгчид тавигдах үндсэн хуулийн 51.4-т байгаа шаардлагуудаас гадна бусад шаардлагуудыг тавьсан байдаг. Хуульчийн зөвшөөрөлтэй байх, ёс зүйн өндөр шаардлага хангасан байх, өмгөөлөгч прокуророор тэдэн жил ажилласан байх гэсэн ийм шаардлагууд одоогийн хуульд байдаг.

Тэгэхээр энийг хууль тогтоогч одоогийн Үндсэн хуулийн хүрээнд бас нарийсгаад тогтоох боломжтой гэж харж байгаа. Тэгээд ер нь Үндсэн хуулийн өөрчлөлт маань хүлээн зөвшөөрөгдөх чадвартай байх шаардлагатай учраас Ерөнхийлөгчийн болон Ардчилсан намын нэлээн олон саналуудыг тусгах үүднээс. Дээрээс нь Үндсэн хуулийн нийт зүйлийн 35 хувиас хэтрэх ёсгүй учраас 62 гишүүний анхны төслийнх заалтын зарим нь ингэж хасагдаж одоогийн энэ төсөл гарсан гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Ц.Товуусүрэн гуай. 89 дүгээр микрофон.

Ц.Товуусүрэн: Ш.Раднаасэд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өргөн барьсан төсөлд бол сум, дүүргийн Засаг даргыг иргэдээс сонгоно. Сонгогдсон Засаг дарга нь баг, хорооны Засаг даргыг томилно гэсэн ийм байдлаар өргөн баригдсан.

Нэгдүгээр хэлэлцүүлгийн дараагаар гишүүд орон нутагт ажиллаад, хүрч ирээд Төрийн байгуулалтын байнгын хороо, Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хоёрдугаар хэлэлцүүлэг хийх явцад гишүүд олон талаас нь ярьж байгаад сум, дүүргийн Засаг даргыг сонгох нь одоохондоо арай болоогүй юм байна. Цаг нь болоогүй юм байна гэж үзсэн. Энэ бол олон зүйл ярьсан. Энэ протоколд бүгд тэмдэглэгдэж үлдсэн. Юу гэхээр улс орны аюулгүй байдал, эдийн засгийн хүч чадал гэх мэтчилэнгийн олон учир шалтгааны улмаас сум, дүүргийг бие даалгаж Засаг даргыг нь сонгох арай болоогүй байна гэж ингэж хэлсэн.

Нэгэнт сум, дүүргийн Засаг даргыг сонгохгүй байгаа учраас баг, хорооны Засаг даргыг томилох нь дагаад тийм учир холбогдол багатай болсон байх. Ингээд Улсын Их Хурлын гишүүдийн олонхын саналаар энэ саналууд унасан гэдгийг би хэлье.

Г.Занданшатар: Ням-Осорын Учрал гишүүн асуулт асууна.

Н.Учрал: 2015 онд яг одоо энэ Улсын Их Хурлын тухайн үеийн 48 гишүүний бас Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг хэлэлцээд нийгэмд хэлэлцүүлгүүдийг өрнүүлж байхад тухайн хэлэлцүүлгүүдэд оролцож явсан бас нөгөө Үндсэн хуулийн эрх зүйн багш байсны хувьд оролцож явсан хүн л дээ.

Тэгээд “Гадаад орнуудын Үндсэн хуулийн эрх зүй” гэдэг нэг ном гаргаад Д.Лүндээжанцан гишүүнээр редакторлуулаад тэр Германы, Финландын сонгодог парламентын жишээнүүдийг оруулаад ингээд тухайн үед ном гаргаад үүнийг анхаарч үзээрэй гээд Д.Лүндээжанцан гишүүнд хэлж байсан. Тэгээд 4 жилийн дараа яг энэ төслийнхөө 80, 90 хувийг нь багтаасан Үндсэн хуулийг батлалцах хувь тохиосонд би бэлэгшээж их баяртай байгаа.

Үнэхээр Улсын Их Хурлын парламентын гурван бүрэлдэхүүний түвшинд яригдаж, хэлэлцсэн үндсэн хуулийн төслийн хэлэлцүүлэг өнөөдөр гурав дахь хэлэлцүүлгээ хийж байна. Тэгэхээр би энэ асуудал дээр нэг зүйлийг тодотгож хэлэхийг хүсэж байна.

Үнэхээр хэлэлцүүлгийн явцад сайн заалтууд хасагдсан. Сайн заалтууд хасагдсан. Ялангуяа Ерөнхийлөгчийг парламентаас сонгох, мөн иргэдийн аймаг, нийслэлийн иргэдийн хурал сум, дүүргийнхээ иргэдийн хурлаас төлөөлөгчдөөс бүрдэх буюу тэр улс төржилтөөс хол байх маш сайн заалт. Тэгээд мөн шүүх эрх мэдэлтэй холбоотой харин тэр нэг миний гол санаа хэлээд байсан шүүгчдийн босгыг өндөрсгөх гэж байгаа биш зарим хүнд таалагдах, улс төр шүүгчдийг бий болгох гэж байсан харин маш сайн заалтуудыг энд хасаж оруулаад өнөөдрийн Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл дээр байхгүй байгаад баярлаж байгаа.

Гэхдээ дунд нь нөгөө миний “мэргэжлийн холбоо” гэдэг үгийг хамтад нь аваад явсан. Ерөнхийдөө эндээс юу хэлэх гээд байна вэ гэхээр “шатлан дэвших зарчмыг үндэслэнэ” гэж нэг аймшигтай үг Үндсэн хуульд орох шахаж байхад би их бухимдсан. Энэ юу вэ гэхээр 7 жилийн дараа, 10, 20 жилийн дараа магадгүй. Чи бас залуу хүн байсан байж энэ Үндсэн хуулийг хэлэлцэж байхад бид нарын төрийн үйл ажиллагаанд оролцох энэ босгыг өндөрсгөсөн,

боомилсон энэ шатлан дэвших зарчим гэдэг дээр чи яагаад үг хэлээгүй юм бэ, чи яагаад энэ дээр дуугараагүй юм бэ гэж надаас асуух байх даа гэж би бас залуу хүнийхээ үүргийг биелүүлж энэ шатлан дэвших зарчмыг авч Монголын олон мянган сайхан залуучуудад бас боломж бололцоо Үндсэн хуулиараа одоо нээгдээд явчихна гэдэгт итгэлтэй байгаа. Үүн дээр бол мэргэжлийн холбоотой холбогдуулаад энэ асуудлуудаа аваад явах нь зохистой юм гэж ингэж үзэж байгаа юм. Асуулт, саналыг бол ингээд хамтад нь хэлж байгаа юм.

Хөгжлийн бодлогын асуудлууд дээр нэг зүйлийг тодруулмаар байгаа юм. Шадар сайд бол хөгжлийн бодлогын асуудлуудыг хариуцсан ийм сайд байна юм уу, эсвэл “хөгжлийн бодлого нь тогтвортой байна” гэдэг үгийн цаана хөгжлийн бодлогын асуудал хариуцсан тодорхой нэг байгууллага Шадар сайдын дэргэд байх юм шиг ийм утга энэ дотор ингээд ороод яваад байгаа байхгүй юу.

Ерөнхийдөө хөгжлийн бодлого, төлөвлөлтийг хариуцсан бие даасан тийм төрийн захиргааны төв байгууллага байх юм уу, үгүй юм уу гэдэг асуудал бол нэг их тийм тодорхой бус. Тэгээд энэ Үндсэн хуулийг баталсны дараа дагаж тэр органик бараг 26 хуульд өөрчлөлт орно гэж байгаа юм. Тэгэхээр тэр тухайн хуулиуд дээр өөрчлөлт оруулахад хэрхэн үүн дээр бид нар анхаарч ажиллах ёстой юм бэ гэдгийг бас тодотгомоор байна.

Хоёрт. Намын босго гэдэг чинь бүх сонгууль өгөх эрхтэй хүмүүсийн нэг хувь гээд байгаа юм. Үүнийг одоо зүгээр тэр гишүүн болсноор нь авч үзэх юм уу, эсвэл тухайн намыг дэмжиж байна гээд гарын үсэг цуглуулаад нэг хувь хүргэжээд нам байгуулна гээд явах юм уу? Тэгэх юм бол яг ялгаа байхгүй шүү дээ. Энийг уншихаар ерөөсөө намын гишүүн нь нэг хувь нь, сонгууль өгөх эрхтэй хүмүүсийн нэг хувь нь намын гишүүн байна биш. Энэ чинь тухайн намыг байгуулахыг дэмжиж байна гэдэгтэй ийм ойлгомжгүй байдал үүсээд байгаа юм.

Тэгэхээр би нам байгуулна гэж хэлэнгүүтээ сонгууль өгөх эрхтэй хүмүүсээс нэг хувийн хүмүүсийн гарын үсэг цуглуулаад, одоогийн нөгөө гарын үсэг цуглуулдагтай адилхан цуглуулаад аваачиж өгөөд тоо нь өссөн байдлаар өөр намын хүмүүс ч гэсэн хамаагүй энэ дээр ингээд гарын үсэг зураад өгөөд байх юм уу гэдэг нь их ойлгомжгүй заалт.

Тэгэхээр энэ дээр нөгөө дагалдах хуулиуд дээр анхаарахгүй бол үүнийг ашиглаад ерөөсөө л гарын үсэг цуглуулдаг юм чинь явсаар байх юм байна. Тэгэхээр энэ дээр нэг тайлбар өгөөч.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Тэгэхээр сүүлийн асуултаас эхэлье.

Улс төрийн намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэд эвлэлдэн нэгдэж байгуулна гэсэн заалт Үндсэн хуульд орсон байгаа. Ерөнхийлөгчийн саналаар орсон.

Энэ дээр улс төрийн намууд, улс төр судлаач, олон улсын байгууллагууд тодорхой байр сууриа илэрхийлж байгаа. Иргэдийн эвлэлдэн нэгдэх үндсэн эрх рүү халдсан, хэт их өндөр шалгуур болчих вий гэдэг болгоомжилсон үгнүүд хэлж байгаа. Бас албан бичиг бидэнд ирүүлсэн. Тийм болохоор Үндсэн хууль дээр тусгагдаж байгаа ерөнхий агуулгаар тусгаж байгаа. Үндсэн хууль батлагдсаны дараа таны бас түрүүн хэлж байгаа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбогдуулан тодорхой хуулиудад шинэчилж найруулах, өөрчлөх ийм жагсаалт гарна. Энэ жагсаалтын хамгийн тэргүүний ээлжид улс төрийн намын тухай хууль орох байх.

Тэгэхээр Улс төрийн намын тухай хууль дээр ажлын хэсэг гарсан ажиллаж байгаа. Улс төрийн намын тухай хуулийг бид нар боловсруулж, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулах үедээ энэ Үндсэн хуульд тавигдсан хэтэрхий өндөр шалгуур гэж байгаа асуудлыг бид нар аль болох зохицуулах, уян хатан байх тийм байдлаар бас хувилбар томъёоллыг оруулж батлуулах, ажиллах нь зөв байх гэж бодож байгаа.

Энэ хүрээнд өөрөөр хэлбэл хатуу сонгогчдын нэг хувиас дээш хатуу гишүүнчлэлтэй байх, түүнийг нь жил бүр бүртгэдэг, хүрээгүй байна, хасагдсан байна гээд татан буулгах гэдэг асуудал ярихгүй байх. Энэ ерөөсөө л одоо анх байгуулагдахад нь 20 мянгаас дээш гишүүдийн дэмжигч нам байгуулахыг дэмжиж байна гэсэн дэмжигч байдлаар бүртгэж байх гэсэн уян хатан зохицуулалтыг бид нар Улс төрийн намын тухай хуульдаа хийх нь зөв юм болов уу. Ингэхгүй бол бас бусад улс орнуудын жишгээс өндөр болчихлоо, хатуу боллоо гэдэг байгууллагад. Тухайлбал, Европын аюулгүй ажиллагаа, хамтын ажиллагааны байгууллагаас бас албан бичиг бидэнд ирсэн байгаа.

Энэ нь Оросын Холбооны Улс, Румын зэрэг улсууд бас хэт их өндөр тийм гишүүнчлэлтэй байж байгаа. Үүнийгээ багасгаж уян хатан болгосон ийм юмнууд байгаа юм.

Ер нь яагаад улс төрийн намуудын тухай ийм заалт бас оруулах болсон бэ гэдэг дээр та бүхэн мэдэж байгаа байх. Улс төрийн намууд маань бүртгэгдээд 801 хүн гарын үсэг зураад бүртгэгддэг. Үйл ажиллагаа явуулж эхэлдэг. Олон сонгуульд оролцдог. Сонгууль болохоор гарч ирээд сонгуульд оролцоно гэдэг бусад үедээ алга болчихдог. Энэ дээрээс нь улс төрийн намуудын бодлого, үзэл баримтлал, үйл ажиллагаа гэдэг юм тодорхой бус, тогтвортой бус. Эргээд энэ олон намуудын нэр хүнд нийгэмд, ард иргэдийн дунд унасан. Үүнтэй холбоотойгоор намыг дуртай болгон л байгуулаад төрийн бус байгууллага байгуулагдахтай адилхан нэг компани, хувийн компани байгуулахтай адилхан байгуулаад байж болохгүй юм.

Энэ нам чинь, намаар дамжиж сонгуульд оролцсон, сонгуулийн үр дүнгээр Засгийн эрх барина, төр барина. Тэгэх гэж байгаа бол энэ намууд маань өөрийн гэсэн бас бодлоготой, үзэл баримтлалтай, шалгууртай, тодорхой төрөөс шаардлага тавьдаг байх нь зөв юмаа гэдэг агуулгаар орж ирсэн. Энэ бол улс төрийн намын тухай хуулийн хувьд илүү уян хатан болгох нь зөв байх гэж бодож байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудлыг яах ёстой юм бэ гэж. Тэгэхээр хөгжлийн бодлого, төлөвлөлт. Ер нь Үндсэн хуулийн нэмэлт,

өөрчлөлт орсны дараа тодорхой хуулиуд төрөн батлагдана. Түрүүн хэлсэн 26 орчим хууль байх нь уу. Цааш нь нэмэгдэх нь үү. Энэ хуулиуд дээр бас органик хуулиуд буюу энэ хуулиуд дээрээ бид нар энэ тодорхой Үндсэн хуульд орсон томоохон бодлогын зорилтуудыг хэрхэн яаж хангах юм, биелүүлэх юм. Тухайлах юм бол одоо эдийн засгийн, Үндсэн хуулийн эдийн засгийн асуудал. Дээрээс нь улс орны төрийн бодлого, хөгжлийн бодлогын асуудал. Энэ асуудлыг шинээр оруулж байгаа учраас үүнтэй холбоотой тодорхой зохицуулалтыг хийж өгнө.

Бид нар төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гээд үндсэндээ энэ бол аудитын байгууллага. Одоо манай төрийн аудитын байгууллага байдаг шүү дээ. Энэ байгууллагын үндсэндээ бол ингээд зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно гэсэн байж байгаа. Яг үүнтэй адилхан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага байх юм уу. Тийм үү. Үүний эрх, зохион байгуулалтыг хуулиар тогтоож өгнө. Ингэхдээ хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуульд бас тодорхой зохицуулалтыг бас орж ирэх байх гэж бодож байна.

Г.Занданшатар: Лхагвын Элдэв-Очир гишүүн асуулт асууна.

Л.Элдэв-Очир: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлэг үндсэндээ өнөөдрөөр шувтарч хууль маань батлагдах байх. Энэ хууль манай намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан. Заавал ард түмнээр хүлээлгэсэн, батлах ёстой ийм хууль. Хэлэлцүүлэг маань харьцангуй нэлээн удаан явлаа.

Хэлэлцүүлгийн эхнээс миний хувьд хоёр зүйл дээр хатуу байр суурьтай байсан юм.

Нэгдэх нь яах вэ гэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ард түмний санал асуулгаар заавал оруулах ёстой юм шүү гэдэг асуудал. Тэгэхээр энэ асуудал яах вэ гэхээр үндсэндээ хэлэлцүүлгийн явцад хасагдлаа. Хориг тавигдлаа. Энд үнэхээр харамсаж байгаа. Энэ явуулахгүй гэсэн шалтгаан нь болохоор хөрөнгө мөнгөний асуудал ярьж байгаа юм. Хөрөнгө мөнгө бол ямарваа нэг асуудал байгаагүй. Боломжтой гаргах нөөц бол Монгол Улсын Засгийн газарт бий. Тэр битгий хэл нэг хэсэг хүмүүс концессын гэрээгээр ч юм уу, янз янзын байдлаар идэж уугаад алга болдог ийм л мөнгө шүү дээ. Энэ бол асуудал байгаагүй.

Дараагийн нэг зохиомол хүндрэл үүсгэсэн юм юу гэхээр ирц хүрэхгүй гэдэг асуудал. Монголын ард түмэн бол улс төрийн идэвхтэй ард түмэн. Ялангуяа Үндсэн хуулийн санал асуулгад бүгдээрээ өвөл, зуны аль ч улиралд байсан гоё хувцсаа өмсөөд энэ санал асуулгадаа ирц хүргээд оролцох баараггүй байсан гэж би бүрэн итгэлтэй байдаг. Энэ бол ард түмний санал асуулгаар ороогүйд үнэхээр харамсаж байгаа.

Мэдээж энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсаны дараа баахан мэргэн жарахайнууд гарч ирнэ. Тэгээд өнөөдөр Үндсэн хууль баталж байгаа 76 гишүүд, энэ ажлын хэсэг, дараагийн Үндсэн хуулийн өөрчлөлт болтол баахан баалуулах байх. Насаараа баалуулах байх. Нөгөө дордохын

долоон өөрчлөлт гэдэг шиг ямар нэр өгөх юм байгаа юм. Тэгээд баахан баалуулж баалуулж дараагийн Үндсэн хуулийн өөрчлөлт рүү очих байх. Нэг ийм явдал болох байх. Энд би харамсаж байгаа юм.

Хоёрдугаарт нь, өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад энэ пропорционал элементийг оруулж ирэх асуудал орж ирээд байгаа юм. Энийг оруулж ирэхдээ бид нар яриагаа бас нэг зөв цэгцтэй байлгахгүй бол бид чинь бас Их Хурлын гишүүд, чуулганы хуралдаан, хуулийн хэлэлцүүлэг шууд явж байна.

Ард түмнээ доромжлоод байж болмооргүй байх юм. Жалга довны үзэл бодол гэж яриад байх юм. Жалга довны ард түмэн гэж яриад байх юм. Жалга довны ард түмэн. Юу гэдэг юм нийслэлийн ард түмэн гэж ард түмнээ хувааж л байгаа юм аа даа. Хөдөөгийн ард түмнийг жалга довынхон гэгчихсэн. Тэд нарт ер хөрөнгө оруулах хэрэг байхгүй. Гишүүд тэнд байх шаардлага байхгүй. Ер нь тийм асуудал явагдаж байна.

Тийм учраас бид нар бас хууль батлахдаа хэлж ярьж байгаа үг дээрээ бас жаахан бодохгүй бол. Үүнээс хойш одоо энэ жалга довын гэдэг асуудлыг болимоор байна. Үндсэндээ мажоритар тогтолцоо Монголын хөрсөн дээр буусан ийм тогтолцоо. Монгол Улс газар нутаг нь бүрэн бүтэн, улс нь тусгаар байхын тулд энэ мажоритар тогтолцоог авч явахаас өөр арга байхгүй. Одоохондоо.

Тэр яриад байгаа жишээ татаад байгаа улсуудын жишигт хүрээд, пропорционал төр рүү шилжих үе ирж магадгүй. Гэхдээ өнөөдөртөө бол бид энэ тогтолцоогоороо явах нь зайлшгүй юм гэж би бол ингэж бодож байгаа юм.

Улсын хэмжээнд бодлого ярьдаг 26 гишүүн байна гэж ярих юм. Энэ Улсын Их Хурлын гишүүд чинь тангараг өргөхдөө нийт ард түмэн, улс орны эрх ашгийн төлөө л гэж тангараг өргөдөг шүү дээ. Зөвхөн жалга довынхоо асуудлыг ярина гээд Улсын Их Хурлын томоохон бодлогын асуудалд оролцохгүй байгаа гишүүн хэн байгаа юм. Бүгдээрээ л оролцож байгаа шүү дээ. Засгийн газар бодлогоо оруулж ирж батлаад дэмжээд өгч байна. Бодлогоо Засгийн газар тодорхойлж байна. Засгийнхаа, төрийн бодлогыг дэмжээд л явж байна.

Одоо энэ У.Хүрэлсүхийн Засгийн газрын нэг хийсэн том ажил байна шүү дээ. Энэ утаагүй болсон асуудал. Өчигдөрхөн олон улсын байгууллагууд хараат бус үнэлгээний байгууллагууд судалгааг нь гаргачихсан. Агаарын бохирдолтой дэлхийн 10 улсын нэгд байснаа огцом рейтинг нь өсөж одоо Канадын Ванкувер, Японы Осака хотуудын дунд эрэмбэлэгдсэн байна шүү дээ. Монгол агаарын бохирдлоороо Улаанбаатар хот. Ийм сайхан мэдээ байна. Ийм сайхан хийж байгаа ажлууд байна. Энэ болгоныг бас ярьж баймаар байгаа юм. Энийг далимдуулаад бас энэ У.Хүрэлсүхийн Засгийн газарт, ялангуяа муу хэлүүлэх нь ахиухан шиг, магтуулж байгаа нь ховор энэ Засгийн газарт бас ард түмнийхээ өмнөөс баяр хүргэхийг хүсэж байгаа. Улаанбаатарчуудын өмнөөс. Үнэхээр сайн ажиллаж байгаа. Энэ бодлогыг чинь Улсын Их Хурлын гишүүд дэмжээд л явж байгаа шүү дээ. Тийм

болохоор одоо энэ жалга дов гэж нөхдүүдээ ард түмнээ ингэж ангилахаа больё.

Дараагийн нэг асуудал. С.Бямбацогт гишүүн, түрүүн бас хоёр гурван гишүүд хэлэх шиг боллоо. Энэ бөхөөр жишээ авдгаа больчих оо. Одоо энэ чинь гишүүд нь сонгогдоогүй байж байхад энийг пропорционал элементийг лоббидох маягтай баахан жишээ татаад орж ирж байгаа асуудал яах вэ гэхээр бөх яриад байх юм.

Тэгээд энэ чинь яах юм. Одоо бөхчүүд чинь эрэмбэтэй шүү дээ. Аваргынхаа дээр аймгийн арслан гарч суухгүй шүү дээ. Одоо яах юм. Орж ирээгүй байхад ингээд бөхийн эрэмбээр бүгдийг нь эрэмбэлчихсэн. Тэгээд хөдөөгийн бөх, хотын бөх гээд, ноёны бөх гээд сууж байх ийм асуудал байж болохгүй. Бүгдээрээ бас энэ хэлж ярих үг дээрээ бодъё.

Одоо удахгүй Сонгуулийн тухай хууль орж ирнэ. Сонгуулийн тухай хууль дээр би бас гишүүдээсээ хүсэж байгаа. Юу гэхээр энэ царцаа гэдэг үгийг битгий хэрэглээрэй. Албатай юм шиг баахан ард түмнийг, ах дүү нараа хуулийн дагуу нүүлгэж очиж санал өгүүлчхээд тэд нарыгаа царцаа гээд нэрлэчихдэг. Ард түмэн чинь ингэж доромжлуулаад байж болмооргүй байна шүү. Мөрөөрөө байгаа ард түмнийг мөрөөр нь байлгая л даа. Сайхан амьдруулж чадахгүй юм гэхэд доромжлохгүй байя бүгдээрээ. Энэ асуудал дээрээ гишүүд маань бүгдээрээ анхааръя гэж бодож байгаа.

Нэг асуулт байна. 39.4. Засгийн газарт Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайд Улсын Их Хуралд танилцуулна гэж байгаа. Хэрвээ Ерөнхий сайд амьтан ах дүү нараараа хаан шиг ойр дотныхоо хүмүүсийг Засгийн газрын гишүүнээр томилуулна гээд оруулаад ирэх юм бол Их Хурал танилцаад энэ дээр залруулга хийж болох уу, үгүй юу. Тийм нөхцөл боломж бий юу, байхгүй юу? Зүгээр Ерөнхий сайд бүрэн эрхийнхээ хэмжээнд миний хамгийн итгэлтэй хүмүүс гээд хамаг ах дүү нараа, найз нөхдөө оруулж ирээд, Улсын Их Хурал дээр оруулж ирээд энийг танилцуулж байна. Батлах батлахгүй нь та нарын асуудал биш миний асуудал гээд ингээд явах юм бол энэ чинь бас айхтар том супер Ерөнхий сайд болчих гээд байдаг. Энэ дээр ямар зохицуулалт байх юм. Органик хуулиар зохицуулахаар байна уу, яаж бодож байгаа вэ?

Г.Занданшатар: Д.Лүндээжанцан дарга асуултад хариулна.

Д.Лүндээжанцан: 62 гишүүний өргөн барьсан төсөл дээр та бас оролцоод Ерөнхий сайд Улсын Их Хурал болон Ерөнхийлөгчид танилцуулснаар Засгийн газрын гишүүдийг томилж, чөлөөлж, огцруулна гэдэг заалтыг өргөн барьсан.

57 гишүүний дэмжлэг авч чадаагүй. Ингээд үүнийг гуравны хоёроор буцаагаад зөвшилцөөний үндсэн дээр оруулж ирж байгаа. Тэгэхээр ер нь улс орнуудын жишигт. Яах вэ, бид гадаадын орны жишиг ярихад зарим нь дургүй л байгаа юм. 24 орны яг энэ чиглэлийн, одоо манайх шиг засаглалтай улсуудын юуг судлаад үзэхэд 18 нь Ерөнхий сайд нь танхимынхаа гишүүдийг өөрөө томилж, чөлөөлж, огцруулж байна. 4 улсад манайх шиг парламентаасаа добро авч байж томилж байна.

Тэгэхээр энийг оруулж ирэхэд Их Хуралд нэгдүгээрт оруулж ирнэ. Дээд шүүхийн шүүгчдийг танилцуулдаг. Түүнтэй адилхан Засгийн газрын гишүүдийг оруулж ирж танилцуулна гээд Засгийн газрын хууль болон Улсын Их Хурлын дэгийн хуульд зааж өгнө. Ингээд танай энэ энэ чинь салбарынхаа бодлогыг аваад явах хэмжээний түвшний хүн байна. Энэ чинь болохгүй байна. Энэ нөхөр бол. Энэ болгоныг хэлж ярьж өгөөд. Ерөнхий сайд та одоо ингээд цаашаа ажиллана гэж байгаа бол ээдээ энэ хүнтэй барахгүй байна гээд.

Ерөнхийлөгчид танилцуулаад Ерөнхийлөгч бас саналаа хэлэх байх. Тэгээд ер нь улс орны хэмжээнд Засгийн газрыг авч явж, Их Хурлын өмнө хууль биелүүлэх ажлыг хэрэгжүүлнэ гэвэл өөрөө сайн танхим бүрдүүлж байж л ажиллаж байж сая авч явна. Хэрвээ Ерөнхий сайд Засгийн газрынхаа гишүүд буюу танхимынхаа гишүүдийн алдаа оноо, хувийн зан суртахуун, өөрийнхөө хар толгойгоор хариуцна гэсэн үг.

Тэгэхээр хамгийн хүлээн зөвшөөрөгдсөн тэнд энэ салбарынхаа ажлыг авч явах чадвар бүхий гэсэн шилдэг хүмүүсийг л оруулж ирж байж сая ажил нь явна гэдэг ерөнхий зарчим барьж байгаа юм. Хэрвээ өөрөө янз бүрийн иймэрхүү маягийн юм гаргах юм бол өөрөө унахын цондон болж, хариуцлагаа хар толгойгоороо хүлээнэ гэдэг ийм асуудал яригдаад л энэ оруулж ирэх нь зүйтэй юм. Олон улсын жишиг тийм байна. Эрсдэлүүдийг зөндөө ярьсан. Яг таны ярьдаг эрсдэлүүдийг. Тэгээд тодорхой хүмүүс дээр ярин бас. Бүр даже.

Ингээд манай гишүүд тал талаас нь хэлэлцсээр байгаад энэ ер нь парламентын засаглалтай улсын бас нэг том эрх мэдлийн хуваарилалтын зөв тэнцвэр, голдирол руу орох бас арга зам юм байна гэдэг дээр зөвшилцөл хийгдээд ингээд явж байгаа.

Хоёрдугаарт, энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт бол зөвшилцлийн замаар явах ёстой гэдгийг бид хатуу барьж ирсэн. Түүрүү Ж.Бат-Эрдэнэ гишүүн ч ярьж л байна билээ. Зөвшилцөх хэрэгтэй. Улс төрийн намуудыг оруулах хэрэгтэй. Ерөнхийлөгчийн институттэй зөвшилцөх хэрэгтэй. Улс төрийн намуудын бусад намууд, иргэний нийгмийн байгууллагуудын санаа бодлыг сонсох хэрэгтэй, иргэдтэйгээ уулзах хэрэгтэй гээд. Энэ бүх шат дамжлагыг бид чадлынхаа хирээр хийсэн гэж үзэж байгаа.

Хамгийн сүүлийн жишээ гэхэд сая 50 гаруй төрийн бус байгууллага тийм үү, гуравдугаар хэлэлцүүлгээр батлах нь зүйтэй гэсэн бичиг барина гээд ирсэн байна гэсэн. Бодвол С.Бямбацогт дарга хүлээж авсан байх. Энэ мэтчилэнгээр дэмжсэн ч юм байна, ийм ийм шаардлага тавьсан ч юм байна. Тэр намын гишүүнчлэлийн тооны асуудлаар Европын аюулгүй байдлын байгууллагаас бас шүүмжилсэн маягийн зөвлөмж ирсэн. Түүнтэй холбогдуулаад бид сая протоколд тийм үү, “эвлэлдэн нэгдэх эрх” гэдгийг юу гэж ойлгох вэ гэдэг зүйлээр тайлбар хийлээ. Энэ мэтчилэнгээр юм явагдаж байгаа юм гэдгийг Танд хэлье.

Г.Занданшатар: Гишүүд Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж хариулт авч дууслаа. Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатарын урилгаар Увс аймгийн сумдын төрийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Одоо Байнгын хорооноос гаргасан саналын томъёолол тус бүрээр санал хураалт явуулна. Саналын томъёолол тус бүр дээр дэмжсэн дэмжээгүй байр суурьтай гишүүд үг хэлж болно.

Төрийн байгуулалтын байнгын хорооноос дэмжсэн саналуудын томъёоллоор санал хураалт явуулна. Ажлын хэсгээс зөвшилцөн оруулж ирсэн хоёр дахь хэлэлцүүлгээр шийдвэрлэгдсэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын зөвлөлийн санал нэг, хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төсөлд дор дурдсан агуулгатай 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг нэмэх.

Дөрөв. Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.

Ирцээ бүрдүүлээрэй. О.Баасанхүү гишүүн үг хэлнэ.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат.

О.Баасанхүү: Би дахиад цагаа авъя. Тантай зэрэгцэж ярих гээд. 15 секунд алдлаа. Дахиад өгчих үгээ.

Г.Занданшатар: Үг хэл гэхээр хэлэхгүй юм байна шүү дээ. За О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Манайхан 30 жилийн зовлонгоос саллаа гээд пропганда буюу тархи угаалт хийгээд байх юм.

Ерөнхийдөө миний хэлээд байгаа санаа бол энэ шүү дээ. Маш тодорхой. Ерөнхий сайд бүхий парламент байх уу, Ерөнхийлөгч бүхий парламент байх уу, эсвэл парламентын засаглалтай байх юм уу, эсвэл супер Ерөнхийлөгч байх юм уу гээд.

Бүх юм чинь онолтой. Онол практик хоёр чинь “онолгүй практик сохортой адил, практикгүй онол хоосонтой адил” гээд ийм үг байдаг л даа. Тэгээд манай их мэдэгч нар болохоор 30 жилийн зовлонгоо өнөөдөр засаж байна гэж буруу яриад байна. 30 жилийн зовлон чинь энэ засаглалтай ямар ч хамаагүй шүү дээ. Цэвэр намтай хамаатай шүү дээ.

1996-2000 онд Ардчилсан нам “Эх орон эвсэл” гэж орохдоо хамгийн анх “фракц” гэдэг нэртэй гадаад үг оруулж ирээд эхэлсэн. Тэр нь хөдөөгийн фракц, хотын фракц, өөр ямар фракц гэдэг юм янз бүрийн нэр өгөөд. 2000

онд 72 суудалтай Ардын нам болонгуутаа МАНАН гэдэг нэртэй бүлэг бий болгосон. МАНАН бүлгийн даргаар хэн байдаг юм тодорхой хүмүүс яваад. МАНАН бүлэг нь 2000-2009 онд явж байгаад. Одоо би засаглалын хэлбэр ярьж байхын тулд.

Г.Занданшатар: Саналын томьёоллыг дэмжсэн дэмжээгүй гэдгээр үг хэлнэ.

О.Баасанхүү: Би дэмжээгүй, яагаад дэмжихгүй байгаагаа тайлбарлаж байна л даа энэ ард түмэндээ.

Яагаад гэхээр 2009-2012 оны хооронд ямар байсан бэ гэвэл “мөнгөний МАНАН” байсан бол одоо 2012-оос хойшоогоо ингээд 2020 он руу “цусан төрлийн МАНАН” бий болсон. “Худ ургийн, удам судрын МАНАН” бий болсон.

Ийм ноцтой оршин тогтнож байгаа. Бид нар нэг талаасаа цөөхөн улс төрчидтэй, цөөхөн хүн амтай, бие биеэ таньдаг ийм нөхцөлтэй байдаг хүмүүс энэ засаглалыг зөв хэлбэр лүү оруулах ёстой юм. Та бүхэн өнөөдөр харж байна. Намын дарга бөгөөд Ерөнхий сайд. Тэгээд намын даргыг бид нар томилоод. Угаасаа намын дарга юм чинь Ерөнхий сайд болох нь ойлгомжтой. Харин Ерөнхий сайд нь өөрөө хэнтэй ажиллахаа өөрөө шийдэх юм байна л даа.

Бид нар ажиллах гэж байгаа хүмүүсийг нь сонгоод л болоо. Би гудамжинд явах нь намайг нэг хараарай. Би энэ Орхон аймгаас сонгогдсон хүн шүү гэж хэлэх юм уу, хаашаа юм. Нөгөө сайд болох гэж байгаа хүн. Сайд нь авсныхаа дараа нөгөө намын санхүүжилтийг шийдээрэй. Хөөе чи ажлаа хийгээрэй. Үгүй бол халлаа гэх юм байна л даа.

Өнөөдөр та бүхэн мэдэж л байгаа шүү дээ. Цэцэд “ланд крузер” гээд машин бэлэглээд л зөв зүгээр явж байсан хуулийг хүчингүй болгосон. Жүгнээгийн Амарсанаа гэдэг хүнд тухайн үед дарга байхад нь ланд машин өгөөд л. Тэгээд нөгөөдөх нь юу вэ гэвэл байхгүй болсноос болж сайдыг огцруулах боломжгүй болсон.

Өмнө нь Х.Тэмүүжин гээд сайдыг огцруулъя гээд явсан. Тухайн үедээ эмнэлгийг шоронд болгосон учраас гээд явсан. Буруу юм байгаагүй шүү дээ. Тэрийг нь манай хэд бүсэлхийнээс доошоо хэрүүл болоод байсан учраас за больё ямар анх Их Хурлын гишүүн болчихоод бөгсний хэрүүл хийлтэй биш гээд больсон. Одоо бол бид нар огцруулмаар байгаа мянга түмэн сайд байна шүү дээ. Одоо энэ хөөрхий гадаа Болороо гээд охин хөлдөж үхээд 10 хонож байхад сайд нь өгзөг өмөөрөөд л сууж байсан шүү дээ. Ийм балай саарал жагсаалтад орсон салгалсан өвгөнийг өнөөдөр огцруулъя гээд хэлэх нь юу нь болохгүй байгаа юм. Зөв биз дээ.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Октябрийн Баасанхүү саналын томьёоллыг дэмжих, дэмжихгүй агуулгаар үг хэлнэ.

О.Баасанхүү: Тэгээд ийм зүйлийг өнөөдөр ярья гэх боломжгүй байхад бүр баталгаажуулаад У.Хүрэлсүхэд таалагдаад ажлаараа баяртай гээд явуулчихаар юу болох юм бэ.

Дараа нь төсвөө оруулаад ирэхээр бид төсөв дээр яаж хяналт тавих юм. Төсөв дээр ямар хяналт тавих юм. Уг нь бол энэ чинь нөгөө салбар салбараар нь бид нар хяналтаа тавиад явдаг байсан.

Тэгэхээр ийм ноцтой байгаад байгаа юм. Одоо У.Хүрэлсүх хүсээд сайдаа огцруулъя ч гэсэн чадахгүй байгаа шүү дээ. Их Хурлын гишүүдийг давхар дээлгүй болгоё гэгчхээд 4 ч билүү яамыг давхар дээлтэй болгоё гэсэн. Тэгээд 76-гаа сонгуулах юм байна л даа. Энэ 76-гийн 4-ийг нь сайд болгоно. Ямар азтай юм бэ та 4 минь. Сайн яваад ирээрэй гээд одоо бид нар хэлээд өнгөрнө л дөө. Ямар нэгэн томилолт ч өгөхгүй. Тэгээд сайн яваад харина. Замдаа битгий саарал жагсаалтад ороорой. Авлигад битгий өртөөрэй. Тийм. Авгай хүүхэнтэй битгий орооцолдоорой. Амиа бодож яваарай. Хөөрхий 4 жилийн дараа баларна даа баларна. Намын даргатайгаа хамт гээд ингээд суух юм уу. Энэ одоо 7 удаагийн сонгуулиар өнөөдөр .../минут дуусав/

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Танхимдаа бэлдээрэй. Санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт явуулъя. Д.Цогтбаатар, Ө.Энхтүвшин сайд нар чуулганы танхимд ирье. Санал хураалт.

61 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ.

2.а. Энэ санал дэмжигдсэн учраас 2.а дахь санал хураалт явагдана. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн өөрчилсүгэй гэсэн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуулийн” гэсний дараа “Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж,” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Г.Занданшатар, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, С.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Санал хураалт явуулна. Санал хураалт. Санал хураалт явчихлаа.

60 гишүүн дэмжиж, 87.0 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. 57-оос дээш учраас заавал хувь хэлэх шаардлагагүй л дээ уул нь.

2.б. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн өөрчилсүгэй гэсэн 4 дүгээр зүйлд “, Гучин есдүгээр зүйлийн “3” дахь хэсгийн дугаарыг “4” гэж” гэж нэмэх. 2.а санал дэмжигдсэн учраас энэ санал хураагдахгүй юм байна.

3. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1, 2 дахь өгүүлбэр нэмэх:

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.”

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Ж.Мөнхбат, Б.Пүрэвдорж, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, Н.Энхболд, Д.Эрдэнэбат, М.Энхболд. Санал хураалт явуулна. Санал хураалт явуулах уу. Санал хураалт явуулъя.

Кнопоо дарж үгээ ав л даа. Орилоод байх юм. Санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Үг хэлэх саналууд гарсан учраас. О.Содбилэг, О.Баасанхүү. Гурван хүн үг хэлнэ. За О.Баасанхүү гишүүн үг хэлнэ. Д.Эрдэнэбат гишүүн, О.Баасанхүү гишүүн, О.Содбилэг гишүүн.

О.Содбилэг: Энэ Тамгын газрынхан алдаа гаргасан бололтой байна. Энэ саналыг оруулахад би нэрээ оруулаагүй шүү. Холимог системийг оруулж байна гэж нэрээ өгөөгүй ээ. Хасна уу.

Г.Занданшатар: Байнгын хорооноос тэгж нэр ирсэн. О.Баасанхүү гишүүн.

О.Баасанхүү: Би гайхаад байна л даа. Дэгээ барья л даа. Дэгээрээ Улсын Их Хурлын гишүүн 10 минут үг хэлнэ гэж байгаа шүү дээ.

Өнөөдөр та бүхэн хэлэлцүүлэгтээ өнөөдөр МАНАН, мафийн бүлгийнхэн хэлэлцүүлэг хийчхээд өнөөдөр МАХН-ын 114 мянган хүний төлөөллийг орж зөвшилцөл, хэлэлцүүлэгт оруулаагүй байж байж үг хэлье гэхээр энийг болиулаад байгаа бол маргааш жинхэнэ юм хийнэ шүү. Би хатуу хэлээд байгаа шүү. Яагаад өнөөдөр энийг ингээд үг хэлүүлэхгүй, дундуур хаагаад, боогоод байгаа юм бэ.

Энд өнөөдөр та бүхэнд ойлгомжтой байж болно. Та бүгд өнөөдөр энд саарал ордонд суух нь тодорхой байж болно. Гэхдээ нөгөө нэг та нарын хэлдгээр гудамжныхан гэж хэлээд байгаа тэр ядарсан ард түмэн чинь өнөөдөр энэ юуг хийгээд, яаж хуйвалдаад байгааг чинь мэдмээр байна шүү дээ. Та нар ч гэсэн өнөөдөр намайг гудамжинд гарна хохь чинь л гэдэг. Гудамжныхан гээд байгаа чинь тэнэгүүд биш шүү.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Октябрийн Баасанхүү хэлэлцэж байгаа асуудал саналын томъёоллыг дэмжсэн, дэмжээгүй үг хэлнэ.

О.Баасанхүү: Энэ яриад байгаа зүйлийг чинь хэлмээр байна. Би одоо энэ хэлэлцүүлж байгаа асуудалтай холбоотой хэлье. Жагсаалтад орох дуртай хүмүүсийг хараад би ичиж байна та нарыг. Өмнө нь одоо энэ яриад байдаг энэ сонгуулийн жагсаалт гэдэг хуулийг 2012 онд оруулж ирсэн. 2012 онд оруулж ирэхдээ та нар ямар зорилготой оруулж ирсэн бэ гэвэл тойрогт ямар ч шансгүй байгаад оруулж ирсэн. Батлагдсан хуулийн дагуу Г.Баянсэлэнгэ бид хоёр бас бус нөгөө Ц.Нямдорж гуай, нөгөө Сү.Батболд гуай өөр хэн байдаг юм ингээд архаг улс төрчидтэйгөө хамт ороод ирсэн чинь нөгөө ах Ц.Нямдорж гуай жагсаалтын хууль шиг заваан юм хаана байна, жагсаалтын хуулийн алдаа бол О.Баасанхүү байна гээд орилсоор байгаад байхгүй болгосон. Одоо тэгээд та нар яасан бэ гэвэл хулгайч, хятадын тагнуулуудтайгаа нийлчихсэн жагсаалтын хууль оруулж ирэх гээд улайраад байгааг чинь хараад ичиж байна, санаа зовж байна. Би бол маш их ичиж

байна. Яагаад ичиж байгаа вэ гэхээр өнөөдөр тойргоос сонгогдоход.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн 10 дугаар хорооны иргэд сонгогчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Одоо Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Баярлалаа. Энэ санал хураалт бол Ардчилсан намын зарчмын 3 саналын нэг гол санал хураалт болох гэж байна. Би энэнтэй холбогдуулаад бас гишүүддээ хандаж нэг зүйлийг хэлэх нь зөв байх аа гэж ингэж бодож байгаа.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хийгдэж байгаа хамгийн гол зарчмын гурван тулгуур асуудлыг Ардчилсан нам санал болгож тавьсан байдаг.

Гишүүд жаахан чимээгүй байгаад өгөх үү. Жаахан чимээгээ намдчих уу.

Энэний нэг нь бол яах аргагүй энэ холимог тогтолцоо юм. Яагаад гэвэл энэ ардчилсан парламентыг төлөвшүүлэх, ирээдүйд энэ улс төрийн намууд нь бодлоготой байх, түүгээрээ дамжаад төрийн уламжлалт бодлого хадгалагдах, парламент дахь гишүүдийн сахилга хариуцлага, энэ бүх зүйл бол шууд энэ сонголттой бол холбоотой зүйлээ гэж бид ингэж үздэг ээ.

Тийм учраас Ардчилсан нам өнөөдөр энэ асуудлыг ярихдаа ямарваа нэгэн намын эрх ашиг ч юм уу, нэг эсвэл нэг гишүүнийхээ хувь хүнийхээ Д.Эрдэнэбатын ч юм уу асуудал огт яригдаагүй ээ гэдгийг манай гишүүд маш сайн ойлгоосой гэж би ингэж бодож байна.

Хамгийн гол нь энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт 2020 оноор дуусахгүй л дээ. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд энэ Ерөнхий сайдаас, Засгийн газраас сонгох асуудал, парламентаас сонгуулийг холимог тогтолцоогоор явах асуудал, Ерөнхийлөгчийг парламентаас сонгох асуудал бол энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн тулгуур гурван зарчим гэж бид ингэж харсан учраас энэ саналыг оруулсан.

Ер нь үе үеийн парламентуудын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан, Үндсэн хууль баталсан явцыг харахад парламент дахь улс төрийн намуудын нэгдсэн ойлголт зөвшилцөл дээр бүх хуулиуд батлагдаж байсан юм.

Тийм учраас энэ удаа энэ хууль ингэж батлагдаасай гэж бид нар чин хүсэлтэй байгаа учраас энэ хэлэлцүүлэгт өнөөдрийг хүртэл, өнөөг хүртэл оролцоод бид нар явж байгаа шүү.

Тийм учраас би гишүүддээ хэлэхэд энэ асуудал дээр зөвхөн 2020 оны сонгуулиа битгий хараарай манай гишүүд. Энэ Монголын хөгжлийн 20, 30 жилийн дараах энэ төлөвшлийн асуудлын суурийг өнөөдөр бид нар тавьж байгаа юм шүү гэдэг энэ бодлын үүдэн дээрээс энэ санал хураалтад би оролцохыг Та бүхнээс хүсэж байна.

Яг үнэндээ өнөөдөр би зөвшилцөл явагдаж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Зөвшилцсөн. Яагаад гэвэл энэ улс төрийн намуудын ард талд хэчнээн ард иргэд итгэл хүлээлгэн өнөөдөр тэнд харж суугаа гэдгийг бид мартаж болохгүй ээ. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явахдаа гуравдугаар хэлэлцүүлэгтээ шийдэгдэхдээ Ардчилсан нам энэ гурван саналыг дэмжвэл энэ Улсын Их Хурлынхаа хувьд, бүгдээрээ хамтдаа хариуцлагаа үүрвэл үүрье, нэг эсвэл хамтдаа гавьяагаа аваад явбал явъя гэдэг зарчим дээр өнөөдөр хүртэл бид нар явж байгаа шүү гэдгийг Та бүхэндээ бас сануулж хэлэхийг бодож байна.

Тийм учраас энэ саналыг бол бүгдээрээ дэмжиж өгөөрэй. Энэ бол өнөөдрийн асуудал биш шүү. Монголын хөгжлийн 20, 30 жилийн асуудлыг өнөөдөр бид нар кнопдох гэж байгаа гэдгийг манай гишүүд ухамсартайгаар ойлгож, саналаа өгнөө гэж бид итгэж байна. Тэгээд энэ саналын үр дүнгээс цаашдын бас Үндсэн хуулийн хувь заяа их юм шалтгаалах байх аа гэж би бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна.

“Улсын Их Хурлын сонгуулийг олонхийн болон хувь тэнцүүлэх зарчмыг хослуулан явуулна. Сонгогч тойрогт нэр дэвшсэн болон намын жагсаалтад орсон нэр дэвшигчийн төлөө саналаа өгнө.” гэсэн энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Гишүүд бэлэн байна уу. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 69 гишүүн оролцож, 41 гишүүн дэмжиж, 59.4 хувиар энэ санал дэмжигдсэнгүй.

Дараагийн найруулгын саналуудаа уншихъя. Найруулгын саналууд орно. Дэгийн хуулийн 24⁶.2.4. 4.Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна.” гэснийг “улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.” гэж өөрчлөх.

Найруулгын саналуудаар санал хураалт явуулна. Д.Эрдэнэбат, О.Баасанхүү, Б.Пүрэвдорж гишүүд үг хэлнэ. Кнопоо дараад нэрээ ав. Нэр тасаллаа. З.Нарантуяа, Д.Оюунхорол гишүүдээр тасаллаа. Дондогдоржийн Эрдэнэбат гишүүн үг хэлнэ.

Д.Эрдэнэбат: Тун харамсалтай байна. Өнөөдрийг хүртэл Ардын намтай бид нар энэ асуудлаар зөвшилцөж ирсэн. Ардчилсан намын гурван зарчмын саналын хоёр нь ингээд үндсэндээ уналаа.

Би өнөөдөр энийг юу гэж дүгнэж байна вэ гэхээр бидний зөвшилцлийн үр дүн гарсангүй ээ гэж ингэж харж байна. Би нэг юмыг Та бүхэнд бүр тодорхой хэлье. Ардчилсан Нам энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өөрчлөхийн төлөө өнөөдөр хүртэл яг шударга, зорилготой, бие биендээ итгэлцэж явсан гэдгийг би онцолж хэлмээр байна.

Харамсалтай нь бидний тавьсан санал өнөөдөр ингээд унаж байгаагаар Ардчилсан нам өнөөдрөөс эхлээд энэнээс цааш хэлэлцүүлэгт орох боломжгүй боллоо гэдгээ би Та бүхэнд мэдэгдье.

Энэ Үндсэн хууль, энд олон хууль байж болохгүй ээ. Энэ Үндсэн хуулийг бүтэн байлгахын төлөө, энэ ардчилсан парламентын төлөвшлийг, хөгжлийг бүрэн хангахын төлөө Ардчилсан намын энэ гурван санал байсан шүү гэдгийг би Та бүхэнд хариуцлагатайгаар мэдэгдье. Их баярлалаа.

Г.Занданшатар: О.Баасанхүү гишүүн үг хэлнэ.

О.Баасанхүү: Би тодорхой зүйл хэлмээр байна.

Нэгдүгээрт нь, энэ нам хоёр янзын чиглэлтэй байгаа юм л даа. Салбарын, бодлогын гээд. Салбарын гэдэг нь бол өнөөдөр баг, хороо, суманд нийтэд нь дэмжигч гэдэг юм уу, хатуу гишүүнчлэлдээ суурилад салбар, үүрүүдээ байгуулах.

Хоёрдугаарт нь, бодлогын гэдэг нь одоо тодорхой бодлого тодорхойлоод. Жишээлбэл, ипотекийн зээлийн хүүг 3 хувь болгоё ч гэдэг юм уу, зээлийн хүүг буулгана ч гэдэг юм уу. Иймэрхүү тодорхой бодлого тогтоогоод ингээд өнөөдөр явж байгаа намыг за энэ бол хамаагүй ээ. Мөнгөгүй байж болно. Тэгэхдээ зөв бодлого ярьж байна. Зөв хөтөлбөр тавьж байна. Зөв баг гаргаж байна.

Тийм учраас энэ хороодоо байна уу, багтаа байна уу, хаалга хашаагаар оруулж ирээд мөнгө шиднэ үү, байна уу хамаагүй ямар ч байсан энэ намыг зөвшөөрье гээд ингээд ерөнхийдөө сонгуульд ялах магадлал өндөр байдаг учраас ард түмний бол нөгөө би монгол хүний саруул ухаанд итгэдэг гэдэг шиг ийм намуудаас ялах боломж байгаа юм.

Гэтэл өнөөдөр төсөл орж ирэхдээ улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулна гэж оруулж ирсэн. Тэгэхээр би энэ хоёр дахь бодлогын нам тасарчихлаа гэнгүүт нь улсын хэмжээнд бодлого тавьдаг нам гээд ингээд бас мушгиад оруулаад ирсэн.

Тэгэхээр улсын хэмжээний бодлого, орон нутгийн хэмжээний бодлого гэж энэ бол маш түвэгтэй. Орон нутгийн хэмжээний бодлого гээд одоо орон нутагт нэр дэвших гэж байгаа хүн бол орон нутгийн хэмжээний бодлого л ярина шүү дээ. Бие дааж байгаа хүн бол бас тойргийн хэмжээний бодлого ярьж болно. Зөвхөн тойрогт одоо яах вэ, тойргийн гишүүдтэй яаж ажиллах вэ гээд. Нам гээд аваад үзэх юм бол өнөөдөр зөвхөн гэр хорооллыг асуудлаар ярьдаг бодлого байж болно. Гэр хороолол улсын хэмжээний гэж үзэх үү, аймгийн хэмжээний гэх үү, эсвэл малчидтай холбоотой асуудал ярьж болно. Малчдын асуудал бол улсын хэмжээний гэх үү, одоо тухайн орон нутгийн

хэмжээний гэх үү гээд ингээд үгээр хөөгөөд нөгөө хавчин гадуурхах, ялгаварлах, үзэл бодлоор нь бууруулах ийм асуудал байгаа учраас би уул нь горимын санал тавьж байсан юм.

Тэр нь юу вэ гэвэл Үндсэн хуульд нийцсэн бодлого явуулна гэж. Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн бодлого явуулна. Эсвэл бүр болохгүй юм бол бид нар чинь нөгөө урт удаан хугацааны болон богино хугацааны одоо хөгжлийн бодлого тодорхойлсон бол тэр хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх асуудлаар бодлого тодорхойлно ч гэдэг юм уу нэг иймэрхүү байдлаар хийчихсэн бол болох байсан.

Тэгээд даанч харамсалтай нь зөвшилцөөгүй, нөгөө нэг ингээд ярихаараа зөвшилцдөггүй гэдэг шиг тэгээд манай Ардчилсан Нам молигоддуулсан байна. Тийм. Анхнаасаа л молигоддуулна гэдгийг би өөрт нь хэлсэн. Харамсалтай нь үгэнд ороогүй. Тийм. Ингэж л явдаг шүү дээ. Бид нар 30 жил бие биенийгээ молигодсоор байгаад ингээд нэг талдаа гарлаа шүү дээ.

Өнөөдөр ард түмэнтэйгээ уул нь зөвшилцдөггүй юмаа гэхэд ядаж суудал бүхий намуудтай зөвшилцөх ёстой байсан. Тэгээд манайхтай бас зөвшилцөөгүй учраас Ардчилсан намтай адил Ардын нам дангаараа хуурамч нөгөө шинэ хүчинтэйгээ нийлээд энэ хуулиа батална биз дээ.

Та бүхэнд амжилт хүсье. Ард түмнээрээ дүн тавиулаад, албан ёсоор ард түмнээрээ дүн тавиулаад албан ёсоор олонх болж орж ирээд олон алдааг чинь засаж өгөхийг хичээе.

Анхаарал тавьсанд баярлалаа. Тийм учраас хэлэлцүүлгээс албан ёсоор гарлаа.

Г.Занданшатар: Б.Пүрэвдорж гишүүн үг хэлнэ

Б.Пүрэвдорж: Тэгэхээр өнөөдрийн энэ Үндсэн хуулийн өөрчлөлт үнэхээр мөлгөр өөрчлөлт болж байгаа. Үндсэн хуулийн хэлэлцүүлэг бол гурилдсан.

Энэ хэлэлцүүлгийн тайлан дээр 163 мянган иргэн энэ хэлэлцүүлэгт оролцсон гэж тайланд ирсэн боловч харамсалтай нь миний явсан, уулзсан хүн болгоноос ингээд асуулт асуухад нэг ч хүн оролцоогүй гэж ярьдаг аа. Энэ зунжингаа би уулзалт хийлээ, энэ намаржингаа уулзалт хийлээ. Үнэхээр гурилдсан.

Тэрэнтэй адилхан энэ Үндсэн хуулийг батлах үйл явц үнэхээр гурилдаж байна. Өнөөдөр бүх зүйл дээр одоо миний хурууны хээ болсонгүй, яасан ийсэн гээд бүгдээрээ асуудал гаргадаг. Энэ хурууны хээ чинь зүв зүгээр ажиллаж байгаа шүү дээ. Яагаад бид нар энэ Ардчилсан Намын энэ секторт байгаа хүмүүс хурууны хээ болохгүй байна гэж нэг ч өгүүлэл тавихгүй байгаа юм.

Зүгээр ажиллаж байгаа юмыг яадаг вэ гэхээр та нар энэ Үндсэн хуулийн ийм өндөр босготой баталдаг үйл явц дээр бүгдээрээ шантааж

тавьж байгаа шүү дээ. Миний тойргийг ингэжээд, миний энэ тендерийг авч өг, миний энэ асуудлыг шийд гэж бүгдээрээ энэ Их Хурлын дарга руугаа, бүлгийн дарга руугаа шантааж хийдэг. Ц.Даваасүрэн дандаа тэр үүдэн дээр сууж байдаг. Ирцэндээ орооч гээд тэгэхээр ордоггүй. Ийм л байгаа шүү дээ. Үндсэн хуулийг батлах үйл явц чинь бүгдээрээ гурилдаж байгаа.

Тэгээд өнөөдөр энэ нэр хүнд нь уначихсан энэ Их Хурлаар Үндсэн хуулийг батлуулж болохгүй ээ гэж ард түмэн яриад байна. Та нарыг харин зүгээр яах вэ өөрт чинь нэг зүйлийг өөрчилж болох юм тэр 2000 оны дордуулсан долоон өөрчлөлтийг одоо өөрчил өө гэж, болох юм гэж ярьж байгаа. Харамсалтай нь тэрний дөнгөж нэгхэнийг нь хагас зассан байгаа шүү дээ. Өөр юу ч өөрчлөөгүй.

Тэгээд өнөөдөр энэ эцэст нь хэлэхэд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтөөр яг тэр Ховдын Зэрэгт байгаа аль эсвэл Өмнөговийн Цогтцэцийд байгаа хүмүүсийн амьдрал нэг ширхэг ч өөрчлөгдөхгүй. Өнөөдөр Үндсэн хууль батлаагүй, энэ үйлчлэл нь явж байна. Маргааш тэд нарын амьдралд нэг ширхэг ч өөрчлөлт орохгүй. Энийг баталлаа гэхэд. Ганцхан одоо энэ Их Хуралд сууж байгаа энэ хүмүүс дахин сонгогдох, сонгогдохгүй тухай асуудал, өөрсдийнх нь дарга, цэрэг болохгүй тухай асуудал л байгаа болохоос бусдаар ард түмний амьдралд хэрэг болох өөрчлөлт энд огт явагдахгүй байгаа.

Тэгээд би та нарт нэг зүйл захья. 2016 онд Ерөнхийлөгчийн сонгуулийг болохоос өмнө би хэлж байсан. Та нарын тогтоосон дэг журмаар чинь, тэр хуулиар чинь сонгууль явуулна. Бид нар, ард түмэн цаг тухайд нь хариу өгнө гэж байсан тэрийгээр болсон. Та нар өнөөдөр энэ Үндсэн хуулийг өөрчлөөд яг тэр та нарын тэр тоглосон, тогтоосон хуулиар чинь, тоглож байгаа дүрмээр чинь сонгууль болно. Тэр үед ард түмэнтэйгээ хариугаа өгнөө гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Содномзундуйн Эрдэнийн урилгаар Баянгол дүүргийн 4 дүгээр хорооны иргэд сонгогчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Одоо эрхэм гишүүн Дуламсүрэнгийн Оюунхорол үг хэлнэ.

Д.Оюунхорол: Үндсэн хуулийн гурав дахь хэлэлцүүлэгтэй холбоотойгоор бас нэг хоёр, гурван асуудал дээр байр сууриа илэрхийлье гэж бодож байна.

Энэ Үндсэн хуулиас болоод ер нь энэ Монгол Улсын хөгжил болж бүтэхгүй байгаа бүх бэрхшээлүүдийг түлхэж бол бид олон жил ярьсан. Гурван парламент дамжиж Үндсэн хуулийнхаа өөрчлөлтийг хийе гэж ярьсан. Ер нь Монголын ард түмнээрээ бас нэлээн том хэлэлцүүлгүүд, саналыг авсан. Нийт тоогоороо 5.4 сая санал ирснийг бас шүүж, тунгааж, ярилцаж, долоо хэмжиж, нэг огтолж Монгол Ардын Намын бүлэг Улсын Их Хурлын энэ 75 гишүүн одоо бас урт хугацаанд хэлэлцлээ.

Өмнөх Үндсэн хуулийн өөрчлөлтийг 3 хоног хэлэлцээд, бас өөрчлөлт оруулж баталж байсан. Энэ 3 хоногийн өөрчлөлтөөр хийсэн 7 өөрчлөлтийг

саяын гишүүдийн ярьж байгаа шиг дордуулсан долоо гэдэг нэмэлт, өөрчлөлт хийсэн тухай ярьдаг. Энэ дордуулсан долоогийн 4 заалтыг бол засаж чадсан гэж бодож байгаа юм.

Би хууль тогтоох байгууллагын үйл ажиллагаа учир дутагдалтай байна. Улс орны хөгжлийн үндэс болсон хувийн өмч хөрөнгийг баталгаажуулаагүй байна. Шударга ёсыг тогтоох учиртай шүүх эрх мэдлийн хараат бус байдал хангагдахгүй байна. Ингээд ийм олон зүйлүүдийг бол бид их ярьсан. Том эрх ашгаа ярьсан. Харамсалтай нь өнөөдөр манай одоо зарим нэг Улсын Их Хурлын гишүүдийн илэрхийлж байгаа байр суурийг сонсоод бас харамсалтай санагдаж байна.

Бид бол өнөөдөр энэ 76 л Монголын ард түмнийг төлөөлж байна гэж бол ярих эрхгүй ээ. Тэгж болохгүй байх. Бид нар энэ Монголын ард түмний 5.4 сая иргэдээс ирсэн саналыг бид нар шүүж, тунгааж, олон талаас нь ярилцах ёстой байсан. Өнөөдөр бид нар улс төрийн соёлтойгоор, улс төрийн зөвшилцлөөр Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийх ёстой гэж ойлгож байгаа. Монгол Ардын намын 64, Үндсэн хуулийг дангаараа шийдвэрлэж, асуудлыг шийдэх гэж улайрч байгаа юм бол байхгүй ээ гэж үзэж байгаа.

Тийм учраас Монгол Ардын намын бүлэг одоо саяын унагаасан санал болох пропорционал систем буюу холимог систем, сонгуулийн системийг авах ёстой гэсэн байр суурьтайгаар намын бүлгийн шийдвэр гарсан гэж би ойлгож, сая би саналаа өгч дэмжсэн.

Манай О.Баасанхүү гишүүн сая энэ холимог тогтолцоог авч намын листийн ард нуугдах гээд байгаа нөхдүүд л энийг ярьж байнаа гэж ийм одоо буруу тайлбар хийж байгааг би үгүйсгэж одоо энэ мэдээллийг өгч байгаа юм. Энэ удаагийн өөрөөр хэлбэл холимог систем бол намыг дугуйлахгүйгээр хүнийг улс орон даяар 26 хүнийг дугуйлах тухай асуудал ярьж эрэмбэлүүлэх тухай ярьсан. Харамсалтай нь хуулийнхаа үндсэн заалтыг уншиж чадсангүй.

Хоёрдугаарт, улс төрийн намуудтайгаа зөвшилцөж, ярилцаж, дэмжсэнгүй ээ гэж ярьж байна. Энэ бол өнөөдөр пропорционал системийн хамгийн одоо давуу тал бол улс төрийн намуудыг төлөвшүүлэх, гадна талд байгаа улс төр хийж байгаа намуудыг 5 хувийн босго даваад, хэрвээ одоо олон түмний санал авч чадвал парламентын зааланд орж ирээд улс төрийнхөө мэтгэлцээнийг хийж, улс төрийн соёлтойгоор улс төрөө хийх ийм боломжийг олгож байгаа.

Манай зарим нэг намын листээр анх орж ирж байсан улс төрчид маань өнөөдөр энийг үгүйсгэж яриад, улс төрийн намуудыг бэхжүүлэх, төлөвшүүлэх, улс төр хийх боломжийг нь парламентын зааланд хийх ёстой энэ асуудлыг хойш нь татаж байгааг би үнэхээр харамсаж байна, гайхаж байна. Бид л зөвхөн гарах ёстой гэж бодож бид нар энэ удаагийн Үндсэн хуульд, сонгуулийн хуульд хандаж болохгүй гэж бодож байгаа. Нөгөө талаас энэ пропорционал системийг дэлхийн олон улс орон авч хэрэглэж байгаа. Энэний одоо хамгийн сайн тал нь сонгогчдын санал гээгдэхгүй, хаягдахгүй ийм давуу талтай.

Өнөөдөр Ардчилсан нам Монголын ард түмний 40 хувийн саналыг авчихсан мөртлөө 9 гишүүнтэй сууж байгаа явдал нь сонгогчдын санал хэр их хаягдаж, орхигдож, гээдэг, улс төрд байгаа энэ тогтолцоо чинь өөрөө гажиг нь засагдахгүй байгаагийн хамгийн том алдаа энд байсан юм. Харамсалтай нь энийг үгүйсгэснээрээ энэ алдаагаа засаж чадсангүй.

Нөгөө талд нь төлөөллийн ардчилал улс төрд оролцох боломж пропорционал системээр дамжиж бий болох ёстой байсан. Нөгөө талаас нийгмийн бүх давхаргуудыг Монгол Улсын парламентад орж ирэх боломжийг нь олгож өгөх ёстой байсан.

Нөгөө талаас энэ Жендэрийн эрх тэгш байдлыг одоо хангах тухай хуулийг хэрэгжүүлэхэд пропорционал систем давуу талтай. Пропорционал систем бол маш давуу талтай байсан. Бие даасан олон үндэстний цөөнхийн төлөөллөө оруулж ирэхэд пропорционал систем бол бас илүү давуу талтай байсан. Магадгүй шударга сонгууль болох байсан байх аа. Улс төрийн намууд бүгдээрээ энэ системийг бас шийдвэрлэхийг байх. Улс төр дэх ардчиллыг энэ Монгол Улс Үндсэн хуулиараа хүлээн зөвшөөрч өгөх юм байна гэж бид нараас харж байсан байх аа.

Тийм учраас бид өнөөдөр бие биенийгээ хардаж, жижиг жижиг эрх ашгаа бас бодолцож, энэ удаагийн энэ том улс төрийн реформ хийх гэж байгаа том шинэчлэлээсээ ухарч байна гэж харж байгаа.

Тэгээд бид нарыг ийм юм ярихаар та нар тойрогт очиж чадахгүй, нүүргүй болчихсон юм уу гэж байна. Уучлаарай, 2020 оны сонгуульд Баянзүрх дүүргийн 49 дүгээр тойрог дээр нэр дэвшээ гэдэг гэрийн даалгаврыг намаас өгвөл тэр тойрог дээр очоод өрсөлдөхөд бэлэн байгаа. Яагаад гэвэл бид нар сонгогчдоо хэзээ ч хуурдаггүй. Амласан, ярьсан, хэлсэн бүх ажлуудаа хийж явдаг. Энэ одоо төр, ард түмний гүүр болж ажиллах бүх ажлаа маш сайн хийж гүйцэтгэж яваа гэж боддог.

Тийм учраас энд бид нар ямар нэгэн намын листийн ард орж нуугдах сонирхол байдаггүй. 5 удаагийн сонгуульд ороход бид нэг ч тойргийн сонгуульд намын листийн ард нуугдаж орох гэж явсангүй ээ. Тийм учраас өнөөдөр улс төрийн энэ тогтвортой байдлыг бий болгож, сонгуулийнхаа үр дүнг хүлээн зөвшөөрөхийн тулд энэ асуудалд илүү хариуцлагатай хандаж, намын листийг өөрөөр хэлбэл пропорционал системийг оруулж ирээд, хүнээ улс орон даяар дугуйлаад эрэмбэлүүлчих ийм эр зориг бидэнд дутаж байна. Энэ бол бас харамсмаар байна.

Энэ алдаагаа дараа дараагийн хуулиараа бас засаж залруулах ажлыг бусад хуулиараа оролцуулах тал дээр Их Хурлын дарга Г.Занданшатар дарга аа, би танаас одоо нэг зүйлийг хүсээд байна. Энэ улсын намуудыг төлөвшүүлэх, бэхжүүлэх, сонгогчдын саналыг гээгдүүлэхгүй, орхигдуулахгүй байх тал дээр.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Загдхүүгийн Нарантуяа гишүүн үг хэлнэ.

3.Нарантуяа: Баярлалаа. Энэ оны 7 сараас хойш энэ Үндсэн хуулийг хэлэлцэх явц ямар замаар явав, одоо яг өнөөдөр ямар үр дүнд хүрэв ээ гэдгийг одоо эргэж харах юм бол сонин дүр зураг харагдаж байна.

Анхнаасаа олонхынхоо түрэмгийллээр энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг эхэлсэн. Хуулиа зөрчөөд, журмын хуулиа үл тоогоод, процессоо алгасаад явсан. Яг өнөөдөр одоо бол олонхынхоо хүслээр энэ Үндсэн хуулийн хэлэлцүүлэг өндөрлөх гэж байна. Үнэхээр харамсалтай байна.

Бид ард иргэдийнхээ санал хүсэлтийг бүх ард түмний санал асуулгаар явуулна гэсэн тэрийгээ орхигдуулсан. Улс төрийнхөө бусад намтай зөвшилцье гэсэн энэ зөвшилцлөө бас үгүйсгэлээ. Би өнөөдөр үнэхээр их гайхаж байна. Анх удаа Улсын Их Хуралд сууж байгаа гишүүний хувьд Монгол Улсын үндэсний хэмжээний ийм том намын бүлгийнхэн, ийм том намын хүмүүс ингэж урд урдаасаа бие биеэ харж сууж байгаад зөвшилцлөө гэж хэлээд эргэхдээ ар хударгаар нь ингэж хуурдгийг анх удаа харлаа. Энэ бол үнэхээр манай улс төрийн намууд ямархуу хэмжээнд соёлгүй байгааг, манай улс төрчид ямархуу хэмжээнд хэлсэндээ хүрдэггүйг харуулж байгаагийн илрэл боллоо гэж ард түмэндээ бас хэлэхийг хүсэж байна.

Энэ зөвшилцлийн ажлын хэсгийг анхнаас нь санаачилж, анхнаас нь оролцож явсан. Энэ мөчийг хүртэл бас зөвшилцөх юм болов уу гэж бодож явсан. Өнөө өглөөг хүртэл бид нар хугацаан дээрээ зөвшилцөөд, эцсийн хувилбараар бид нар пропорционал, холимог тогтолцоогоо нийлээд батална гэдэг итгэл үнэмшлээр орж ирсэн. Харамсалтай нь Та бүхэн маань урдаас нөгөө нүүрээ харууллаа. Үнэхээр харамсалтай байна.

Тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлтийн амин чухал сүнс нь энэ парламентыг төлөвшүүлэх, энэ увайгүй, худалч, хулгайч ийм улс төрчдийг энэ танхимд оруулахгүй байх үүдийг хаах гэсэн жижиг мажораторийг үүрд хаях гэсэн ийм л зорилго байсан. Харамсалтай нь тэгсэнгүй.

Хоёрхон хоногийн өмнө энэ танхимд Улсын Их Хурлын чуулган дээр бид нар улсын төсвөө баталсан. Энэ төсвийн зарцуулалт ямар замаар хуваарилагдсаныг бүх хүмүүс харсан. Та бүхэн бүгдээрээ жижиг жижиг тойрогтоо сонгогчдынхоо саналыг авахын төлөө л энэ мөнгийг хуваарилсан гэдгийг бүх хүн харсан.

Одоо 2020 онд сонгуульд бүх улс төрийн намын нэр дэвшигчид бие дааж нэр дэвшигчид та нартай бол үнэхээр хөрөнгө санхүү, хүчний хувьд тэнцвэргүй байдалд үлдлээ. Тэгэхдээ ард түмний ухаан гээгдээгүй байх. Эрүүл саруулаар сонголтоо хийх байх аа гэж найдаж байгаа.

Тэгээд баярлалаа. Өнөөдрийг хүртэл, энэ цагийг хүртэл хамт явсан зөвшилцлийн ажлын хэсгийнхэндээ, тэгээд бидэнд одоо өөр энд хийх ажил үлдсэнгүй учраас одоо энэ чуулганыг орхилоо.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Тэгэхээр зэрэг энэ саналыг одоо энэ Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаарх саналын

томъёоллыг санал хураахдаа миний бодоход бол дэмжсэн, дэмжээгүй гурав гурван хүний үг авна л гэж бодоод байгаа юм л даа.

Ялангуяа одоо энэ найруулгын шинжтэй биш ийм зарчмын саналыг жаахан тойруулаад яриулах тийм боломж олгосон бол бас чухал байсан байх гэж бодож байгаа юм. Тухайлах юм бол би энд кноп дараад миний нэр орсонгүй. Нэрээ одоо энд дэмжсэн, дэмжээгүй гурав гурван хүн одоо үг хэлэх ёстой биз дээ гэж асуугаад миний нэр орсонгүй. Би өмнө нь би бас үг аваад асуусан. Тэгээд надад одоо яг нэг бүрэн хэмжээний итгэл үнэмшил төрөхгүй байгаа байхгүй юу.

Энэ чинь ямар эхлэлтэй юм гэхээр зэрэг тэр 2012 онд одоо намын листээр хүмүүс оруулдаг ийм тогтолцоогоор сонгуулийг явуулсан. Тэр бол одоо аль аль энэ улс төрийн намууд тэр намын листэндээ иргэдийн дэмжиж байгаа биш тийм хүмүүсийг суулгасан учраас энэ намын листээр сонгодог энэ тогтолцоо чинь нэр хүнд нь их унасан шүү дээ.

Тэгээд тийм учраас энэ 2012-2016 онд энэ намын нэрээр Улсын Их Хуралд сонгогддог энэ байдлыг халах ёстой гэж ярьж, шаардаж байсан хүмүүсийн нэг. Тийм учраас өнөөдөр би энийг дэмжих надад бололцоо байхгүй байгаа юм.

Нөгөө талд нь би энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулахдаа улс төрийн намуудтай зөвшилцөх хэрэгтэй. Хамгийн түрүүнд энэ Их Хуралд суудалтай улс төрийн намуудтайгаа хэл амаа ололцоо гэдэг ийм шаардлагыг би тавьж байгаа. Эхнээс нь тавьж байгаа хүн. Тэгээд энэ одоо Ардчилсан намын зөвлөл энэ холимог тогтолцоог авъя гээд зөвшилцөж байгаа гол юм нь энэ байж байгаа юм.

Ингээд энэ чинь надтай адилхан ингээд хоёр талын шахалт савслагад байж байгаа улсууд энэ дотор одоо санал өгөх гээд байж байгаа улсуудад би байгаа байх гэж би ингэж ойлгож байгаа байхгүй юу. Тийм учраас ядаж одоо хуулийнхаа дагуу нэг гурав гурван хүмүүсийг хэлүүлчих ийм боломж байгаагүй юм болов уу гэж би ингэж бодож байгаа юм.

Тэгээд тийм учраас ингээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдана гээд тэгэхэд энэ улс төрийн намууд одоо энэ Их Хуралд сууж байгаа Ардчилсан Намын зөвлөл гараад явчихлаа. Би өмнө нь одоо тэр том ажлын хэсэг, зөвшилцлийн ажлын хэсэг байгуулагдахад энэ Монгол Ардын Хувьсгалт Намыг төлөөлөөд байж байгаа энэ О.Баасанхүүг оруулаач ээ гэж би санал эндээс хэлээд Та бүхэн маань хүлээж аваагүй л дээ. Уг нь бол тэгээд эндээ байж байгаа энэ төлөөлөл болсон хүмүүсийгээ тэр ажлын хэсэгтээ аваад оруулчих ёстой байсан юм.

Дараагийнх нь нэг юм бол энэ ард түмний санал асуулга, ард нийтийн санал асуулга авч байгаад энийг нэг талд нь гаргачихсан бол одоо зөв байсан юм л даа. Тэгтэл би энэ асуудлыг эхнээс нь тавьж байсан хүн. Тэгээд энэ маань явцдаа тэгээд орхигдчихлоо л доо. Тэгээд ийм ийм учир шалтгаанууд байх юмаа. Тэгээд энэ чинь цаашдаа ингээд Монгол Ардын Нам жаран хэдэн суудалтай ч байдаг юм тэгээд энүүгээрээ сууж байгаад одоо энэ нэмэлт, өөрчлөлтийг батлаад явна гэвэл ямар хэмжээнд байх юм бол доо.

Ер нь бид бас иргэд олон түмэнтэй нэлээн уулзаж, хэлэлцүүлэг юм зохион байгуулсан. Би өөрийнхөө санаагаар энэ ард нийтийн санал асуулгыг явуулаач ээ гэж ийм шаардлагыг би хэлээд байсан зүйл биш. Манай тойргийн тэгээд бас одоо өөр аймаг, энэ нийслэлийн дүүргүүдээр би бас иргэдтэй уулзаж байсан. Ерөнхийдөө одоо зонхилох иргэд сонгогчдын тавьж байгаа шаардлага бол та бүхэн маань одоо Үндсэн хуулийнхаа нэмэлт, өөрчлөлтийн асуудлыг ард нийтийн санал асуулга, биднээс асууж байж энэ асуудлаа эцэслэнэ биз дээ гэсэн нийтлэг ийм санал хэлж байсан учраас би тэр шаардлагыг тавьж байсан юм. Тэгтэл харамсалтай нь ард нийтийн санал асуулга явагдахааргүй ийм байдалтай болсон.

Одоо дээрээс нь энэ Их Хуралд суудалтай байж байгаа улс төрийн намууд энэ төлөөлсөн хүмүүст чинь хаяад гараад явчихлаа. Ийм нөхцөл байдалтай байна. Энийгээ нэг эргэж харсан нь зөв байхаа гэж би ингэж бодож байна.

Г.Занданшатар: Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Гишүүд суудлаа эзэлнэ үү. Санал хураалтад бэлтгэнэ үү.

Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан, Гомпилдоогийн Мөнхцэцэг нарын урилгаар Дорноговь аймгийн Айраг сумын төрийн албан хаагчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Санал хураалт явуулна. Бэлэн болсон уу? Найруулгын саналаар санал хураалт явуулъя. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулна.

61 гишүүн дэмжиж, 93.8 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Дараагийн найруулгын санал. Дэгийн хуулийн 24^б.2.4-т заасны дагуу. Эхлээд уншаадахъя, дараа нь. 5. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалт буюу Арван ес¹ дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “зарчимд нийцэж” гэснийг “зарчимд нийцсэн” гэж, “байгуулалт нь” гэснийг “байгуулалт”, “эх үүсвэр болон” гэснийг “эх үүсвэр,” гэж өөрчлөх. Найруулгын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. Дараагийнх дээр үг хэлчих.

62 гишүүн дэмжиж, 95.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал. 6 дахь санал байна. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тулгуурласан” гэснийг “тулгуурлаж”, “иргэн бүрт” гэснийг “ирээдүй үеийн” гэсний дараа оруулах, “бүрт” гэснийг “бүрд” гэж, мөн “эрхийнхээ хүрээнд” гэсний дараах “газрын хэвлийн баялаг” гэснийг “газрын хэвлийн баялгийг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-

Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. За Н.Цэрэнбат гишүүн үг хэлнэ.

Н.Цэрэнбат: Өнөөдөр бид нар 2016 онд Улсын Их Хуралд Монгол Ардын Нам нэр дэвшигчиддээ ард иргэддээ танилцуулж байсан мөрийн хөтөлбөрийн одоо бас чухал заалт биелж байгаад таатай байна. Яг энэ заалтан дээр.

Тэгээд энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэйгөө холбогдуулж бас үг хэлье. Монгол Ардын Нам хуурамч ардчиллыг устгаж, дүр эсгэсэн ардчиллаас жинхэнэ ардчиллын ололт, үнэ цэнийг хамгаалах зайлшгүй цаг үе тулгараад байна. Монгол Улсад бий болоод байгаа Үндсэн хуулийн хямралыг энэ өөрчлөлтөөр бид засна гэж амлаж байсан юм. Ингээд бид энийг одоо ингээд чадан ядан хийж байгаадаа баяртай байна.

Сүүлийн үед гишүүд маань ингээд бас ирээдүй ярьж байгаа юм шиг мөртлөө одоо цаг, өнгөрсөн цаг дээр их ард иргэдийнхээ зовлонтой хамт байгаагаа яриад, ард иргэдийнхээ нэр барьж их юм яриад байна. Эндээсээ болих хэрэгтэй бид.

Бид ард иргэддээ тулгараад байгаа зовлонг арилгая, хүндрэлийг шийдье гээд сонгогдсон болохоос биш хэн их зовлон ярьсан, хэн зовлонтой нь хамт байнга байдаг байснаараа ялгарах цаг үе өнгөрсөн. Ийм ч учраас Үндсэн хуулийн өөрчлөлт яригдаж байх үед миний бие Улсын Их Хурлын гишүүнийг 5 жилээр, гишүүдийн тоог 108, сонгуулийн системийг холимог байх нь зүйтэй гэж үзэж байсан юм. Яагаад вэ гэвэл олон ургалч үзлээр асуудлыг би шийддэг байх ёстой гэдэг үүднээс энд одоо бид холимог системийг оруулах ёстой гэсэн байр суурьтай байгаа.

Дээрээс нь бидний энэ өөрчлөөд байгаа 1992 оны 01 сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хууль дээр эхний дөрөв дөх мөрөн дээр байгаа. Хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзнэ гэж. Ер нь улс төрийн системд байдаг холимог буюу энэ пропорционал гэж яриад байгаа систем бид цаашдаа ч бий болно. Эндээс бид одоо зугтах хэрэггүй гэдгийг бас хэлье.

Дараагийн нэг юу нь өнөөдөр бид нар энэ Үндсэн хууль дээр яадаг эрх мэдлийг тодорхой болгосноор ямар амжилтад хүрэх ёстой юм бэ гэвэл саяын хэлсэн Монгол Ардын намын мөрийн хөтөлбөрийн 2.4.4-т заасан уул уурхайн баялгаас олох орлогыг одоо болон ирээдүй, хойч үедээ тэгш хүртээх гэдэг заалт яг бид нарын яриад байгаа иргэн бүрт гэдгээр орж байгааг бас хэлэхэд таатай байна. Энэ нь бидний ирээдүй хойч үеийн төлөө зөндөө ажиллалаа.

Гэхдээ бид нэг юмыг ойлгох хэрэгтэй байна. Бид хоорондоо хэрэлдэж талцаж энэ зүйл, заалт энгийн иргэдэд ингэж хүрэх ёстой гэж хэтэрхий хөөсрөлөөр, хэтэрхий ерөнхий ярьснаас болж бидний хөгжлийг тэтгэдэг, эдийн засаг, эрчим хүч, уул уурхайн салбарт бид нар тодорхой ахиц авчирч чадсангүй. Энэ дээр бид ний нуугүй үнэнтэй нүүр тулж энэ алдаагаа засдаг болох ёстой учраас энэ Үндсэн хуулийн энэ заалт бидэнд илүү боломжийг авчирна.

Харин эрх мэдлийг бид илүү тодорхой болгохгүй бол цаашид бид өмнө нь яригдаж ирсэн гурван толгойтой төрийг бид хэзээ өөрчлөх юм бэ. Энэ дээр бид хариуцлагатай, тодорхой өөрчлөлтийг хийе гэж хүсэж байсан боловч улс төрийн үл ойлголцол, өөр өөр өнцгөөс хараад энэ шийдэлд хүрч чадсангүй болж байна. Гэсэн хэдий ч Монголын ирээдүй илүү сайхнаар, илүү урагшилж байгаа гэдгийг бид ойлгох ёстой.

Дээрээс нь бүгд улс төрийн намаас нэр дэвшдэг. Тэгчхээд бүгд улс төрийн намынхаа удирдлагуудын тэр намын жагсаалт гэдэг юмыг өөрсдийнхөө сэтгэл хөөрөл, эмоциор өнгөрсөн түүхээр дүгнээд байна. Цаашид дэлхий дээр улс орны эрх мэдэлд хамгийн ардчилсан зарчмаар эрх мэдэл авч, бодлогоо хэрэгжүүлдэг бол улс төрийн намаа.

Тийм учраас аль ч нам бай олонх ч бай, цөөнх ч бай улс төрийн намыг сахилга хариуцлагатай байх, тэр намын жагсаалт гэж яригддаг юм цаашид бий болоход шалгуур хэмжээгээ цаг үе, ирээдүй хойч аяндаа өндөрсгөөд явчихна. Ийм учраас цаашид улс төрийн намыг муулсан, улс орныхоо ирээдүйд хойш нь татсан, өнгөрсөн түүхийг ирээдүйд давтагдах юм шиг битгий ард иргэдээ ухуулан сурталчлаасай гэж хүсье та бүгдээсээ. Тэгээд энэ Үндсэн хуулийн өөрчлөлт олон түгжээг бүгдийг мулталж чадаагүй ч гэсэн олон гарцыг нээж, олон хариуцлагыг чангатгасан Үндсэн хууль болж байгаа гэдэгт итгэж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Сайхан үг хэллээ. Одоо санал хураалт явуулна. Санал хураалтад бэлэн үү. Санал хураалт явуулъя. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 61 гишүүн дэмжиж, 95.3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Б.Жавхлан гишүүний кноп ажиллахгүй байна уу, буруу яагаад байна уу. Протоколд тусгахаар.

7 дахь санал хураалт. Дэгийн хуулийн 24⁶.2.1-ийн заалтын дагуу орж байгаа. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалт буюу Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.” гэсэн 4 дэх өгүүлбэр нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гишүүд байна. Санал хураалт явуулъя. Санал хураалт. Энд протоколд.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 62 гишүүн дэмжиж, 96.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Дэгийн хуулийн 24⁶.2.4-ийн дагуу орж байгаа. 8.Төслийн 3 дугаар зүйлийн 2 дахь заалт буюу Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гуравны хоёроос доошгүй нь үзсэн,”

гэснийг “гуравны хоёроос доошгүй нь үзэж” гэж, “даргатай зөвшилцөн” гэснийг “даргатай зөвшилцөж” гэж, “санал болгосноор” гэснийг “санал болгосон бол” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд. Санал хураалт явуулья.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 62 гишүүн дэмжиж, 96.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Төслийн 3 дугаар зүйлийн 7 дахь заалт буюу Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “батлагдсанд тооцож” гэснийг “баталсанд тооцож” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Санал хураалт явуулья. Баталсанд тооцож гэсэн өөрчлөлт. Санал хураалт явж байхад шууд санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 61 гишүүн дэмжиж, 95.3 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

10 дугаар санал. Дэгийн хуулийн 24⁶.2.4-ийн дагуу найруулгын санал. 10. Төслийн 3 дугаар зүйлийн 9 дэх заалт буюу Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэснийг “Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой зөвлөлийн үйл ажиллагааны тайланг” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Ц.Гарамжав гишүүн үг хэлнэ. Ц.Гарамжав гишүүнээр үг тасаллаа.

Ц.Гарамжав: Энэ нөгөө 6.2 дээр байгаа стратегийн ордуудын дийлэнх хувийг Монгол Улсын эрх ашгийн талд үлдээх гэсэн заалтыг 20 гишүүний санаачилснаар уг нь явж байсан юм. Тэгээд нөгөө ард нийтийн санал асуулгаар орох байсан чинь одоо ажлын хэсгийн саналаар болоод явчихлаа л даа. Энийг даргаа тэр 20 гишүүний санаачилснаар нь үлдээж өгөөч гэсэн санаа. Тийм. Ийм санал байна.

Г.Занданшатар: За ойлголоо. Их Хурлын Тамгын газар 20 гишүүний нэрээр болгооч. Нөгөө Төрийн байгуулалтын байнгын хорооны 3-ны 2-оор босно гэсэн тийм журмын тухай хуулиа дагаад ингээд Төрийн байгуулалтын байнгын хороо биччихсэн байх. Тэгэхээр энэ дээрээ оруулья. Ц.Гарамжав гишүүний саналыг хүлээж авлаа. Зүйтэй байна. Одоо санал хураалтаа явуулна. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 63 гишүүн дэмжиж, 98.4 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Найруулгын санал. Дэгийн хуулийн 24⁶.2.4-ийн дагуу. 11.Төслийн 3 дугаар зүйлийн 11 дэх заалт буюу Тавин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хот; тосгоны” гэснийг “хотын, түүнчлэн тосгоны” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Д.Эрдэнэбат. Үг Ж.Батзандан гишүүн, Ц.Цогзолмаа гишүүн нар хэлнэ. Тасаллаа.

Ж.Батзандан: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн 3 дугаар хэлэлцүүлэг болж байна. Энэ хэлэлцүүлэгт ШИНЭ нам 3 зүйл, заалтыг оруулахын төлөө зуны 3 сарыг, бараг намрын 3 сарыг та бүхэнтэй тулалдаж, заримдаа гуйж, заримдаа бас загнаж, зандарч элдвээр ярьж байж энэ 3 заалтыг орууллаа.

Төслийн 11 дүгээр заалт. Баянзүрх, Сонгинохайрхан гэх мэт томоохон дүүргүүдийг хот болгох, Дархан, Эрдэнэт гэх мэт томоохон засаг захиргааны нэгжээ хотын статустай болгох эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тулд энэ 11 дүгээр заалт Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд орж ирж байгаа гэдгийг Та бүхэн мэдэж байгаа байх аа. Энэ заалтыг дэмжиж байгаа, дэмжиж өгсөн Та бүхэнд талархаж байгаагаа илэрхийлье.

Хоёрдугаар асуудал. ШИНЭ намын хоёр дахь хатуу байсан байр суурь бол шүүхийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх чиглэлд Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхтэй холбоотой заалтуудыг оруулж ирж байгаа. 10 дугаар заалт. Энэ заалт орж ирснээр шүүхийн хараат бус байдал сайжирна гэж бид үзэж байгаа юм. 10-ыг дэмжиж өгсөн гишүүддээ баярлаж байгаагаа илэрхийлье.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд ШИНЭ намын оролцож байгаа хамгийн чухал, амин чухал заалт бол, бодлого бол стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа баялгийн үр өгөөжийн дийлэнх хувь нь ард түмэнд оногддог байна гэж Үндсэн хуульд зүйл, заалт оруулж байгаа явдлыг бид дэмжиж, хоёр гараа өргөж дэмжиж байгаа юм. Баялгийн сан байгуулж, баялгийн сангаасаа Монголын ард түмэндээ хувь, ногдол ашиг хүртээх бодлогыг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр оруулж ирэхийн төлөө 3 сар та бүхэнтэй бас маргалдаж, хэрэлдэж, бас заримдаа хатуу үг хэлж байсандаа хүлцэл өчье. Энэ 3 заалтыг дэмжиж өгсөн Улсын Их Хурлынхаа нийт гишүүдэд талархаж байгаагаа илэрхийлье.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Цэдэнбалын Цогзолмаагийн урилгаар Ховд аймгийн иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөе. Одоо эрхэм гишүүн Цэдэнбалын Цогзолмаа үг хэлнэ.

Ц.Цогзолмаа: Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн гуравдугаар хэлэлцүүлэгтээ үнэхээр чухал саналуудыг үнэхээр Монгол Улсын ирээдүйн хөгжилд нэмэр болох олон асуудлуудыг бас Улсын Их Хурлын гишүүд маань дэмжиж байгаад талархалтай байгаа.

Яг энэ төслийн 3 дугаар зүйлийн 11 дүгээр заалт дээр түрүүчийн одоо хэлэлцүүлэг дээр санал гарсан гишүүдээс маань санал гаргасан Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах чиглэлээр, мөн түүнчлэн ер нь Монгол Улс маань нүүдэлчин соёл ахуйгаас хот, иргэншлийн соёл ахуйд ороод бас хөгжлийн концепц маань тодорхой болоод явж байгаа. Энэ тохиолдолд бид нар 21 аймгийнхаа төвүүдийг бид нар ер нь хот болгох тэр хөгжлийн концепцийг нь нээж өгөх зайлшгүй шаардлагатай байна.

Тийм учраас зөвхөн Дархан, Эрдэнэтээр хотыг хязгаарлахгүйгээр найруулгын гэхээсээ илүүтэй төвлөрлийг сааруулах ийм агуулгын өөрчлөлтийг бас энд хийж өгөх асуудлыг дараагийн хэлэлцүүлгээр оруулж ирээсэй гэсэн ийм саналыг хэлэхийг хүсэж байна. Төслийг дэмжиж байна.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна. Одоо санал хураалт явуулна. Гишүүд байраа эзлээрэй. Санал хураалт.

58 гишүүн дэмжиж, 92.1 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ. Нэг гишүүний карт яагаад сугарчхаж, 64 гишүүн байсан чинь хэн гарчхав. Ирцээс хүн гарахгүй шүү.

Одоо санал хураалт явуулна. 12 дугаар санал. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 6 дугаар зүйлийн “рашаан барилдлагатай өлзийт сайн шар луу” гэснийг хасах.

Санал гаргасан Н.Амарзаяа, Ж.Батзандан, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Г.Занданшатар, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Санал хураалт явуулъя. Санал хураалтдаа анхаараарай. Санал хураалт.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 59 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ. Шар луу хасагдлаа.

Найруулгын санал. Дэгийн хуулийн 24⁶.2.4. 13. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 12 дахь заалт буюу Дөчин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “төсөв,” гэснийг “төсвийн болон” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, Ж.Батзандан, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Д.Эрдэнэбат нарын гишүүд байна. Д.Оюунхорол гишүүн санал хэлнэ. 5 минутад багтаад.

Д.Оюунхорол: Би богинохон санал хэлнэ.

Ер нь энэ жил бүрийн улсын төсөв хэлэлцэх үед Улаанбаатар хотын төсвийн хөрөнгө оруулалт бага байгаа тухай, төвлөрөл бий болсон, энэ

хөрөнгө оруулалтууд ер нь тэнцвэртэй хуваагдаж чадахгүй байгаа, шударга биш байгаа тухай Их Хурлын гишүүд маш их ярьж байгаа.

Тэгээд цаашдаа энэ Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцүүлэг дээр тогтоол оруулж ирэхдээ 350 мянга гаруй хүн амтай Баянзүрх дүүрэг, Сонгинохайрхан дүүргийг хоёр дүүрэг болгож хуваагаад, тэгээд хүн амынх нь тоонд харьцуулсан нэг 170, 180 орчим мянган хүн амтай 4 дүүрэг шинээр бий болгооч ээ гэдэг асуудлаар санал оруулж ирж, тогтоолоор үүрэг, чиглэл өгмөөр байна гэдгийг Төрийн байгуулалтын байнгын хороонд үүрэг болгож өгмөөр байна.

Энэ хоёр том дүүрэг бол үнэхээр маш их хүн амтай. Төрийн бодлогын гадна олон мянган иргэд нь үйлчилгээ авч чадахгүй хаягдаж байгаа, орхигдож байгаа ийм сул талууд байгаа учраас энэ том дүүргүүдийг ингэж хувааж өгөөч ээ гэдэг саналыг Төрийн байгуулалтын байнгын хороон дээр санал хураалт тогтоолын төслөөр оруулж ирээч ээ гэж чиглэл өгмөөр байна.

Тэгэх юм бол энэ төсвийн хуваарилалт, Улаанбаатар хотын хүн ам нэмэгдэж байгаа, хөдөөнөөс ирж байгаа шилжин ирэгсдийн тоо буурахгүй байгаа, энэ цаг үед бол илүү шударга төсвийн хуваарилалт явагдах болно гэж ингэж бодож байна. Тийм учраас ийм чиглэлээр тогтоол оруулж ирээч ээ гэж үүрэг болгомоор байна.

Г.Занданшатар: Одоо санал хураалт явуулна. 13 дугаар саналаар. Гишүүд. С.Чинзориг, Д.Сарангэрэл сайд хоёр суудалдаа сууна. Чуулганы дараа завсарлахаар та хоёр уулзаа. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 58 гишүүн дэмжиж, 92.1 хувийн саналаар санал дэмжигдлээ.

14 дэх санал. Сүүлийн санал. Д.Оюунхорол гишүүн дараачийн мөрдөх хууль дээр түүнийг ярина. Тэгэхдээ шилжих. Энийг одоо Төрийн байгуулалтын байнгын хороо анхаараарай гэсэн чиглэл өгч байна. Д.Оюунхорол гишүүний гаргасан саяын саналыг одоо анхаарах чиглэл өгч байна.

14. Хоёр дахь хэлэлцүүлгийн дараах төслийн 3 дугаар зүйлийн 13 дахь заалт буюу Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тойргийн” гэсний өмнө “шүүхийг” гэж нэмэх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Н.Амарзаяа, С.Бямбацогт, Д.Лүндээжанцан, Д.Тогтохсүрэн, Л.Оюун-Эрдэнэ, О.Содбилэг, Д.Хаянхярваа, Н.Цэрэнбат, М.Энхболд, Н.Энхболд, Д.Эрдэнэбат. Санал хураалт явуулъя. Гишүүд. Ц.Цогзолмаа гишүүн алга байна. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 61 гишүүн дэмжиж, энэ санал дэмжигдлээ. 96.8 хувийн санал дэмжигдлээ.

Эрхэм гишүүд ээ. Саналын томъёолол тус бүрээр санал хурааж дууслаа. Одоо Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 3-аас доошгүй нь дэмжсэн саналууд төсөлд туссанд тооцлоо. Одоо Төрийн байгуулалтын байнгын

хорооноос дэмжсэн саналуудыг төсөлд тусгасан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн эцсийн хувилбарыг бэлтгэж оруулж ирэх тул хуралдааныг 5 минут түр завсарлуулъя.

Төсөл бэлэн болмогц төслийг бүхэлд нь уншиж танилцуулан, бүхэлд нь батлах санал хураалт явуулна. 5 минут түр завсарлуулъя.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Эрхэм гишүүд ээ. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл бэлэн боллоо.

Одоо Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг бүхэлд нь уншиж танилцуулна.

Ингээд төслийг нэр, зүйл, хэсэг, заалт, цэг, таслал бүрээр нь уншиж танилцуулна. Ингээд бүхэлд нь уншиж танилцуулсны дараа Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бүхэлд нь батлах санал хураалтыг явуулна. Жавхлан гишүүн санал хэлнэ гэсэн үү. Больсон уу. Ингээд бүхэлд нь уншиж танилцуулъя.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Нэгдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/ Арван ес¹ дүгээр зүйл:

“Арван ес¹ дүгээр зүйл

1. Нам Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 10-т заасны дагуу байгуулагдаж, улсын хэмжээний бодлого дэвшүүлж ажиллана.

2. Намыг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэдийн нэг хувиас доошгүй тооны иргэн эвлэлдэн нэгдэж байгуулна.

3. Намын дотоод зохион байгуулалт ардчилсан зарчимд нийцсэн, хөрөнгө, орлогын эх үүсвэр, зарцуулалт нь нийтэд ил тод байна. Намын зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, санхүүжилт, төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг хуулиар тогтооно.”

2/ Хорин хоёрдугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

“3. Ерөнхийлөгч Үндсэн хуулийн гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг томилох саналыг Улсын Их Хуралд анх оруулснаас хойш дөчин тав хоногийн дотор, эсхүл Үндсэн хуулийн дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулснаас,

түүнчлэн дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцорсонд тооцсоноос хойш гуч хоногийн дотор Улсын Их Хурал Ерөнхий сайдыг томилоогүй бол Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах шийдвэр гаргана.

4. Энэ зүйлийн 2, эсхүл 3 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр гаргаснаас хойш Улсын Их Хурал арав хоногийн дотор сонгуулийг товлон зарлаж, жар хоногийн дотор явуулна. Шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөтөл Улсын Их Хурал бүрэн эрхээ хадгална.”

3/ Хорин долдугаар зүйлийн 7 дахь хэсэг:

“7. Улсын Их Хурлын гишүүд саналаа илээр гаргаж асуудлыг шийдвэрлэнэ. Үндсэн хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи дэмжсэн бол нууц санал хураалт явуулна.”

4/ Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэг:

“6. Хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл ногдуулах чиг үүрэг бүхий Шүүхийн сахилгын хороо ажиллах бөгөөд түүний бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.”

Хоёрдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалтад “Монгол Улс өөрийн тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг үгүйсгэх аливаа оролдлогыг үл зөвшөөрөх бөгөөд мөнхүү зорилгоор ард нийтийн санал асуулга явуулахыг хориглоно;” гэсэн агуулгатай 2 дахь өгүүлбэр, Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангарагаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.” гэсэн агуулгатай 1 дэх өгүүлбэр тус тус нэмсүгэй.

Гуравдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ Зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн нийтийн өмч мөн.

Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ.

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй.

Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглахдаа байгалийн баялаг ард түмний мэдэлд байх зарчимд нийцүүлэн түүний үр өгөөжийн дийлэнх нь ард түмэнд ногдож байх эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.”

2/ Хорин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

“4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно. Улсын Их Хурлын ээлжит сонгууль явуулахын өмнөх нэг жилийн дотор Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулахыг хориглоно.”

3/ Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзэж, эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж санал болгосон бол Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар өөрөө тарах шийдвэр гаргаж болно.”

4/ Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үндсэн чиглэлийг тодорхойлж, хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцүүлэн боловсруулсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

Хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байна.

Улсын төсвийг хэлэлцэн батлахдаа төсвийн орлого, зарлагын бүтцийг өөрчилж болно. Ингэхдээ Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын хэмжээг нэмэгдүүлж үл болно.

Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно;”

5/ Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдлэх бөгөөд энэхүү эрхийн хүрээ, хязгаарыг хуулиар тогтооно.”

6/ Хорин долдугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6. Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

Үндсэн хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар хуулийг эцэслэн батална.”

7/ Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.

Байнгын болон бусад хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.”

8/ Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Ерөнхийлөгчөөр тавин нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг зургаан жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгоно.”

9/ Гучин гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4. Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно.”

10/ Гучин есдүгээр зүйл:

“Гучин есдүгээр зүйл

1. Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ. Ерөнхий сайд болон Засгийн газрын дөрвөөс илүүгүй гишүүн Улсын Их Хурлын гишүүний албан тушаалыг хавсарч болно.

2. Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг; бусад тохиолдолд Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхийг бүрдүүлж нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Ерөнхийлөгч тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулна.

3. Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд энэ асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

4. Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулснаар Ерөнхий сайд томилж, чөлөөлж, огцруулна. Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөнө.”

11/ Дөчин гуравдугаар зүйл:

“Дөчин гуравдугаар зүйл

1. Улсын Их Хурлын гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй нь Ерөнхий сайдыг огцруулах саналыг албан ёсоор тавибал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор шийдвэрлэнэ. Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи уг саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.

2. Ерөнхий сайд огцорвол Засгийн газар бүрэлдэхүүнээрээ огцорно.”

12/ Дөчин дөрөвдүгээр зүйл:

“Дөчин дөрөвдүгээр зүйл

1. Ерөнхий сайд улсын төсвийн болон бодлогын тодорхой асуудлаар өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулбал Улсын Их Хурал гурав хоногийн дараа хэлэлцэж эхлэн арав хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэнэ.

2. Улсын Их Хурал тогтоолыг баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолыг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, шинэ Ерөнхий сайдыг гуч хоногийн дотор томилно.”

13/ Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“1. Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.”

14/ Дөчин есдүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

“5. Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож, бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно. Тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллах бөгөөд Зөвлөлийн даргыг гишүүд дотроосоо сонгоно. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна. Зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, бүрэлдэхүүнд тавих шаардлага, томилох журмыг хуулиар тогтооно.”

15/ Тавин долдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг:

“2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын, түүнчлэн тосгоны өөрийн удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

Хот, тосгонд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан, тухайн нутгийн иргэдийн саналыг үндэслэн Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.”

16/ Тавин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

“2. Нутгийн өөрөө удирдах байгууллага нь аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулиар тогтоосон хязгаарын хүрээнд өмчийн удирдлагыг хэрэгжүүлэх, татварын хувь хэмжээг тогтоох эрхтэй.

Нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг, төсвийн харилцааны үндсийг тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тодорхой онцлогт нийцүүлэн хуулиар тогтоож болно.”

Дөрөвдүгээр зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын “Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд,” гэснийг “Ерөнхий сайд,” гэж, Хорин долдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “тавиас доошгүй” гэснийг “далан таваас доошгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

Тавдугаар зүйл

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Зургадугаар зүйл

Дагаж мөрдөх хугацаа

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг 2020 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны төмөр хулгана жилийн зуны тэргүүн сарын шинийн гуравны өдрийн морин цагаас эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9¹.2-т ил санал хураалтыг гар өргөж, эсвэл цахим тоолуураар явуулна гэж заасан тул ил санал хураалтыг гар өргөж явуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг бүхэлд нь баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна.

Гишүүд гар өргөж, саналаа танилцуулна. Горимын саналаа дараа нь танилцуулчих уу. За гишүүд гараа өргөнө үү. Баталгаажуулна. Босож болно.

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Дуламдоржийн Тогтохсүрэн, Миеэгомбын Энхболд, Сандагийн Бямбацогт, Дуламсүрэнгийн Оюунхорол, Баттогтохын Чойжилсүрэн, Баагаагийн Баттөмөр, Содномын Чинзориг, Жамъянгийн Мөнхбат, Өлзийсайханы Энхтүвшин, Сүхбаатарын Батболд, Данзангийн Лүндээжанцан, Цэндийн Нямдорж, Отгонбилэгийн Содбилэг, Шатарбалын Раднаасэд, Батбаярын Ундармаа, Агваансамдангийн Сүхбат, Жаргалтулгын Эрдэнэбат, Чүлтэмийн Улаан, Янгугийн Содбаатар, Дорждамбын Дамба-Очир, Хишгээгийн Нямбаатар, Цэдэнгийн Гарамжав, Ганзоригийн Тэмүүлэн, Намсрайн Амарзаяа, Ням-Осорын Учрал, Наваан-Юндэнгийн Оюундарь, Лхагвын Мөнхбаатар, Төмөрбаатарын Аюурсайхан, Цэндийн Мөнх-Оргил, Хаянгаагийн Болорчулуун, Агваанлуvsангийн Ундраа, Хавдисламын Баделхан, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ, Лувсангийн Энхболд, Цэрэнпилийн Даваасүрэн, Дамдины Хаянхярваа, Даваагийн Ганболд, Мөнхөөгийн Оюунчимэг, Даваажанцангийн Сарангэрэл, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг, Магваны Билэгт, Борхүүгийн Дэлгэрсайхан, Жадамбын Бат-Эрдэнэ, Гомпилдоогийн Мөнхцэцэг, Жамбалын Ганбаатар, Жадамбын Энхбаяр, Чимэдийн Хүрэлбаатар, Отгоогийн Батнасан, Батсүхийн Саранчимэг, Батжаргалын Батзориг, Намсрайн Цэрэнбат, Болдын Жавхлан, Гомбожайн Солтан, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ, Нямаагийн Энхболд, Лхагваагийн Элдэв-Очир, Цэдэнбалын Цогзолмаа, Дамдины Цогтбаатар, Бямбасүрэнгийн Энх-Амгалан, Самандын Жавхлан, Жалбасүрэнгийн Батзандан, Лувсанвандангийн Болд, Гомбожавын Занданшатар.

Чуулганд 63 гишүүн оролцож, 100.0 хувийн саналаар. Чуулганд 63 гишүүн оролцож, 63 гишүүн дэмжиж, 100.0 хувь буюу Монгол Улсын Их Хурлын нийт гишүүний 4-ний 3-аас дээш хувь нь батлах санал өгсөн тул Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт батлагдлаа. /алга ташив/

Бүрэн эрхт Монгол Улсын нийт иргэд ээ,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгч өө,

Монгол Улсын Ерөнхий сайд аа,

Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт батлагдлаа. Хоёр гурван жил яригдаж сүүлийн 3 парламент дамжин идэвхтэй өрнөсөн 4 төсөл өргөн баригдсан Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулж, төрийнхөө

ирээдүйн зам мөрөө тэгшлэн засах, олон жилийн, олон хүний хүсэл эрмэлзэл ажил хэрэг боллоо.

Монголын ард түмний сонголтоор байгуулагдсан 7 дахь удаагийн Улсын Их Хурал энэ үйл хэргийг 3 жилийн турш хэлэлцэж өрнүүллээ. Нэмэлт, өөрчлөлтийн төслийн эх өргөн баригдсанаас хойш Улсын Их Хурал 4 сарын турш тасралтгүй хэлэлцэж, зуны сард ч завсарлагагүй ажилласан. Энэ хугацаанд чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанаар нэмэлт, өөрчлөлтийн төслийг 36 удаа 105.9 цаг хэлэлцжээ. Улсын Их Хурлын гишүүд төслийн танилцуулга, хэлэлцүүлгийг 21 аймаг, 9 дүүрэгт зохион байгуулж, иргэдээс 306 мянган санал ирсэн байна. Төрийн ордонд олон өдөр үргэлжилсэн хэлэлцүүлгүүдээр төрийн болон төрийн бус байгууллага, улс төрийн намууд, эрдэмтэн судлаачдаас 600 гаруй санал гарсан. Эдгээр санал нэг бүрийг нухацтай авч үзэж хэлэлцлээ.

Өөрөөр хэлбэл Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нийгмийн зөвшилцлийг хангаж, өргөн хүрээг хамруулан хэлэлцэж, баталж байгаа юм. Энэ үйл хэрэг амар хялбар байгаагүй ээ. Гэхдээ бэрхшээл саад тохиолдсон гэхээсээ илүү асар их хариуцлага, эх орон, ард түмэн ирээдүй маргаашаа бодсон чин сэтгэл, хичээнгүй тууштай зүтгэл, нөр их хөдөлмөрийг шаардсан гэж хэлж болно.

Ойлголцол, зөвшилцлийг гүнээ эрхэмлэж, түмний төлөөх үйл хэрэгт хүчээр түрэхийг бус хүлцэн тэвчих, нэгдэн хамтрах зарчмыг баримталж ажилласан. Төсөлд санал ирүүлж, зөвшилцөн хэлэлцэж, хамтарч ажилласан Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хурлын эрхэм гишүүд, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагуудад гүн талархал илэрхийлье.

Энэ үйл хэрэг зөв оновчтой, бүтэмжтэй сайн байгаасай хэмээн мэргэн ухаан, үнэт сургаалиа харамгүй хайрласан Монголынхоо нийт ард түмэнд, эрдэм мэдлэг, оюун билгээ шавхан дайчилсан эрдэмтэн судлаачиддаа, түүний дотор ачааны хүндийг үүрсэн ажлын дэд хэсгийн гишүүдэд, нүсэр ажлын найдвартай ар тал болж ажилласан Улсын Их Хурлын Тамгын газрын хамт олонд онцгойлон Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаныханд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Эрхэм нөхөд өө,

Бид Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нам, улс төр, бүлгийн ашиг сонирхлоос ангид, зөвхөн Монгол Улс, Монголын ард түмний язгуур эрх ашигт нийцэж байх тулгуур зарчмыг баримталсан. Түүнчлэн одоо л өөрчлөхгүй бол оройтно, өнөөдрийг алдвал маргаашийн өмнө хариуцлага хүлээнэ. Бид хийхгүйгээр хэн хийнэ гэж хүлээж суух вэ гэсэн итгэл үнэмшлээ мөрдлөг болгосон. “Өнгөрсөн бол сургамж, өнөөдөр бол боломж, маргааш харин бэлэг” гэж Махатма Ганди хэлсэн байдаг. Тиймээс өнгөрсөн сургамжаа цэгнэн дүгнэж, өнөөгийн түүхэн боломжийг алдалгүй ашиглаж, маргаашийнхандаа бэлэг барина гэж, барих ёстой гэж бид үзсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан энэхүү томоохон нэмэлт, өөрчлөлт төр тогтвортой, түмэн амгалан, засаглал нь тэнцвэртэй, шүүх нь

хараат бус, нутгийн удирдлагын тогтолцоо нь зөв болж, төр цэгцрэх их өөрчлөлт авчирна гэдэгт эргэлзэхгүй байна. Үүний төлөө бид хичээн зүтгэсэн билээ. Тиймээс өөрчлөлт маань эрүүл нийгэм, шударга улс төр, хөгжсөн эдийн засаг руу биднийг хөтлөн замчилна гэдэгт итгэлтэй байна. “Холын зорилго үгүй бол ойрын зовлон оршино” гэж эзэн Богд Чингис хаан хэлсэн билээ. Тиймээс ойрын зовлонгоо арилгаж, холын зорилгодоо хүрэх нь энэ цагийн бидэнд ногдсон хүндэт үүрэг юм. Эх хуулийнхаа энэхүү нэмэлт, өөрчлөлт, хууль эрх зүйн хувьсгалын эхлэл болох болно.

Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагалдан Үндэсний баялгийн сангийн тухай хууль, Шүүхийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Сонгуулийн тухай хууль, Улс төрийн намуудын тухай хууль зэрэг 30 шахам хуульд өөрчлөлт орж, эрх зүйн хувьсгал хийгдэж, нийгэмд шударга ёс, төрд эмх замбараа цэгц, сахилга, хариуцлага баттай ноёрхох суурийг тавих болно. Үр дүнд нь парламентат ёс бэхжиж, зөвхөн хууль засагласан, шударга ёс ердийн хэм хэмжээ болон төлөвшсөн, хариуцлага, сахилга бүх шатанд хэвшсэн, баялгийн өгөөж тэгш шударга хүртэгдэж, хүний хийгээд нийгмийн хөгжилдөө зориулагдсан хөгжингүй улс орон болно гэдэгт эргэлзэхгүй байна.

Өнөөдрөөс өөр байхыг, өөрчлөгдөн хувьсахыг, буруудсанаа залруулахыг Монгол Улсын эрх ашиг шаардаж байна. Энэхүү шаардлагыг хэрэгжүүлэхийн төлөө өөрчлөлт Үндсэн хуулиасаа эхэлж байна гэдгийг бид ойлгох ёстой. Иймээс Үндсэн хуулиа сахин дагаж, шинэ нэмэлт, өөрчлөлтийг сайн цагийн уриа дуудлага хэмээн хүлээн авч, зөв тууштай хэрэгжүүлэхийн төлөө бүх нийтээрээ хамтран зүтгэхийг уриалъя.

Монголоо монголоор нь үлдээж, монгол түмнээ мохоохгүйн төлөө эрхэм зорилго энэ өөрчлөлтөөр дамжин хэрэгжих учиртай. Эцэг өвгөдийн бидэнд өвлүүлсэн эрдэнэсийн эх орондоо амар түвшин, айх аюулгүй, бухимдах зовлонгүй аз жаргалтай амьдран суухыг л ард түмэн маань хүсэж байгаа. Энэ хүсэмжлэлийг төр нь биелүүлэх ёстой. Монголын төр оршин байхын утга учир нь энэ билээ. Монгол түмэндээ төрөө түшиж, түмнээ жаргааж, их Монголын суу алдрыг эгнэгт бадраахын өлзийт ерөөлийг өргөн барья.

Мөнх тэнгэрийн дор Монгол орон мөнх оршиж, сэргэн мандан, хөгжин бадрах болтугай. /Төрийн дуулал эгшиглэв/

Одоо Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Энэний дараа чуулган эргэж хуралдаад нөгөө 57-оос дээших босготой хуралдах учраас өнөөдөртөө ингээд хэлэлцэн баталъя гэж үзэж байна.

Чуулган түр завсарлалаа. Б зааланд Төрийн байгуулалтын байнгын хороо Б зааланд цуглана уу. Ажлын хэсгийнхэндээ энд сууж байгаа манай Д.Ламжав гуай, О.Мөнхсайхан доктор, А.Бямбажаргал, О.Машбат, Ц.Товуусүрэн гуай, Р.Хатанбаатар гуай, Н.Лувсанжав гуай нартаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлж байна.

Нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хэлэлцэхдээ олон улсын байгууллага, Европын Аюулгүй Байдал, Хамтын Ажиллагааны Байгууллагаас тэр улс төрийн намуудын бүртгэлийн нэг хувьтай холбоотой санал ирсэн тул энийг хэлэлцэх хугацаандаа хойшлуулж, дахин авч үзэх боломжийг олгох чиглэлийг өгч байна. Төрийн байгуулалтын байнгын хороонд чиглэл өглөө.

ЗАВСАРЛАГА

Г.Занданшатар: Гишүүд чуулганы танхимдаа цуглана. Төрийн байгуулалтын байнгын хороо хуралдаж дууссан. Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Гурав. Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төсөл */эцсийн хэлэлцүүлэг/*

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын эрхэм гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Дэлгэцээ, микрофоноо нээе. С.Бямбацогт дарга бэлэн болсон уу.

Дараагийн асуудалдаа орьё.

Чуулганы хуралдаан нээснийг мэдэгдье.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт танилцуулна. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлсэн.

Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24⁷ дугаар зүйлийн 24^{7.6} дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийлээ.

Хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд зааснаар төслийн Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх. Монгол Улсын Үндсэн хуулийн 57 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдүүлнэ гэсэн анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн санал болон Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн 19^{1.2} дахь хэсгийг 2028 оны 01 сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөх талаар холбогдох зохицуулалтыг гүйцээн боловсруулах чиглэлийг хуралдаан даргалагчаас өгсний дагуу саналыг томъёоллоо.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган, эцсийн хувилбарыг саналын томъёоллын хамт бэлтгэн Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны танилцуулга, саналын томъёоллыг хэлэлцэн Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг баталж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны танилцуулгатай холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүн байна уу? Л.Болд гишүүнээр тасаллаа. Эрхэм гишүүн Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ асуулт асууна.

Л.Оюун-Эрдэнэ: Баярлалаа. Засгийн газрын хувьд хугацаа бол маш шахуу ийм юм орж ирж байгаа юм байна. Тэгэхээр тэр дээр гишүүд бас тооцоорой гэж бас хэлэхийг хүсэж байна. Дархан, Эрдэнэттэй холбоотой асуудал, бусад хот, тосгонтой холбоотой асуудлууд гээд ингээд бас нэлээдгүй тийм шахуу үзэл баримтлалын хувьд ийм болох нь ээ гэж.

Хоёрдугаарт, С.Бямбацогт гишүүн болон одоо ажлын хэсэгт ажиллаж байсан Ц.Товуусүрэн гуайгаас бас асуухыг хүсэж байна.

Ажлын хэсэг дээр бид нар ярьж байхад энэ тосгон гэдэг дотор нутаг дэвсгэрийн маргаан байхгүй. Гэхдээ эдэлбэр газраар зааглагдсан Бэрх, Өлзийт, Тахилгат зэрэг Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 50 орчим ийм тосгодууд байгаа юм.

Энэ бүхний асуудал одоо үүн дээр хөндөгдөөд одоо энэ орж байгаа хуулиар шийдэгдэнэ гэж ойлгож болох уу. Энийг бас нэгдүгээрт асуумаар байна.

Хоёрдугаарт, С.Бямбацогт гишүүнээс Төрийн байгуулалтын байнгын хорооны даргын хувьд, бас боломжтой бол Их Хурлын даргаас нэг зүйлийг асуумаар байна. Тэр нь сая одоо Үндсэн хуулийн ерөнхийг одоо концепцоор бага хуульд одоо 30 гаруй хууль батлагдана гэж байгаа юм. Сая Үндсэн хуулийн бидний баталсан концепц дунд Монгол Улс урт хугацааны хөгжлийн хөтөлбөртэй байна гэж ийм агуулга орсон.

Хоёрдугаарт, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлт тогтвортой байна гэдэг ийм үзэл санаа орсон. Тэгэхээр Засгийн газар дээр ерөнхийдөө өнгөрсөн 30 жилийг дүгнэж, ирээдүйн 30 жилийг бас харсан ийм одоо урт хугацааны бодлогын баримт бичиг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад, сүүлийн бараг 4, 5 сар ажиллаад явж байгаа.

Тэгэхээр үүнийг дагах хууль дунд оруулаад ингээд явах уу? Энийг тодруулаад өнөөдрийн протоколд үлдэх нь бас Засгийн газрын цааш цаашдын зохион байгуулж байгаа ажиллагаанд хэрэгтэй байгаа учраас зайлшгүй протоколд үлдэх нь зүйтэй байх аа гэдэг байдлаар тодруулж асууж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Нэгдүгээрт нь, сая бид нар Байнгын хороо хуралдаад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийг баталсан. Эцсийн хэлэлцүүлэг хийсэн.

Энэ дээр бол хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн. Тухайлах юм бол Ч.Хүрэлбаатар гишүүн 21 аймгийг хот болгох асуудлыг бас анхаарах ёстой гэсэн санал хэлж байсан. Ц.Мөнх-Оргил гишүүн Налайх, Багануур дүүргийг одоо хот болгох асуудлыг ярьж байсан. Мөн Д.Оюунхорол гишүүн, Ж.Батзандан гишүүн нар Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийг бас хуваах асуудлыг анхаарах ёстой гэсэн саналууд хэлсэн. Үүнийг эцсийн хэлэлцүүлгээр анхаар гэсэн хуралдаан даргалагчаас чиглэл өгсөн. Үүний дагуу бид нар Дархан, Эрдэнэтийг одоо улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагаст багтааж шийдээрэй.

Хоёрдугаарт нь, бусад хот, тосгон, дүүргийн эрх зүйн байдлыг шийдэх асуудлыг бас Улсын Их Хуралд оруулж ирэх ёстой гэсэн чиглэлийг Засгийн газарт өгч байгаа.

Тэгэхээр таны одоо асууж байгаа тэр бусад тосгон гэдэгт бол үлдсэн одоо нэлээн олон тосгон байгаа. Бусад хотод бас тэр 21 аймгийн төвийг хот болгох асуудал орж байгаа. Тэгэхээр өргөн утгаараа үндсэндээ бол бусад аймгийн төвүүдийг хот болгох, тосгодын асуудлыг шийдэх асуудал бол үндсэндээ хамтдаа ингээд дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулиар шийдэгдэнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд сая бас нэг хамгийн том одоо бас нэг суусан асуудлын нэг бол 25.1.7-д Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт нь тогтвортой байна, Монгол Улсын хөгжлийн бодлогын асуудлыг Улсын Их Хурал одоо онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд одоо авч үзэж, баталдаг байна. Мөн одоо бас урт, дунд, богино хугацаанд бодлого нь уялдаатай байх, урт хугацааны бодлого дээр тулгуурлаж байгалийн баялгаа ашиглана гэх мэтийн одоо тодорхой заалтууд орсон.

Үүнтэй холбоотойгоор бид нар Үндсэн хуулиа хэрэгжүүлэх үүднээс Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, мөн одоо бас Монгол Улсын төрийн хар хайрцгийн бодлого буюу одоо алсын хараа, хөгжлийн стратегийг бид нар батлах ёстой.

Тийм болохоор таны одоо тавьж байгаа санал, бидний бас хийх ёстой ажил. Энэ ажлаа бид хийх ёстой. Монгол Улсын төрийн одоо хамгийн том бодлогын бичиг баримт. Монгол Улсын одоо урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтыг бид батална. Урт хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтаа хэрхэн, яаж хэрэгжүүлэх вэ, хэрэгжилтэд нь яаж хяналт тавих вэ, яаж зохион байгуулах вэ гэдэг тал дээр бас Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг бас шинэчилж найруулах асуудлыг бас Үндсэн хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинэчлэх шаардлагатай хуулиудын жагсаалт гарна. Үүн дотор бас оруулж явна гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Ц.Товуусүрэн гуай 89 дүгээр микрофон асуултад хариулна ажлын хэсэг.

Ц.Товуусүрэн: С.Бямбацогт дарга хариулчихлаа даа ер нь.

Яах вэ, газар эдэлбэр газрын маргаан байхгүй. Тэгээд Засгийн газар бол энийг судалж оруулж ирнэ гэж байгаа. Тийм учраас Засгийн газар судлаад, энэ шаардлагатай, энэ одоо ямар ямар эрх мэдлийг шилжүүлэх вэ, яаж өөрийн удирдлагыг зохион байгуулах вэ гэдэг асуудлаа Засгийн газар судлаад шийдчих юм бол энийг одоо Их Хуралд оруулаад л одоо шийдвэрлүүлэх бололцоотой гэж хэлмээр байна.

Энд бол хэдэн тосгон байх, ямар тосгон байх тухай бол яг тодорхой биш. Засгийн газрын судалгаанд л тэр нь тодорно.

Г.Занданшатар: Лувсанвандангийн Болд гишүүн асуулт асууна.

Л.Болд: Баярлалаа. Тэгэхээр энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэлэлцүүлгийн явцад ШИНЭ намын зүгээс нэг зарчмын зөрүүтэй санал оруулсан.

Энэ нь юу вэ гэхээр Монгол Улсад, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, дамжуулан өнгөрүүлэх аливаа үйл ажиллагааг хориглоно гэж. Энэ санал бол ажлын хэсэг дээр нэлээн дэмжлэг авсан. Тэгээд тухайн үедээ ямар тайлбар өгсөн гэхээр ийм хууль гарах ёстой юмаа. Энэ хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд олон хууль байгаа. Тэр дотор оруулаад ингээд үүрэгжүүлээд энэ хууль гарах асуудал тусгагдана гэсэн юм. Тэгээд одоогийн байдлаар төсөвт байхгүй байгаа. Энэ талаар бас

Байнгын хорооны даргаас асууя. Ямар журмаар, яаж шийдэхээр Байнгын хороон дээр шийдсэн бэ гэдэг энийг нэг тодорхой хариулж өгнө үү. Баярлалаа.

Г.Занданшатар: С.Бямбацогт дарга асуултад хариулна.

С.Бямбацогт: Л.Болд гишүүн, Ж.Батзандан гишүүд бас энэ Монгол Улсын нутаг дэвсгэр дээр цөмийн хог хаягдлыг буюу бас аюултай хог хаягдлыг булшлахгүй байх ийм хуулийн төслийг бид батлах ёстой. Энийг Үндсэн хуульдаа тусгая гэдэг асуудал ярьж байсан. Хөндөгдөөгүй заалт учраас одоо бас тусах бололцоо байхгүй байсан. Мөн бас Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хууль дээр тусгах ийм саналыг гаргаж байгаа. Энэ бол бас яг энэ хуульд бол Журмын тухай хуульдаа суулгах боломж байхгүй. Гэхдээ түрүүн бас Байнгын хороон дээр би хэлсэн.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуулийг шинэчлэн батлах хүртэлх хугацаанд тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг баримтална. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг Улсын Их Хурлаас баталсан хуваарийн дагуу хийж дуусна гэсэн нэгдүгээр заалт байж байгаа. Нэгдүгээр зүйлийнхээ энэ хүрээнд бид нар ярьж байгаад Улсын Их Хурлаас ойрын үед одоо Төрийн байгуулалтын байнгын хорооноос Үндсэн хуультай нийцүүлээд одоо холбогдох хууль, тогтоомжийн өөрчлөлтийг ийм хуваарийн дагуу, ийм хугацаанд ийм ийм хуулиудыг батална гэдэг жагсаалт гаргана. Тэр жагсаалтад одоо таны санал болгож байгаа хуулийг бас оруулаад явах бололцоотой гэж үзэж байгаа. Тэгээд тэр жагсаалтад одоо тэр саяны асуудлыг бас оруулаад явъя.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураана. Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэлх гишүүн л үг хэлж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулья.

1.Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний эрх зүйн байдалтай холбогдох хууль тогтоомжийг баталсны үндсэн дээр Засгийн газар Дархан, Эрдэнэтийг улсын зэрэглэлтэй хот болгох асуудлыг 2020 оны эхний хагас жилд багтаан шийдвэрлэх, Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу бусад хот, дүүрэг, тосгоны өөрийн удирдлагыг шинэчлэн зохион байгуулах, тэдгээрт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын зарим чиг үүргийг шилжүүлэх асуудлыг судлан, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.” гэж өөрчлөх.

Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Болдын Жавхлан, Дамдины Хаянхярваа, Отгонбилэгийн Содбилэг, Дуламсүрэнгийн Оюунхорол, Жалбасүрэнгийн Батзандан, Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжсэн санал.

Гишүүд ээ, санал хураалтандаа бэлдээрэй. Д.Оюунхорол гишүүн суудалдаа, Б.Саранчимэг гишүүнээ суудалдаа, Б.Бат-Эрдэнэ гишүүн суудалдаа, Д.Сарангэрэл гишүүн ээ, дараа нь. Санал хураалт явууллаа. Санал хураалт.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 62 гишүүн дэмжиж, 96.9 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

Түрүүний саналд 64 гишүүн орж, 64 гишүүн гар өргөж баталсан юм байна лээ шүү. Түрүүн энэ компьютер дээр 63 гэж гарсан, зааланд Улсын Их Хурлын Тамгын газар тоолоод 64 гишүүн байсан байна. Нэг гишүүний карт уншигдаагүй салсан байсан юм шиг байна лээ. 64 гишүүн байхыг 3 удаа гаргасан. Тэгэхээр 64 гишүүнээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсан гэж протоколд албан ёсоор тэмдэглүүлж байна.

Одоо дараагийн санал хураалтыг явуулна.

2.Төсөлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн Арван ес¹ дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг 2028 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн зүйл нэмэх.

Санал гаргасан Төрийн байгуулалтын байнгын хороо. Төрийн байгуулалтын байнгын хорооны дэмжсэн санал байна. Санал хураалт явуулъя.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 63 гишүүн дэмжиж, 98.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооны саналаар Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн төслийг бүхэлд нь баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт Л.Энх-Амгалан гишүүн ээ.

Санал хураалтад 64 гишүүн оролцож, 62 гишүүн дэмжиж, 96.9 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Нямдорж гишүүн, Л.Энх-Амгалан гишүүн техник ажиллаагүй учраас дэмжсэнд тооцуулж, 100.0 хувийн саналаар энэ санал батлагдлаа. Л.Энх-Амгалан, Ц.Нямдорж гишүүд гараа өргөж дэмжсэнээ илэрхийллээ. Ингээд 100.0 хувийн саналаар энэ хууль батлагдлаа.

Хуулийн төсөл батлагдлаа. Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Ажлын хэсэг Д.Ламжав, О.Мөнхсайхан, А.Бямбажаргал, О.Машбат, Р.Хатанбаатар,

Н.Лувсанжав, Ц.Товуусүрэн гуай нарт бас чин сэтгэлээсээ баярласан талархсанаа Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс илэрхийлж байна.

Эрдэмтэн судлаачиддаа бас ажил хөдөлмөрийн өндөр амжилт хүсэн ерөөе. Зунжин ажилласан. Тэнд байгаа манай Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг батлах ажлыг эхнээс нь оролцож, зөвлөлдөх зөвлөлд ажилласан энэ ажлын хэсэгт ажилласан Б.Цогтгэрэл Монголын Үндэсний Ардчилсан Намын дарга, П.Амаржаргал Үндсэн хууль судлаач, эрдэмтэн доктор, П.Амаржаргал зөвлөлдөх санал асуулга зохион байгуулсан. А.Ариунзаяа Үндэсний статистикийн газрын дарга, ажлын хэсгийн гишүүн Б.Гүнбилэг нарт бас талархал илэрхийлж байна, баяр хүргэж байна. Гишүүд зургаа.

Дууны бичлэгээс буулгасан:

ГЭРЭЭТ

Б.УРАНЧИМЭГ

Б.БААСАНЖАВ

Д.ЭНЭБИШ